

СЭХ
Оч 2019 сн 01, 0-9
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2018 -11- 29
БҮРТГЭВ-02

2018

Ард
Кредит
ББСБ ХХК



ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА



000001





ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн холбогдох журмуудын дагуу олон нийтэд анх удаа хувьцаагаа нээлттэй санал болгон гаргаж байгаа болно.

Энэхүү баримт бичиг нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооны Бүртгэлийн журам, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн Үнэт цаасны бүртгэлийн журамд заасан үнэт цаасыг олон нийтэд санал болгохтой холбоотой бүхий л шаардлагатай мэдээллийг агуулсан болно. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь энэ баримт бичигт агуулсан мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд бөгөөд хуурамчаар бүрдүүлсэн ямар нэгэн баримт байхгүй гэдгийг албан ёсоор баталж байна. Энд заасан мэдэгдэл худал байх тохиолдолд үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь дангаар болон хамтын журмаар хариуцлага хүлээхийг хүлээн зөвшөөрч байна. “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК нь энэхүү баримт бичигт агуулагдсан аливаа мэдээлэл, баримт бичиг, материалын агуулга, тэдгээрийн үнэн зөв, бүрэн гүйцэд эсэх асуудлаар ямар нэг хариуцлага хүлээхгүй. Тус баримт бичгийн агуулгын улмаас үүссэн аливаа хохирол, үр дагаврыг гагцхүү үнэт цаас гаргагч хариуцна.

ҮНЭТ ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Энэхүү үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч Танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Танилцуулгад хөрөнгө оруулагчид шаардлагатай мэдээллийг бүрэн оруулаагүй байж болох ба лавлах тодруулах зүйл гарвал Үнэт цаас гаргагч “Ард Кредит ББСБ” ХХК болон Андеррайтерийн компани болох “Ард Капитал Групп ҮЦК” ХХК-д хандана уу.

Андеррайтерийг төлөөлж:



Үнэт цаас гаргагчийг төлөөлж:



000002



ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

“Ард Кредит ББСБ” ХХК нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3, 62.1.4 дэх заалтууд, Үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг болон Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4.2, 7.4.4 дэх заалт болон хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 8 сарын 02 өдрийн 2018/12 тоот тогтоолыг тус тус үндэслэн компанийн хэлбэрээ өөрчлөн нээлттэй хувьцаат компани болж, олон нийтэд хувьцаагаа санал болгон гаргаж байгаа болно.

Үнэт цаас гаргагч	“Ард Кредит ББСБ” ХХК
Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
Нийт гаргасан хувьцааны тоо	210,000,000 ширхэг
Нэрлэсэн үнэ	10 төгрөг
Олон нийтэд санал болгох хувьцааны тоо	70,000,000 ширхэг
Олон нийтэд санал болгох хувьцааны хувь	25 хувь
Санал болгох хувьцааны доод үнэ (үнийн түвшин)	70 төгрөг (70-85 төгрөг)
Нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн доод дүн	4,900,000,000 төгрөг
Олон нийтэд санал болгосны дараах хувьцааны тоо	280,000,000 ширхэг
Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох арга	Тогтоосон үнийн арга
Олон нийтэд санал болгох арга	Захиалгын бүртгэлийн арга
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	Зээлийн бүтээгдэхүүнийг санхүүжүүлэх
Арилжааг зохион байгуулах байгууллага	“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК
Үндсэн андеррайтер	"Ард Капитал Групп ҮЦК" ХХК
Туслах андеррайтер	"Ард Секьюритиз ҮЦК" ХХК



000003



Сүүнэт цаасны танилцуулга
он 2019-р 01. 09-нд
БҮРТГЭВ
№ 01

ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД

МОНГОЛЫН УРСЭНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ARD КРЕДИТ
ББСБ
2018-11-29
БҮРТГЭВ-02

Үнэт цаас гаргагч

Компанийн нэр: "Ард Кредит ББСБ" ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 9015002031
Регистрийн дугаар: 5459567
Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж, "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн байр, 2 давхар
Хаяг:
Утас: 7700-3322
Цахим хаяг: info@ardcredit.com

ARD КРЕДИТ
ББСБ

Үндсэн андеррайтер

Компанийн нэр: "Ард Капитал Групп ҮЦК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 9011125147
Регистрийн дугаар: 5183855
Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити центр, 1003 тоот
Хаяг:
Утас: 7731-0262
Цахим хаяг: info@ardcapital.mn

ARD CAPITAL
Investment Firm

Туслах андеррайтер

Компанийн нэр: "Ард Секюритиз ҮЦК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 9011472112
Регистрийн дугаар: 2111063
Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж, "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн байр, 2 давхар
Хаяг:
Утас: 11-321899
Цахим хаяг: info@ardsecurities.com

ARD СЕКЮРИТИЗ
ҮЦК

Үнэлгээний компани

Компанийн нэр: "БДО Аудит" ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 9018001010
Регистрийн дугаар: 2546442
Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам 62, Юнескогийн гудамж, Юнион биолдинг, Б блок, 1502 тоот
Хаяг:
Утас: 7740-4040
Цахим хаяг: info@bdo.mn

BDO

Хуулийн фирм

Компанийн нэр: "Өмгөөллийн И Эл Си" ХХН
Регистрийн дугаар: 9022001046
5765412
Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Гэндэнгийн гудамж 16, Ардчиллын өргөө, 6 давхар
Хаяг:
Утас: 7711-8193
Цахим хаяг: info@elclawoffice.mn

ELC LLP ADVOCATES
ӨМГӨӨЛЛИЙН ҮНЭГЧ ХХН


Аудитын компани

Компанийн нэр: "Далайван Аудит" ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 9018001041
Регистрийн дугаар: 2018365
Монгол Улс, Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16-р хороо, Амарсанаагийн гудамж 5, "Далайван Аудит" ХХК байр
Хаяг:
Утас: 7000-5401
Цахим хаяг: info@dalaivanaudit.mn

ДАЛАЙВАН
АУДИТ
УЛААНБААТАР ХОТ
ARD КРЕДИТ ББСБ
ХХК
ТТН 5756 д. 5459567



000004



АГУУЛГА

ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА	2
ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД	3
НЭР ТОМЪЕОНЫ ТАЙЛБАР	9
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	13
1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ	15
1.1. Товч танилцуулга	15
1.2. Зорилго, зорилт, стратеги	16
1.3. Компанийн түүх	19
1.4. Компанийн давуу тал	21
1.5. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц	24
1.6. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө	25
1.7. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, удирдлага	26
1.8. Бүтээгдэхүүн үйлчилгээ	33
1.9. Санхүүгийн төлөв байдал	39
1.9.1. Баланс	39
1.9.2. Орлогын тайлан	42
1.9.3. Эздийн өмч, мөнгөн гүйлгээний тайлан	44
1.10. Үнэт цаас гаргагчийн хийсэн гэрээ хэлцэл	45
1.10.1. ХНХ-ийн 5 хувь буюу түүнээс дээш үнийн дүн бүхий гэрээ, хэлцэл	45
1.10.2. Их хэмжээний хэлцэл	46
1.10.3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл	46
1.11. Эрх бүхий албан тушаалтан	47
1.12. Холбоотой этгээдүүдийн мэдээлэл	48
1.13. Ногдол ашгийн бодлого	56
2. БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ	57
2.1. Макро эдийн засгийн төлөв	57
2.1.1. Дэлхийн ба хөрш улс орнуудын эдийн засаг	57
2.1.2. Олон улсын түүхий эдийн зах зээл	58
2.1.3. Монгол улсын эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын төлөв	61
2.2. ББСБ-ын зах зээлийн төлөв	67
2.2.1. ББСБ-ын харилцагчдын тоо	67
2.2.2. Хүртгэмжтэй байдал	68
2.2.3. Хөрөнгө	69
2.2.4. Зээл	69



000005





2.2.5.	Эх үүсвэр	71
2.2.6.	Ашигт ажиллагаа	73
2.2.7.	Бизнесийн хууль, эрх зүйн орчин	74
2.2.8.	Ард Кредит ББСБ-ын зах зээлд эзлэх байр суурь	74
2.3.	Зах зээлийн багтаамж	79
2.4.	Ард Кредит ББСБ-ын бизнесийн үйл ажиллагаа	81
2.4.1.	Бичил болон Жижиг дунд бизнесийн зээл	85
2.4.2.	Төслийн болон хоршоо хөгжлийн зээл	85
2.3.3.	Кредит карт	87
2.3.4.	“Ард” бүтээгдэхүүн, үйлчилгээ	90
2.4.	Маркетингийн стратеги	95
2.5.	Санхүүгийн төлөвлөгөө	97
2.6.	Санхүүжилт, эх үүсвэрийн төлөвлөгөө	100
2.7.	Эрсдэлийн шинжилгээ	102
3.	ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА	110
3.1.	Үнэт цаас гаргах тухай шийдвэр	110
3.2.	Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдээс гаргасан шийдвэр	110
3.3.	Хувьцаа эзэмшигчийн бүтэц, хувь нийлүүдсэн хөрөнгө	110
3.4.	Үнэт цаасаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	111
3.5.	Үнэт цаасны үнэ тогтоосон үндэслэл	112
3.6.	Үнэт цаасны өгөөжийн төсөөлөл	116
3.7.	Хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэг	117
3.8.	Үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох	118
3.9.	Нээлттэй хувьцаат компанийн үйл ажиллагаа явуулах хууль, эрх зүйн орчин	121
3.9.1.	Компанийн тухай хууль	121
3.9.2.	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль	125
3.9.3.	МХБ болон СЗХ-ноос баталсан журам	127
4.	ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ТАНИЛЦУУЛГА	128
4.1.	Үндсэн Андеррайтер	128
4.2.	Туслах Андеррайтер	129
4.3.	Хуулийн фирм	130
4.5.	Үнэлгээний компани	133
	ХАРААТ БУС ЗОХИЦУУЛАЛТАЙ ЭТГЭЭДҮҮДИЙН ДҮГНЭЛТ	135
	Андеррайтерийн дүгнэлт	
	ХАВСРАЛТ	
	Тайлангийн дараах үйл явдал	



000006





Хүснэгт 1. Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл	25
Хүснэгт 2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт	26
Хүснэгт 3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн задаргаа	26
Хүснэгт 4. ТУЗ-ийн бүрэлдэхүүн	27
Хүснэгт 5. Гүйцэтгэх удирдлагын баг	32
Хүснэгт 6. Үйл ажиллагааны журмууд	33
Хүснэгт 7. Зээлийн мэдээлэл	34
Хүснэгт 8. Зээлийн хүүгийн орлого (сая төгрөг)	36
Хүснэгт 9. Итгэлцэлийн үйлчилгээ	37
Хүснэгт 10. Санхүүгийн тайлангийн мэдээлэл (сая төгрөг)	40
Хүснэгт 11. Зээл (сая төгрөг)	40
Хүснэгт 12. Авлага (сая төгрөг)	40
Хүснэгт 13. Үндсэн хөрөнгө (сая төгрөг)	41
Хүснэгт 14. Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл (сая төгрөг)	41
Хүснэгт 15. Бусад эх үүсвэр (сая төгрөг)	41
Хүснэгт 16. Балансын харьцаа үзүүлэлтүүд	41
Хүснэгт 17. Орлогын тайлан (сая төгрөг)	42
Хүснэгт 18. Ашигт ажиллагааны харьцаа	43
Хүснэгт 19. Өмчийн өөрчлөлтийн тайлан (сая төгрөг)	44
Хүснэгт 20. Мөнгөн гүйлгээний тайлан (сая төгрөг)	44
Хүснэгт 21. ХНХ-ийн 5% буюу түүнээс дээш үнийн дүн бүхий гэрээ хэлцэл	46
Хүснэгт 22. Сонирхлын зөрчилтэй хэлцэл	47
Хүснэгт 23. Эрх бүхий албан тушаалтан	47
Хүснэгт 24. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц (2017)	49
Хүснэгт 25. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хөрөнгө оруулалтын бүтэц (2017)	49
Хүснэгт 26. Орлогын тайлан (аудитлагдсан, сая төгрөг)	50
Хүснэгт 27. Ард Даатгал ХХК-ийн санхүүгийн үзүүлэлт (сая төгрөг)	50
Хүснэгт 28. Монгол шуудан ХК-ийн санхүүгийн үзүүлэлт (сая төгрөг)	51
Хүснэгт 29. Ард Секюритиз УЦК ХХК-ийн санхүүгийн үзүүлэлт (сая төгрөг)	52
Хүснэгт 30. Ард Менежмент УЦК-ийн санхүүгийн үзүүлэлт (сая төгрөг)	52
Хүснэгт 31. Жинст Увс ХК-ийн санхүүгийн үзүүлэлт (сая төгрөг)	53
Хүснэгт 32. Ард Лайф ХХК-ийн санхүүгийн үзүүлэлт (сая төгрөг)	54
Хүснэгт 33. Ард актив ХЗХ-ийн санхүүгийн үзүүлэлт (сая төгрөг)	54
Хүснэгт 34. Тэнгэр системс ХХК-ийн санхүүгийн үзүүлэлт (сая төгрөг)	55
Хүснэгт 35. Улс орнуудын эдийн засгийн өсөлтийн хувь	57
Хүснэгт 36. Голлох түүхий эдийн үнэ (ам.доллар)	59
Хүснэгт 37. Нүүрсний хэрэглээ (сая тонн)	59
Хүснэгт 38. БНХАУ-ын коксжих нүүрсний импорт (мянган тонн)	60
Хүснэгт 39. Монгол Улсын ДНБ	61
Хүснэгт 40. Гадаад худалдаа (сая ам.доллар)	65
Хүснэгт 41. Голлох валютын ханш (төгрөг)	66
Хүснэгт 42. ББСБ-ын байршил (бүсчиллээр)	68
Хүснэгт 43. Зээлдэгчийн дундаж зээл, зээлийн үйлчилгээний хүртээмж	69
Хүснэгт 44. ББСБ-ийн хөрөнгө (активын хэмжээгээр)	69
Хүснэгт 45. Бүтээгдэхүүн үйлчилгээний зээлийн багцад эзлэх хувь	83
Хүснэгт 46. Харилцагчийн тоо, зээлийн төсөөлөл	83



000007




СЗҮ
 Үнэт цаасны танилцуулга
 он 2019-д 01-09-р
 БҮРТГЭВ
 №

АРД КРЕДИТ
 МОНГОЛ АРД ТҮҮХЭЙН БИРЖ
 БЭСБ
 MONGOLIAN STOCK EXCHANGE
 2018-11-29
 БҮРТГЭВ-02

Хүснэгт 47. Зээлийн үлдэгдэл.....	84
Хүснэгт 48. Итгэлцлийн үйлчилгээний нөхцөл.....	84
Хүснэгт 49. Итгэлцлийн төсөөлөл.....	84
Хүснэгт 50. Зах зээлд нэвтэрсэн кредит картын харьцуулалт.....	88
Хүснэгт 51. Ард Кредит картын харилцагчдын тооны төсөөлөл.....	89
Хүснэгт 52. Ижил төрлийн аппликэйшний харьцуулалт.....	92
Хүснэгт 53. "Ард" зээлийн бүтээгдэхүүний ерөнхий нөхцлийг өрсөлдөгч байгууллагуудын бүтээгдэхүүнтэй харьцуулсан байдал.....	93
Хүснэгт 54. "Ард" зээлийн бүтээгдэхүүний ирэх 5 жилийн төсөөлөл.....	94
Хүснэгт 55. "Ард" бүтээгдэхүүний орлогын төсөөлөл (сая төгрөг).....	94
Хүснэгт 56. Санхүү байдлын тайлангийн төсөөлөл (сая төгрөг).....	97
Хүснэгт 57. Орлого үр дүнгийн тайлангийн төсөөлөл (сая төгрөг).....	99
Хүснэгт 58. Мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл (сая төгрөг).....	100
Хүснэгт 59. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт.....	100
Хүснэгт 60. Санхүүжилтийн төлөвлөгөө (сая төгрөг).....	101
Хүснэгт 61. Зээлийн бүтээгдэхүүний хязгаар.....	105
Хүснэгт 62. Олон нийтэд санал болгосны дараах хувьцаа эзэмшигчдийн бүтэц.....	111
Хүснэгт 63. Олон нийтэд хувьцаа санал болгосны дараах хувь нийлүүлсэн хөрөнгө.....	111
Хүснэгт 64. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт.....	111
Хүснэгт 65. Үнэлгээнд ашигласан параметрууд.....	114
Хүснэгт 66. Үнэт цаасны өгөөжийн төсөөлөл.....	116
Хүснэгт 67. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах хуваарь.....	119
Хүснэгт 68. Андахгч зах зээлд санал болгох хэлбэр.....	120

График

График 1. Ногдол ашгийн түүх.....	24
График 2. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц.....	24
График 3. Зээлийн төрөл.....	34
График 4. Бизнесийн зээл (сая төгрөг).....	35
График 5. Хэрэглээний зээл (сая төгрөг).....	35
График 6. Шуурхай зээл (сая төгрөг).....	35
График 7. Зээлийн хүү (жигнэсэн дундаж).....	36
График 8. Чанаргүй зээлийн мэдээлэл.....	36
График 9. Нийт хөрөнгөд эзлэх зээлийн хувь.....	36
График 10. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц.....	62
График 11. Мөнгөний нийлүүлэлт (их наяд төгрөг).....	62
График 12. Санхүүгийн байгууллагын зээлийн үлдэгдэл (их наяд төгрөг).....	62
График 13. Санхүүгийн байгууллагын чанаргүй зээл (их наяд төгрөг).....	63
График 14. Зээлийн өсөлт ба чанаргүй зээлийн хувь.....	63
График 15. Нэгдсэн төсөв (тэрбум төгрөг).....	63
График 16. Гадаад шууд хөрөнгө оруулалт (сая ам.доллар).....	64
График 17. Төлбөрийн тэнцэл.....	64
График 18. Инфляц (хувь).....	65
График 19. Гадаад валютын албан нөөц (ам.доллар).....	66
График 20. ББСБ-ын тоо болон харилцагчдын тоо.....	68
График 21. ДНБ-ийн өсөлт, ББСБ-ын салбарын эзлийн өсөлт.....	70
График 22. ББСБ-аас гаргасан зээлийн үлдэгдэл.....	70



000008





График 23. ББСБ-ын салбар болон Банкны салбарын зээлийн үлдэгдэл харьцаа	70
График 24. Банк болон ББСБ-ын чанаргүй зээлийн хувь	71
График 25. ББСБ ба банкны зээлийн хүү (жигнэсэн дундаж)	71
График 26. ББСБ-ын өр, төлбөрийн бүтэц (тэрбум төгрөг)	72
График 27. ББСБ-ын өөрийн хөрөнгө (тэрбум төгрөг)	72
График 28. ББСБ-ын нийт актив, эздийн өмч, харьцаа	72
График 29. ББСБ-ын нийт орлого ба цэвэр ашиг	73
График 30. ББСБ-ын голлох ашигт ажиллагааны харьцаанууд	73
График 31. Ард Кредит хөрөнгө, өсөлт	74
График 32. ББСБ салбарын хөрөнгө, өсөлт	74
График 33. Ард Кредит ББСБ болон салбарын зээлийн харьцуулалтууд	75
График 34. Ард Кредит болон салбарын зээлийн чанарын харьцуулалтууд	75
График 35. Ард Кредит болон салбарын орлогын харьцуулалтууд	75
График 36. Ард Кредит ББСБ-ын ББСБ-ын салбарын орлого болон ашигт эзлэх харьцаа	76
График 37. ББСБ-ын ашиг Ард Кредит ББСБ-ын ашгийн харьцуулалт	76
График 38. ААН, ЖДҮ эрхлэгчдийн тоо	79
График 39. ЖДҮ-ийн шаардлагатай санхүүжилтийн хэмжээ	80
График 40. Иргэдийн зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөг)	81
График 41.2. Өрхийн илүүдэл зардал санхүүжүүлэх эх үүсвэр	81
График 42.1. Өрхийн мөнгөн орлого, зарлага	81
График 43. Бичил болон жижиг дунд бизнесийн зээл (сая төгрөг)	85
График 44. Төслийн зээл (сая төгрөг)	86
График 45. Кредит картын зээлийн чанар	89
График 46. Кредит картын зээл (тэрбум төгрөг)	89
График 47. Нийт активын өсөлтийг графикаар дүрслэн үзүүлбэл (сая төгрөг)	98

Зураг

Зураг 1. "Ард Кредит ББСБ" ХХК-ийн хамт олон	16
Зураг 2. Ард кредит карт	22
Зураг 3. Ард аппликэйшн	23
Зураг 4. Жилийн тайлан	23
Зураг 5. ББСБ-ын хүртээмжтэй байдал (газарзүйн байршлаар)	68
Зураг 6. Төслийн хамрах хүрээ	86
Зураг 7. Ард Кредит картын загвар	87
Зураг 8. Ард аппликэйшн	90
Зураг 9. Маркетингийн иж бүрдлүүд	96

Схем

Схем 1. "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн хөрөнгө оруулалтын бүтэц	21
Схем 2. Бүтэц зохион байгуулалт	26
Схем 3. ТУЗ-ийн дэргэдэх хороод	31
Схем 4. Зээлийн төрөл	34
Схем 5. "Ард" аппликэйшний функц	39
Схем 6. "Ард" аппликэйшн онлайн зээл олгох үе шат	91



000009





НЭР ТОМЪЕОНЫ ТАЙЛБАР

Үнэт цаас	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1 зүйлд заасан санхүүгийн хэрэгслийг хэлнэ.
Үнэт цаас гаргагч	Үнэт цаасны зах зээлд арилжих үнэт цаасаа Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлсэн, эсхүл бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа этгээдийг хэлнэ.
Санхүүгийн Зохицуулах Хороо	Улсын санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага юм.
Андеррайтер	Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх ажиллагааг андеррайтерийн үйл ажиллагаа гэнэ.
Хувьцаа	Компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаасыг хэлнэ.
Нэрлэсэн үнэ	Хувьцаа нь компанийн дүрмээр тогтоосон нэрлэсэн үнэтэй байх бөгөөд тухайн компанийн нэг төрлийн хувьцааны нэрлэсэн үнэ ижил байна.
Үнэт цаасны төрөл Хувь нийлүүлсэн хөрөнгө	Хувьцаа нь энгийн, давуу эрхийн, алтан гэсэн төрөлтэй байна. Тухайн компаниас хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг хэлнэ.
Зарласан хувьцаа	Компанийн энгийн болон давуу эрхийн хувьцааны тоог компанийн дүрмээр тогтоох бөгөөд үүнийг зарласан хувьцаа гэнэ.
Гаргасан хувьцаа	Хувьцаа эзэмшигчдэд худалдсан хувьцаа бөгөөд энэ хувьцааны хэмжээгээр компанийн эзэмшил тодорхойлогдоно.
Энгийн хувьцаа	Саналын эрхтэй, ногдол ашиг хүртэх /ашигтай ажилласан үед/, бүх өр төлбөрийг барагдуулсны дараа үлдэх хөрөнгөөс давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дараа нэхэмжлэх эрхтэй гаргасан хувьцаа.
Ногдол ашиг	Жил бүрийн ашгийн хуваарилалт юм. Компанийн тухай хуулийн 46.1 зүйлийн дагуу ТУЗ нь хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг гаргадаг. Ногдол ашгийг компанийн татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилна. Давуу эрхийн хувьцаанд хуваарилах ногдол ашгийг тусгайлан байгуулсан сангаас олгож болно.
Хөрөнгө оруулалт	Ашиг олох зорилгоор үнэт цаас, эд хөрөнгө худалдан авах, эсхүл ямар нэг бараа, үйлдвэрийн тоног төхөөрөмж, байшин барилга худалдаж авах зэрэг нь хөрөнгө оруулалт болно.



000010



СЗУ
Үнэт цаасны танилцуулга
сн 2013 с. 01. 09-р
БҮРТГЭВ
№ Анхдагч зах зээл

МОНГОЛЫН КРЕДИТНИЙ БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2018-11-29
БҮРТГЭВ-02

Хоёрдогч зах зээл	Үнэт цаас гаргагч үнэт цаасаа нийтэд санал болгон арилжих үйл явц
Хаалттай бонд	Анхдагч зах зээлээс худалдан авсан үнэт цаасыг дахин худалдах, худалдан авч буй зах зээлийг хэлнэ.
Нийтэд санал болгох (IPO)	Бонд гэдэг нь тодорхой хэмжээний мөнгийг тогтоосон хугацааны дараа тодорхой хүүтэйгээр эргүүлэн төлөхийг амлаж байгааг баталсан үнэт цаас юм. 50-с доош тооны этгээдэд санал болгохыг хаалттай бонд гэнэ.
Финтек	Үнэт цаасны анхдагч зах зээл дээр үнэт цаас гаргагчаас үнэт цаасаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан нийтэд санал болгож худалдах ажиллагаа
Охин компани	Финтек (FinTech – financial technology) буюу англиар санхүүгийн технологи гэсэн хоёр үгийн нийлмэл товчлол бөгөөд орчин үеийн техник технологийн дэвшилд тулгуурлан санхүүгийн үйлчилгээг нэвтрүүлэх.
Зэргэлдээ компани	Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 50-аас дээш хувийг өөр (толгой) компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг бие даасан компанийг охин компани гэнэ.
Хараат компани	Нэг толгой компанийн хараат болон охин компаниуд, эсхүл нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг компани
Их хэмжээний хэлцэл	Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 20.0-50.0 хувийг өөр (толгой) компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа компани
Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Компанийн өөрийн хөрөнгийн 25.0 хувиас дээш хэмжээтэй тэнцэхүйц үнийн дүн бүхий гэрээ, хэлцэл
Хувьцаа эзэмшигчдийн хурал	Компанийн тухай хуулийн 89.1 зүйлд заасныг ойлгоно.
Төлөөлөн удирдах зөвлөл	Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг компанийн санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор зарлан хуралдуулана.
Зээлийн шугам	Компанийг удирдлагаар хангаж, стратеги хэтийн төлөвийг тодорхойлох, хувьцаа эзэмшигчдийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх байгууллага
	Эргэлтийн хөрөнгө байнга шаардагддаг бизнесийн онцлогт уялдуулан зээлдэгч нь банкнаас батлагдсан зээлийн эрхийн хэмжээнд өөрийн мөнгөн урсгалаас хамаарч хүссэн үедээ авч болдог зээл



000011





Мөнгөн хөрөнгийн өгөөж, хугацаа зэргийг харилцан тохиролцсоны үндсэн дээр харилцагчдаасаа мөнгөн хөрөнгийг авч, зах зээлийн эрсдэл, үнэгүйдлээс хамгаалж, тэдгээрийг удирдан өндөр өгөөж хүртээх зорилготой зээл хэлбэрээр гаргах, хянах, захиран зарцуулах үйл ажиллагаа

Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан

"Бичил санхүүгийн хөгжлийн сан" нь иргэдийн амьжиргааны эх үүсвэрийг дээшлүүлэх, орлогыг нэмэгдүүлэх зорилгоор шаардлага хангасан арилжааны болон банк бус санхүүгийн байгууллагуудад зээлийн эх үүсвэрийг хуваарилаж, харин шалгарсан байгууллага зээлийн эх үүсвэрийг 21 аймагт дамжуулан зээлдүүлдэг.

Мобайл хэтэвч (цахим хэтэвч)

Төлбөрийн карт болон банкны гүйлгээ хийх, АТМ-ээс бэлэн мөнгө авах, орон сууц, ахуйн хэрэглээнийхээ төлбөр хийх, утас, данс, картын дугаараар мөнгө шилжүүлэх үйлчилгээ

Рибрэндинг

Шинэ брэндээ олон нийтийн цахим мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээ, фэйсбүүкийг ашиглан таниулах

Олон Улсын Валютын Сан

Олон Улсын Валютын Сан (ОУВС) нь олон улсын санхүүгийн тогтвортой байдал болон хамтын ажиллагааг дэмждэг, эдийн засгийн тогтвортой өсөлт болон ажлын байр бий болгохыг дэмжиж, дэлхий дахинаа ядуурлыг бууруулахад үйл ажиллагаагаа чиглүүлдэг байгууллага

Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөр

ОУВС нь гишүүн орнууддаа төлбөрийн тэнцэлтэй холбоотой хүндрэлээс гарах боломжийг олгодог бөгөөд энэ хүрээнд дэмжлэг авч буй орны эрх баригчид ОУВС-тай нягт хамтран ажиллах байдлаар ОУВС-гаас санхүүжигдэх хөтөлбөр боловсруулах бөгөөд тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлаас хамааран санхүүжилт үргэлжлэн олгогдох эсэх нь шийдэгддэг. Монгол улс 2017 оны 5 сарын 24-ний өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай хөтөлбөрт хамрагдаж байгаа юм.

Дотоодын нийт бүтээгдэхүүн

Тодорхой хугацаанд тухайн улсын нутаг дэвсгэрт шинээр бүтээгдсэн бараа болон үйлчилгээнүүдийн зах зээлийн үнийн нийлбэр

M2 мөнгө

Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, төгрөг болон валютын хадгаламж, хадгаламжийн сертификатын нийлбэр

M1 мөнгө

Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэр

Нөөц мөнгө

Хадгаламжийн байгууллагуудын касст байгаа бэлэн мөнгө, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон банкуудын Монголбанк дахь төгрөг, валютын харилцах, валютын хадгаламжийн нийлбэр



000012





Хугацаа хэтэрсэн зээл	Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээл
Чанаргүй зээл	Зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээл
Зээлийн лимит	Зээлийн дээд хэмжээ
Peer-to-peer	Хөндлөнгийн санхүүгийн зуучлагчийн оролцоогүйгээр энгийн хоёр хүн хоорондоо зээлийг олгох
QR-код	"Түргэн хариу өгөх код" гэдэг үгний товчилсон хэлбэр бөгөөд хялбар байлгах үүднээс "дөрвөлжин зураасан код" бий болгож анх Японы автомашины үйлдвэрт ашигласан байдаг.
QRay	Үйлчилгээний болон олон нийтийн байгууллагуудыг QR кодоор бүртгэж банкуудтай холбосон төлбөрийн системийн үйлчилгээ
Хиймэл оюун ухаан	Тасралтгүй хөгжиж байдаг төгс программ
Дижитал маркетинг	Компьютер, ухаалаг гар утас, энгийн гар утас, таблет, ТВ, тоглоомны удирдлага гэх мэт электрон төхөөрөмжүүдийг ашиглан сурталчилгаа явуулах маркетинг



000013





ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР



СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
МХБ	Монголын Хөрөнгийн Бирж
АХБ	Азийн Хөгжлийн Банк
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ҮЦК	Үнэт цаасны компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
БСБ	Боловсрол соёлын байгууллага
ХК	Хувьцаат компани
ХХН	Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл
БСХС	Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан
АТМ	Автомат теллерийн машин
ХХБ	Худалдаа Хөгжлийн Банк
ҮЦТХТ	Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв
ҮЦЗЗ	Үнэт Цаасны Зах Зээл
ОУ	Олон улс
ГУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УЗ	Удирдах зөвлөл
КТХ	Компанийн тухай хууль
ХЗХ	Хадгаламж Зээлийн Хоршоо
ЖДБ зээл	Жижиг дунд бизнесийн зээл
МТНД	Монголын тэтгэврийн нэгдсэн данс ХХК
МУ	Монгол улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард улс
ОХУ	Оросын Холбооны улс
АНУ	Америкийн Нэгдсэн улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс
БНАСАУ	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард улс
ОУВС	Олон Улсын Валютын Сан
OECD	Эдийн засгийн хамтын ажиллагаа болон хөгжлийн байгууллага
ОПЕК (ОPEC)	Газрын Тос Экспортлогч Орнуудын Байгууллага (Organization of Petroleum Exporting Countries)
IEA	International Energy Agency (Олон улсын энергийн агентлаг)
EIU	Economist Intelligence Unit (Эдийн засгийн тандалт судалгааны нэгж)
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДХ	Жигнэсэн дундаж хүү
ГШХО	Гадаадын шууд Хөрөнгө оруулалт
ГВАН	Гадаад валютын албан нөөц
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
IOS	iPhone гар утсанд ашигладаг программ хангамж
IPO	Хувьцааг нийтэд санал болгох Initial public



000014





ОАТ
 УОУК
 УОУС
 ЖКАЗ
 ЖААЗ
 ХМУ
 КЖДӨ
 КХҮЗ
 МҮЦАЭХ
 М&А
 ЛСА

Offering
 Орлогын албан татвар
 Үнэлгээний Олон Улсын Консул
 Үнэлгээний Олон Улсын Стандарт
 Жишиг компанийн арга зүй
 Жишиг арилжааны арга зүй
 Хорогдуулсан мөнгөн урсгал
 Капиталын жигнэсэн дундаж өртөг
 Капитал хөрөнгө үнэлгээний загвар
 Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо
 Merger and Aquisition (компанийн нэгдэх, нэгтгэх үйл явц)
 Япон улсын хамтын ажиллагааны байгууллага (The Japan International Cooperation Agency)



000015





1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

1.1. Товч танилцуулга

Бүртгэл:	“Ард Кредит ББСБ” ХХК УБД: 9015002031 РД: 5459567
Байгуулагдсан он:	2011 он
Үйл ажиллагааны чиглэл:	<ul style="list-style-type: none"> - Зээлийн үйл ажиллагаа - Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга - Гадаад валютын арилжаа - Хөрөнгө оруулалт, санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх - Хаалттай өрийн бичиг - Итгэлцлийн үйлчилгээ - Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх
Санхүү: (2017-12-31, аудитлагдсан)	Хөрөнгө: 10.2 тэрбум төгрөг Өр төлбөр: 6.5 тэрбум төгрөг Өмч: 3.7 тэрбум төгрөг
Бизнес үнэлгээ (олон нийтэд хувьцаа арилжаалсны дараах):	22.2-28.6 тэрбум төгрөг
Хувьцаа эзэмшигч:	3
Ажилтан:	13
Гүйцэтгэх захирал:	Чулуун овогтой Ганзориг
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-2, “Ард Холдингс” ХК байр, 2 давхар 77003322

“Ард Кредит ББСБ” ХХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан Монгол Улсын тэргүүлэх банк бус санхүүгийн байгууллагуудын нэг юм.

Ард Кредит ББСБ нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш тогтмол өсөн дэвшиж, жил бүр ашигтай ажиллаж ирсэн ба сүүлийн 3 жилд ногдол ашиг тааралгүй олгосон. Тухайлбал, 2017 онд 1.8 тэрбум төгрөгийн орлоготой, 641.8 сая төгрөгийн ашигтай ажиллаж, 320.0 сая төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдээ олгосон байна. Уг онд компанийн нийт хөрөнгө 10.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 79.1 хувиар нэмэгдсэн байна.

Компани нь зээл олгох, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, итгэлцэл татах зэрэг 7 төрлийн санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд үзүүлж буй санхүүгийн үйлчилгээгээ хүмүүсийн эрэлт хэрэгцээ, технологийн дэвшилтэй хослуулан харилцагчиддаа байнга шинэчлэн, хүргэдэг. Үүний нэг тод жишээ бол 2016 онд банк бус санхүүгийн байгууллагуудаас анх удаа олон нийтэд “кредит карт”-ыг санал болгон зах зээлд амжилттай нэвтрүүлсэн. Үнэт цаас гаргагч нь “Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан” (БСХС)-тай хамтран төслийн бага хүүтэй зээлийг бичил ба жижиг дунд бизнес эрхлэгчдэд олгож эхэлснээр олон хүмүүст бизнесээ өргөжүүлж, амьжиргаагаа дээшлүүлэх боломж олгосон. Мөн орчин үеийн технологид суурилсан төлбөр тооцоо хийх, богино хугацаанд зээл авах зэрэг санхүүгийн байгууллагын цогц үйлчилгээг нэвэрүүлэхээр ажиллаж байна.

2018 онд компани нь уламжлалт үйл ажиллагааны арга барилаа өөрчлөн орчин үеийн Финтек банк, санхүүгийн байгууллага болохоор төлөвлөсөн бөгөөд “Ард” гар утасны аппликэйшнийг зах зээлд нэвтрүүлсэн. Ингэснээр харилцагчид “Ард” аппликэйшнээр дамжуулан өөрийн гар утсаараа хүссэн цагтаа хаанаас ч төлбөр тооцоо хийх, дансаа хянах, шилжүүлэг хийх боломжтой болсон. Мөн компани нь харилцагчиддаа илүү ойртож ажиллах үүднээ стратегийн хамтрагч байгууллагууд болох “Монгол Шуудан” ХК, “Ард Даатгал” ХХК-ийн Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт байрлах салбаруудыг ашиглан санхүүгийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилт тавин ажиллаж байна.

“Ард Кредит ББСБ” ХХК нь дээрх зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх үүднээ 2018 онд компаниа Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлэх, олон нийтээ хөрөнгө оруулалт татах түүхэн шийдвэр гаргаад байна.



000016





АЛСЫН ХАРАА

Бид Монгол Улсад банкны үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж, санхүүгийн боловсролыг дэлгэрүүлэх зорилго бүхий нийгмийн хариуцлагын тэргүүлэгч байгууллага болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Ард Кредит нь санхүүгийн шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэн зах зээлд манлайлж ажиллана.

ҮНЭТ ЗҮЙЛС

Сэтгэл ханамжтай ажиллагсад
Харилцагч төвтэй, шинэлэг үйлчилгээ
Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа
Нийгмийн хариуцлаг
Тогтвортой өндөр өгөөж

1.2. Зорилго, зорилт, стратеги

Ард Кредит ББСБ нь санхүүгийн шинэлэг үйлчилгээг орчин үеийн технологи дээр тулгуурлан иргэд, аж ахуйн нэгжүүдэд хүргэхээр зорьж ажиллаж байна. Ингэснээр харилцагчид дэлхийн хаанаас ч өөрийн санхүүгээ хүссэн цагтаа удирдах боломжтой юм. Энэхүү зорилгын хүрээнд Ард Кредит ББСБ нь дараагийн 5 жилд хоорондоо харилцан хамаарал бүхий доорх зорилт, стратегийг дэвшүүлэн ажиллаж байна:

- ❖ Финтек санхүүгийн байгууллага болох;
- ❖ Үйл ажиллагааны бүтцийг сайжруулах;
- ❖ Үйл ажиллагаагаа зогсолтгүй, хурдтай өргөжүүлэх;
- ❖ Хувьцаа эзэмшигчиддээ үнэ цэнэ бий болгох;



000017



СЭХ
ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
ОН 2019 СЭ 01.09
БҮРТГЭВ
№01

Финтек банк бус санхүүгийн байгууллага

Болох

Ард Кредит ББСБ нь дэлхийн банк санхүүгийн байгууллагын чиг хандлага болоод байгаа финтек санхүүгийн байгууллага болохоор зорьж байна. Финтек санхүүгийн байгууллага нь санхүүгийн үйлчилгээг технологи ашиглан хүмүүст хүргэдэг байгууллага юм. Тухайлбал, хүмүүс заавал банк санхүүгийн байгууллага дээр очихгүйгээр өөрийн гар утас болон компьютер ашиглан дэлхийн хаанаас ч хүссэн цагтаа санхүүгийн үйлчилгээг хялбар авах юм.

Энэхүү зорилгын хүрээнд Ард Кредит ББСБ нь уламжлалт үйл ажиллагааны арга барилаа өөрчлөн финтек бизнесийн загвар руу эргэлт буцалтгүй шилжээд байна. Тухайлбал, Ард Кредит ББСБ нь 2018 оны хоёрдугаар улиралд “Ард” гар утасны аппликэйшнийг зах зээлд нэвтрүүлсэн. Ингэснээр харилцагчид “Ард” аппликэйшнээр дамжуулан өөрийн гар утсаараа хүссэн цагтаа хаанаас ч төлбөр тооцоо хийх, дансаа хянах, шилжүүлэг хийх боломжтой болсон. Удахгүй тус аппликэйшнээр дамжуулан 3 сая хүртэл төгрөгийн барьцаагүй зээлийг 15 минутад олгох үйлчилгээг нэвтрүүлэх юм. Мөн компани нь цаашид Ард Санхүүгийн Нэгдэл нэрийн дор үйл ажиллагаа явуулж буй үнэт цаас, даатгал, хадгаламж зээлийн хоршоо зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, данс нээх, хадгаламж үүсгэх, зээл авах, даатгал хийлгэх, тэтгэврийн санд хамрагдах, үнэт цаасны арилжаанд оролцох, валютын арилжаа хийх, гадаад мөнгөн гуйвуулга хийх зэрэг санхүүгийн цогц үйлчилгээг “Ард” аппликэйшнээр хүргэхээр зорьж ажиллаж байна.

❖ Үйл ажиллагааны бүтцийг сайжруулах

Финтек бизнесийн загвар нь орчин үеийн дэвшилтэт технологийг үйл ажиллагаандаа ашиглан харилцагчдад санхүүгийн үйлчилгээг хялбар авах боломжийг олгодог. Энэхүү үйл ажиллагаатай уялдан гүйгээний өгөгдлийг хурдан шуурхай дамжуулах, бүртгэл, төлбөр тооцоог түргэн гүйцэтгэх зэрэг банк, санхүүгийн байгууллагын “арын алба”-ны үйл ажиллагааг автоматжуулах шаардлага зайлшгүй тулгардаг. Иймд Ард Кредит ББСБ нь үйл ажиллагаагаа дээрх шаардлагад нийцүүлэх зорилгоор банкны суурь бүртгэлийн систем болох Поларис Смарт программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна. Энэхүү программ нь 20 жилийн турш үйл ажиллагаа явуулж буй банк, санхүүгийн

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
АРД КРЕДИТ ББСБ
2018 -11- 29
Шигтгээ 1: БҮРТГЭВ-02

Дэлхийн банк, санхүүгийн чиг хандлага

Банк санхүүгийн салбарт сүүлийн 50 жилд 3 шинэчлэлийн давалгаа болж өнгөрсөн байна. Үүнд:

Эхний давалгаа:

1970-аад оны дундуур Сити банк АТМ буюу автомат теллерийн машиныг туршиж эхэлсэн. Энэхүү машин нь иргэдийн банкны үйлчилгээг шинэ түвшинд авчирсан юм. Тухайлбал, банкны хязгаарлагдмал цагт баригдахгүй бэлэн мөнгө хуримтлуулах, зарлага гаргах зэрэг үйл ажиллагааг авах боломжтой болсон. 1980-аад оноос интернэт банкны судалгаа хийгдэж эхэлсэн ч интернэт хэрэглээ нэмэгдэх хүртэл буюу 1990 он хүртэл дэлгэрч чадаагүй. Энгийн броузерууд нь банкаар гүйлгээ хийх, төлбөр төлөх зэргээр боломж олгож эхэлсэн бөгөөд 1996 онд хамгийн алдартай интернэт банк нь NETBank байв.

Хоёрдох давалгаа буюу дижитал холимог

Энэ үеийн гол төлөөллүүд бол Fidor Bank (Герман), Atom Bank (Англи), LHV Bank (Истон), DBS Digibak (Сингапур) зэрэг банкууд юм. Эдгээр банкууд нь дижитал холимог банкууд бөгөөд харилцагчийн үйлчилгээг сайжруулах зорилгор сүүлийн үеийн санхүүгийн технологиудыг ашигласан боловч арын алба нь уламжлалт банкны шинж чанарыг агуулсан байдаг байна. Эдгээр банкууд нь уламжлалт банктай харьцуулахад үйл

ARND CAPITAL GROUP SECURITIES COMPANY LLC
ULANBAATAR, KHOT TTA8632-545956

000018

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ
ТТГ 56 + 545956

СЭХ
Унэт наасны танилцуулга
ОМ 2019-07-04
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХАРААГИЙН БАНК
АРД КРЕДИТ ББСБ
2018-11-24
БҮРТГЭВ-02

программаар мэргэшсэн, салбартаа тэргүүлэгч “Грэйпсити Монголиа” ХХК-ийн вэб технологи дээр суурилсан программ юм. Тус программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр төлбөр тооцоо, гүйлгээ хийхэд шаардлагатай бүхий л өгөгдөл болон мэдээллийг дамжуулах, хянах, бүртгэх үйл ажиллагааг автоматжуулах юм. Ингэснээр арын албатай холбоотой үүсэх эрсдэл болон зардлыг бууруулах давуу талтай.

❖ **Үйл ажиллагаагаа зогсолтгүй, хурдтай өргөжүүлэх**

Финтек банк, санхүүгийн байгууллага болсноор харилцагчдын тоог хязгааргүй нэмэх боломжтой бөгөөд компани нь энэхүү давуу талаа ашиглан үйл ажиллагаагаа богино хугацаанд өсгөн томруулах стратеги баримтлана. “Ард” аппликэйшнийг хөгжүүлж санхүүгийн бүтээгдэхүүнээ төрөлжүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх, хүмүүсийн амьдралд зохицсон аргаар илүү хялбар хүргэх зэргээр хэрэглэгчдийг татан үйл ажиллагаагаа хурдтай өргөжүүлнэ. Финтек бизнесийн загвар нь үйл ажиллагааны зардлыг багасгадаг тул зах зээлд өрсөлдөхүйц хүүтэй зээл олгох боломжийг компанид олгох юм.

Мөн компани нь өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээг ганц гар утас гэхгүй “Ард” аппликэйшн руу нэвтрэх боломжгүй эсхүл уламжлалт банк, санхүүгийн үйлчилгээг илүүд үздэг харилцагчдад зориулан “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК, “Монгол Шуудан” ХК болон “Ард Даатгал” ХХК-ийн Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт байрлах салбаруудаар хүргэхээр зорьж байна. Тухайлбал, хүмүүс Улаанбаатар хотын томоохон оффис, худалдаа, үйлчилгээний төв болох Шангри-Ла Молл болон Сентрал Тауэрт очин санхүүгийн үйлчилгээгээ өдөр харгалзахгүй авах боломжтой бөгөөд Монгол Шуудан ХК-ийн нийт 283 салбар, Ард Даатгалын нийт 24 салбараас санхүүгийн үйлчилгээ авах боломж нээгдэх юм.

ажиллагааны зардал 30-50% бага, хүний нөөцийн зардал 10-15% тус тус бага байдаг байна. Эдгээр банкууд нь дижитал банк болон уламжлалт банк 2-ыг холбосон гүүр юм.

Гуравдах давалгаа буюу дижитал үндэстэн

Хүмүүсийн амьдралын хэв маягтай хамгийн зохицсон шинэ технологийн эрин үе эхлээд байна. Энэ технологи нь амьдралын өдөр тутмын хэрэглээний нэг хэсэг болох компьютер, утас болсон дижитал хүмүүсийн хэрэгцээ шаардлагаас үүсэн бий болсон юм. Хүмүүсийн амьдралыг нэгтгэх боломжийг олгосон, тэдний амьдралын хэв маягт хурдан дасан зохицдог хэрэгсэл болгар утас юм. Гар утас нь дижитал түрүүч болоод байна. Ингэснээр аюулгүй байдлыг хувьд нэгдсэн нэг өгөгдлийн санд мэдээллийг хадгалахаа болих бөгөөд хэрэглээний хувьд хурдан, хялбар болж, хүмүүсийн амьдралын хэв маягт хурдан дасан зохицож явах юм.



000019





Ард Кредит ББСБ нь “Ард” аппликэйшнээс гадна шинэлэг бүтээгдэхүүн, хялбар үйлчилгээг тасралтгүй нэвтрүүлэн үйлчлүүлэгчиддээ хүргэн ажиллаж байна. Тухайлбал, 2016 онд компани олон нийтэд анхны кредит карт гаргасан ББСБ болсон бөгөөд энэхүү үйлчилгээ нь маш их эрэлт, хэрэгцээтэй байгаа тул цаашид уг бүтээгдэхүүн үйлчилгээгээ өргөжүүлэх, хөгжүүлэх тал дээр түлхүү анхаарч ажиллах болно.

❖ **Хувьцаа эзэмшигчдэд үнэ цэнэ бий болгох**

Ард Кредит ББСБ нь өрийн болон өмчийн хэрэгслээр дамжуулан үйлчлүүлэгчдэд шаардлагатай байгаа санхүүжилтийг шийдвэрлэдэг. Компани нь ногдол ашиг олгох, компанийн үйл ажиллагаа, цар хүрээг өргөжүүлэх замаар хувьцааны үнэ цэнийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээгээ хөнгөлөлттэй нөхцлөөр хүргэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд үр ашиг өгөхийг зорьж байна. Тухайлбал, компани нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш 7 жилийн турш үйл ажиллагаа явуулахдаа тасралтгүй ашигтай ажилласан бөгөөд сүүлийн 3 жил дараалан ногдол ашиг хувьцаа эзэмшигчдэд олгосон ба жил бүр өсгөж олгохоор зорьж байна.

❖ **Гүйцэтгэлээ хэрхэн дүгнэх вэ**

Компанийн дэвшүүлж буй стратеги нь компанийг хаана хүрэх, яаж хүрэх, хэрхэн өрсөлдөх зэргийг тодорхойлж, чиглүүлж өгч байгаа гол бодлого юм. Иймд стратегийнхаа хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, хувьцаа эзэмшигчид, ажилчид, үйлчлүүлэгчид зэрэг бүхий л оролцогч талуудад мэдээллээ тогтмол хүргэж ажиллахаар зорьж байгаагаа мэдэгдэхэд таатай байна.

1.3 Компанийн түүх

❖ **Компани үүсгэн байгуулагдав.**

“Ард Кредит ББСБ” ХХК нь 2011 оны 3 сард үүсгэн байгуулагдаж, 2011 оны 4 сард Санхүүгийн Зохицуулах Хорооноос эзэлийн үйл ажиллагаа, валют арилжаа, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна. Компани нь тусгай зөвшөөрлийнхөө хүрээнд бичил болон жижиг, дунд зээлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

❖ **Бизнесийн загвар, стратеги бодлогоо бүхлээр нь шинэчлэв.**

2013 онд “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь Ард Кредит ББСБ-ын 50 хувийг худалдан авч менежмент болон бүтэц зохион байгуулалтын цогц шинэчлэл хийсэн байна. 2014 онд компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага шинээр томилогдож, компанийн сайн засаглалыг бүрдүүлэхийг зорьжээ. Тус онд компани нь анхны бондоо гаргаж, Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан болон арилжааны банкнаас зээлийн санхүүжилт татан авч, итгэлцлийн үйлчилгээг нэвтрүүлэн нийт 300.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллав.

2011 он: Ард Кредит ББСБ нь “Интергрупп Интернэйшл” ХХК-ийн хөрөнгө оруулалттай үүсгэн байгуулагдав.


- 2013 он**
- Ард Санхүүгийн Нэгдэл нь Ард Кредит ББСБ-ын 50.0 хувийг худалдан авснаар, компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оров.
 - Хөдөөгийн Бичил Санхүүгийн Хөгжлийг Дэмжих Холбоотой хамтарч хөдөө орон нутгийн иргэдэд зээл олгож эхлэв.

- 2014 он**
- СЗХ-ны зөвшөөрлөөр анхны бондоо хаалттай хүрээнд гаргаж, 550 сая төгрөгийн эх үүсвэрийг амжилттай татав.
 - Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг анх удаа хуваарчлав.



000020





Эдийн засгийн уналтын үед үйл ажиллагаагаа тогтворжуулж, хүрсэн амжилтуудаа бататгав.

2015 онд компани нь Монголын ББСБ-ын Холбооноос шилдэг нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч байгууллагаар өргөмжлөгдөв. Мөн Ард Санхүүгийн Нэгдэл нь тус ББСБ дахь эзэмшил хувиа 50 хувиас 58 хувь хүртэл өсгөснөөр компанийн нийт гаргасан хувьцааны хяналтын багцыг эзэмших болсон байна. 2015 онд эдийн засгийн хямралтай, хүндхэн жил байсан хэдий ч оюутны зээлийг шинээр нэвтрүүлж, зээлийн өргөдлийг цахим хэлбэрээр хүлээж авах зэргээр бүтээгдэхүүн үйлчилгээгээ хөгжүүлсэн бөгөөд зах зээл дэх компанийн байр сууриа бэхжүүлж ажиллажээ. Тус онд БСХС-гаас 500.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг авч эмзэг, бага орлоготой иргэдэд хадгаламж, зээлийн хоршоогоор дамжуулан олгож байв.

❖ Үйл ажиллагаагаа өргөжүүлж, санхүүгийн цогц үйлчилгээг үзүүлэх зорилгодоо нэг шатаар ойртов.

2016 онд эдийн засгийн өсөлт саарсан хэвээр байсан боловч компани нь шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, харилцагчидтайгаа илүү ойртон ажиллах зорилгынхоо хүрээнд Худалдаа Хөгжлийн Банк (ХХБ)-тай хамтран кредит карт гаргаж, зах зээлд нэвтрүүлсэн байна. Ингэснээр Ард Кредит ББСБ нь салбартаа анх удаа олон нийтэд зориулан кредит карт гаргасан байгууллага болон харилцагчдынхаа талархлыг хүлээн ажиллаж чадсан юм. Мөн онд хувь нийлүүлсэн хөрөнгөө төлөвлөгөөнийхөө дагуу 1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн бөгөөд “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь Ард Кредит ББСБ-ын нийт хувьцааны 80.7 хувийг дангаараа эзэмших болсон байна. Компанийн засаглалын хувьд сайн засаглал, удирдлагыг үйл ажиллагаандаа хэвшүүлж чадсан бөгөөд 3 дахь жилдээ дараалан олон улсын нэр хүндтэй аудитын компани “БДО Аудит” ХХК-аар санхүүгийн тайландаа аудит хийлгэсэн байна.

❖ Санхүүгийн чадавхаа дээшлүүлж, үйл ажиллагааны цар хүрээгээ тэлсэн жил байв.

2017 оны 6 сард Ард Кредит ББСБ нь хаалттай хүрээнд бонд гаргаж, 1.7 тэрбум төгрөгийн санхүүгийн эх үүсвэрийг амжилттай татан төвлөрүүлж чадсан. Санхүүгийн эх үүсвэр нэмэгдсэнтэй холбоотойгоор

- СЗХ-оос итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаагаа өргөжүүлэв.
- БСХС-тай хамтран ажиллаж, амьжиргааны түвшнөөс доогуур орлоготой айл өрхөд хөнгөлөлттэй зээл олгож эхлэв.

2015 он

- Хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж, Ард Санхүүгийн Нэгдэл нь компанийн 58.0 хувийг эзэмших болов.
- БСХС-аас 500.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй санхүүжилт авч, амьжиргааны төвшнөөс доогуур орлоготой иргэдэд зээл олголтоо нэмэгдүүлэв.

2016 он

- СЗХ-ны шинэ журмын дагуу Хөрөнгө удирдлагын үйл ажиллагаа эрхлэх төрөлд хамрагдах ББСБ болов.
- Хувь нийлүүлсэн хөрөнгөө 1.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, СЗХ-ны шалгуур үзүүлэлтийг ханган ажиллав.
- Хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж, Ард Санхүүгийн Нэгдэл нь компанийн 80.7 хувийг эзэмших болов.
- Худалдан авалтын зээлийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүлж, 10 гаруй бэлтгэн нийлүүлэгчтэй ажиллаж эхлэв.

2017 он

- ББСБ-ын салбарт анхны Кредит картын бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүлэв.
- ББСБ-ын салбарт хамгийн бага зээлийн хүүтэй байгууллага болов.
- “ГрэйпСити Монголиа” ХХК-тай хамтран ажиллахаар болж, Поларис үндсэн банкны систем



000021



Үнэт цаасны танилцуулга
 СЗХ
 он 2019-01-09
 БҮРТГЭВ-02

МОНГОЛЫН КРЕДИТНИЙ БИРЖ
 MONGOLIAN SECURITIES EXCHANGE
 2018-11-29
 БҮРТГЭВ-02

кредит картын үйлчилгээ болон зээлийн багц нэмэгдсэн. Бэлэн мөнгөний нөөцөө үр дүнтэй удирдах, орлогоо нэмэгдүүлэх зорилгоор богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах тусгай зөвшөөрлийг СЗХ-оос авч, амжилттай хөрөнгө оруулалтууд хийж эхэлсэн байна.

❖ **Орчин үеийн технологид суурилсан үйл ажиллагааг явуулж эхлэв.**

2017 онд цахим хэлбэрээр санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх зорилгоор компанийн програм хангамж, техник технологид хөрөнгө оруулалт хийн компанийн хөгжлийг дараагийн түвшинд гаргахаар ажиллаж эхэлсэн. Үүний үр дүнд “Ард” аппликэйшнийг нэвтрүүлж, 2018 оны 4 сард Ард Санхүүгийн Нэгдэлийн хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр нээлтээ хийсэн байна.

болон Мостмони дээр суурилсан “Ард” үйлчилгээг нэвтрүүлэх гэрээ байгуулав.
 - СЗХ-оос богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөл авав.
 - Хаалттай хүрээнд компанийн бонд гаргаж, 1.7 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг амжилттай татан төвлөрүүлэв.

2018 он

- Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг СЗХ-оос авав.
- “Ард” гар утасны аппликэйшнийг зах зээлд нэвтрүүлэв.

1.4 Компанийн давуу тал

➢ **"Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн бүрэлдэхүүн компани юм.**

“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК буюу Ард Холдингс нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй манлай компаниудад хөрөнгө оруулалт хийж, зах зээл дэх байр суурь, өрсөлдөх чадвар болон үнэ цэнийг нь дээшлүүлэх замаар хувьцаа эзэмшигчдийнхээ өгөөжийг өсгөх зорилт тавин ажиллаж байгаа үндэсний санхүүгийн холдинг компани юм. 2017 оны байдлаар Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь доорх 12 компанийн хувьцааг эзэмшиж байна.


Схем 1. "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн хөрөнгө оруулалтын бүтэц

"Ард Санхүүгийн Нэгдэл" ХК			
Ард Даатгал	Ард Кредит ББСБ	Ард Секюритиз УЦК	Ард Менежмент УЦК
- Ердийн даатгал - 1994 он	- Банк бус санхүүгийн байгууллага - 2011 он	- Үнэт цаасны компани - 1997 он	- Хөрөнгө оруулалтын менежмент - 2011 он
Ард Актив	Ард Лайф	Монгол Шуудан	Жинст Увс
- Хадгаламж зээлийн хоршоо - 2008 он	- Хувийн тэтгэврийн үйлчилгээ - 2010 он	- Шуудан, логистик - 1921 он	- Бизнес зөвлөгөө - 1993 он
Тэнгэр Системс	Номын Хишиг	Крипто Үндэстэн	ТТДС
- Программ хангамж - 2007 он	- Хэвлэн нийтлэх - 2000 он	- Цахим худалдаа - 2017 он	- Дээд сургууль - 2000 он



000022





Эдгээр компаниуд нь харилцан бие биеийнхээ бизнесийг дэмжиж, хамтдаа санхүүгийн цогц үйлчилгээг Ард Санхүүгийн Нэгдэл нэрийн дор үзүүлдэг байна. Ингэснээр Ард Кредит ББСБ нь группын дотоод огтолцоо борлуулалт хийх, мөнгөн хөрөнгийн нөөцөө зөв зохистой удирдах чадавхийг бий болгосон.

> Олон нийтэд танигдсан брэнд.



“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь 2013 онд өөрийн онцлог, өнгө үзэмж, өвөрмөц үзэл баримтлалтайгаар компанийн брэндийг бүрдүүлэн олон нийтэд хүргэж эхэлсэн билээ. Хас Банкныг үүсгэн байгуулагчдын нэг Ч.Ганхуяг нь бүтээсэн баялгийнхаа өгөөжийг ард түмэн өөрсдөө хүртэх ёстой гэсэн санаачлага гаргасан бөгөөд уг санаачлагын хүрээнд түүний хөрөнгө оруулалт хийсэн компаниуд “Ард” гэсэн нэрийн дор нэгдэн нэр, лого, уриа, бэлгэдлээ өөрчлөн баталж, рибрендингийг амжилттай хийсэн. Энэхүү шинэ брэндээ олон нийтийн цахим мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээг ашиглан таниулж эхэлсэн бөгөөд одоогоор “Ард” брэнд нь санхүүгийн салбартаа хамгийн түгээмэл, олны итгэлийг хүлээсэн брэндийн нэг болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

> Тасралтгүй, тогтвортой ажиллаж, зах зээлд өөрийн байр суурийг эзэлсэн компани.

Ард Кредит ББСБ нь 2011 онд үүсгэн байгуулагдаж, тус ондаа 500 сая төгрөгийн хөрөнгөтэйгөөр банк бус санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж эхэлсэн билээ. Түүнээс хойш 7 жилийн хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлж, 2017 оны жилийн эцсээр 10.2 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй болж, үүсгэн байгуулагдах үеийн хөрөнгөө 10 мянга дахин нэмэгдүүлж чадсан байна. Цаашид ч үйл ажиллагаагаа хурдтай өргөжүүлэн ажиллахаар төлөвлөөд байна. 2018 оны хоёрдугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн зах зээлд 537 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс 32 ББСБ нь 5.0 тэрбум төгрөгөөс дээш активтай байна. Ард Кредит ББСБ нь актив хөрөнгөөрөө тэргүүлж буй 32 ББСБ-ын нэг бөгөөд зах зээлд өөрийн байр сууриа олсон тэргүүлэх банк бус санхүүгийн байгууллага гэдгийг харуулж байна.

> Санхүүгийн салбарт шинэ санаа, бүтээгдэхүүнийг тасралтгүй хэрэгжүүлэгч компани.



Зураг 2: Ард кредит карт

Ард Кредит ББСБ нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн үйлчлүүлэгчдийнхээ эрэлт хэрэгцээнд тулгуурлан санхүүгийн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд байнга нэвтрүүлж ажиллаж ирсэн. 2016 онд Ард Кредит ББСБ нь Худалдаа Хөгжлийн Банктай хамтарч кредит карт гаргасан бөгөөд энэ нь ББСБ-ын салбарт олон нийтэд зориулан гаргасан анхны кредит карт юм. Тус кредит картын зээл нь хурдтай өсөн нэмэгдэж байгаа зээлийн төрөл бөгөөд 2017 онд кредит картын зээлийн үлдэгдэл 573.0 сая төгрөгт хүрч, нийт зээлийн үлдэгдлийн 7.2 хувийг бүрдүүлэх болсон



000023



Үнэт цаасны танилцуулга
ОН 2019-01-09
БҮРТГЭВ
№ 01
Зураг 3. Ард аппликэйшн

МОНГОЛЫН КРЕДИТ ББСБ
ARD КРЕДИТ ББСБ EXCHANGE
2018-11-29
БҮРТГЭВ-02




Бид сүүлийн үеийн мэдээлэл, технологийн ололт амжилтыг өөрсдийн стратегийн гол давуу тал гэж үзэж байгаа бөгөөд “ГрэйпСити Монголиа” ХХК-тай стратегийн төвшинд хамтран ажиллаж 2018 оны хоёрдугаар улиралд “Ард” гар утасны аппликэйшнийг зах зээлд нэвтрүүлсэн. Энэхүү аппликэйшнийг хүмүүс утсандаа татаж, суулгаснаар Ард Кредит ББСБ-аас үзүүлж буй данс нээлгэх, бэлэн мөнгө авах, мөнгө шилжүүлэх, төлбөр төлөх зэрэг үйлчилгээнүүдийг авах боломжтой болох юм.

➤ **Компанийн сайн засаглал, ил тод байдлыг хэвшүүлсэн компани.**

Ард Кредит ББСБ нь олон улсын жишигт нийцэхүйц компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэн Монгол Улсын банк бус санхүүгийн салбарт жишиг байгууллага болон ажиллаж байна. Тухайлбал, хувьцаа эзэмшигчдийн эрхийн асуудал нь компанийн засаглалын тогтолцооны нэг чухал үзүүлэлт байдаг бөгөөд Ард Кредит ББСБ нь жил бүр хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулж, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх боломжоор байнга ханган ажилладаг болно.

Зураг 4. Жилийн тайлан



Мөн компани нь компанийн засаглалын ил тод, нээлттэй байх зарчмыг баримталж ажилладаг бөгөөд энэхүү зарчмын хүрээнд 2014 оноос жил бүр “Жилийн тайлан” гаргаж олон нийтэд хүргэж эхэлсэн.

➤ **Санхүүгийн зах зээлд туршлагатай, мэргэжлийн удирдлагын баг, хамт олон**

Ард Кредит ББСБ-ын төлөөлөн удирдах зөвлөл болон удирдлагын багийн гишүүд нь санхүүгийн салбарт олон жил ажилласан туршлагатай хамт олон юм. Компанийн ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг нь Хас Банкныг үүсгэн байгуулж, тус банкныг 8 жилийн турш удирдсан, банк санхүү, хөрөнгийн зах зээлд 19 жилийн туршлага хуримтлуулсан мэргэжилтэн билээ. Компанийн гүйцэтгэх багийн гишүүд олон улсын нэр хүнд бүхий их дээд сургуулиудыг төгсөж, шаардлагатай мэдлэг боловсролыг эзэмшсэн, санхүүгийн зах зээлд 1-14 жилийн турш ажилласан туршлагатай юм. Ажиллагсад компанийн алсын хараа зорилгыг бүрэн ойлгосон, зээл олголт, түүний эрсдэл зэргийн талаар бүрэн туршлага, мэдлэгтэй болно.

➤ **Үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш тасралтгүй ашигтай ажиллаж, сүүлийн 3 жил хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгож байна.**




000024



Сүүт цаасны танилцуулга
 ОН 2019-01-09
 БҮГДЭВ
 №01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЭМРЖ
 МОНГОЛЫН СТОК СӨНӨНӨӨ
 ARD КРЕДИТ ББСБ
 2018-11-29
 БҮРТГӨВ-02



Компани нь 2011 онд үүсгэн байгуулагдаж үүсгэн байгуулагдсан анхны жилдээ 22.0 сая төгрөгийн татварын дараах ашигтай ажиллаж байсан бол 2017 онд 641.8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Энэ хугацаанд эдийн засгийн нөхцөл байдал тогтворгүй байсан ч удирдлагын багийн ур чадвар, мэдрэмж, туршлага зэргээс шалтгаалан тасралтгүй ашигтай ажилласан ба сүүлийн 3 жилд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсан байна.


➤ **Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч байгууллага**

Ард Кредит ББСБ нь хөдөө орон нутгийн айл өрхүүдэд санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй байдлаар хүргэх, түүнчлэн орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулах зорилгоор 2013 оноос Хөдөөгийн Бичил Санхүүгийн Хөгжлийг Дэмжих Холбоотой хамтран ажиллаж, тус холбооны гишүүн Хадгаламж Зээлийн Хоршоодоор дамжуулан хөдөөгийн иргэдэд зээл олгож эхэлсэн. Тайлант онд бид 19 хоршоонд нийт 163 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Энэхүү хамтын ажиллагаагаа цаашид улам өргөжүүлж, бүх төрлийн бичил санхүүгийн байгууллагад үйлчилдэг Апекс буюу Дээвэр байгууллага болон хөгжих үндэс сууриа тавин ажиллаж байна. Нийгмийн хариуцлагыг ухамсарлан тодорхой ажлуудыг зохион байгуулдаг ба жил бүр Сонголын бэрхшээлтэй хүүхдийн 29-р тусгай сургуульд тусламж үзүүлдэг бөгөөд, мөн параолимпийн тамирчин Э.Содномпилжээг ивээн тэтгэдэг. Тэрээр 2014 онд Солонгос Улсын Сөүл хотод болсон Азийн наадмаас хүрэл медаль, 2015 онд Дубайд болсон Дэлхийн цомын тэмцээнээс мөнгөн медаль, 2016 оны Бразил Улсын Рио Де Жанейро хотод болсон олимпын наадмаас хүрэл медаль авч, эх орныхоо нэрийг өндөрт өргөөд байна. Компани 2015 онд Монголын ББСБ-ын Холбооноос тодруулдаг шилдэг нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч байгууллагаар шалгарч байжээ.

1.5 Үнэт цаас гарагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Ард Кредит ББСБ нь нийт 210 сая ширхэг энгийн хувьцаа гаргасан бөгөөд доорх 3 хувьцаа эзэмшигч нийт гаргасан хувьцааг эзэмшиж байна. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, мэдээллийг доорх графикаар харуулав.

График 2. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц



000025



Үнэт цаасны танилцуулга
 он 2019.01.09-р
 БҮРТГЭВ
 Хүснэгт 1. Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
 MONGOLIAN STOCK EXCHANGE
 КРЕДИТ
 ББСБ
 2018-11-29
 БҮРТГЭВ-02

Хувьцаа эзэмшигчийн нэр	Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн дугаар	Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг	Эзэмшиж буй хувьцааны хувь
“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК	5024145	9011036140	169,472,000	80.70%
Сэдбазар овогтой Гэрэлтуяа	ХА77042160		26,672,000	12.70%
Ванданцэрэн овогтой Баяржаргал	РЮ85100310		13,856,000	6.60%
Нийт			210,000,000	100.0%

“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК

Ард Кредит ББСБ-ын хувьцааны дийлэнх буюу 80.7 хувийг эзэмшигч “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь 2005 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудад хөрөнгө оруулалт хийж, зах зээл дэх байр суурь, өрсөлдөх чадвар болон үнэ цэнийг нь дээшлүүлэх замаар өөрийн хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөжийг өсгөх зорилт тавин ажиллаж байгаа үндэсний санхүүгийн холдинг компани юм.

Компани нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш санхүүгийн салбарт хөрөнгө оруулалт хийж, хөрөнгө оруулалт хийсэн компаниудаа амжилттай удирдан, зохион байгуулж байна. 2017 оны жилийн эцсээр 12 компанийн 39.1 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий хувьцааг эзэмшиж байна.

С. Гэрэлтуяа:

С.Гэрэлтуяа нь 1998 онд МУИС-ийг олон улсын харилцаа, аялал жуулчлалын бакалавр зэрэгтэй төгссөн. 2000-2003 оны хооронд “МИАТ” ХК-ийн төлөөлөгчөөр БНХАУ-ын Бээжин хотод ажиллаж байсан бөгөөд 2003 оноос хойш “Мон-Интернэшнл” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. С.Гэрэлтуяа нь Ард Кредит ББСБ-ын 12.7 хувийн хувьцааг эзэмшдэг бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болно.

В. Баяржаргал

В.Баяржаргал нь 2006 онд Техникийн Их Сургуулийг бизнес менежментийн чиглэлээр төгссөн. 2006 онд “М-Си-Эс Электроникс” ХХК-аас ажлын гараагаа эхэлсэн бөгөөд 2012 оноос “Прогресс Транс” ХХК болон “Интергрупп Интернейшнл” ХХК-ийн үйл ажиллагаа эрхэлсэн захирлаар тус тус ажиллаж байна. В.Баяржаргал нь Ард Кредит ББСБ-ын 6.6 хувийн хувьцааг эзэмшдэг бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болно.


1.6 Үнэт цаас гаргачийн хувь нийлүүлсэн хөрөнгө

Ард Кредит ББСБ нь 2011 оны 3 сарын 22-ны өдөр 1.0 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгээр байгуулагдаж байсан бөгөөд 2018 оны 5 сарын 23-ны өдрөөр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэн 2.1 тэрбум төгрөгт хүргэсэн. ББСБ-ын зах зээл хурдтай өсөн нэмэгдсэн



000026





СҮНЭТ цаасны танилцуулга

2019.01.09

БҮРТГЭЭЛЭЛТ

мөн СЗХ-оос ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгө (ХНХ)-ийн доод хязгаарыг шинэчлэн тогтоосон зэрэг нөхцөл байдлаас компани нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш 4 удаа ХНХ-өө нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт

	УБЕГ-т бүртгүүлсэн огноо	ХНХ-ийн хэмжээ сая төг	СЗХ-оос баталгаажуулсан огноо
1	2011-3-22	1.0	
2	2011-5-13	500.0	2011-4-21-ний өдөр СЗХ-ны 108 тоот тогтоол
3	2013-7-24	1,000.0	2013-7-5-ны өдөр СЗХ-ны 194 тоот тогтоол
4	2017-7-31	1,312.5	2017-3-22-ны өдөр СЗХ-ны 161 тоот тогтоол
5	2018-5-23	2,100.0	2018-4-17-ны өдөр СЗХ-ны 302 тоот тогтоол

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт 2.1 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 210,000,000 (хоёр зуун арван сая) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.

Хүснэгт 3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн задаргаа

Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо (ширхэг)	Нэгжийн үнэ (төгрөг)	Хувь нийлүүлсэн хөрөнгө (сая төгрөг)	Эзлэх хувь (хувь)
1 “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК	169,472,000	10	1,695	80.7%
2 В.Баяржаргал	13,856,000	10	139	6.6%
3 С.Гэрэлтуяа	26,672,000	10	267	12.7%
Нийт хувьцаа эзэмшигчид	210,000,000	10	2,100	100.0%

1.7 Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, удирдлага

Ард Кредит ББСБ нь үйл ажиллагааны бүтцийн хувьд чадварлаг, цомхон бүрэлдэхүүнтэй ажиллахыг зорьж байгаа бөгөөд 4 албатай, 13 ажилтантай, доорх бүтэц зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулж байна. Уг бүтэц нь функционал буюу чиг үүргийн хэлбэртэй бүтэц бөгөөд ажилчдын ажил үүргийг нарийн тодорхойлж өгсөн тул дээрээс удирдах, компанийн засаглалаа зүй зохистой хэрэгжүүлэх хувьцаа эзэмшигчиддээ нээлттэй ил тод байх боломжийг олгодог байна.

Схем 2. Бүтэц зохион байгуулалт



000027





Ард Кредит ББСБ-ын хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага бөгөөд уг хурал нь компанийн дүрмийг батлах, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, үйл ажиллагааг хянах зэрэг Монгол Улсын Компанийн тухай хуульд тусгасан асуудлуудыг хэлэлцэх, шийдвэрлэх боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгодог. Ард Кредит ББСБ нь хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбоотой зохицуулалтуудыг компанийн дүрмийн 7 дугаар бүлэгт тусгаж өгсөн болно. Тухайлбал, компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт “компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш 3 сарын дотор зарлан хуралдуулна” гэж заасан байна. Энэхүү зохицуулалтын хүрээнд компани нь жил бүр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хийж, уг хурлын бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргадаг юм.

Төлөөлөн удирдах зөвлөл

Ард Кредит ББСБ-ын төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийг удирдлагаар хангадаг бөгөөд стратеги болон хэтийн төлөвийг тодорхойлох, хувьцаа эзэмшигчдийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр ажилладаг. Ард Кредит ББСБ-ын дүрмийн 8 дугаар бүлэгт ТУЗ-ийн үйл ажиллагаа, гишүүдийн тооны талаар зохицуулж өгсөн болно. Компанийн дүрэмд “Ард Кредит ББСБ-ын хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт түүний бүрэн эрхийг компанийн ТУЗ хэрэгжүүлэх бөгөөд ТУЗ нь 7 хүртэл гишүүнтэй байж болно” гэж заасан байна. Мөн ТУЗ-ийн үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байх бөгөөд Компанийн дүрэмд тусгаснаар Ард Кредит ББСБ-ын ТУЗ нь улиралд нэг удаа хуралдана гэж заасан байдаг. Ард Кредит ББСБ-ын ТУЗ нь дүрэмд заасны дагуу тогтмол хуралддаг бөгөөд гүйцэтгэх удирдлагатайгаа нягт ойр ажилладаг байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтыг хамгаалах, компанид үр ашигтай шийдвэр гаргах, компанийн бодлого, стратегийг тодорхойлох зэрэг чухал шийдвэрүүдийг гаргаж ажилладаг тул мэргэжлийн, чадварлаг, туршлагатай ТУЗ-ийн гишүүдийг сонгох нь маш чухал байдаг. Одоогоор Ард Кредит ББСБ-ын ТУЗ нь 7 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд үүнээс 2 гишүүн нь хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүд нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах өндөр хариуцлага хүлээдэг. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд банк, эдийн засаг, бизнесийн менежмент, олон улсын харилцааны чиглэлээр мэргэшсэн, тус бүрийн чиглэлээр компани болон ТУЗ-ийн үйл ажиллагаанд бодит хувь нэмэр оруулж чадах хүмүүс багтсан. ТУЗ-ийн бүх гишүүд нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8-д заасны дагуу компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн дарга нарт зориулсан компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.

Хүснэгт 4. ТУЗ-ийн бүрэлдэхүүн

Нэр	ТУЗ-ийн гишүүн	Эрхэлж буй албан тушаал	Компанийн засаглалын сургалтанд хамрагдсан эсэх
1 Ч.Ганхуяг	ТУЗ-ийн дарга	“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК – Гүйцэтгэх захирал	Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөл 2014 оны 11 сарын 29-ний дугаар: 0130277
2 С.Гэрэлтуяа	Ердийн гишүүн	“Мон-Интернэйшнл” ХХК – Гүйцэтгэх захирал	Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөл 2014 оны 2 сарын 28-ны дугаар: 0730170



000028



Сүнэт цаасны танилцуулга
 ОН 2019-01-09
 БҮРТГЭВ
 № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
 МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
 КРЕДИТ
 ББСБ Ү
 БҮРТГЭВ-02

3	В.Баяржаргал	Ердийн гишүүн	“Интергрупп Интернэйшл” ХХК – Үйл ажиллагаа хариусан захирал	Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөл 2014 оны 2 сарын 28-ны дугаар: 0730169
4	Б.Ганбат	Ердийн гишүүн	Техник Технологийн Дээд Сургууль – Гүйцэтгэх захирал	Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөл 2015 оны 11 сарын 7-ны дугаар: 0430408 Directors Corporate Governance Training Program on the Role of a Listed Company Director 12 сарын 2-ны өдөр
5	В.Ганзориг	Хараат бус	“Бат Солюшн Партнерс” ХХК УЗ-ийн дарга	Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөл 2016 оны 8 сарын 26-ны дугаар: 930307
6	М.Тулгат	Хараат бус	“Хишиг Арвин Индастриал” ХХК – Дэд захирал	Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөл 2015 оны 11 сарын 7-ны дугаар: 0430404
7	Ч.Ганзориг	Ердийн гишүүн	“Ард Кредит ББСБ” ХХК – Гүйцэтгэх захирал	Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөл 2018 оны 4 сарын 14-ний дугаар: 0430550
8	Д. Сувдмаа	Нарийн бичгийн дарга	“Ард Кредит ББСБ” ХХК – Маркетингийн мэргэжилтэн	

➤ ТУЗ-ийн гишүүдийн удирдах чадвар, дадлага туршлагын байдал



Ч. Ганхуяг
 Гүйцэтгэх захирал
 “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК

Чулууны Ганхуяг нь “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК – ийн үүсгэн байгуулагчдын нэг төдийгүй, тус компанийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Монголын Хөрөнгийн Биржээс 1991 онд хөдөлмөрийн гараагаа эхэлсэн тэрбээр 1997 онд Унгар Улсын Будапешт хотын Корвинус Эдийн Засгийн Их Сургуулийг дүүргэж, Монголбанкинд хянан шалгагчаар оржээ. 1998 онд НҮБ-ын бичил санхүүгийн Микростарт төсөл дээр Санхүүгийн менежерээр шалгаран ажилласан ба 1999 онд Монголын анхны банк бус санхүүгийн байгууллага болох Хөгжлийн Алтан Сан (ХАС)-г үүсгэн байгуулан Гүйцэтгэх захирлаар нь томилогдон ажилласан юм. ХАС нь бичил зээлийн үйл ажиллагааг амжилттай явуулсаар 2001 онд Говийн Эхлэл ББСБ-тай нэгдэж, өнөөгийн ХасБанк байгуулагдсан түүхтэй. Ганхуяг нь ХасБанкийг байгуулагдсан цагаас хойш 2009 оныг хүртэл Гүйцэтгэх захирлаар ажилласан бөгөөд 2009-2010 онд ХасБанкны толгой компани болох Тэнгэр Санхүүгийн Нэгдэлийн Гүйцэтгэх захирлын албан тушаал, 2010-2012 онд Монгол Улсын Сангийн Дэд Сайдын албанд томилогдон тус тус ажиллаж байв. Тэрээр Унгар Улсын өргөмжит консул, Монголын Эдийн Засгийн Форумын санаачлагч, Ерөнхий нарийн бичгийн дарга, Монголын Оюутны Холбооны Ерөнхийлөгч, Олон Улсын Бичил Санхүүгийн Төвийн УЗ-ийн гишүүн, Монголын Сагсан Бөмбөгийн Холбооны Ерөнхийлөгч зэрэг албан



000029



Сүхэт цаасны танилцуулга
Орн 2019-01-09
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ARD КРЕДИТ ББСБ
2018-11-29
БҮРТГЭВ-02

тушаал хашиж байснаас гадна Монгол Улсад анхлан хадгаламж зээлийн хоршооны хөдөлгөөнийг 1990-ээд оны сүүлээр эхлүүлж, “СИДАН” ХЗХ-ны удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байжээ. 2009 онд Дэлхийн Эдийн Засгийн Форумаас түүнийг Дэлхийн Залуу Манлайлагчаар өргөмжилсөн байна.



С. Гэрэлтуяа
Гүйцэтгэх захирал
“Мон Интернейшнэл” ХХК

С.Гэрэлтуяа нь 1998 онд МУИС-ийг олон улсын харилцаа, аялал жуулчлалын бакалавр зэрэгтэй төгссөн. 2000-2003 оны хооронд “МИАТ” ХК-ийн төлөөлөгчөөр БНХАУ-ын Бээжин хотод ажиллаж байсан бөгөөд 2003 оноос хойш “Мон-Интернэшнл” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. С.Гэрэлтуяа нь Ард Кредит ББСБ-ын 12.7 хувийн хувьцааг эзэмшдэг бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болно.



Б. Ганбат
Гүйцэтгэх захирал
Техник Технологийн дээд сургууль

Б.Ганбат нь 1994 оноос 1998 онд МУИС-ийг Эдийн засагч мэргэжлээр, 2009 оноос 2011 онд Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль (СЭЗДС)-ийг Санхүүгийн менежмент мэргэжлээр магистр зэрэгтэй суралцаж төгссөн. ХасБанканд үйл ажиллагааны хэлтсийн дарга, үйл ажиллагаа эрхэлсэн захирал, “И Ай Ти” ХХК-д гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан бөгөөд одоо Техник Технологийн Дээд Сургууль (ТГДС)-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



В. Баяржаргал
Үйл ажиллагаа эрхэлсэн захирал
Интер Групп ХХК

В.Баяржаргал нь 2006 онд Техникийн Их Сургуулийг бизнес менежментийн чиглэлээр төгссөн. 2006 онд “М Си Эс Электроникс” ХХК-аас ажлын гараагаа эхэлсэн бөгөөд 2012 оноос “Прогресс Транс” ХХК болон “Интергрупп Интернейшнл” ХХК-ийн үйл ажиллагаа эрхэлсэн захирлаар тус тус ажиллаж байна. В.Баяржаргал нь Ард Кредит ББСБ-ын 6.6 хувийн хувьцааг эзэмшдэг бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болно.



000030



Сүүт цаасны танилцуулга
он 2019-01-09-д
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN CREDIT EXCHANGE
ББСБ
2018-11-29
БҮРТГЭВ-02



М. Тулгат
Бизнес хөгжил хариуцсан захирал
Хишиг Арвин Индастриал ХХК

М.Тулгат нь 2003 онд Япон Улсын Киото Их Сургуулийг эдийн засгийн ухааны бакалавр зэрэгтэй, 2005 онд Япон Улсын Киото Их Сургуулийг эдийн засгийн ухааны магистр зэрэгтэй төгссөн бөгөөд 2005-2010 онд Софтбанк групп-д бизнес төлөвлөгч, 2010-2013 онд “Бэкфөрст” ХХК-д захирал, 2013 оноос хойш одоог хүртэл “Хишиг Арвин Индастриал” ХХК-д дэд захирлаар ажиллаж байна.



Ч. Ганзориг
Гүйцэтгэх захирал
Ард Кредит ББСБ ХХК

Ч.Ганзориг нь 2005-2007 оны хооронд Шанхайн Их Сургуульд Хятад хэлний анги, 2007-2010 онд Унгар Улсын Корвинусын Их Сургуульд Бизнес менежментийн чиглэлээр бакалавр зэрэгтэйгээр суралцаж төгссөн. 2010-2012 оны хооронд одоогийн Ард Секюритиз УЦК-д хөрөнгө оруулалтын шинжээчээр, 2012- 2013 оны хооронд одоогийн Ард Санхүүгийн Нэгдэлд Хөрөнгө оруулалтын мэргэжилтнээр, 2013 оноос одоог хүртэл Ард Кредит ББСБ-ын Гүйцэтгэх захиралаар ажиллаж байна. Мөн тэрээр Ард Секюритиз УЦК, Вайлд Дижитал Аженси болон Дуулиан 2020 ТББ зэрэг байгууллагуудын ТУЗ-ийн гишүүнээр ажилладаг.




В. Ганзориг
ТУЗ-н дарга
Бат Солюшн Партнерс ХХК

В.Ганзориг нь 2003-2005 онд Австрали Улсын Norte Dome Их Сургуульд MBA зэрэг, 2009-2010 онд Япон Улсын IUS сургуульд цахим бизнесийн мастер зэрэгтэйгээр суралцаж төгссөн. “BSP” ХХК-д Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар 3 жил ажилласан. Австрали болон Япон Улсуудад бизнесийн удирдлага ба цахим бизнесийн удирдлагаар мастерийн зэрэг хамгаалсан бөгөөд АНУ (Yale), Англи (Oxford), Өмнөд Африк (WITS) улсуудад удирдлага, манлайлал, өөрчлөлтийн менежмент чиглэлээр мэргэжлийн сургалтуудад хамрагдсан байна. Бат Солюшн Партнерс компанийн УЗ-ийн даргаар ажилладаг. МУИС-ийн Худалдааны Сургууль, Худалдаа Хөгжлийн Банк, ХасБанк, Шунхлай Группийн удирдлагын багт ажиллаж байсан ба сүүлийн жилүүдэд хэвлэл мэдээлэл, олон нийтийн харилцааны чиглэлээр ажилладаг Медиа Групп ба Бат Солюшн Партнерс компаниудад удирдах албан тушаал хашиж байсан туршлагатай. Тэрбээр Монголын Дауны Холбооны тэргүүн ба Монголын Тусгай Олимпын Хороо,



000031





Цахим Өртөө Холбооны удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллахаас гадна Global Teacher Prize - ийн академийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-т Хувьцаат компанийн ТУЗ нь 9 буюу түүнээс дээш гишүүнтэй, тэдний гуравны нэг нь хараат бус гишүүн байна хэмээн заасан байдаг. Ард Кредит ББСБ нь хуулийн уг заалтыг дагаж мөрдөн хувьцаат компанийн дүрмийн төслийг боловсруулсан бөгөөд уг төсөлд ТУЗ-ийн гишүүдийн тоог 9 болон түүнээс дээш гэж зааж өгсөн болно. Ард Кредит ББСБ нь нээлттэй хувьцаат компани болсноор ТУЗ-ийн гишүүдийнхээ тоог хууль журмын дагуу нэмэгдүүлэнэ.

ТУЗ-ийн дэргэдэх хороод

Компанийн засаглалын үр ашгийг нэмэгдүүлэх суурь нөхцөл нь ТУЗ-ийн дэргэдэх хороод байдаг бөгөөд хороод нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор санал дүгнэлт гаргаж ажилладаг. Ард Кредит ББСБ-ын ТУЗ нь 2018 оны 1 сарын 18-ны өдрийн 2018/02 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх хороодыг доорх бүтэцтэй байхаар баталсан байна.


Схем 3. ТУЗ-ийн дэргэдэх хороод

Төлөөлөн Удирдах Зөвлөл		
Дотоод Аудитын Хороо	Зээл, Эрсдэлийн Хороо	Засаглалын Хороо
<p>Зорилго: Компанийн үйл ажиллагаанд хяналт тавих, удирдлага болон аудиторыг үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх.</p>	<p>Зорилго: Компанийн зээлийн үйл ажиллагаа</p>	<p>Зорилго: ТУЗ болон удирдлагын багийн гишүүдийн үйл ажиллагааг идвэхижүүлэх, тэдгээрийн ажилд үнэлэлт өгөх, урамшуулах.</p>
<p>Бүрэлдэхүүн: В.Ганзориг (хорооны дарга), Б.Ганбат, В.Баяржаргал</p>	<p>Бүрэлдэхүүн: Б.Ганбат (хорооны дарга), С.Гэрэлтуяа, Ч.Ганзориг</p>	<p>Бүрэлдэхүүн: С.Гэрэлтуяа (хорооны дарга), В.Баяржаргал, М.Тулгат</p>
<p>Үйл ажиллагааны цар хүрээ: Дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, сайжруулах, үнэлэх бодлого гаргах; Санхүүгийн тайлан, мэдээнд хяналт тавих, үнэн зөв, ил тод байдлыг хангуулж ажиллах; Хөндлөнгийн аудитыг оруулах, хамтран ажиллах талаар зөвлөмж гаргах Дотоод аудитыг хэрэгжүүлэх талаар зөвлөмж гаргах, аудитын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх.</p>	<p>Үйл ажиллагааны цар хүрээ: Зээлийн үйл ажиллагаанд баримтлах бодлого, мөрдөгдөх журам, зааврыг боловсруулах, эрсдэлийг тодорхойлох; Зээлийн бүтээгдэхүүнүүдийн төвлөрлийн харьцаа, хязгаар, холбогдох этгээдийн зээлийн дээд хэмжээ, холбогдох этгээдийн зээлийн багцын хязгаар, нэг зээлдэгчид олгох зээлийн дээд, доод хэмжээг тогтоох, Зээлийн ажилтануудын хүний нөөцийн бодлогыг тодорхойлох; Дээрх асуудлаар ТУЗ-д санал оруулах,</p>	<p>Үйл ажиллагааны цар хүрээ: ТУЗ-ийн гишүүдийн шаардлага шалгуурыг тодорхойлох, нэр дэвшүүлэх; Удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур боловсруулах, тогмол үнэлэх; Удирдлагын цалин, урамшууллын бодлогыг боловсруулж, түүний хэрэгжилтэд хяналт тавих.</p>



000032





Ард Кредит ББСБ-ын төлөөлөн удирдах зөвлөл 2013 оны 6 сарын 1-ний өдөр Ч.Ганзоригийг компанийн гүйцэтгэх захирлаар томилсон бөгөөд Ч. Ганзориг нь 6 жилийн турш компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээг байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах чиг үүрэгтэй ажилладаг бөгөөд компанийн дүрмийн 9 дүгээр бүлэгт гүйцэтгэх удирдлагатай холбоотой хууль зүйн зохицуулалтыг оруулсан байна. Доорх хүснэгтээр компанийн гүйцэтгэх удирдлагын талаар дэлгэрэнгүй мэдээлэл хүргэж байна.

Хүснэгт 5. Гүйцэтгэх удирдлагын баг

Гүйцэтгэх захирлын товч намтар

Овог нэр	Ч.Ганзориг
Боловсрол	2007-2010 Бизнес менежментийн бакалавр, Унгар Улсын Будапешт хотын Корвинусын Их Сургууль 2005-2007 Хятад хэл, Шанхай Хотын Их Сургууль 1994-2004 Нийслэлийн 23-р дунд сургууль
Ажилласан туршлага	2013-оноос Гүйцэтгэх захирал, “Ард Кредит ББСБ” ХХК 2013 оноос ТУЗ-ийн гишүүн, “Ард Кредит ББСБ” ХХК 2013 оноос ТУЗ-ийн гишүүн, “Ард Секюритиз ҮЦК” ХХК 2013 оноос ТУЗ-ийн гишүүн, “Вайлд Дижитал Аженси” ХХК 2013 оноос ТУЗ-ийн гишүүн, Дуулиан 2020 ТББ 2012-2013 Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн, “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК 2010-2012 Хөрөнгө оруулалтын шинжээч, “Монет” ХХК (одоогийн “Ард Секюритиз ҮЦК” ХХК)

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга товч намтар

Овог нэр	Д.Сувдмаа
Боловсрол	2011-2013 Эдийн засагч, Edinboro University 2009-2011 Бизнесийн удирдлага, Peralta Community College 2000- 2009 Meadville Senior High School
Ажилласан туршлага	2016 оноос ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, “Ард Кредит ББСБ” ХХК 2015 оноос Маркетинг хариуцсан мэргэжилтэн, “Ард Кредит ББСБ” ХХК 2013-2015 Судалгаа хариуцсан мэргэжилтэн, Нийслэлийн Эдийн Засгийн Хөгжлийн газар

Зээл эрхэлсэн захирлын товч намтар

Овог нэр	Н.Отгонжаргал
Боловсрол	2013 Төслийн удирдлагын менежер сургалт, Төслийн удирдлагын хөгжлийн хүрээлэн 1997-2001 Эдийн засагч бизнесийн удирдлага 1985-1995 Хутаг-Өндөр сумын 10 жилийн сургууль, Булган аймаг
Ажилласан туршлага	2016 оноос Зээл эрхэлсэн захирал, “Ард Кредит ББСБ” ХХК 2012-2015 Үйл ажиллагаа эрхэлсэн захирал, “Аодэ” ХХК 2007-2012 Борлуулалт бүтээгдэхүүн хариуцсан мэргэжилтэн, “Хас Лизинг” ХХК 2003-2007 Зээлийн мэргэжилтэн, ХасБанк


Ерөнхий нягтлан бодогчийн товч намтар

Овог нэр	Д.Дархижав
Боловсрол	2003-2006 Санхүү, Бизнесийн удирдлагын бакалавр, МУИС 1999-2003 Улс төр судлалын бакалавр, МУИС 1990-1999 Боловсрол цогцолбор, Бүрэн дунд боловсрол



000033





Ажилласан туршлага 2014 оноос Ерөнхий нягтлан бодогч, “Ард Кредит ББСБ” ХХК
 2013-2014 Нягтлан бодогч, “SLD” ХХК
 2011-2013 Оператор, “Скайтел” ХХК
 2006-2009 Теллер, Харилцааны менежер, ХасБанк

Компанийн засаглалын зарчмыг ханган ажиллаж байгаа тухай

Компанийн сайн засаглалыг үйл ажиллагаандаа хэвшил болгох нь компанид тогтвортой хөгжил авчраад зогсохгүй улс орны эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах үндэс суурь болдог. Санхүүгийн Зохицуулах Хорооноос компанийн сайн засаглалтай холбоотойгоор 2014 оны 5 сарын 7-ны өдөр 162 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн баталж, Монголын Хөрөнгийн Биржийн А самбар дээр бүртгэлтэй хувьцаат компаниудад энэхүү кодексийг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосон билээ. Мөн хязгаарлагдмал хариуцлагатай компани болон бусад хуулийн этгээдийн тухайд өөрийн онцлогт тохируулан хэрэглэх боломжтой юм. Иймд Ард Кредит ББСБ нь компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх, нээлттэй хувьцаат компани болох бэлтгэл ажлаа хангах зорилгоор доорх бичиг баримтыг батлан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Хүснэгт 6. Үйл ажиллагааны журмууд

	Журам	Баталсан тогтоол, шийдвэр
1.	Дотоод хяналтын журам	2013-10-1-ний өдрийн Гүйцэтгэх захирлын 10 тоот тушаал
2.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам	2018-1-18-ны өдрийн ТУЗ-ийн 2018/1Б тоот тогтоол,
3.	ТУЗ-ийн ёс зүйн кодекс	2014-9-3-ны өдрийн ТУЗ-ийн 15А тоот тогтоол
4.	Засаглалын хорооны үйл ажиллагааны журам	2014-9-3-ны өдрийн ТУЗ-ийн 20 тоот тогтоол
5.	Дотоод аудитын хорооны үйл ажиллагааны журам	2014-9-3-ны өдрийн ТУЗ-ийн 20 тоот тогтоол
6.	Зээл, эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам	2014-9-3-ны өдрийн ТУЗ-ийн 20 тоот тогтоол
7.	Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны заавар	2015-1-19-ны өдрийн ТУЗ-ийн 5А тоот тогтоол
8.	Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах	2014-10-29-ны өдрийн ТУЗ-ийн 18 тоот тогтоол
9.	Ногдол ашгийн бодлого	2014-10-29-ны өдрийн ТУЗ-ийн 19 тоот тогтоол
10.	Хөндлөнгийн аудит томилох тухай журам	2016-10-26-ны өдрийн ТУЗ-ийн 2016/22А тоот тогтоол
11.	Эрсдэлийн удирдлагын бодлого	2016-10-26-ны өдрийн ТУЗ-ийн 2016/22А тоот тогтоол

1.8 Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ард Кредит ББСБ нь Улаанбаатар хот болон 21 аймагт давхардсан тоогоор 1,581 харилцагчдад зээл, төлбөр тооцоо, гадаад валютын арилжаа, итгэлцэл, хөрөнгө оруулалт болон санхүүгийн зөвлөхийн үйлчилгээ үзүүлсэн байна.



000034



Үнэт цаасны танилцуулга
 СЗХ
 01.01.2019
 БҮРЭГ
 № 01

ARD КРЕДИТ БЭСБ
 МОНГОЛЫН ТӨГРӨГ
 EXCHANGE
 2018-11-29
 БР-1135-02

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь зээл бөгөөд зээлдэгчтэй урт хугацаанд тогтвортой хамтран ажиллах, бичил болон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр шинээр бий болгох чиглэлээр зээлийн бодлого баримтлан ажиллаж байна. 2017 онд компани нь 13.1 тэрбум төгрөгийн зээлийг 632 удаагийн олголтоор олгосон байна. Жилийн эцсээр нийт зээлийн үлдэгдэл 8.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 56.1 хувиар өссөн байна. Энэхүү өсөлтөд компанийн зээлийн шинэ төрөл болох “Ард” кредит картын үйлчилгээ эрчимжсэн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 7. Зээлийн мэдээлэл

	2015	2016	2017	2017/2016 өөрчлөлт	
				дүн	хувь
Харилцагчийн тоо	199.0	329.0	691.0	362.0	110.0%
Нийт зээл (нөхцөл өөрчилсөн зээл оруулсан дүн, сая төг)	7,635.1	7,979.6	13,106.0	5,126.4	64.2%
Зээлийн үлдэгдэл (сая төг)	3,706.1	5,109.4	7,974.5	2,865.2	56.1%

Одоогоор компани нь бизнесийн, хэрэглээний, шуурхай зээл гэсэн 3 төрлийн үндсэн зээлийн үйлчилгээг харилцагчдад үзүүлж байна.

График 3. Зээлийн төрөл



2017 оны жилийн эцсээр нийт зээлийн үлдэгдлийн 50.1 хувь буюу 4.0 тэрбум төгрөгийг бизнесийн зээл, 20.9 хувь буюу 1.7 тэрбум төгрөгийг хэрэглээний зээл, 29.0 хувь буюу 2.3 тэрбум төгрөгийг шуурхай зээл эзэлж байна.

Схем 4. Зээлийн төрөл

Зээл	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Шуурхай зээл
Зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ	- Төслийн - Бичил бизнес - Жижиг, дунд бизнес - Бөөний - Зээлийн шугам	- Цалин - Ажиллагсад - Өрх - Кредит карт - Лизинг - Худалдан авалт - Сургалтын төлбөр - Итгэлцэл	- Орон сууц барьцаалсан - Хашаа, байшин барьцаалсан - Авто машин барьцаалсан
Зээлийн нөхцөл	- Хугацаа: 3-24 сар - Хүү: 1.8-2.3% (сар)	- Хугацаа: 3-24 сар - Хүү: 2.6-3.0% (сар)	- Хугацаа: 1-12 сар - Хүү: 2.8-3.0% (сар)
Хэмжээ	- Доод: 2 сая төг - Дээд: 500 сая төг	- Доод: 0.5 сая төг - Дээд: 100 сая төг	- Дээд: 50 сая хүртэл төг

ARD CAPITAL GROUP SECURITIES COMPANY LLC
 УЛААНБААТАР ХОТ ТТ8632-4434655

000035

УЛААНБААТАР ХОТ
 ARD КРЕДИТ БЭСБ
 ХХК
 ТТ8734-5459567


Үнэт цаасны танилцуулга
 он 2018-01-03
 БҮРГЭЭГ
 №01

МОНГОЛЫН АРД КРЕДИТ БИЧИЛ ББСБ
 MONGOLIAN ARD CREDIT BICHIL BBSB
 2018-11-29
 БҮРГЭЭГ 02

Бизнесийн зээл

Ард Кредит ББСБ нь үйлдвэрлэл, худалдаа, санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, иргэдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор бизнесийн зээлийг олгодог бөгөөд уг зээл нь 3 сараас 24 сарын хугацаатай байдаг. Энэхүү зээл нь зориулалтаасаа

График 4. Бизнесийн зээл (сая төгрөг)




шалтгаалан төслийн, бичил бизнес, жижиг дунд бизнес, бөөний, зээлийн шугам гэсэн төрлүүдтэй байдаг. Төслийн болон бөөний зээлийн хувьд Хадгаламж Зээлийн Хоршоогоор дамжуулан хөдөөгийн иргэдэд олгодог бага хувийн хүүтэй зээл бөгөөд 2013 оноос Ард Кредит ББСБ нь Хөдөөгийн Бичил Санхүүгийн Хөгжлийн Дэмжих Холбоотой хамтран олгож эхэлсэн. Анх энэ зээлийг компани нь борлуулалтын шинэ гарцтай болох, харилцагчтайгаа илүү ойртон тулж ажиллах зорилгоор нэвтрүүлж ажиллаж байсан бол одоо энэ зээлийн багцын чанар нь компанийн хамгийн эрсдэлгүй багц болон хөгжжээ. 2017 онд бизнесийн зээлийн үлдэгдэл 4.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 102.3 хувиар өссөн байна.

шалтгаалан төслийн, бичил бизнес, жижиг дунд бизнес, бөөний, зээлийн шугам гэсэн төрлүүдтэй байдаг. Төслийн болон бөөний зээлийн хувьд Хадгаламж Зээлийн Хоршоогоор дамжуулан хөдөөгийн иргэдэд олгодог бага хувийн хүүтэй зээл бөгөөд 2013 оноос Ард Кредит ББСБ нь Хөдөөгийн Бичил Санхүүгийн Хөгжлийн Дэмжих Холбоотой хамтран олгож эхэлсэн. Анх энэ зээлийг компани нь борлуулалтын шинэ гарцтай болох, харилцагчтайгаа илүү ойртон тулж ажиллах зорилгоор нэвтрүүлж ажиллаж байсан бол одоо энэ зээлийн багцын чанар нь компанийн хамгийн эрсдэлгүй багц болон хөгжжээ. 2017 онд бизнесийн зээлийн үлдэгдэл 4.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 102.3 хувиар өссөн байна.

Хэрэглээний зээл

График 5. Хэрэглээний зээл (сая төгрөг)




Ард Кредит ББСБ нь хэрэглээний зээлийг иргэдийн өрхийн болон хувийн хэрэгцээнд зориулан тэдний тогтмол орлогод тулгуурлан олгодог бөгөөд 2017 онд нийт хэрэглээний зээлийн үлдэгдэл 1.3 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 170.9 хувиар өссөн байна. Хэрэглээний зээл нь хөрөнгө худалдан авахад зориулсан зээл, цалингийн зээл, өрхийн хэрэгцээний зээл, итгэлцэл барьцаалсан зэрэг олон төрөлтэй байдаг. 2016 онд Ард Кредит ББСБ нь хувь хүний гэнэтийн болон богино хугацааны мөнгөний хэрэгцээнд зориулан “Ард” кредит карт гаргасан

билээ. Ингэснээр ББСБ-ын салбарт олон нийтэд зориулан анх удаа кредит карт гаргасан байгууллага болсон бөгөөд энэхүү үйлчилгээ нь хурдтай өсөн нэмэгдэж байгаа зээлийн төрөл болоод байна. Тухайлбал, 2017 онд кредит картын зээлийн үлдэгдэл 573 сая төгрөгт хүрч, нийт зээлийн үлдэгдлийн 7.2 хувийг бүрдүүлэх болсон.

Шуурхай зээл

График 6. Шуурхай зээл (сая төгрөг)



Ард Кредит ББСБ нь шуурхай зээлийг зориулалт харгалзахгүй зээлдэгчийн орлого бус автомашин, орон сууц, хашаа байшин гэх мэт барьцаа хөрөнгө дээр тулгуурлан ажлын 1-2 хоногийн дотор шийдвэрлэдэг. 2017 онд шуурхай зээлийн үлдэгдэл 2.3 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оноос 8.2 хувиар буурсан байна. Энэ нь цаашид барьцаа хөрөнгөд тулгуурлан олгох зээлийн багцыг бууруулах, шуурхай зээл дээрээ тодорхой хэмжээгээр орлого баримтжуулж зээлийн эрсдэлийг



000036



Унэт цаасны танилцуулга
 он 2017.01.09
 БҮРТГЭВ
 № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГӨЙН БИРЖ
 MONGOLIAN STOCK EXCHANGE
 ARD КРЕДИТ
 ББСБ
 БҮРТГЭВ-02


бууруулах бодлого барин ажиллаж эхэлсэнтэй холбоотой юм.

2017 онд компанийн нийт зээлийн хүүгийн орлого 1.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 17.7 хувиар өссөн үзүүлэлт юм. Хүүгийн орлогын өсөлтөд хэрэглээний зээлийн хүүгийн орлого 124% буюу 158 сая төгрөг, шуурхай зээлийн хүүгийн орлого 22.7% буюу 113 сая төгрөгөөр өссөн нөлөөлсөн байна. Харин бизнесийн зээлийн хүүгийн орлого буурсан байна. Энэ нь бизнесийн зээлийн хүү буурсантай холбоотой юм.

Хүснэгт 8. Зээлийн хүүгийн орлого (сая төгрөг)

	2015	2016	2017	2017 эзлэх хувь	Өөрчлөлт дүн	%
Бизнесийн зээл	926	881	877	49.5%	(4)	-0.4%
Хэрэглээний зээл	87	128	286	16.1%	158	124.0%
Шуурхай зээл	352	495	608	34.3%	113	22.7%
Нийт хүүгийн орлого	1,364	1,504	1,771	100.0%	267	17.7%

График 7. Зээлийн хүү (жигнэсэн дундаж)



Ард Кредит ББСБ-ийн зээлийн жигнэсэн дундаж хүү жил бүр буурч байгаа бөгөөд 2017 онд сарын жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 2.36 хувь болсон нь салбарын ЖДХ болох 3.4 хувиас нэг нэгжээр бага байна. ЖДХ буурч байгаа нь зээл олголт нэмэгдэж компани чадваржиж байгаатай холбоотой юм.

График 8. Чанаргүй зээлийн мэдээлэл



График 9. Нийт хөрөнгөд эзлэх зээлийн хувь



2017 онд компанийн нийт зээлийн багцын 4.3 хувь буюу 344.9 сая төгрөг нь чанаргүй зээл байсан бөгөөд энэ нь банк бус санхүүгийн байгууллагын салбарын чанаргүй зээл (12.7 хувь)-тэй харьцуулахад хоёр дахин бага үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл салбарын хэмжээнд Ард Кредит ББСБ-ын зээлийн эргэн төлөлт болон үйл ажиллагаа нь сайн байна гэж үзэж болох төдийгүй нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ жил ирэх тусам багасаж байна. 2017 онд компанийн нийт хөрөнгө 10.2 тэрбум төгрөг байсан бөгөөд үүний 78%-ийг зээл эзэлж байна. Энэхүү үзүүлэлт нь 2016 онтой харьцуулахад 12 нэгжээр буурсан байгаа бөгөөд энэ нь компани үйл ажиллагаагаа төрөлжүүлж зээлээс гадна хөрөнгө оруулалт хийж эхэлсэнтэй холбоотой юм.



000037



Унот цаасны танилцуулга
2019-01-09
БҮРТГЭВ
№ 01

АРД КРЕДИТ
ББСБ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2018-11-29

2018 оны 5 сарын 24-ний өдөр Ард Кредит ББСБ нь цахим төлбөр тооцоо, мөнгөн туйвуулгын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос авч тус үйлчилгээг эхлүүлэх бэлтгэл ажлаа хангаад байна. Ард Кредит ББСБ-ын харилцагчид шимтгэл, хураамжгүй харилцах данс нээж төлбөр тооцоо болон мөнгөн шилжүүлгийг хүссэн үедээ түргэн, шуурхай, найдвартай хийх боломжтой юм.

Итгэлцэл

Ард Кредит ББСБ нь мөнгөн хөрөнгийн өгөөж, хугацаа зэргийг харилцан тохиролцсоны үндсэн дээр харилцагчдаасаа мөнгөн хөрөнгийг авч зах зээлийн эрсдэл, үнэгүйдлээс хамгаалж, тэдгээрийг удирдан өндөр өгөөж хүртээх зорилготой зээл хэлбэрээр гаргадаг. 2017 оны байдлаар 24 харилцагчид 2.7 тэрбум төгрөгийн итгэлцлийн үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оноос 161.0 хувиар өссөн үзүүлэлт юм.

Хүснэгт 9. Итгэлцэлийн үйлчилгээ

	2015	2016	2017	Өөрчлөлт	
				дүн	хувь
Харилцагчийн тоо	11	22	24	2	9.0%
Итгэлцлийн үлдэгдэл (сая төгрөг)	856.0	1,555.0	2,689.0	2,507.0	161.0%

Гадаад валютын арилжаа

Ард Кредит ББСБ нь анх үүсгэн байгуулагдахдаа гадаад валютын арилжаа хийх тусгай зөвшөөрөл авсан бөгөөд энэхүү тусгай зөвшөөрлийн хүрээнд валютын зээл гаргах болон дотоод үйл ажиллагаанд валютын гүйлгээ хийдэг байна.

Хөрөнгө оруулалт, санхүүгийн мэдээлэл, зөвлөгөө өгөх

Ард Кредит ББСБ нь өөрсдийн харилцагч байгууллага, иргэддээ хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө өгч ажилладаг.

Бүтээгдэхүүн хөгжүүлэлт: “Ард” аппликэйшн

Санхүүгийн салбарын чиг хандлага

Олон улсад 2009 оноос санхүүгийн технологийг үйл ажиллагаандаа ашигласан банк, санхүүгийн байгууллагууд гарч эхэлсэн байна. Эдгээр банк, санхүүгийн байгууллагууд нь өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээгээ дэвшилтэт технологи ашиглан харилцагчдад хүргэдэг бөгөөд салбар, тооцооны төвгүй, бүх үйлчилгээгээ цахим хэлбэрээр явуулдаг онцлогтой юм. Тухайлбал, үйлчлүүлэгчид санхүүгийн үйлчилгээг авахын тулд өөрийн биеэр санхүүгийн байгууллагын аль нэг салбар дээр очих, анкет бөглөх, материал бүрдүүлэх зэрэг олон төрлийн шат дамжлага дамжиж цаг хугацаа алддаг байсан бол эдгээр банк, санхүүгийн байгууллагаар үйлчлүүлснээр ухаалаг төхөөрөмж ашиглан хэдхэн хормын дотор санхүүгийн үйлчилгээг хаанаас ч авах боломжтой болсон. Англи Улсын Банкны Холбооноос гаргасан судалгаанаас 2011 оноос 2016 оны хооронд Англичууд банкны салбар дээр очиж үйлчлүүлэх нь 36 хувиар буурсан. Мөн интернэт банкны үйлчилгээ ч бууралттай байна. Харин жилийн дотор утсанд аа банкны аппликэйшн татах нь 25 хувиар өсч, гар утсаараа төлбөр тооцоо хийх нь 250 хувиар өссөн гэж мэдээлсэн байна.



000038




Үнэт цаасны танилцуулга
2018-01-09
Зорилго
№ 01

АРД КРЕДИТ
ББСБ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2018-11-29

Ард Кредит ББСБ нь дэлхий нийтийн чиг хандлагыг даган үйлчлүүлэгчдээ гар утсаараа дамжуулан санхүүгийн цогц үйлчилгээг авах боломж олгохоор зорьж ажиллаж байна.



Энэхүү зорилгын хүрээнд орчин үеийн технологийн дэд бүтэцтэй “Ард” аппликэйшнийг нэвтрүүлсэн бөгөөд энэхүү аппликэйшнээр дамжуулан Ард Кредит ББСБ нь санхүүгийн цогц бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчиддаа цаг алдалгүй хүргэнэ. “Ард” аппликэйшн нь төлбөр тооцоо хийх, зээл авах, хадгаламж хийх, үнэт цаасны арилжаанд оролцох зэрэг хүнд хэрэгтэй санхүүгийн бүхий л үйлчилгээг нэг дор багтаасан байх юм. Ингэснээр харилцагчид заавал өөрийн биеэр салбар дээр ирэх, бичиг цаас бүрдүүлэх зэрэг зардал, чирэгдэлгүйгээр гар утсан дээрээ “Ард” аппликэйшнийг суулгаж, санхүүгийн үйлчилгээг газар зүйн байршил, цаг хугацаанаас үл хамааран түргэн шуурхай авах боломжтой болох юм.

Технологийн шийдэл

“Ард” аппликэйшн нь харилцагчдад санхүүгийн үйлчилгээг технологийн шийдэл ашиглан хүргэж буй финтек үйлчилгээ юм. Финтек гэдэг нь Financial Technology буюу Санхүүгийн Технологи гэсэн үгний товчлол бөгөөд анх 2008 онд АНУ-д, 2014 онд Япон Улсын өдөр тутмын сонинд дурдагдаж эхэлсэн байдаг. Финтек нь технологийн дэвшлээр дамжуулан илүү хялбар санхүүгийн үйлчилгээг хүмүүст хүргэдгээрээ онцлог юм.

Ард Кредит ББСБ нь “Ард” аппликэйшнийг “Мост ПСП” ХХК болон “Грэйпсити Монголиа” ХХК-тай хамтран харилцагчдад хүргэж байна. “Ард” аппликэйшн нь Монгол Улсын үндэсний хэмжээний цахим төлбөр тооцооны систем болох Мост Мони системийн дэд бүтэц дээр суурилан ажиллах юм. Систем нь бүх банкуудыг холбосон нээлттэй интерфэйстэй бөгөөд Монголбанкны клирингийн сүлжээг ашигласан банк хоорондын тооцооны онлайн шийдэлтэй болно. “Мост ПСП” ХХК нь энэхүү системийг 2012 оноос эхлэн олон нийтэд хүргэж байна.


Үйлчилгээний хамрах хүрээ

“Ард” аппликэйшн нь цахим хэтэвчний нэг хэлбэр юм. Цахим хэтэвч нь хэрэглэгчийн цаасан болон хуванцар хэлбэрээр өвөртөө тээж явдаг банкны карт, купон, эрхийн тасалбар, даатгал болон бусад бүх төрлийн картыг цахим руу хөрвүүлэн гар утсанд шингээсэн технологийн хэрэгсэл юм.



000039





Унэт цаасны танилцуулга

Цахим хэтэвч нь билл төлөх, үйлчилгээний карт цэнэглэх, мөнгө шилжүүлэх, дэлгүүрүүдийн барааны нэвтэрхий лавлагаа үзэх, газар зүйн байршил лавлах зэрэг үйлчилгээнүүдийг давхар багтаасан байдаг тул таны өдөр тутмын амьдралын салшгүй хэрэглээ болох болно. “Ард” аппликэйшн нь харилцагч өөрийн гар утсаа ашиглан хаанаас ч банк, санхүүгийн үйлчигээг авч санхүүгийн төлбөр тооцоогоо хийх, хянах боломжтой үйлчилгээ юм. “Ард” аппликэйшн нь мөнгөн шилжүүлэг, төлбөр тооцоо, зээлийн үйлчилгээ үзүүлэх цогц бүтээгдэхүүн бөгөөд өөрийн мөнгөн хөрөнгийг удирдах, захиран зарцуулах, хянах, боломжийг олгож байгаагаараа давуу талтай.

Функц

“Ард” аппликэйшн нь цахим төлбөр тооцоог хэдхэн хормын дотор хийдэг бөгөөд аппликэйшний функцийг доорх схемээр харуулж байна.

Схем 5. “Ард” аппликэйшний функц

Мөнгөн шилжүүлэг	- Өөрийн данс хооронд гүйлгээ хийх - Бүх арилжааны банк хооронд гүйлгээ хийх - Утасны дугаар гүйлгээг хийх
Билл төлөх	- Бүх төрлийн хэрэглээний төлбөрөө төлөх
Нэгж/карт авах	- Гар утасны дугаарыг нэгжээр цэнэглэх
Худалдан авалт	- Мост Монид холбогдсон үйлчилгээний байгууллагуудаас картгүйгээр, гар утсаараа худалдан авалт хийх - Кино театр болон бусад үзвэрийн билетийг онлайнаар худалдан авах
Төрийн үйлчилгээ	Гаалийн төлбөр төлөх
qPay	- QR код ашиглан төлбөр төлөх, төлбөр лавлах, өөрийн дансандаа QR код болон нэхэмжлэх үүсгэж орлого хүлээн авах боломжтой. - QR код бүхий таних тэмдэгтэй бүх газруудад банк үл харгалзан төлбөрөө төлөх боломжтой
Дансаа хянах	- Дансны үлдэгдэл шалгах - Дасны хуулга харах - Гүйлгээний лавлагаа байримт харах

Компани нь цаашид 300,000-3,000,000 төгрөг хүртэлх зээлийг барьцаа хөрөнгөгүй, түргэн шуурхай олгох үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

1.9 Санхүүгийн төлөв байдал

1.9.1.Баланс

2017 онд ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ 969.2 тэрбум төгрөгт хүрсэн ба Ард Кредит ББСБ-ын хөрөнгө 10.2 тэрбум төгрөгт хүрч, нийт ББСБ-ын салбарын хөрөнгийн 1.1 хувийг



000040



СҮГЭТ цаасны танилцуулга
 он 2019 сар 01, 0-9 өр
 БҮРТГЭВ
 № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГӨН БИРЖ
 МОНГОЛЫН ХӨРӨНГӨН БИРЖ
 АРД КРЕДИТ ББСБ
 MONGOLIAN EXCHANGE
 2019-11-29
 БҮРТГЭВ-02

бүрдүүлсэн байна. Доорх хүснэт нь Ард Кредит ББСБ-ын сүүлийн 3 жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан дахь жилийн эцсийн санхүүгийн үзүүлэлтүүдийг хураангуйлан харуулж байгаа болно.

Хүснэгт 10. Санхүүгийн тайлангийн мэдээлэл (сая төгрөг)

	2015	2016	2017	Оөрчлөлт	
				дүн	хувь
ХӨРӨНГӨ	4,651.5	5,692.7	10,193.3	4,500.7	79.1%
Мөнгө	667.2	233.2	1,095.3	862.1	369.7%
Зээл болон хүүгийн авлага	3,733.1	5,056.1	8,023.7	2,967.6	58.7%
Хөрөнгө оруулалт	5.0	5.0	28.0	23.0	460.0%
Санхүүгийн хөрөнгө	55.2	11.2	495.1	483.9	4324.0%
Үндсэн хөрөнгө	126.1	233.8	237.8	4.0	1.7%
Биет бус хөрөнгө	4.0	2.7	1.4	(1.3)	-47.0%
Бусад	60.8	150.6	312.0	161.4	107.1%
ӨР ТӨЛБӨР	2,760.8	2,399.1	6,458.0	4,058.9	169.2%
Банкны зээл	1,819.4	630.2	1,621.1	990.9	157.2%
Бусад эх үүсвэр	845.5	1,555.1	4,402.3	2,764.2	168.7%
Хүүний өр төлбөр	56.4	96.3	352.5	256.1	265.8%
Бусад өр төлбөр	39.4	34.4	82.1	47.7	138.8%
ЭЗДИЙН ӨМЧ	1,891.7	3,293.6	3,735.3	441.8	13.4%
Энгийн хувьцаа	1,000.0	1,312.5	1,312.5	-	0.0%
Нэмж төлөгдсөн капитал	100.0	787.5	787.5	-	0.0%
Хуримтлагдсан ашиг	791.7	1,193.6	1,635.3	441.8	37.0%

Хөрөнгө

2017 онд Ард Кредит ББСБ-ын нийт хөрөнгө 10.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 79.1 хувиар өссөн байна. Энэхүү өсөлт нь зээл олголт нэмэгдсэнтэй холбоотой юм. 2016 онд зээлийн үлдэгдэл 5.1 тэрбум төгрөг байсан бол 2017 онд 8.0 тэрбум төгрөгт хүрч 56.1 хувиар өссөн байна.


Хүснэгт 11. Зээл (сая төгрөг)

	2015	2016	2017	Оөрчлөлт	
				дүн	хувь
Нийт зээл	3,706.1	5,109.4	7,974.5	2,865.2	56.1%
Шуурхай зээл	998.9	2,518.2	2,312.4	(205.8)	-8.2%
Бизнесийн зээл	2,497.2	1,976.6	3,999.1	2,022.5	102.3%
Хэрэглээний зээл	210.1	614.6	1,663.0	1,048.5	170.6%
Зээлийн эрсдэлийн сан	(127.0)	(241.3)	(178.5)	62.9	-26.1%
Зээлийн хүүгийн авлага	154.0	188.1	227.6	39.5	21.0%
Зээл, хүүгийн авлага	3,733.1	5,056.1	8,023.7	2,967.6	58.7%

Тайлант онд компанийн санхүүгийн хөрөнгө 495.1 сая төгрөг байсан бөгөөд үүний 89.0 хувь буюу 440.4 сая төгрөг нь байгууллагаас авах авлага байна.


Хүснэгт 12. Авлага (сая төгрөг)

	2016	2017		Оөрчлөлт	
		дүн	ЭЗЛЭХ ХУВЬ	дүн	хувь
Байгууллагаас авах авлага	-	440.4	89.0%	440.4	142.0%
Хувь хүнээс авах авлага	36.1	87.3	17.6%	51.2	31.4%
Авлагын болзошгүй эрсдэлийн сан	(24.9)	(32.7)	-6.6%	(7.8)	4,324.0%
Нийт	11.2	495.1	100.0%	483.9	



000041





Хүснэгт 13. Үндсэн хөрөнгө (сая төгрөг)

	2015	2016	2017	Өөрчлөлт	
				дүн	хувь
Тавилга	10.0	9.4	8.0	(1.4)	-17.1%
Компютер	3.6	4.2	2.8	(1.4)	-50.4%
Тээврийн хэрэгсэл	102.5	210.2	217.0	(6.8)	3.1%
Бусад	10.0	10.0	10.0	0	0.0%
Нийт	126.1	233.8	237.8	4.0	1.7%

Өр төлбөр ба эздийн өмч

Тайлант хугацаанд компанийн өр төлбөрийн дүн 169.2 хувиар өсөж, 6.5 тэрбум төгрөгт хүрчээ. Энэ нь үйл ажиллагаагаа өргөжүүлж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэхтэй холбоотойгоор нэмэлт эх үүсвэр татсантай холбоотой юм. Тухайлбал, тайлант онд банкны зээл 1.6 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүний 34.1 хувь нь кредит картын үйлчилгээ нэвтрүүлж, өргөжүүлсэнтэй холбоотой банкны зээл байв. Тайлант хугацаанд бусад эх үүсвэр 4.4 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүний 61.0 хувь буюу 2.7 тэрбум төгрөг нь итгэлцлийн үйлчилгээнээс татсан эх үүсвэр, 39.0 хувь буюу 1.7 тэрбум төгрөг нь бонд гаргаж татсан эх үүсвэрээс тус тус орж ирсэн мөнгө байв.

Хүснэгт 14. Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл (сая төгрөг)

	2015	2016	2017	Өөрчлөлт	
				дүн	хувь
Богино хугацаат зээл	1,597.0	630.0	1,068.0	438.0	70%
ХХБ	250.0	190.0	300.0	110.0	58%
БСХС	432.0	400.0	200.0	(200.0)	-50%
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	915.0	40.0	438.0	398.0	989%
Ард Даатгал ХХК	-	-	130.0	130.0	
Урт хугацаат зээл	222.0	83.0	553.0	470.0	566%
ХХБ	-	83.0	553.0	470.0	566%
Хаан банк	222.0	-	-	-	
Нийт	1,819.0	713.0	1,621.0	908.0	127%

Хүснэгт 15. Бусад эх үүсвэр (сая төгрөг)

	2015	2016	2017	Өөрчлөлт	
				дүн	хувь
Итгэлцлийн үйлчилгээний өглөг-хувь хүн	746.0	605.0	2,139.0	1,534.0	254%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг-байгууллага	100.0	950.0	550.0	(400.0)	-42%
Бонд	-	-	1,713.0	1,713.0	
	846.0	1,555.0	4,402.0	2,847.0	183%

Тайлант хугацаанд компанийн эздийн өмч 3.7 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 13.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Энэхүү өсөлтөд 2017 онд компани 641.8 сая төгрөгийн ашигтай ажилласан нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 16. Баланын харьцаа үзүүлэлтүүд

	2015	2016	2017



000042



СЭНэт цаасны танилцуулга
 2019 о. 01. 09
 БҮРТГЭВ
 № 91

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БҮЭЖ
 MONGOLIAN CREDIT BUREAU
 ARD КРЕДИТ ББСБ
 2018-11-29
 БҮРТГЭВ-02

Хөрөнгийн эргэц	32.0%	27.1%	23.4%
Үндсэн хөрөнгийн эргэц	4.0	3.9	3.9
Өрийн харьцаа	59.4%	42.1%	63.4%
Санхүүгийн хошүүрэг	2.3	2.0	2.3

Хөрөнгийн эргэц

2017 онд нийт хөрөнгийн эргэцийн харьцаа 23.4 хувь, үндсэн хөрөнгийн эргэцийн харьцаа 3.9 дахин байна. Компани нь үйл ажиллагаагаа олон жилийн турш тогтвортой явуулж ирсэн бөгөөд үүнтэй холбоотойгоор хүүгээ бууруулсан нь хөрөнгийн эргэцийг сүүлийн жилүүдэд сулрахад нөлөөлсөн байна.

Өрийн харьцаа

2017 онд өрийн харьцаа нь 63.4 хувьтай байсан бөгөөд энэ нь компанийн нийт хөрөнгийн 63.4 хувь нь өр төлбөрөөр санхүүжигдсэн байгааг харуулж байна. Энэхүү харьцаа сүүлийн 3 жилд өсөлттэй байгаа нь компанийн итгэлцлийн үйлчилгээ нэмэгдсэн болон бонд гаргасантай холбоотой байна.

1.9.2. Орлогын тайлан


Ард Кредит ББСБ нь 2017 онд 1.8 тэрбум төгрөгийн хүүгийн орлоготой, 641.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Доорх хүснэгт нь сүүлийн 3 жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан дахь жилийн эцсийн орлогын тайланг хураангуйлан харуулж байгаа болно. 2015 болон 2016 оны компанийн санхүүгийн тайланд “БДО Аудит” ХХК аудит хийсэн бол 2017 оны санхүүгийн тайланд “Далайван Аудит” ХХК аудит хийсэн байна.

Хүснэгт 17. Орлогын тайлан (сая төгрөг)

	2015	2016	2017	Өөрчлөлт	
				дүн	хувь
Цэвэр хүүгийн орлого	943.8	1,005.4	1,110.4	105.0	10.4%
Хүүгийн орлого	1,234.0	1,363.8	1,766.9	403.0	29.6%
Хүүгийн зардал	290.2	358.4	656.4	298.0	83.1%
Хүүгийн бус орлого	455.3	327.4	179.9	(147.5)	-45.1%
Гадаад валютын арилжааны орлого	3.1	2.0	0.9	(1.1)	-54.1%
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	401.8	288.2	87.8	(200.4)	-69.5%
Үйлчилгээний орлого	50.4	37.2	91.2	53.9	144.9%
Хүүгийн бус зардал	872.3	771.3	797.7	26.4	3.4%
Гадаад валют арилжааны зардал	3.43	3.9	1.9	(2.1)	-52.5%
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн гарз	390.8	261.5	85.3	(176.1)	-67.4%
Боловсон хүчний зардал	228.2	277.7	310.0	32.3	11.6%
Үйл ажиллагааны бусад зардал	249.9	228.1	400.4	172.3	75.5%
Эрсдэлийн сангийн зардал	66.3	154.1	140.6	(13.5)	-8.8%
Үндсэн үйл ажиллагааны ашиг	460.5	407.5	352.1	(55.4)	-13.6%
Үйл ажиллагааны бус ашиг	(2.1)	46.3	361.9	315.6	682.4%
Татварын өмнөх ашиг	458.4	453.7	713.9	260.2	57.4%
Орлогын татвар	(47.5)	(51.9)	(72.2)	(20.2)	39.0%
Татварын дараах цэвэр ашиг	410.9	401.8	641.8	240.0	59.7%


Татварын дараах цэвэр ашиг

Тайлант хугацаанд Ард Кредит ББСБ нь 641.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд энэхүү үзүүлэлт нь өмнөх оны ашгаас 59.7 хувиар өссөн үзүүлэлт юм. Энэхүү өсөлтөд шинэ



000043





бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт их байсантай холбоотойгоор хүүгийн орлого болон хөрөнгө оруулалтын өгөөж өссөн нь нөлөөлсөн байна.

Хүүгийн орлого

2017 онд компанийн хүүгийн орлого 29.6 хувиар өсөж, 1.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэхүү хүүгийн орлогын 34.3 хувийг бүрдүүлж буй шуурхай зээлийн хүүгийн орлого 22.7 хувиар өссөн, хүүгийн орлогын 16.1 хувийг бүрдүүлж буй хэрэглээний зээл 124.0 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна. Тухайлбал, хэрэглээний зээлийн шинэ төрөл болох картын зээл олголт өссөнтэй холбоотой хүүгийн орлого өмнөх онтой харьцуулахад 252 дахин өсч, 97 сая төгрөгт хүрсэн.

Хүүгийн зардал

2017 онд хүүгийн зардал 83.1 хувиар өсч 656.4 сая төгрөгт хүрсэн байна. Энэхүү өсөлт нь компани бонд, итгэлцэл зэрэг өрийн эх үүсвэр татаж, зээл олголтоо нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Тухайлбал, хүүгийн зардлын 30.9 хувь буюу 202.9 сая төгрөгийг 2017 онд гаргасан Ард Кредит бондын хүүгийн зардал эзэлж байна. Мөн итгэлцлийн үйлчилгээ 2017 онд өссөнтэй холбоотой хүүгийн зардал 129.2 хувиар өсөж 382.5 сая төгрөг болсон байна.

Хүүгийн бус зардал

Хүүгийн бус зардалд боловсон хүчний зардал болон бусад компанийн үндсэн үйл ажиллагаа явуулахад шаардагдах зардлууд багтсан бөгөөд энэхүү зардал 2017 онд 3.4 хувиар өсч, 797.7 сая төгрөгт хүрсэн байна. Нийт хүүгийн бус зардлын 38.9 хувь буюу 310.0 сая төгрөгийг боловсон хүчинтэй холбоотой зардал, 50.2 хувийн үйл ажиллагааны бусад зардал, 11.7 хувийг гадаад валюттай холбоотой зардал эзэлж байна. Тайлант хугацаанд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэхтэй холбоотой зардлууд гарсан нь зардлын өсөлтөд нөлөөлсөн байна.

Үйл ажиллагааны бус ашиг

2017 онд Ард Кредит нь хугацаа хэтэрсэн чанаргүй зээлийг барагдуулах ажлыг түлхүү хийсний үр дүнд хугацаа хэтэрсэн зээлүүд эргэн төлөгдөж, үйл ажиллагааны бус орлогыг нэмэгдүүлсэн байна. Мөн тайлант хугацаанд компани нь хөрөнгө оруулалт хийсэн нь 184.3 сая төгрөгийн үйл ажиллагааны бус орлогыг авчирсан байна.

Орлогын албан татвар

Ард Кредит нь 2017 онд 713.9 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан бөгөөд үүнээс 72 сая төгрөгийн орлогын албан татвар төлсөн байна.

Хүснэгт 18. Ашигт ажиллагааны харьцаа

	2015	2016	2017
Ахиуц ашиг			
Хүүгийн ахиуц ашиг	29.6%	22.8%	17.0%
Үйл ажиллагааны ахиуц ашиг	37.3%	29.9%	19.9%
Ахиуц цэвэр ашиг	32.0%	28.7%	34.5%
Өгөөж (дундаж)			
Зээлийн өгөөж	38.7%	30.9%	27.0%
Хөрөнгийн өгөөж (ROeA)	10.2%	7.8%	8.1%
Эздийн өмчийн өгөөж (ROeE)	23.7%	15.5%	18.3%



Ахиуц ашиг

000044



Үнэт цаасны танилцуулга
 2019-01-09
 БҮРГЭВ
 №01

ARD КРЕДИТ ББСБ
 2018-11-29
 БҮРГЭВ-02

2017 онд компанийн хүүгийн ахиуц ашиг 17.0 хувьтай байсан бөгөөд энэ нь компани нийт зээл санхүүгийн эх үүсвэрийн өртгийг хасаад 17.0 хувийн өгөөж авчирч байгааг харуулж байгаа болно. Энэхүү харьцаа нь жил ирэх тусам багасч байгаа бөгөөд энэ нь компанийн зээлийн хүүгээ багасгаж байгаатай холбоотой болно. Хэдийгээр үйл ажиллагааны ахиуц ашиг зээлийн хүү буурсантай холбоотой багасч байгаа хэдий ч ахиуц цэвэр ашиг 2017 онд 34.5 хувьд хүрсэн нь өмнөх оноос 5.8 нэгжээр өссөн үзүүлэлт болсон байна. Энэ нь компани үйл ажиллагааны цар хүрээгээ тэлж байгаатай холбоотой юм.

Өгөөж

Ард Кредит ББСБ нь 2017 онд 1.8 тэрбум төгрөгийн хүүгийн орлоготой ажилласан бөгөөд тухайн жилийн дундаж зээлтэй харьцуулахад 27.0 хувьтай байна. Энэ нь 2017 онд зээл дунджаар 27.0 хувийн ашиг өгөөжийг авчирсан гэсэн үг юм. Компанийн нийт хөрөнгийн өгөөж тогтвортой буюу 8.1 хувьтай байна. Эздийн өмчийн өгөөж 18.3 хувьтай байгаа нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө оруулалтын жилийн өгөөжийг харуулж байгаа болно.

1.9.3. Эздийн өмч, мөнгөн гүйлгээний тайлан

Доорх хүснэгт нь сүүлийн 3 жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан дахь жилийн эцсийн эздийн өмч болон мөнгөн гүйлгээний тайланг хураангуйлан харуулж байна.

Хүснэгт 19. Өмчийн өөрчлөлтийн тайлан (сая төгрөг)

	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт
2015 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	1,000.0	100.0	791.8	1,891.8
Тайлант хугацааны цэвэр ашиг			401.8	401.8
Хувьцаат капиталын өсөлт	312.5	687.5		1,000.0
2016 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	1,312.5	787.5	1,193.6	3,293.6
Тайлант хугацааны цэвэр ашиг			641.8	641.8
Зарласан ногдол ашиг			(200.0)	(200.0)
2017 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	1,312.5	787.5	1,635.3	3,735.3

Хүснэгт 20. Мөнгөн гүйлгээний тайлан (сая төгрөг)

	2015	2016	2017
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(161.8)	(156.9)	(2,563.8)
Татварын өмнөх ашиг	458.5	453.7	713.9
Тохируулга			
Элэгдэл, хорогдлын зардал	24.1	22.8	28.5
Авлагын эрсдэлийн сангийн зардал	2.3	22.6	7.8
Үндсэн хөрөнгө актасны олз (гарз)	(3.3)	(71.3)	(16.6)
Зээлийн эрсдэлийн сангийн зардал	66.3	131.5	132.8
Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний тэгшитгэл	3.1	-	-
Ажлын капиталын өөрчлөлт			
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	20.0	30.0	-
Зээл ба урьдчилгааны өөрчлөлт	(1,034.5)	(1,420.4)	(2,928.0)
Бусад санхүүгийн хөрөнгийн өөрчлөлт	106.9	21.4	(491.7)
Бусад санхүүгийн бус хөрөнгийн өөрчлөлт	(39.4)	7.8	(34.4)
Өмчлөх бус үл хөдлөх хөрөнгийн өөрчлөлт	(3.1)	(97.6)	(126.3)

ARD CAPITAL GROUP ULC
 ARD CAPITAL GROUP SECURITIES COMPANY LLC
 4400045

000045

АНГАГААР ХОТ
 ARD КРЕДИТ ББСБ ХХК
 ТТГ 44, 5459567

С Үнэт цаасны танилцуулга
 он 2019.01.09
 БҮРТГЭВ
 № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
 MONGOLIAN STOCK EXCHANGE
 ББСБ
 2018-11-29
 БҮРТГЭВ-02

Итгэлцлийн үйлчилгээний өр төлбөрийн өөрчлөлт	344.7	709.6	
Бусад санхүүгийн өр төлбөрийн өөрчлөлт	10.0	74.7	(18.0)
Санхүүгийн бус өр төлбөрийн өөрчлөлт	3.8	1.6	22.1
Төлсөн орлогын албан татвар	(45.1)	(49.0)	(61.7)
Хүүгийн орлого	(1,234.0)	(1,363.8)	(1,951.2)
Хүлээн авсан хүү	1,127.2	1,329.8	1,911.6
Хүүгийн зардал	290.2	358.4	656.4
Төлсөн хүү	(259.4)	(318.5)	(409.2)
Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ	(114.1)	(425.2)	(33.6)
Худалдан авсан үндсэн хөрөнгө	(109.1)	(425.2)	(110.2)
Худалдсан үндсэн хөрөнгө	-	-	16.0
Худалдан авсан санхүүгийн хөрөнгө	(5.0)	-	(1,090.6)
Худалдсан санхүүгийн хөрөнгө	-	-	1,151.2
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	460.5	178.1	3,459.6
Гаргасан хувьцаат капитал	-	1,000.0	-
Гаргасан өрийн бичиг	-	-	1,743.0
Өрийн бичгийн эргэн төлөлт	(250.0)	-	(25.0)
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	1,597.4	2,954.9	3,606.9
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн эргэн төлөлт	(786.8)	(3,776.8)	(1,843.7)
Төлсөн ногдол ашиг	(100.0)	-	(22.9)
Ханшийн зөрүүний гарз	-	-	1.2
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	184.6	(404.0)	862.1
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	452.6	637.2	233.2
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	637.2	233.2	1,095.3

Аудитын дүгнэлтээс

“Далайван Аудит” ХХК нь “Ард Кредит ББСБ” ХХК-ийн 2017 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэсэн болно. “Далайван Аудит” ХХК-аас “Ард Кредит ББСБ” ХХК-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг доорх байдлаар тайлагнасан байна.

“Бидний дүгнэлтээр “Ард Кредит ББСБ” ХХК-ийн 2017 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна” гэж дүгнэсэн байна.

1.10 Үнэт цаас гаргагчийн хийсэн гэрээ хэлцэл

1.10.1. ХНХ-ийн 5 хувь буюу түүнээс дээш үнийн дүн бүхий гэрээ, хэлцэл

2017 онд Ард Кредит ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгө 1.3 тэрбум төгрөг байсан бөгөөд үүний 5 хувьтай тэнцэх үнийн дүн нь 65.6 сая төгрөг юм. Тус онд Ард Кредит ББСБ нь 65.6 сая төгрөгийн үнийн дүн болон түүнээс дээш хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хэлцэл 11 хийснээс 7 гэрээ дуусгавар болж, 4 гэрээ зохих ёсоор хэрэгжиж байна.



000046



Сүүдэт цаасны танилцуулга

он 2019-01-09
БҮРТГЭВ

МОНГОЛЫН АРД КРЕДИТ
MONGOLIAN ARD КРЕДИТ
ББСБ ББСБ

2019-11-29

Хүснэгт 21. ХНХ-ийн 5% буюу түүнээс дээш үнийн дүн бүхий гэрээ хэлцэл

Огноо	Гэрээ	Гэрээний эсрэг тал	Гэрээний агуулга
3/20/2017	Зээлийн гэрээ	“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК (хувьцаа эзэмшигч)	Зээлдэгч нь зээлдүүлэгчийн зээл авах хүсэл зоригийн дагуу 117,555,000 төгрөгийг 24 сарын хугацаатай, жилийн 22%-ийн хүүтэй зээлэх
3/28/2017	Зээлийн гэрээ	“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК (хувьцаа эзэмшигч)	Зээлдэгч нь зээлдүүлэгчийн зээл авах хүсэл зоригийн дагуу 161,400,000 төгрөгийг 24 сарын хугацаатай, жилийн 22%-ийн хүүтэй зээлэх
5/12/2017	Зээлийн гэрээ	“Алтан Хоромсог ҮЦК” ХХК	Зээлдэгч нь зээлдүүлэгчийн зээл авах хүсэл зоригийн дагуу 250,000,000 төгрөгийг 12 сарын хугацаатай сарын 2%-ийн хүүтэй зээлэх
5/19/2017	Бондын гэрээнд нэгдэн орох	“Мастер Түншлэл” ХХК, ХасБанк	Жилийн 24%-ийн хүүтэй, 390,000,000 төгрөгийн барьцаат өрийн бичиг худалдан авах
7/28/2017	Авлага барагдуулах гэрээ	“Ард Даатгал” ХХК	Ард Кредит нь 148,000,000 төгрөгийн авлагыг жилийн 10%-ийн хүүтэй 5 жилийн хугацаатай барагдуулах
9/22/2017	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ	“Ард Актив” ХЗХ	Ард Кредит ББСБ нь “Ард Актив” ХЗХ-ийн хүсэл зоригийн дагуу 150,000,000 төгрөгийг 6 сарын хугацаатай жилийн 16%-ийн хүүтэй итгэмжлэх
9/22/2017	Зээлийн гэрээ	В.Баяржаргал	Зээлдэгч нь зээлдүүлэгчийн зээл авах хүсэл зоригийн дагуу 149,000,000 төгрөгийг сарын 2%-ийн хүүтэй зээлэх
10/4/2017	Бонд шилжүүлэх мэдэгдэл	“Ард Даатгал” ХХК (зэрэгцээ компани)	“Ард даатгал” ХХК-д өөрийн өмчлөлийн 390,000,000 төгрөгийн үнэ бүхий 390 ширхэг Бондыг шилжүүлж байгаа болохыг мэдэгдэх
11/22/2017	Зээлийн гэрээ	“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК (хувьцаа эзэмшигч)	Зээлдэгч нь зээлдүүлэгчийн зээл авах хүсэл зоригийн дагуу 120,000 доллар 365 хоногийн хугацаатай жилийн 12%-ийн хүүтэйгээр зээлдүүлэх
11/20/2017	Зээлийн гэрээ	“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК (хувьцаа эзэмшигч)	Зээлдэгч нь зээлдүүлэгчийн зээл авах хүсэл зоригийн дагуу 147,000,000 төгрөгийг 365 хоногийн хугацаатай жилийн 16%-ийн хүүтэйгээр зээлдүүлэх
11/22/2017	Зээлийн гэрээ	Б.Цэнгүүн	Зээлдэгч нь зээлдүүлэгчийн зээл авах хүсэл зоригийн дагуу 120,000 доллар 24 сарын хугацаатай, жилийн 14%-ийн хүүтэйгээр зээлдүүлэх

1.10.2. Их хэмжээний хэлцэл

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд их хэмжээний гэрээ хэлцлийг тодорхойлсон байх бөгөөд “Ард Кредит ББСБ” ХХК нь сүүлийн 3 жилд буюу 2015 оноос хойш хийгдсэн хэлцлүүдийн үнийн дүнг компанийн санхүүгийн тайланд тусгагдсан активын дүнтэй харьцуулж үзэхэд сүүлийн 3 жилийн хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй.

1.10.3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл

Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай хэлцэл



000047



СЭХ
 2019.01.09
 БҮРТГЭВ-02

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН СЭХ
 MONGOLIAN STOCK EXCHANGE
 КРЕДИТ
 ББСБ 29
 БҮРТГЭВ-02

Үнэт цаасны танилцуулга

хийсэн бол компанитай эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцно гэж заажээ. Ард Кредит ББСБ нь сүүлийн 3 жилийн хугацаанд нийт 33 сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцэл хийсэн байна.

Хүснэгт 22. Сонирхлын зөрчилтэй хэлцэл

	2015	2016	2017	2018 Q1	Нийт
Хэрэгжиж байгаа гэрээ хэлцэл	-	2	7	2	11
Дуусгавар болсон гэрээ хэлцэл	2	8	11	1	22
Нийт гэрээ хэлцэл	2	10	18	3	33

“Өмгөөллийн И Эл Си” ХХН нь Ард Кредит ББСБ-ын сүүлийн 3 жилийн хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон түүнтэй холбогдох гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх дээр дүгнэлт гаргасан болно. Хууль зүйн дүгнэлтээс дурдвал, “Ард Кредит ББСБ” ХХК нь сонирхлын зөрчилтэй этгээдүүтэй байгуулах хэлцүүлдээ ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан байгаа нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодексийн шаардлагад нийцсэн байна гэж дүгнэсэн байна.

1.11. Эрх бүхий албан тушаалтан

Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-д “компанийн төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх), гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно” гэж заажээ. Энэхүү заалтаар Ард Кредит ББСБ-ын доорх ажилтан, удирдах албан тушаалтнууд нь эрх бүхий албан тушаалтан байна. Үүнд:

Хүснэгт 23. Эрх бүхий албан тушаалтан

№	Нэр	Төрийн байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх	Ял шийтгэл эдэлж байгаа эсэх	Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх	Хувь хүн байх
1	Ч.Ганхуяг (ТУЗ-ын дарга)	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
2	С. Гэрэлтуяа (ТУЗ-ийн гишүүн)	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
3	В. Баяржаргал (ТУЗ-ийн гишүүн)	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
4	Б. Ганбат (ТУЗ-ийн гишүүн)	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
5	Ч. Ганзориг (ТУЗ-ийн гишүүн)	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
6	В. Ганзориг (ТУЗ-ийн гишүүн)	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
	М. Тулгат (ТУЗ-ийн гишүүн)	Үгүй	Үгүй	Тийм	Тийм



000048



СҮНэт цаасны танилцуулга
 2019 оны 01.09 өдөр
 БҮРТГЭВ
 № 01

МОНГОЛЫН АРД КРЕДИТ
 ББСБ
 2018-11-29

8	гишүүн) Ч.Ганзориг (Гүйцэтгэх захирал)	Үгүй	Үгүй	Хамааралгүй	Тийм
9	Д.Отгонжаргал (Зээл эрхэлсэн захирал)	Үгүй	Үгүй	Хамааралгүй	Тийм
10	Д. Сувдмаа (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга)	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
11	Д. Дархижав (Ерөнхий нягтлан бодогч)	Үгүй	Үгүй	Хамааралгүй	Тийм

БҮРТГЭВ-02

“Өмгөөллийн И Эл Си” ХХН нь Монгол Улсын холбогдох хууль, журмыг үндэслэн “Ард Кредит ББСБ” ХХК-ийн хууль зүйн дүгнэлтийг гаргасан болно. Энэхүү хууль зүйн дүгнэлтийн 2 дугаар бүлэгт компанийн эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомжийн шаардлага, шалгуурыг хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргасан байна. Тухайлбал, Эрх бүхий албан тушаалтнууд нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн засаглалын кодекс болон холбогдох журамд заасан эрх бүхий албан тушаалтнуудад тавигддаг нийтлэг шаардлагуудыг хангасан байна. ТУЗ-ийн гишүүд болон нарийн бичгийн дарга нь Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан, хувь хүн байх зэрэг шаардлагыг хангасан байна хэмээндүгнэлтэндээ дурьджээ.

1.12. Холбоотой этгээдүүдийн мэдээлэл

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.30-д заасны дагуу 2017 оны байдлаар Ард Кредит ББСБ-тай холбоотой компаниудад түүний толгой компани болон толгой компанийн хөрөнгө оруулалттай 12 компани хамаарч байна.

ARD САНХҮҮГИЙН
НЭГДЭЛ

Үнэт цаас гаргагчийн толгой компани

“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь банк бус санхүү, даатгал, үнэт цаас, үл хөдлөх хөрөнгө, боловсрол гэх мэт эдийн засгийн өндөр өсөлттэй салбаруудад хөрөнгө оруулалт хийн ажиллаж буй холдинг компани юм. Компани нь 2005 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд 13 жилийн турш тасралтгүй, тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. 2017 оны жилийн эцсээр компани нь 12 компанид хөрөнгө оруулалт хийсэн байна.

Сүүлийн үеийн үйл явдал

- “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь 3 дахь жилдээ Хөрөнгө Оруулагч Үндэстэн чуулга уулзалтыг амжилттай зохион байгуулж, төр засаг, олон нийт болон салбарын мэргэжилтнүүдийг хамруулав.
- Анх удаа 2.0 тэрбум төгрөг болон 1 сая долларын бондыг хаалттай хүрээнд хөрөнгө оруулагчдад санал болгож амжилттай арилжаалав.
- Ард Даатгал компани дэх эзэмшил хувиа нэмэгдүүлж 95%-д хүргэв.
- Олон нийтийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор Ард Академиар дамжуулан санхүү болон үнэт цаасны зах зээлийн сургалтыг зохион байгуулж, “Миний Анхны Хөрөнгө Оруулалт” болон “Цахим Алт” номыг бичиж хэвлүүлэв.
- Техник Технологийн Дээд Сургуулийн 12.41 хувийг эргүүлэн худалдан авч, хөрөнгө оруулалтын



000049





багцаа нэмэгдүүлэв.

- Шангри Ла Моллд анхны салбараа нээн ажиллуулж эхэлсэн бөгөөд цаашид харилцагчдынхаа цаг завьг хэмнэх үүднээс уг салбараар дамжуулан санхүүгийн цогц үйлчилгээг нэг дороос өгөхөөр төлөвлөж байна.
- 100 гаруй хөрөнгө оруулагчдыг хамарсан уулзалт зохион байгуулж, 3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татан төвлөрүүлж Крипто Үндэстэн ХХК-г үүсгэн байгуулав. Уг компани нь крипто валют олборлох, хөрөнгө оруулалт хийх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Монгол Улсын анхдагч компаниудын нэг юм.

Хувьцаа эзэмшигчид

2014 онд Ард Санхүүгийн Нэгдэл нь компанийн хэлбэрээ өөрчлөн хаалттай хувьцаат компани болсон бөгөөд энэ нь бизнесийн үйл ажиллагаагаа ил тод нээлттэй явуулж, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдлэн хамгаалах тал дээр томоохон алхам болсон юм. Ард Санхүүгийн Нэгдэл нь 2017 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 1,006 хувьцаа эзэмшигчтэй байна.

Хүснэгт 24. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц (2017)

Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Хувь
“Ард Секюритиз УЦК” ХХК.....	3,315,435	19.3%
Х.Батхишиг.....	1,689,415	9.8%
“Луна Энд Луна” ХХ.....	1,333,154	7.8%
Бруно Рашле.....	1,317,337	7.7%
Венчурс Ван БВ.....	1,316,103	7.7%
Ч.Ганхуяг.....	1,145,400	6.7%
“Жинст Увс” ХК.....	1,020,998	5.9%
“Ард Лайф” ХХК.....	611,051	3.6%
Г.Уянга.....	596,037	3.5%
“Алтан Хоромсог УЦК” ХХК.....	456,290	2.7%
Эхний 10 хувьцаа эзэмшигч.....	12,777,170	74.3%
Үлдэх 996 хувьцаа эзэмшигч.....	4,417,194	25.7%
Нийт гаргасан хувьцаа.....	17,194,364	100.0%

Санхүүгийн үзүүлэлт

2017 онд “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн нийт хөрөнгө 49.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 26.0 хувиар өсчээ. Нийт хөрөнгийн 87.0 хувийг эздийн өмч, 13.0 хувийг өр төлбөр бүрдүүлж байна. Ард Санхүүгийн Нэгдэл-ийн хөрөнгө оруулалт нь 2017 оны байдлаар дараах бүтэцтэй байна.

Хүснэгт 25. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хөрөнгө оруулалтын бүтэц (2017)

Хөрөнгө оруулалт	Үйл ажиллагааны чиглэл	Эзэмшлийн хувь	Үнэлгээ (сая төгрөг)
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ			39,033.9
“Монгол Шуудан” ХК	Шуудан, логистик	29.2%	16,046.8
“Ард Даатгал” ХХК	Ердийн даатгал	95.3%	9,527.7
“Ард Кредит ББСБ” ХХК	Банк бус санхүүгийн байгууллага	80.7%	4,558.0
“Ард Секюритиз УЦК” ХХК	Үнэт цаасны компани	100.0%	2,126.2
“Номын Хишиг” ХХК	Хэвлэн нийтлэх, гадаад худалдаа	20.0%	1,780.0
“Ард Менежмент УЦК” ХХК	Хөрөнгө оруулалтын менежмент	100.0%	100.0
“Ард Лайф” ХХК	Хувийн тэтгэвэр	100.0%	1,010.0
“Жинст Увс” ХК	Бизнес зөвлөгөө	9.6%	295.5
Техник Технологийн дээд сургууль	Сургууль	12.4%	2,337.2
“Крипто Үндэстэн” ХХК	Цахим худалдаа	32.4%	950.0
“Ард Актив” ХЗХ	Хадгаламж зээлийн хоршоо	9.7%	29.0



000050



Үнэт цаасны танилцуулга
 2019-01-09
 БҮРТГЭВ
 № 21

“Тэнгэр Системс” ХХК Програм хангамж
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
НИЙТ

ARD КРЕДИТ ББСБ
 МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД
 МОНГОЛЫН STOCK EXCHANGE
 100.0% 273.5
 2018-11-29 107.5
 39,141.4
 БҮРТГЭВ-02

Орлогын хувьд тайлант онд Ард Санхүүгийн Нэгдэл нь 2.1 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны орлоготой, 5.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн өсөлттэй ажиллаж, үүнээс 5.7 тэрбум төгрөг нь ашгаар бүртгэгдсэн байна.

Хүснэгт 26. Орлогын тайлан (аудитлагдсан, сая төгрөг)

	2015	2016	2017
Борлуулалтын орлого	11,831.4	11,795.1	2,088.0
Борлуулалтын өртөг	11,684.8	10,013.1	-
Нийт ашиг	146.6	1,782.0	2,088.0
Татварын дараах цэвэр ашиг	(689.6)	746.0	1,023.8
Хөрөнгө оруулалтын үнэ цэнийн өсөлт	-	3,010.5	5,500.8
Хойшлогдсон татварын зардал	-	302.6	858.5
Бусад дэлгэрэнгүй орлого	(689.6)	3,453.8	5,666.2

ARD | ДААТГАЛ
 SINCE 1994

Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани

“Ард Даатгал” ХХК нь 1994 онд үүсгэн байгуулагдсан Монголын анхны хувийн даатгалын компани юм.

2017 оны байдлаар компани нь 63,633 харилцагчдад 13 төрлийн ердийн даатгалын үйлчилгээг үзүүлсэн байна. Одоогоор компани нь 24 салбар, 238 төлөөлөгч, 100 гаруй ажиллагсадтайгаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж байна. “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь тус компанийн 95.31 хувийг эзэмшдэг.

Сүүлийн үеийн үйл явдал


- Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт онцгой анхаарч, 500 мянган төгрөг хүртэлх нөхөн төлбөрийг ажлын 3 өдөрт багтаан шийдвэрлэж байна.
- Цаашид даатгуулагчдын цагийг хэмнэн интернет орчинд ашиглах боломжтой нөхөн төлбөрийн үйлчилгээг шуурхай үзүүлэх цахим программ үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна.
- 2018 онд Ард Даатгал нь хэлбэрээ өөрчлөн Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлж нээлтэй хувьцаат компани болохоор шийдвэрлэсэн байна.

Санхүүгийн үзүүлэлт

Хүснэгт 27. Ард Даатгал ХХК-ийн санхүүгийн үзүүлэлт (сая төгрөг)

Үзүүлэлт	2015	2016	2017
Хөрөнгө	8,759	9,541	11,727
Өр төлбөр	4,947	5,299	6,490
Эздийн өмч	3,811	4,242	5,237
Нийт хураамжийн орлого	9,160	7,172	10,355
Цэвэр ашиг	(139)	431	1,124

- Ард Даатгал нь тайлант хугацаанд 10.4 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажилласан



000051



С Үнэт цаасны танилцуулга
2019.01.09
БҮРТГЭВ-02

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРГЭЭ
МОНГОЛЫН КРЕДИТ ББСБ
2019 11 29
БҮРТГЭВ-02

- бөгөөд энэ нь өмнөх оноос 44.4 хувиар өссөн үзүүлэлт юм.
- 2017 онд нийт 3,408 даатгуулгчид 4.1 тэрбум төгрөгийн хохирлыг төлж барагдуулан даатгалын гэрээний үүргээ нэр төртэйгээр биелүүллээ.
 - Нийт ашгийн хувьд 1.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, өөрийн хөрөнгийн өгөөж 23.7 хувьтай гарлаа.



Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани

“Монгол Шуудан” ХК нь 1921 онд байгуулагдсан Монгол Улсын өнцөг булан бүрийг холбосон дэд бүтэцтэй шуудангийн байгууллага юм. Компани нь одоогоор 283 салбар нэгжээр дамжуулан 913 ажилчинтайгаар шуудангийн 20 гаруй нэр төрлийн үйлдвэрлэл үйлчилгээг хүргэж байна. “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь 2016 онд “Монгол Шуудан” ХК-г хувьчлагдах үед нь худалдан авсан бөгөөд 2017 оны жилийн эцсийн байдлаар 29.16 хувийг эзэмшиж байна.

Сүүлийн үеийн үйл явдал

- “Монгол Шуудан” ХК нь логистик үйлчилгээний бизнесийг хөгжүүлэх зорилтын хүрээнд дотоод болон хил дамнасан и-худалдаа буюу транзит шуудангийн үйлчилгээг нэвтрүүлсэн байна.
- Шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хүрээнд банкуудын карт, цахим иргэний үнэмлэх, гадаад паспорт торгуулийн хуудас зэргийг харилцагчийн гарт хүргэж байна.
- Орчин үеийн шуудангийн салбарын өнгө төрхийг тодорхойлох зорилгоор шуудангийн үйлчилгээний жишиг салбар байгуулсан.
- Хэвлэл захиалгыг боловсронгуй болгох зорилгоор postnews.mn сайтыг ашиглалтад оруулав.

Санхүүгийн үзүүлэлтүүд

Хүснэгт 28. Монгол шуудан ХК-ийн санхүүгийн үзүүлэлт (сая төгрөг)

Үзүүлэлт	2015	2016	2017
Хөрөнгө	15,296	28,059	40,852
Өр төлбөр	1,686	7,551	19,435
Эздийн өмч	13,610	20,508	21,417
Орлого	9,971	10,879	12,117
Цэвэр ашиг	94	1,007	1,224

Компани нь 2017 онд 12.1 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан бөгөөд энэ нь өмнөх оноос 11.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Нийт ашгийн хувьд 1.2 тэрбум төгрөгт хүрснээр өөрийн хөрөнгийн өгөөж 5.4 хувьтай гарсан байна.



Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани

“Ард Секюритиз ҮЦК” ХХК нь 1997 онд үүсгэн байгуулагдсан Монгол Улсын" ууган үнэт цаасны компаниудын нэг юм. Компани нь хувьцаа, бонд, хөрөнгө оруулалтын зөвлөх зэрэг үнэт цаасны зах зээлтэй холбоотой цогц үйлчилгээг харилцагчиддаа хүргэдэг. “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь Ард Секюритиз компанийг 100 хувь эзэмшдэг.

Сүүлийн үеийн үйл явдал

- 2017 онд Ард Секюритиз ҮЦК нь нийтдээ 18.4 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийсэн.




000052





2018-11-29



- Компанийн нийт харилцагчдын тоо 14,991-д хүрсэн байна.
- 2017 онд Ард Секюритиз УЦК нь санхүү, барилга, тээврийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, компаниудад 6.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хаалттай бонд гаргах замаар амжилттай босгож өгсөн.
- “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” хаалттай ХК-г “Жинст Увс” ХК-тай нэгтгэн Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлсэн бөгөөд энэ нь үнэт цаасны зах зээлд цаашид нэгдэж, нийлэх томоохон туршлагыг бий болгосон.

Санхүүгийн үзүүлэлт

Хүснэгт 29. Ард Секюритиз УЦК ХХК-ийн санхүүгийн үзүүлэлт (сая төгрөг)

Үзүүлэлт	2015	2016	2017
Хөрөнгө	5,747	3,189	3,489
Өр төлбөр	5,700	1,466	1,344
Эздийн өмч	47	1,723	2,145
Орлого	218	547	396
Цэвэр ашиг	66	175	(79)

2017 онд Ард Секюритиз УЦК-ийн нийт хөрөнгө 3.5 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 9.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Орлогын хувьд 396 сая төгрөгийн орлоготой ажиллаж, 79 сая төгрөгийн алдагдал хүлээсэн байна. Энэ нь ажилчдын цалин, урамшуулал нэмэгдсэн болон үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн өнгөрсөн оноос 177 хувиар буурсантай холбоотой юм.



МЕНЕЖМЕНТ КОМПАНИ

Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани

“Ард Менежмент УЦК” ХХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг болно. 2014 онд “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь Ард Менежментийг худалдан авч 100 хувь эзэмших болсон.

Сүүлийн үеийн үйл явдал

Ард Менежмент УЦК нь “Үндэсний Хувьчлалын Сан” хаалттай хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулахаар холбогдох бичиг баримтыг бэлтгэж байна. Уг хөрөнгө оруулалтын сан нь улс орны эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг компаниудын төрийн өмчийн хувьчлалд оролцох, Монголын Хөрөнгийн Биржид арилжаалагдаж буй нээлттэй хувьцаат компанийн хувьцаа болон бонд зэрэгт хөрөнгө оруулалт хийх зорилготой болно.

Санхүүгийн үзүүлэлт

2017 онд Ард Менежментийн хөрөнгө 480 сая төгрөгт хүрсэн бөгөөд нийт ашиг 75 сая төгрөг байна.


Хүснэгт 30. Ард Менежмент УЦК-ийн санхүүгийн үзүүлэлт (сая төгрөг)

Үзүүлэлт	2015	2016	2017
Хөрөнгө	107	532	480



000053





Үнэт цаасны танилцуулга

№ Өр төлбөр	8	31	12
Эздийн өмч	100	501	168
Орлого (бусад дэлгэрэнгүй)	0	120	165
Ашиг (нийт дэлгэрэнгүй)	0	102	75



Жинст Увс Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани

2016 онд Ч.Ганхуягийн эхлүүлсэн фэйсбүүк хөдөлгөөнд нэгдсэн 560 иргэн “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” хаалттай ХК-г үүсгэн байгуулсан. Компани нь Монгол Улсын иргэн бүрийг хөрөнгө оруулагч болгон эх орондоо бүтээгдэж буй баялагаас хувь хүртэх боломж олгох зорилготойгоор үүсгэн байгуулагдсан юм. Компани нь одоогоор бизнесийн зөвлөгөө өгөх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Засгийн Газрын Үнэт Цаас, “Монгол Шуудан” ХК, “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК болон “Ард Даатгал” ХХК зэрэг компаниудад хөрөнгө оруулалт хийж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг хүртсэн байна.

Сүүлийн үеийн үйл явдал

“Хөрөнгө Оруулагч Үндэстэн” ХК нь 2017 оны 12 сарын 15-ны өдөр “Жинст Увс” нээлттэй ХК-тай урвуу хэлбэрээр нэгдэн МХБ дээр бүртгүүлэн, хувьцаа нь нээлттэй арилжаалагдах болсон байна. Ингэснээр тус компанийн хувьцааны ханш 2017 оны 1,858 төгрөгт хүрч хувьцаа эзэмшигчиддээ 85.5 хувийн өгөөжийг олгож чадлаа. Тайлант онд компанийн зах зээлийн үнэлгээ 3.1 тэрбум төгрөг хүрээд байна. Нэгдлийн үр дүнд “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” ХК нь “Жинст Увс” ХК нэртэй болсон байна.

Санхүүгийн үзүүлэлт

Хүснэгт 31. Жинст Увс ХК-ийн санхүүгийн үзүүлэлт (сая төгрөг)


Үзүүлэлт	2015	2016	2017
Хөрөнгө	10	11	2,712
Өр төлбөр	10	14	216
Эздийн өмч	-	(3)	2,496
Орлого (бусад дэлгэрэнгүй)	-	-	923
Ашиг (нийт дэлгэрэнгүй)	(114)	(3)	857

2017 онд “Хөрөнгө Оруулагч Үндэстэн”/ “Жинст Увс” ХК-ийн нийт хөрөнгө 2.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 247 дахин нэмэгдсэн байна. Мөн үйл ажиллагаа явуулдаггүй байсантай холбоотой 2016 онд орлогогүй байсан бол 2017 онд хөрөнгө оруулалтаас 183.6 сая төгрөгийн ашиг хэрэгжүүлсэн байна. Үүний 148.7 сая төгрөг нь “Монгол Шуудан” ХК болон “Ард Даатгал” ХХК-ийн хөрөнгө оруулалтаас олсон орлого бол 34.9 сая төгрөг нь Ард Холдингсийн хувьцаа худалдсантай холбоотой ашиг юм. Компани нь 2017 оны жилийн эцсээр 857 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.



ЛАЙФ КОМПАНИ


Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани



“Ард Лайф” ХХК нь 2007 онд байгуулагдсан бөгөөд анх үүсгэн байгуулагдахдаа албан байгууллагуудтай хамтран ажиллаж, тэдгээрийн хүний нөөцийн бодлоготой уялдуулан

000054





Үнэт цаасны танилцуулга



ажиллагедын тэтгэврийн санг үүсгэх зорилготой байсан билээ. Ингэснээр компаниудын ажиллагсад тэтгэврийн насанд хүрээд нэмэлт орлоготой, сэтгэл хангалуун амьдрах боломжтой болох юм. Одоогоор Ард Лайфын хамт олон тэтгэврийн сангийн талаар мэргэшсэн зөвлөгөө өгч, тэтгэврийн хуримтлалын чиглэлээр хувь хүн болон албан байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь “Ард Лайф” ХХК-г 100 хувь эзэмшдэг болно.

Сүүлийн үеийн үйл явдал

- Ард Лайф нь анх зөвхөн компанийн ажилчдад зориулан тэтгэврийн сангийн бүтээгдэхүүнийг санал болгодог байсан бол үйл ажиллагаагаа өргөжүүлэн бусад иргэд, аж ахуй нэгжүүдэд хувийн тэтгэврийн сангийн бүтээгдэхүүнээ санал болгох болсноор харилцагчдын тоо 1,000-д хүрсэн байна.
- Бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалтай тэтгэврийн хуримтлалын бүтээгдэхүүнийг хослуулан хүргэж байна.

Санхүүгийн үзүүлэлт

Хүснэгт 32. Ард Лайф ХХК-ийн санхүүгийн үзүүлэлт (сая төгрөг)

Үзүүлэлт	2015	2016	2017
Хөрөнгө	401	4,038	5,382
Өр төлбөр	401	3,846	,221
Эздийн өмч	(0.4)	19	1,161
Хөрөнгө оруулалтын өгөөж	-	-	339
Цэвэр ашиг	(0.5)	216	(147)
Хуримтлагдсан ашиг	(10)	1,827	(188)

2017 оны байдлаар компани нь 5.4 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байгаа бөгөөд энэ нь өмнөх оноос 33.3 хувиар өссөн үзүүлэлт юм байна. Харин хөрөнгө оруулалтын өгөөжийн хувьд 339 сая төгрөг хүрсэн байна.



Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани

“Ард Актив” ХЗХ нь 2008 онд үүсгэн байгуулагдсан, 922 гишүүнтэй Монгол Улсын томоохон хадгаламж зээлийн хоршоодын нэг юм. Ард Актив нь банкуудын хадгаламжтай өрсөлдөхүйц хүүтэй хадгаламж, зээлийн бүтээгдэхүүнийг гишүүддээ санал болгохоос гадна мөнгөн шилжүүлэг, бэлэн төлбөр тооцоо зэрэг банкны санхүүгийн байгууллагын цогц үйлчилгээг нэг доороос үзүүлж байна.

Сүүлийн үеийн үйл явдал

Ард Актив нь үнийн дүнгийн хязгааргүй даатгагдсан хадгаламжтай анхны хоршоо болсон. Ингэснээр гишүүдийнхээ хадгаламжийн эрсдэлийг бууруулсан.

Бүтээгдэхүүн үйлчилгээгээ шинэчлэн, хадгаламжийн хүүгээ жилийн 16.5 хувь болгож, зээлийн хүүгээ сарын 2.5-3 хувь болгосон.

Санхүүгийн үзүүлэлт

Хүснэгт 33. Ард актив ХЗХ-ийн санхүүгийн үзүүлэлт (сая төгрөг)



000055



СЭҮНэт цаасны танилцуулга
 2019-01-09
 БҮРТГЭВ
 № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ХҮҮ
 MONGOLIAN STOCK EXCHANGE
 ARD КРЕДИТ ББСБ
 2018-11-29
 БҮРТГЭВ-02

Үзүүлэлт	2015	2016	2017
Хөрөнгө	542	629	1,393
Өр төлбөр	407	497	1,128
Эздийн мч	135	132	264
Орлого	81	132	219
Цэвэр ашиг	(20)	(10)	2

2017 онд нийт хөрөнгө 1.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 124.5 хувиар өссөн бол нийт орлогын хувьд 219 сая төгрөгт хүрч, 2017 оноос ашигтай ажиллаж эхэлсэн байна.



Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани

“Тэнгэр Системс” ХХК нь 2007 онд байгуулагдсан программ хангамж боловсруулах, програмын засвар үйлчилгээ, түрээс, зөвөлгөө өгөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. “Тэнгэр системс” ХХК нь “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн 100 хувийн охин компани юм.

Сүүлийн үеийн үйл явдал

- Тэнгэр Системс нь хадгаламж зээлийн хоршоо болон банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан Genius Banker программыг амжилттай нэвтрүүлсэн байна.
- Их Британид үүсгэн байгуулагдсан дэлхийн хаягжилтийн шинэлэг системийн стартап компани болох what3words-ын Монгол дахь албан ёсны төлөөлөгчөөр ажиллаж байна.
- 2017 онд Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон салбар компаниудад дижитал маркетинг, дизайны шийдлийн үйлчилгээг үзүүлж эхэлсэн байна.

Санхүүгийн үзүүлэлт


Хүснэгт 34. Тэнгэр системс ХХК-ийн санхүүгийн үзүүлэлт (сая төгрөг)

Үзүүлэлт	2016	2017
Хөрөнгө	4	65
Өр төлбөр	85	84
Эздийн өмч	(36)	(19)
Орлого	52	116
Цэвэр ашиг	(60)	(56)



Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани

“Крипто Үндэстэн” ХХК нь 2017 онд цахим худалдаа, гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагдсан ба 2.9 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 158 хувьцаа эзэмшигчтэй компани юм. “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь Крипто Үндэстэн компанийн 32.42 хувийг эзэмшдэг юм. Компани нь одоогоор крипто валют олборлох, хөрөнгө оруулалт хийх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд онцлогийн хувьд улирал тутам олборлолтоос олсон цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах бөгөөд биткойноор хувьцаа эзэмшигчиддээ олгож байна. Тухайлбал, 2018 оны 3 сарын 30-ны өдрийн компанийн ТУЗ-ийн хурлын шийдвэрээр хөрөнгө оруулалтын нэг нэгжид 0.0119 биткойн хуваарилахаар шийдвэрлэсэн. Биткойны үнэ ханш хэдий доогуур байгаа ч төгрөгөөр тооцсон өгөөж нь дотоодын арилжааны банкуудын дундаж



000056





хадгаламжийн хүүгээс давсан үзүүлэлттэй байна.



Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани

“Номын Хишиг” ХХК нь 2011 онд байгуулагдсан ба хэвлэлийн үйл ажиллагаа, гадаад, дотоод худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. “Номын Хишиг” ХХК нь Улаанбаатар хотын төвд Сүхбаатар дүүрэг 2,304 м2 талбай бүхий 2 давхар үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг болно. “Номын Хишиг” ХХК-ийн 20 хувийг “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК эзэмшдэг юм.

IET

Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани

Техник Технологийн Дээд Сургууль


Техник технологийн дээд сургууль анх 1984 онд Барилгын 5-р ТМС нэртэйгээр байгуулагдсан. Тус сургууль нь байгуулагдсан цагаасаа хойш нийт 12,400 инженер, техникийн ажилтан бэлтгэн гаргаж улс орныхоо хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулан ажиллаж байна. Шаталсан сургалтын тогтолцоогоор дамжуулан барилга, архитектур, зам гүүр, сантехник, механик, цахилгаан хангамж, хүнсний технологи зэрэг мэргэжлээр мэргэжилтэй ажилтан, техникч болон инженерийн боловсрол олгож байна. Мөн ТТДС нь Сургууль-Бизнесийн байгууллагын түншлэлийг хөгжүүлж, шинжлэх ухааны ололт амжилтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, зам гүүр, барилга, эрчим хүч, хөдөө аж ахуйн инновацийг дэмжих үүднээс сургуулийнхаа дэргэд Технологи нэвтрүүлэх төвийг байгуулсан.

1.13. Ногдол ашгийн бодлого

КТХ-ийн 46.1, Компанийн дүрмийн 8.11.8 дах заалтыг үндсэн Ард Кредит ББСБ-ын ТУЗ нь хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг гаргадаг. Ард Кредит ББСБ нь МХБ-д бүртгэгдэж, нээлттэй хувьцаат компани болсноор хувьцаа эзэмшигчдийн анхдугаар хурлаар доорх “ногдол ашгийн бодлого”-ын төслийг батлахаар төлөвлөж байна. Ногдол ашгийн бодлогын төслийн хураангуйг хүргэж байна.


Ногдол ашгийн бодлогын төслийн хураангуй:

- 1) КТХ-ийн 47.1-д заасны дагуу ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх.
- 2) Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх.
- 3) Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүгдийг нь эргүүлэн авсан байх.
- 4) Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь 25-аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашгаа төлж дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийг бичгээр мэдэгдэх үүргийг гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.
- 5) Компанийн санхүүгийн байдлаас шалтгаалан жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас ногдол ашигт хуваарилна. Хуваарилах дүн нь компанийн тухайн жилийн цэвэр ашгийн 20 хувиас 50 хувь байна.
- 6) Бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх хүртэлх хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусад шилжүүлсэн тохиолдолд уг хувьцаанд ногдох ногдол ашгийг авах эрх нь хувьцаа эзэмшигчдэд үлдэнэ.



000057





7) Хувьцаа эзэмшигчдэд төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг төлбөл зохих өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгаж, ногдол ашиг төлж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр өглөгийн бүртгэл тусгайлан бүртгэнэ.

2. БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1. Макро эдийн засгийн төлөв

2.1.1. Дэлхийн ба хөрш улс орнуудын эдийн засаг

Дэлхийн Банкны 2018 оны 1 сард гаргасан Global Economic Prospects судалгаанд "...хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, худалдаа сэргэснээр дэлхийн эдийн засаг өсөлтийн мөчлөгт ороод байна..." хэмээн дурджээ. Мөн уг судалгаанд үргэлжлүүлэн "энэхүү өсөлт нь санхүүгийн тогтвортой орчин, бизнесийн өндөр итгэл, өсөж буй таваарын үнийн үед таарч байна. Дэлхийн нийт ДНБ-ийн өсөлт 2016 онд 2.4 хувьтай байсан бол 2017 онд 3.0 хувь хүрч Дэлхийн Банкны таамаглал болох 2.7 хувийг давлаа. Энэхүү өсөлт нь өргөн суурьтай ба дэлхийн улс орнуудын талаас илүү хувь нь эдийн засгийн өсөлт үзүүлж, хөрөнгө оруулалт сэргэж, санхүүжилтийн зардал буурч, компаниудын ашиг нэмэгдэж, хөрөнгө оруулагчдын итгэл сэргэсэн нь хөгжингүй болон хөгжиж буй улсуудын эдийн засгийн өсөлт нэмэгдэхэд нөлөөллөө. Энэхүү хөрөнгө оруулалтын өсөлт нь богино хугацаандаа экспорт болон импортод дэмжлэг үзүүлэхээр байна" гэжээ.

Хөгжингүй орнуудад капитал хөрөнгө оруулалт өссөнөөр 2017 онд эдийн засаг 2.3 хувиар өссөн байна. Хөгжиж буй орнуудын эдийн засаг 2017 онд 4.3 хувиар өссөн нь уул уурхайн түүхий эдийн үнэ олон улсын зах зээлд өссөн, түүхий эд импортлогч орнуудын эдийн засгийн өсөлт тогтвортой хадгалагдсан зэргээс шалтгаалсан байна. Хөгжиж буй орнуудын эдийн засгийн энэхүү өсөлт нь Бразил, ОХУ зэрэг улсууд эдийн засгийн уналтаас гарсан, уул уурхайн түүхий эдийн үнэ сэргэсэн, хөрөнгө оруулагчдын итгэл сэргэсэн, өнгөрсөн эдийн засгийн хямралын үед хэрэгжүүлсэн хатуу бодлогын нөлөө арилж буй үед тохиож байгаа юм.

Дэлхийн нийт эдийн засгийн өсөлт 2018 онд 3.1 хувь хүрч, 2019-2020 онд 3.0 хувьд тогтворжино хэмээн Дэлхийн Банк тооцоолж байна. Үүнд уул уурхайн түүхий эд экспортлогчдын эдийн засаг тэлснээр хөгжиж буй улс орнуудын эдийн засгийн өсөлт 2018 онд түргэсэж 4.5 хувь хүрч, 2019-2020 онуудад 4.7 хувьд хүрнэ, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт бага зэрэг удаахрах боловч бусад томоохон эдийн засгийн өсөлт чангарч уг нөлөөг давах болно хэмээжээ. Хөгжингүй орнуудын эдийн засаг 2018 онд 2.2 хувиар, 2019-2020 онуудад тус тус 1.9 болон 1.7 хувиар өснө хэмээн тооцоолсон байна.

Нөгөөтээгүүр дэлхийн эдийн засгийн төлөв байдалд тодорхой эрсдэлүүд байсаар байна. Дэлхийн санхүүжилтийн орчин огцом муудах, санхүүгийн зах зээлийн хэлбэлзэл нэмэгдэх нь эдийн засгийн энэ тэлэлтийг хойш татах эрсдэлтэй. Мөн чөлөөт худалдааг хязгаарлах, геополитикийн сөргөлдөөн улам бүр нэмэгдэх нь эдийн засгийн үйл ажиллагаа, итгэлийг бууруулах магадлалтай юм.


Хүснэгт 35. Улс орнуудын эдийн засгийн өсөлтийн хувь

	2015	2016	2017	2018*	2019*	2020*
Дэлхий	2.8	2.4	3	3.1	3	2.9



000058





Хөгжингүй орнууд	2.2	1.6	2.3	2.2	1.9	1.7
АНУ	2.9	1.5	2.3	2.5	2.2	2.2
Евро бүс	2.1	1.8	2.4	2.1	1.7	1.5
Япон	1.4	0.9	1.7	1.3	0.8	0.5
Хөгжиж буй орнууд	3.6	3.7	4.3	4.5	4.7	4.7
ОХУ	-2.8	-0.2	1.7	1.7	1.8	1.8
БНХАУ	6.9	6.7	6.9	6.4	6.3	6.2

Эх сурвалж: Дэлхийн Банк

БНХАУ: БНХАУ-ын эдийн засаг 2018 оны I улиралд 6.8 хувиар өсөж Дэлхийн Банкны таамаглалыг давсан байна. 2017 онд Дэлхийн Банк Хятадын ДНБ-ий өсөлтийг 6.4 хувь байна хэмээн тооцоолж байсан бол 2018 онд мөн адил хувьтай байна хэмээн тооцжээ. Ажиглагчид БНХАУ эдийн засгийн өсөлтөө зориудаар хязгаарлаж, санхүүгийн эрсдэлээс сэргийлэх бодлого барьж буйг илтгэж байна хэмээн үзжээ. Хятадын Засгийн газраас эдийн засаг дахь эрсдэлийг бууруулах зорилгоор төсвийн алдагдлыг 2018 онд ДНБ-ий 3.5 хувьд хүргэж бууруулахаар байгаа нь нэг талаас аж үйлдвэр болон үл хөдлөх хөрөнгийн салбарт дунд хугацаанд сөрөг нөлөөтэй боловч нөгөө талаас дэд бүтцийн хөрөнгө оруулалтын төсвийг 30 тэрбум юаниар нэмэгдүүлэх, татварын хөнгөлөлт нэвтрүүлэх зэрэг арга хэмжээнүүд хүлээгдэж байгааг Хятадын Сангийн Сайд 2018 оны 3-р сард олон нийтэд хийсэн мэдэгдэлдээ онцоллоо. 2018 оны 3 сарын 5-ны өдөр зохион байгуулагдсан Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн их хурлын үеэр Хятадын ерөнхий сайд Ли Кэчянь Хятад улс нүүрс олборлолтоо 2018 онд 150.0 сая тонн, гангийн үйлдвэрлэлийг 30.0 сая тонноор тус тус бууруулах болсныг зарласан. Нүүрс олборлолтыг өнгөрсөн онд мөн ийм хэмжээгээр бууруулж байсан юм. Энэ нь агаарын бохирдолтой тэмцэх урт хугацааны төлөвлөгөөний хүрээнд хэрэгжиж буй ажил юм.

ОУВС-гийн шинжээчдийн тооцоолсноор Хятад өрхийн, компанийн болон Засгийн газрын зээл 2022 он гэхэд ДНБ-ий 300.0 хувьд хүрч нэмэгдэхээр байгаа нь бизнес эрхлэгчид болон банкны салбарт тогтворгүй байдал бий болгох эрсдэлтэй тул өрийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх шаардлагатайг анхааруулсаар байна.

ОХУ: ОХУ-ын эдийн засаг 2017 онд 1.5 хувиар өссөн бол 2018 оны I улиралд 1.6 хувиар буюу хүлээлтээс доогуур өсөв. 2018 оны I улиралд нийт хөрөнгө оруулалт 3.6 хувиар, өрхийн хэрэглээ 3 хувиар тус тус өсч эдийн засагт эерэг нөлөө үзүүлжээ. Түүнчлэн газрын тосны үнийн өсөлтийн нөлөөгөөр экспорт 17.8 хувиар өсч, урсгал тэнцэл 21.7 хувийн ашигтай гарсан байна. Харин АНУ ОХУ-д тавьсан хоригоо гурав болон дөрөвдүгээр сард чангаруулсан нь хөрөнгө оруулагчдын итгэл сааруулж, хөрөнгө гадагшлах урсгал нэмэгдэх сөрөг нөлөөг үзүүлэв.

Инфляци 2018 оны 3-р сард 2.4 хувьд хүрсэн, төсвийн алдагдал ДНБ-ий 2.0 хувьд, рублийн ханшийн сул түвшин зэргээс шалтгаалан Оросын Төв банк бодлогын хүүгээ 0.25 нэгж хувиар бууруулж 7.5 хувьд хүргэв. 2018 оны 4 сард инфляци 2.4 хувь буюу ОХУ-ын Төв банкны зорилтот түвшин 4 хувиас доогуур хэвээр байгаа, газрын тосны үнэ алгуур өсч, рублийн ханш ялимгүй чангарч эхэлсэн зэргээс харахад Оросын Төв банк 2018 онд бодлогын хүүгээ дахин бууруулах магадлал өндөр байна хэмээн Монгол банкны инфляцийн хүлээлтийн тайланд дурдсан байна.


2.1.2. Олон улсын түүхий эдийн зах зээл

Монгол Улсын эдийн засаг уул уурхайн салбар, түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх эрэлтээс ихээхэн хамааралтай байдаг. 2018 онд уул уурхайн голлох түүхий эдийн үнэ өсөх хандлагатай байгаа бол 2019 оноос алт болон зэсээс бусад түүхий эдийн үнэ бууралттай байхаар байна.



000059





Хүснэгт 36. Голлох түүхий эдийн үнэ (ам.доллар)

	2016	2017	2018*	2019*	2020*
Зэс	4,867.9	6,169.9	7,191.4	7,272.1	7,278.5
Нүүрс	70.6	88.4	97.8	88.2	84.0
Газрын тос	42.8	52.8	61.9	57.0	53.8
Төмрийн хүдэр	57.7	71.8	71.8	65.6	62.0
Цайр	2,090.0	2,890.9	3,523.6	3,400.2	3,186.2
Алт	1,249.0	1,257.6	1,345.1	1,379.3	1,423.4

Эх сурвалж: Блүмберг

Зэс. Дэлхийн зэсийн нийт хэрэглээ 2017 онд 1.3 хувиар өссөн бол 2018 онд 2.9 хувиар өснө гэж шинжээчид төсөөлж байна. Зэсийн нийт хэрэглээний тэн хагасыг эзэлдэг БНХАУ-ын эрчим хүч, барилгын салбарт оруулж буй хөрөнгө оруулалтуудтай холбоотойгоор зэсийн эрэлт нэмэгдэхээр байгаа нь энэхүү таамаглалын үндэс юм. Нөгөө талаас зэсийн томоохон уурхайнуудад (голлон Чили, Перу) "хөдөлмөрийн гэрээ" шинэчлэгдэх хүлээлтээс үүдэн үйл ажиллагааны саатал гарч нийлүүлэлт хумигдах хүлээлтэй холбоотойгоор үнэ өсөх төлөвтэй байна.

Алт. Дэлхийн хамгийн том алт олборлогч БНХАУ-ын Засгийн газраас алтны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа үр ашиг багатай, жижиг уурхайнуудыг хаах шийдвэр гаргаад байгаа нь алтны нийлүүлэлтийн өсөлт саарахад хүргэж байна. Төв банкуудын худалдан авах алтны хэмжээ, жижиглэн хөрөнгө оруулалтууд өсөх төлөвтэй байгаа ба бусад салбарын алтны эрэлт тогтвортой байхаар байгаа нь 2018 онд алтны нийт эрэлтийг 2.3 хувиар өсгөхөөр байна хэмээн *Дэлхийн алтны зөвлөл (WGC), Эдийн засгийн тандалт судалгааны нэгж (EIU)* үзэж байна. Нөгөө талдаа дэлхийн улс төрд тодорхой бус байдал нэмэгдэж, геополитикийн асуудлууд, тэр дундаа АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трампын улс төр, эдийн засгийн гэнэтийн шийдвэрүүд болон АНУ, БНАСАУ-ын харилцаа зэргээс шалтгаалан хөрөнгө оруулагчид алтанд хөрөнгөө байршуулах сонирхол нэмэгдэж байгаа юм.

Нүүрс. Дэлхийн 187 улс орон уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх Парисын хэлэлцээрт нэгдэн орсон бөгөөд үүнээс үүдэн цаашид дэлхийн нүүрсний хэрэглээ буурах хандлагатай байна. Монгол Улсын нүүрсний гол худалдан авагч БНХАУ-ын нүүрсний хэрэглээ 2018 онд бага зэрэг буурах төлөвтэй, учир нь БНХАУ агаарын бохирдолтой тэмцэх зорилгоор хүнд үйлдвэрүүдийнхээ үйл ажиллагааг хязгаарлах арга хэмжээ авч эхлээд байгаа билээ.

Хүснэгт 37. Нүүрсний хэрэглээ (сая тонн)

	2015	2016	2017	2018*	2019*
БНХАУ	3,658.0	3,600.0	3,672.0	3,617.0	3,562.0
Энэтхэг	931.0	965.0	994.0	1,022.0	1,049.0
АНУ	727.0	666.0	660.0	650.0	626.0
ОХУ	237.0	224.0	229.0	233.0	238.0
ХБНГУ	234.0	224.0	217.0	210.0	204.0
Япон	190.0	190.0	188.0	187.0	185.0
Өмнөд Африк	175.0	178.0	180.0	182.0	183.0
БНСУ	133.0	127.0	130.0	130.0	131.0
Польш	134.0	134.0	132.0	130.0	129.0
Австрали	132.0	131.0	131.0	131.0	130.0
Бусад	1,057.0	1,018.0	1,018.0	1,019.0	1,022.0



000060





Нийт	7,608.0	7,455.0	7,549.0	7,511.0	7,461.0
------	---------	---------	---------	---------	---------

2017 онд БНХАУ-ын коксжих нүүрсний импортын хэмжээ 69.9 сая тн-д хүрсэн бөгөөд энэ нь 2016 оноос 17.9 хувиар өссөн үзүүлэлт юм. Нийт коксжих нүүрсний импортын 44.0 хувийг Австрали, 38.0 хувийг Монгол, 7.0 хувийг ОХУ, 6.0 хувийг Канад, 4.0 хувийг АНУ, 1.0 хувийг Индонез улсаас тус тус импортолсон байна.


Хүснэгт 38. БНХАУ-ын коксжих нүүрсний импорт (мянган тонн)

	2015	2016	2017
Австрали	25,870.4	26,819.10	30,978.70
Монгол	12,679.5	23,561.60	26,269.60
Канад	5,711.2	5,188.20	4,252.80
ОХУ	3,228.0	2,620.10	4,620.80
АНУ	115.2	0	2,817.60
Индонез	231	574	714.1
Шинэ Зеланд	276.5	533.7	247.1
Бусад	10	10.5	0
Нийт	48,121.80	59,307.00	69,900.70


Эх сурвалж: sxcoal.com

Газрын тос. Эдийн засгийн хамтын ажиллагаа болон хөгжлийн байгууллага /OECD/-ын гишүүн бус орнуудын газрын тосны хэрэглээ 2018-2019 онуудад нэмэгдэх төлөвтэй байгаагаас шалтгаалж, дэлхийн нийт газрын тосны хэрэглээ 2018 онд 1.8 хувиар, 2019 онд 1.6 хувиар тус тус өсөхөөр байна. ОПЕК-ийн гишүүн болон гишүүн бус улс орнуудын үйлдвэрлэлийн хэмжээ тогтвортой нэмэгдэх хандлагатай байгаа юм. ОПЕК-ийн гишүүн орнуудын үйлдвэрлэлийн хэмжээ 2018 онд 1.1 хувиар, 2019 онд 3.8 хувиар өсөхөөр байгаа бол ОПЕК-ийн гишүүн бус орнуудын үйлдвэрлэл 2018-2019 онд тус тус 2.3 хувиар өсөхөөр байна. Газрын тосны дэлхийн нийт үйлдвэрлэлийн хэмжээ 2018-2019 онд 1.8-1.9 хувиар өсөх таамаглалтай байна. Түүнчлэн, АНУ-ын татварын шинэчлэл газрын тос экспортлогчдын ашгийг нэмэгдүүлэх хүлээлттэй байгаа бөгөөд энэ нь нийлүүлэлтийг нэмэгдүүлэхээр байна хэмээн Олон улсын энергийн агентлаг (IEA), Эдийн засгийн тандалт судалгааны нэгж (EIU) мэдээлжээ.

Төмрийн хүдэр: Хятадын Засгийн газраас өвлийн саруудад нүүрс, гангийн үйлдвэрлэлийг хязгаарласан хориг тавьсан нь ган үйлдвэрлэгчдийн эрэлт нэмэгдэхэд нөлөөлөхөөр байна. Бразил, Австралийн нийлүүлэлт буурсан нь 2018 оны эхний улиралд үнэ өсөхөд нөлөөлсөн гэж үзжээ. “Barclays Plc”-ийн шинжээчдийн үзэж буйгаар Хятадын Засгийн Газраас хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд гангийн үйлдвэрүүдийн ашиг буурч компаниуд үйлдвэрлэлийн хэмжээгээ танахаар байна. Австралийн Нөөц Эрчим хүчний байгууллагын тооцооллоор Бразилын “Vale”, “Minas Rio” уурхайн өргөтгөлийн ажил дуусаж 2019 он хүртэл жилийн үйлдвэрлэлээ 17.0-26.5 сая тонноор нэмэгдүүлэх, “ВНР” компани жилийн үйлдвэрлэлээ 2018 он дуустал 275.0-280.0 сая тоннд хадгалахаар байгаа зэргээс шалтгаалан цаашид нийлүүлэлт нэмэгдэж үнэ буурах төлөвтэй байна.



000061





Макро эдийн засгийн тогтвортой байдалд эдийн засгийн тогтвортой өсөлт, тогтвортой

түвшний инфляци, гадаад валютын нөөцийн хүрэлцээ, валютын ханшийн тогтвортой байдал зэргийг ойлгоно. Өөрөөр хэлбэл, энэхүү тогтвортой байдал хангагдсанаар хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдэж, ГШХО-ын дотогшлох урсгал нэмэгдэхэд эерэг нөлөө үзүүлдэг. МУ-ын Засгийн Газар ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” - ийн хүрээнд төсвийн сахилга батыг сайжруулж, нэгдмэл байдлыг хангах, өрийн дарамтыг бууруулж, төлбөрийн тэнцлийн алдагдлыг багасгахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлж байна. Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн ажлын хэсэг 2018 оны 7 сарын 25-аас 8 сарын 6-ны өдрүүдэд ажиллаж, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тав дахь шатны үнэлгээг хийсэн байна. Үүнд, Санхүүгийн салбарыг чадавхжуулж, шинэчлэх зорилготой бодлого болон бүтцийн өөрчлөлтийн хувьд томоохон ахиц ажиглагдсан. Макро эдийн засгийн бодлогын хүрээнд хэлэлцээрүүд ойрын хугацаанд үргэлжилнэ хэмээжээ. Хэдийгээр дээрх дэвшилүүд гарсан ч түүхий эдийн эрэлт буурах, бүтцийн шинэчлэлийн удаашрал, дотоодын зарлага нэмэгдэх, хөрөнгө оруулалтын орчин дахь сөрөг өөрчлөлтүүд зэрэг эрсдэлүүд байсаар байна. Хөтөлбөрийг амжилттай үргэлжлүүлэхийн тулд банкны системийг бэхжүүлэх, төсвийн хянамгай бодлого баримтлах, инфляцийг анхааралтай ажиглах, эрсдэлээс хамгаалах гадаад валютын албан нөөцийг үргэлжлүүлэн бүрдүүлэх, төсвийн санхүүгийн удирдлагыг сайжруулах зэрэг асуудлуудад хандуулах анхаарлаа бууруулж болохгүй хэмээн дүгнэсэн байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн

2012 оноос Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн хурд тасралтгүй саарч байсан бол 2017 онд эдийн засаг эрчимжиж, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 5.1 хувьд хүрсэн байна. Энэхүү өсөлтөд уул уурхайн бус салбарын өсөлт голлон нөлөөлсөн байна. Хэдийгээр 2017 онд уул уурхайн түүхий эдийн гадаад орчин сайжирч алт, нүүрс зэрэг ашигт малтмалын үнэ нэмэгдсэн боловч Оюу Толгой уурхайн зэсийн баяжмал дахь алтны агууламж буурснаар уул уурхайн салбарын үйлдвэрлэл өмнөх жилтэй харьцуулахад 6.9 хувиар буурсан байна. 2018-2020 онд уул уурхайн томоохон төслүүдийн бүтээн байгуулалт үргэлжлэн хэрэгжсэнээр уул уурхайн салбарын өсөлт 2019 онд 8.2 хувь, 2020 онд 9.9 хувьд тус тус хүрнэ хэмээн ОУВС болон Сангийн Яам үзэж байна. Уул уурхайн салбарын өсөлтийн нөлөөгөөр уул уурхайн бус ДНБ-ий хэмжээ 2018 онд 6.3 хувь, 2019 онд 5.8 хувь, 2020 онд 3.7 хувиар тус тус өсөхөөр байна гэжээ. Цаашид Монгол Улсын эдийн засгийн өсөлт дунд хугацаандаа харьцангуй тогвортой байж, хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх төлөвтэй байна.

Хүснэгт 39. Монгол Улсын ДНБ

	2015	2016	2017	2018*	2019*	2020*
Нэрлэсэн ДНБ (тэрбум төгрөг)	23,150.0	23,935.0	27,167.0	30,662.0	34,383.0	38,019.0
ДНБ-ий бодит өсөлт (хувь)	2.4	1.2	5.1	5.0	6.3	5.0
Уул уурхайн ДНБ-ий бодит өсөлт (хувь)	14.1	0.2	(6.9)	6.0	8.2	9.9
Уул уурхайн бус ДНБ-ий бодит өсөлт (хувь)	(1.0)	1.6	9.0	6.3	5.8	3.7

Эх сурвалж: Сангийн Яам, ОУВС



Мөнгөний нийлүүлэлт

000062



Үнэт цаасны танилцуулга
 он 2019-01-09
 БҮРГЭВ-02


ARD КРЕДИТ ББӨБ 29
 БҮРГЭВ-02

2017 онд Монголбанк бодлогын хүүгээ 2 удаа бууруулж, 11 хувьд хүргэсэн, мөн мөнгөний нийлүүлэлт нэмэгдэж өмнөх жилтэй харьцуулахад 30.5 хувиар өссөн зэрэг нь мөнгөний бодлогын төлөв зөөлрөх чиглэлд явж байгааг харуулж байна. Энэ нь эдийн засгийн өсөлт, бизнесийн идэвхжил, ажил эрхлэлт, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх юм. 2018 оны хагас жилийн байдлаар бодлогын хүү 10 хувьд хүрч, мөнгөний нийлүүлэлт буюу M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 28.6 хувиар өсч 17.3 их наяд төгрөг боллоо. M2 мөнгөний жилийн өсөлтийн 72.4 хувийг төгрөгийн харилцах, хадгаламж; 28.1 хувийг валютын харилцах, хадгаламж; (0.5) хувийг банкнаас гадуурх мөнгө бүрдүүлжээ.

График 11. Мөнгөний нийлүүлэлт (их наяд төгрөг)




График 10. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц



Энэхүү эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд банкуудын бусдаас татсан харилцах, хадгаламж нэмэгдсэнтэй холбоотой юм. Тухайлбал, нийт хадгаламжийн хэмжээ 11.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 24.4 хувиар нэмэгдсэн байна. Нийт хадгаламжийн 84.0 хувь нь буюу 9.9 их наяд төгрөг нь иргэдийн, 16.0 хувь буюу 1.8 их наяд төгрөг нь байгууллагын хадгаламж байна. Иргэдийн хадгаламжийн 19.0 хувийг, байгууллагын хадгаламжийн 32.0 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна. Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдээс хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө өмнөх сарын мөн үеэс 2.9 хувиар буурчээ.

График 12. Санхүүгийн байгууллагын зээлийн үлдэгдэл (их наяд төгрөг)



Эх сурвалж: Монголбанк


2018 оны хагас жилээр санхүүгийн байгууллагуудын олгосон зээлийн үлдэгдэл 18.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 17.7 хувиар өссөн байна. Нийт санхүүгийн байгууллагын зээлийн үлдэгдлийн 85.5 хувь нь хадгаламжийн байгууллагаас олгосон зээл байна.



000063




График 13. Санхүүгийн байгууллагын чанаргүй зээл (их наяд төгрөг)



Эх сурвалж: YCX

бусад салбаруудад хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ дорвитой буурахгүй байгааг Монголбанкны 6 сарын мөнгөний тоймд дурджээ.

График 14. Зээлийн өсөлт ба чанаргүй зээлийн хувь



Эх сурвалж: YCX

Нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2018 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 4.14 их наяд төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 4.13 их наяд төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 12.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. Төсвийн орлогын төлөвлөгөө даван биелж, түүнчлэн төсвийн зарлага санхүүжилтийг хатуу хяналттай гаргаснаар төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ДНБ-ий 0.1 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай гарсан.

График 15. Нэгдсэн төсөв (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Монголбанк, YCX


Улсын өр төлбөртэй холбоотойгоор зээлийн хүүний зардал нэмэгдэж байгаа бөгөөд 2018 оны эхний хагас жилийн байдлаар тэнцвэржүүлсэн орлогын 13.2 хувьтай тэнцэх хэмжээний мөндийг хүүгийн зардалд төлөөд байна. Монгол Улсын Засгийн газар 2018 онд үндсэн төлбөр 2.6 их наяд, хүүгийн төлбөр 1.2 их наяд төгрөг буюу нийт 3.8 их наяд төгрөгийн өр төлбөр төлөх шаардлагатай. 6 сард 753.3 тэрбум төгрөгийн гадаад, дотоод өрийг хуваарин дагуу төлж

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 116.7 хувь буюу төсвийг тодотголоос 0.6 их наяд төгрөгөөр давж биелсэн. Нийт тэнцвэржүүлсэн орлогын 88.4 хувийг татварын орлого, 11.6 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна. Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн зарлага ба цэвэр зээл 76.7 хувь буюу 4.13 их наяд төгрөгийн гүйцэтгэлтэй гарлаа. Сүүлийн жилүүдэд Монгол



000064





барагдуулаад байна. Ингэснээр 2017 оны эцэст 22.7 их наяд төгрөг байсан Монгол Улсын Засгийн газрын өр 2018 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 21.1 их наяд төгрөг болж буурлаа. Он гарснаар Засгийн Газар 2012 онд Олон Улсын зах зээл дээр гаргасан 500.0 сая ам.долларын Чингис бонд болон 2015 онд гаргасан 1.0 тэрбум юаний ДимСам бондын төлбөрүүдийг бүрэн барагдууллаа.

Төлбөрийн тэнцэл болон ГШХО


2018 оны эхний 6 сард төлбөрийн тэнцэл 135.2 сая ам.долларын алдагдалтай гарч алдагдал өмнөх оны мөн үеэс 61.2 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна. Экспортын дийлэнх бүтээгдэхүүний орлого нэмэгдэж, өндөр түвшинд хадгалагдсан боловч дотоод эрэлт, уул уурхайн бүтээн байгуулалт, ургацын гол бүтээгдэхүүний дутагдал үүссэн зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр импорт хурдацтай нэмэгдсэн нь барааны дансны ашиг өмнөх оны мөн үеэс 36.6 хувиар буурсан, тээвэр, санхүүгийн үйлчилгээтэй холбоотой гарах урсгал өссөнөөр үйлчилгээний дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 5 дахин өссөн зэрэг нь төлбөрийн тэнцэлд сөрөг нөлөө үзүүлээ.

Санхүүгийн данс өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 26.7 хувиар өсч, 615.6 сая ам.долларын ашигтай гарчээ. Үүнд гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 65.2 хувиар өсч, 879.2 сая ам.долларт хүрсэн нь нөлөөлсөн байна. Харин багцын хөрөнгө оруулалт 424.4 сая ам.долларын алдагдалтай гарсан байна. Үүнд Чингис болон Димсам бондын үндсэн болон хүүгийн төлбөр, Мазаалай, Гэрэгэ болон Чингис бондын хүүгийн төлбөрүүдийг хийсэн нь нөлөөлсөн байна.

График 17. Төлбөрийн тэнцэл



График 16. Гадаад шууд хөрөнгө оруулалт (сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк

Цаашид “Оюу Толгой” ХХК гүний уурхайн бүтээн байгуулалт, бусад уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалттай холбоотойгоор гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж, хөрөнгө санхүүгийн дансны ашиг нэмэгдэхээр Монголбанк төсөөлж байна.

Гадаад худалдаа

Монгол Улсын барааны гадаад худалдааны тэнцэл сүүлийн 4 жил дараалан ашигтай гарч, 2017 онд 1.8 тэрбум ам.долларт хүрэв. 2018 оны эхний 6 сарын байдлаар гадаад худалдааны тэнцэл 822.3 сая ам долларын ашигтай гарсан байна.



000065



Үнэт цаасны танилцуулга

он 2019-01-09

БҮ Хүснэгт 30. Гадаад худалдаа (сая ам.доллар)

№ 01



	2015	2016	2017	2018 Q2	Өөрчлөлт (YOY)	
					дүн	хувь
Эргэлт	8,466.8	8,274.4	10,537.9	6,340.5	1,310.2	26.0%
Экспорт	4,669.3	4,916.3	6,200.6	3,581.4	475.6	15.3%
Импорт	3,797.5	3,358.1	4,337.3	2,759.1	834.6	43.4%
Тэнцэл	871.8	1,558.2	1,863.3	822.3	(359.0)	-30.4%

Эх сурвалж: YCX, Сангийн Яам


2018 оны эхний 6 сард худалдааны тэнцэл ашигтай гарахад экспорт 15.3 хувиар, импорт 43.4 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ. Экспорт өсөхөд дэлхийн түүхий эдийн зах дээр зэс, алт, нүүрсний үнэ өндөр түвшинд хадгалагдсан, газрын тосны үнэ өссөнтэй холбоотой байв. Тухайлбал, газрын тосны үнэ 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 22.0 хувиар, зэсийн үнэ 19.0 хувиар, алтны үнэ 9.0 хувиар, чулуун нүүрсний хилийн үнэ 17.0 хувиар тус тус өссөн бол төмрийн хүдрийн үнэ 16.0 хувиар буурсан байна. Харин хэрэглээ, хөрөнгө оруулалтын болон шатахууны импортын үнэ өссөнөөр импорт 2.8 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс 834.6 сая ам.доллараар буюу 43.4 хувиар өссөн байна.

2018 оны жилийн эцсээр Оюутолгой ордын баяжмал дахь алтны агууламж нэмэгдэж нийт экспортын хэмжээ 1.8 хувиар өсөж 6.3 тэрбум ам.доллар, уул уурхайн томоохон үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтын ажил үргэлжлэн явагдахтай холбоотойгоор импортын хэмжээ өсөж 4.8 тэрбум ам.долларт хүрч, нийт гадаад худалдааны тэнцэл 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарахаар байна гэж Сангийн Яам тооцоолж байна.

Инфляц

Хэрэглээний үнийн индексээр хэмжсэн жилийн инфляц 2015 оноос хойш тогтвортой нэмэгдэж байгаа бөгөөд 2017 онд 6.4 хувь, 2018 оны 6 сарын байдлаар улсын хэмжээнд 7.2 хувьд хүрсэн байна.

График 18. Инфляц (хувь)



Он гарснаар инфляц өсөхөд хатуу түлш, мах, хүнсний ногоо болон шатахууны үнийн өсөлт голлон нөлөөлсөн байна. ОУВС-тай хамтран баталсан “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд төсөв, мөнгөний уялдаатай, зохистой бодлого хэрэгжүүлснээр макро эдийн засгийн үндсэн тэнцвэрүүд хангагдаж, цаашид эдийн засгийн идэвхжил нэмэгдэж 2018 онд эдийн засгийн өсөлт сайжирч

байгаа нь инфляцийг нэмэгдүүлэх нөлөө үзүүлэх хэдий ч төгрөгийн ханш харьцангуй тогтвортой түвшинд хүлээгдэж байгаатай холбоотойгоор инфляци дунд хугацаанд зорилтот 8.0 хувийн түвшинд тогтворжих төлөвтэй байна. Энэ нь Монгол Улсын инфляцийн олон жилийн дундажтай ойролцоо, эдийн засгийн шокгүй үеийн буюу дунд хугацааны ерөнхий тэнцвэр хангагдах инфляцийн тооцоологдсон түвшин юм.



000066



УНД ХУГАЦААНД ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ НЭМЭГДЭХЭЭР БАЙГАА НЬ ЭРЭЛТИЙН ГАРАЛТАЙ ИНФЛЯЦИЙГ ӨДӨӨХӨӨР БАЙГАА ТУЛ, ЗАСГИЙН ГАЗРААС БИЗНЕСИЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ, НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА.

ARD КРЕДИТ ББСБ
2018-11-29
БҮГТЭВ-02

Гадаад валютын албан нөөц, валютын ханш

Гадаад валютын албан нөөцийн хэмжээ 2018 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,670.0 сая ам. доллараар буюу 126.6 хувиар өсөж 2,989.4 сая ам долларт хүрсэн

График 19. Гадаад валютын албан нөөц (ам.доллар)



байна. Энэ нь валютын төлбөртэй барааны импортын 8 сарын хэрэгцээг хангах түвшин боловч Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжид заасан 12 сарын импортын хэрэгцээт түвшинг хангахгүй байгаа юм. ГВАН одоогийн түвшнээс нэмэгдэх нь гадаад зах зээлээс дотоодын эдийн засгийг хамгаалах дархлааг бэхжүүлэх ач холбогдолтой хэмээн Монголбанкнаас гаргадаг санхүүгийн тогтвортой байдлын тайланд дурджээ.

Эх сурвалж: Монголбанк

ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдах болсонтой холбоотойгоор зах зээлд оролцогчдын хүлээлт эерэг болсон, эдийн засгийн үзүүлэлтүүд сайжирсан зэрэг нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах дарамт буурах суурь нөхцөл болж байна. Гэвч валютын ханш сүүлийн үед багахан өсөх төлөв ажиглагдсан ба эдийн засаг сэргэж гадаад худалдаа, импортыг дэмжсэнтэй холбоотой валютын гадагшлах урсгал ихээр бий болсон. Үндэсний баяр наадмыг тохиолдуулж аж ахуй нэгж, хувиараа бизнес эрхлэгчид баярын бэлтгэл болгож бараагаа гаднаас татан бэлтгэл ажлуудаа хангаж эхлэсэн нь валют гадагш урсах гол нөлөөг үзүүлэв.

Хүснэгт 41. Голлох валютын ханш (төгрөг)

	2015	2016	2017	2018 Q2	Өөрчлөлт (YOY)	
					дүн	хувь
АНУ-ын доллар	1,995.5	2,489.5	2,427.1	2,462.8	113.0	4.8%
Евро	2,181.2	2,605.8	2,897.9	2,862.7	181.0	6.7%
Иен	16.6	21.2	21.5	22.3	1.3	6.2%
Юань	307.3	358.0	371.6	371.8	25.3	7.3%
Рубль	27.0	41.0	42.1	39.2	(0.4)	-1.0%

Эх сурвалж: Монголбанк

Дүгнэлт

2018 оны эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн өсөлт 6.3 хувь хүрсэн нь олон улсын санхүүгийн байгуулагуудын таамаглалыг давж байгаа юм. Уул уурхайн хөрөнгө оруулалт үргэлжлэн тэлж, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн итгэл сэргэж бизнесийн орчин алгуур сайжирч байна. Дэлхийн зах зээл дээр зарим экспортын бүтээгдэхүүний үнэ өсөж, манай

ARD CAPITAL GROUP SECURITIES COMPANY LLC
УЛААНБААТАР ХОТ ТТ8632.26 5167855

000067

УЛААНБААТАР ХОТ
ARD КРЕДИТ ББСБ ХХК
ТТ8636 45459567
66

Үнэт цаасны танилцуулга
он 2019-01-09
БҮРТГЭВ
№ 01

АРД КРЕДИТ
ББСБ 29
БҮРТГЭВ-02

гадаад худалдааны нөхцөл харьцангуй тогтвортой байхаар байна хэмээн Монголбанк 2018 оны 6 сарын 15-ны өдрийн мөнгөний бодлогын мэдэгдэлд дурджээ.

Манай улсын худалдааны гол түнш орнуудын эдийн засаг хурдацтай өсөж, экспортын бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж, улмаар гадаад худалдааны нөхцөл сайжирч байгаа нь эдийн засгийн гадаад орчин таатай нөхцөлд шилжсэнийг илтгэж байна. Төсвийн гүйцэтгэл сайжирч, эдийн засаг хурдацтай өсөх хүлээлттэй байгаа боловч, өрийн дарамт өндөр хэвээр, иргэдийн орлогын хэмжээ бага, мөн эдийн засгийн төрөлжилт сул учир түүхий эдийн ханшийн хэлбэлзлээс эдийн засаг ихээхэн хамаарч байгаа нь эдийн засгийн өсөлтийг удаашруулах магадлалтай.

2018 оны 7 сарын 9-ний өдөр “Фитч” агентлаг Монгол Улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийн үнэлгээг “В-” байсныг “В” болгон дээшлүүлж, төлөвийг “Тогтвортой” болгов. Манай улсын зээлжих зэрэглэлийн төлөв сүүлийн жилүүдэд буурч хөрөнгө оруулалтын хувьд өндөр эрсдэлтэй орны ангилалд багтсан хэвээр байгаа ч зээлжих зэрэглэл тогтоогч агентлагуудын хувьд Монгол Улсын эдийн засгийг богино хугацааны эрсдэл, сорилтуудтай тулгарч байгаа, гэхдээ ирэх жилүүдэд ОУВС-гийн хөтөлбөр үргэлжилж, уул уурхайн томоохон төсөл хөтөлбөрүүд амжилттай хэрэгжсэнээр эдийн засаг сэргэх, улсын төсөв, гадаад төлбөрийн чадвар огцом сайжрах хүлээлттэй буюу Монгол Улсын дунд болон урт хугацааны эдийн засгийн төлөвийг эерэгээр үнэлж байна.

Экспортлогч компаниуд, гадаадын шууд хөрөнгө оруулалт, олон улсын байгууллагууд болон донор орнуудын дэмжлэг, Монголбанкны алт худалдан авалтын үр дүнд валютын нөөц өсөж байна. Энэхүү нөөцийг оновчтой удирдсанаар Монгол Улсын эдийн засаг тогтворжиж зээлжих зэрэглэл сайжрах, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэх, аж ахуйн нэгжүүдийн эдийн засагт итгэх итгэл хадгалагдах онц чухал ач холбогдолтой юм. Манай улсын эдийн засгийн ирээдүйн төлөвийн талаарх хөрөнгө оруулагчдын хүлээлт өөдрөг болж, Монгол Улсын Засгийн газраас уул уурхайн томоохон төслүүдийг эхлүүлэхээр хүлээгдэж байгаа нь гадаадын шууд хөрөнгө оруулалт, түүнийг дагасан санхүүгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхээр байгаа юм.

Төсөв, төлбөрийн тэнцэлд бий болсон эерэг өөрчлөлтүүд мөнгөний бодлого, инфляцийн зорилттой нийцэж бодлогын хүүг алгуур бууруулах боломжийг олголоо. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтворжин, хадгаламжийн долларжилт буурсан, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо нэмэгдсэн зэрэг нь эдийн засгийн төлөвийн талаарх эерэг хүлээлт зах зээл дээр давамгайлж эхэлснийг илтгэж байна.

Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд макро эдийн засгийн гүйцэтгэл эерэг байж, бүх тоон үзүүлэлтүүд зорилтот төвшинөөс давж биелсэн. Харин одоо бий болсон эерэг үр дүнгээ бэхжүүлж, цаашид урт хугацаанд тогтвортой өсөх орчныг бүрдүүлэхэд, нийт эдийн засгийн эмзэг байдлаа бууруулахад чиглэсэн бодлогуудыг хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтийн үр шимийг олон нийтэд хүргэх, хүртээмжтэй өсөлтийг бий болгоход анхаарах хэрэгтэй болж байна.

2.2. ББСБ-ын зах зээлийн төлөв

2.2.1. ББСБ-ын харилцагчдын тоо

2018 оны II улирлын байдлаар Монгол Улсад 539 банк бус санхүүгийн байгууллага 1.4 сая харилцагчдад санхүүгийн үйлчилгээ үзүүлж байна. Банк бус санхүүгийн байгууллагын тоо



000068



СҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
2019-01-09
БҮРТГЭВ
№

2013 оноос хойш огцом нэмэгдэж эхэлсэн боловч сүүлийн жилүүдэд өсөлт нь харьцангуй саарах хандлагатай байна. Энэ нь СЗХ-оос ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргасантай холбоотой юм.

График 20. ББСБ-ын тоо болон харилцагчдын тоо



Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

Тухайлбал, 2 ББСБ-ийн харилцагчдын тоо нийт ББСБ-ын салбарын харилцагчдын 87.7 хувийг бүрдүүлж байна. 2017 оноос эхлэн цахим мөнгөний харилцагчдын бүртгэлийг ББСБ-ын харилцагчдын бүртгэлд бүртгэж эхэлсэн ба 2018 оны II улиралд “Мобифинанс ББСБ” ХХК-ийн гаргасан Sandy цахим мөнгөний харилцагчдын тоо 1.2 саяд хүрсэн, “Ленд МН ББСБ” ХК-ийн цахим зээл олгох финтек үйлчилгээий харилцагчдын тоо 55.9 мянгад хүрсэн нь ББСБ-ын салбарын харилцагчдын өсөлтөд ихээхэн нөлөө үзүүлжээ.

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 2018 оны II улирлын байдлаар 539 ББСБ-ууд 9 төрлийн 775 тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байна. ББСБ-уудын 90.9 хувь буюу 490 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

2.2.2. Хүртээмжтэй байдал

Улсын хэмжээнд нийтдээ тусгай зөвшөөрөл эзэмшиж буй 539 ББСБ байгаагаас 464 буюу 86.1 хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн 75 ББСБ нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 42. ББСБ-ын байршил (бүсчиллээр)

	ББСБ	Салбар	Нийт
Улаанбаатар	464	133	597
Хангайн бүс	24	22	46
Төвийн бүс	22	15	37
Зүүн бүс	14	8	22
Баруун бүс	10	5	15
Говийн бүс	5	7	12
Нийт	539	190	729

Зураг 5. ББСБ-ын хүртээмжтэй байдал (газарзүйн байршлаар)



Хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудаас хамгийн их буюу 11 ББСБ Төв аймагт үйл ажиллагаа явуулж байгаа бол хамгийн бага буюу Ховд, Говь-алтай, Өмнөговь, Дундговь, Булган аймгуудад тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна. Бүсчилж үзвэл баруун бүсэд нийтдээ 10 ББСБ, төвийн бүсэд хамгийн их буюу 22, говийн бүсэд хамгийн бага буюу 5, зүүн бүсэд 14 ББСБ тус тус үйл ажиллагаа явуулж байна.


Зээлийн үйлчилгээний тархалт

Улсын хэмжээнд 2018 оны эхний хагас жилийн байдлаар ББСБ-ын зээлдэгчдийн тоо 150.5 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 1.3 дахин нэмэгдсэн. Зээлдэгчийн тоог улсын хэмжээний 18-

ARD КАПИТАЛ ГРУПП
ARD CAPITAL GROUP
SECURITIES COMPANY
LLC
УЛААНБААТАР ХОТ ТТА8632-4-312855

000069

УЛААНБААТАР ХОТ
ARD КРЕДИТ ББСБ ХХК
ТТ15756-68459567



64 насны хүн амын тоонд харьцуулсан харьцаа 13 байна. Өөрөөр хэлбэл, улсын хэмжээнд 18-64 насны 13 хүн тутмын 1 нь ББСБ-аас зээл авсан байна. Харин орон нутагт уг харьцаа 172, Улаанбаатар хотын хэмжээнд 6 байна. Түүнчлэн Монгол Улсын хэмжээнд ББСБ-аас зээл авсан нэг зээлдэгч дунджаар 5.1 сая төгрөгийн зээлтэй байгаа бол хөдөө орон нутагт нэг зээлдэгч дунджаар 3.7 сая төгрөгийн зээлтэй, Улаанбаатар хотын нэг зээлдэгч дунджаар 5.2 сая төгрөгийн зээлтэй байна.

Хүснэгт 43. Зээлдэгчийн дундаж зээл, зээлийн үйлчилгээний хүртээмж

	Хөдөө орон нутаг	Улаанбаатар хот	Улсын дүн
Зээлдэгчийн дундаж зээлийн хэмжээ (сая төг)	3.7	5.2	5.1
Хүн ам/зээлдэгчийн тоо	172	6	13

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

2.2.3.Хоронго

2007-2017 оны хооронд ББСБ-ын нийт хөрөнгө 66.4 тэрбум төгрөгөөс 969.2 тэрбум төгрөгт хүрч, 13.6 дахин нэмэгдсэн байна. СЗХ-оос 2016 оны 10 сард ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх шийдвэр гаргасан ба уг шийдвэрийн үр дүнд ББСБ-уудын хөрөнгийн чадавх сайжирсан байна. Тухайлбал 2017 оны нийт хөрөнгийн өсөлтийн 84.6 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт бүрдүүлсэн байна. 2018 оны II улиралд ББСБ-уудын нийт хөрөнгө 1.1 их наяд төгрөгт хүрсэн.

ББСБ-уудыг нийт хөрөнгийн хэмжээгээр нь авч үзвэл 1.0 тэрбум төгрөгөөс доош хөрөнгөтэй 142 ББСБ, 1.0-4.9 тэрбум хүртэл төгрөгийн хөрөнгөтэй 361 ББСБ, 5 тэрбумаас дээш хөрөнгөтэй 36 ББСБ байна. 5 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 36 ББСБ нь нийт ББСБ-ын салбарын хөрөнгийн 43.1 хувийн хөрөнгийг бүрдүүлж байгаа юм.

Хүснэгт 44. ББСБ-ийн хөрөнгө (активын хэмжээгээр)

Интервал	ББСБ тоо	Нийт активын дүн (сая төгрөг)	Эзлэх хувь
1 тэрбумаас доош	142	48.9	4.3%
1-4.9 тэрбум хүртэл	361	602.4	52.7%
5 тэрбум ба түүнээс дээш	36	492.4	43.1%
НИЙТ	539	1,143.7	100.0%

2.2.4.Зээл

2018 оны II улирлын байдлаар ББСБ-ын зээлдэгчийн тоо 150,542-д хүрч, өмнөх оны мөн үеэс 1.3 дахин өссөн байна. Үүнд ББСБ-ууд финтек санхүүгийн үйлчилгээг олон нийтэд хүргэж эхэлсэн нь нөлөөлсөн. Тайлант хугацаанд 490 ББСБ 768.3 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй ажилласан ба энэ нь нийт активын 67.2 хувьтай тэнцэж байна. ББСБ-уудын хөрөнгийн чадавх нэмэгдэж байгаатай холбоотойгоор зээлийн нийлүүлэлт нэмэгдэж байна.



000070



Үнэт цаасны танилцуулга
 2019.01.09
 БҮРТГЭВ-02

ARD КРЕДИТНИЙ БИРЖ
 ББСБК EXCHANGE
 2018-11-29
 БҮРТГЭВ-02

График 22. ББСБ-аас гаргасан зээлийн үлдэгдэл






График 21. ДНБ-ийн өсөлт, ББСБ-ын салбарын зээлийн өсөлт



Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

2012-2016 оны хооронд Монгол Улсын эдийн засгийн өсөлт удааширч санхүүгийн байгууллагуудын зээл олголтод сөргөөр нөлөөлсөн билээ. Тухайлбал, 2013 онд ББСБ-уудын зээлийн өрийн үлдэгдлийн өсөлт 41.8 хувьтай байсан бол 2016 онд 22.2 хувийн өсөлт үзүүлсэн байна. Харин банкны салбар энэ хугацаанд зээл олголтдоо эрчимтэйгээр бууруулсан ба 2013 онд 54.4 хувиар өсөлттэй байсан зээлийн өрийн үлдэгдлийн өсөлт буурсаар 2015 онд -6.5 хувьд хүрч зээл олголт хумигдсан юм. 2017 онд Монгол Улсын Засгийн газар ОУВС-ийн Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөрт хамрагдсан, хөрөнгө оруулагчдын итгэл сэргэсэн, олон улсын зах зээлд уул уурхайн түүхий эдийн үнэ өссөн зэрэг эерэг өөрчлөлтүүд гарч Монгол Улсын эдийн засаг 5.1 хувиар өсөж, санхүүгийн байгууллагуудын зээл олголт ч мөн нэмэгдсэн байна.

График 23. ББСБ-ын салбар болон Банкны салбарын зээлийн үлдэгдэл ДНБ-тэй харьцах харьцаа



2017 оны жилийн эцсийн байдлаар банкны салбарын зээлийн өрийн үлдэгдэл ДНБ-ий харьцаа 82.2 хувь байсан бол тус харьцаа нь ББСБ-ын салбарын хувьд 3.8 хувь байсан байна. 2013 онд ББСБ-ын салбарын хувьд энэхүү харьцаа 1.6 хувь байсан ба тогтвортой өссөөр 2017 онд 3.8 хувьд хүрчээ. Энэхүү харьцаа нь банкны салбар болон ББСБ-ын салбарт аль алинд өсөлттэй байгаа нь санхүүгийн байгууллагуудын эдийн засагт үзүүлэх нөлөө нэмэгдэж буйг харуулж байна.

2018 оны эхний хагас жилийн байдлаар ББСБ-ууд нийт 575.2 тэрбум төгрөгийн зээл олгож, 444.5 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, нийт зээлийн үлдэгдэл 768.3 тэрбум төгрөгт хүрсэн. Нийт зээлийн үлдэгдлийн 81.0 хувийг иргэнд, 19.0 хувийг хувийн хэвшилд олгосон зээлийн үлдэгдэл эзэлж байна. Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар нь авч үзвэл шинээр олгосон зээлийн 50.2 хувь нь хэрэглээ, 18.8 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбар, 9.7 хувь нь барилгын салбар, 4.2 хувь нь уул уурхайн салбар, 2.4 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбаруудад тус тус олгосон байна.



000071





Тайлант хугацаанд нийт зээлийн үлдэгдлийн 85.1 хувь нь хэвийн зээл, 4.5 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 10.4 хувь нь чанаргүй зээл байна. Чанаргүй зээлийн 72.1 хувьд эрсдэлийн сан байгуулжээ.

График 24. Банк болон ББСБ-ын чанаргүй зээлийн хувь



2018 оны II улирлын байдлаар нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 10.4 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.6 нэгжээр буурсан үзүүлэлт юм. Хэдийгээр ББСБ-ын нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ буурч байгаа боловч банкны салбараас 1.4 нэгжээр өндөр байна. Энэ нь ББСБ-ын

Эх сурвалж: Монголбанк

салбарын үйл ажиллагаа хүн амын санхүүгийн харьцангуй эрсдэлтэй хэсэгт төвлөрдөгтэй холбоотой юм. 2018 оны II улирлын байдлаар зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй ББСБ-аас 575.2 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд олгосон зээлийн дээд хүү 10.7 хувь, доод хүү 1.0 хувь, жигнэсэн дундаж хүү 3.3 хувь байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеийн зээлийн ЖДХ-тэй харьцуулахад 0.2 нэгжээр буурсан үзүүлэлт юм. 2018 оны 6 сард банкны салбарын олгосон зээлийн ЖДХ 1.5 хувь байсан нь ББСБ-ын салбарын ЖДХ-ээс 1.8 нэгжээр доогуур байна.

График 25. ББСБ ба банкны зээлийн хүү (жигнэсэн дундаж)



Эх сурвалж: СЗХ, ҮСХ

2.2.5. Эх үүсвэр

2018 оны эхний 6 сарын байдлаар ББСБ-ын нийт хөрөнгийн 22.3 хувь буюу 255.2 тэрбум төгрөгийг бусдаас татсан эх үүсвэр, 77.7 хувь буюу 888.5 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна.



000072



График 26. ББСБ-ын өр, толборийн бүтэц (тэрбум төгрөг)



Тайлант хугацаанд ББСБ-ын нийт өр толборийн дүн 255.2 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өр толборийн 52.4 хувь буюу 133.7 тэрбум төгрөгийг банк санхүүгийн байгууллагаас авсан зээл, 17.9 хувь буюу 45.6 тэрбум төгрөгийг итгэлцлийн үйлчилгээний өглөг эзэлж байна.

Эх сурвалж: СЗХ

ББСБ-ын өр толборийн дүн өмнөх оны мөн үеэс 46.4 хувиар өссөн бөгөөд энэхүү өсөлтөд банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл болон өрийн бичиг гаргалт нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Тухайлбал, 2018 оны II улирлын байдлаар 69 ББСБ дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн үлдэгдэл 133.7 тэрбум төгрөг байгаа бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 45.3 хувиар өссөн үзүүлэлт юм. Мөн 14 ББСБ 16.7 тэрбум төгрөгийн өрийн бичиг гаргасан нь өмнөх оны мөн үеэс 3.9 дахин өссөн үзүүлэлт байна.

График 27. ББСБ-ын өөрийн хөрөнгө (тэрбум төгрөг)




Тайлант хугацаанд ББСБ-ын өөрийн хөрөнгө 888.5 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 30.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Нийт өөрийн хөрөнгийн өсөлтийн 76.5 хувь нь хувь нийлүүлсэн хөрөнгө өссөн, 23.4 хувь нь хуримтлагдсан ашиг нэмэгдсэнээр тайлбарлагдаж байна. Нийт өөрийн хөрөнгийн 80.6 хувь буюу 707.8 тэрбум төгрөгийг хувьцаат капитал, 18.0 хувь буюу 170.9 тэрбум төгрөгийг хуримтлагдсан ашиг эзэлж байна.

Эх сурвалж: СЗХ

Сүүлийн 5 жилийн байдлаар нийт ББСБ-уудын өр толбор нийт хөрөнгийн хэмжээнд эзлэх хувь хэмжээ буурсаар байгаа бөгөөд 2018 оны II улирлын байдлаар 22.3 хувь болсон байна. Энэ нь ББСБ-уудын нийт хөрөнгийн 22.3 хувь нь өр толборөөр, үлдэх хувь буюу 77.7 хувь нь өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж байгааг харуулж байна.

График 28. ББСБ-ын нийт актив, эздийн өмч, харьцаа



СЗХ-ноос ББСБ-уудын ХНХ-ийн хэмжээг нэмэгдүүлэх бодлого баримталж байгаа ба СЗХ-ны 2017 оны 1 сарын 13-ны өдөр баталсан 27 дугаар тогтоолын дагуу ББСБ-ууд 2019 оны 2 сарын 10-ны өдрийн дотор ХНХ-ийн хэмжээг 1.4 тэрбум төгрөг, 2021 оны 2 сарын 10-ны өдрийн дотор 2.5 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэх үүрэгтэй юм. Харин тайлант хугацаанд банкны хувьд нийт хөрөнгийн 89.5 хувь нь өр толборөөр санхүүжигдэж байна.

Эх сурвалж: СЗХ




000073



2.2.6. Ашигт ажиллагаа


График 29. ББСБ-ын нийт орлого ба цэвэр ашиг



2017 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-ууд 195.9 тэрбум төгрөгийн орлоготой, 129.1 тэрбум төгрөгийн зарлагатай 66.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. 2013 оноос 2017 оны хооронд ББСБ-ын салбарын нийт орлого дунджаар 16.5 хувиар өссөн бол цэвэр ашиг дунджаар 22.3 хувиар өссөн байна. 2018 оны эхний хагас жилийн байдлаар ББСБ-ын нийт орлого 118.4 тэрбум төгрөг, цэвэр ашиг 46.5 тэрбум төгрөгт хүрсэн байх ба энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.5 хувь, 65.5 хувиар тус тус өссөн үзүүлэлт юм. Энэхүү өсөлтөд нийт орлогын 83.7 хувийг бүрдүүлж буй хүүгийн орлого өссөн нь голлон нөлөөлжээ. Тухайлбал, 473 ББСБ 99.2 тэрбум төгрөгийн хүүгийн орлоготой ажилласан бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 33.4 хувь буюу 24.8 тэрбум төгрөгөөр өссөн байна. 2018 оны II улиралд 539 ББСБ-ын 434 нь буюу 80.5 хувь нь 51.5 тэрбум төгрөгийн ашигтай, 89 нь буюу 16.5 хувь нь 5.0 тэрбум төгрөгийн алдагдалтай, 16 нь буюу 3.0 хувь нь үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Хэдийгээр ББСБ-ын салбарын цэвэр ашгийн маржин 2013 онд 27.4 хувиас өсөж 2017 онд 34.1 хувь болсон боловч нийт хөрөнгийн өгөөж, өөрийн хөрөнгийн өгөөж зэрэг ашигт ажиллагааны харьцаанууд буурсан үзүүлэлттэй байна. ББСБ-ын салбарын нийт хөрөнгийн өгөөж 2013 онд 9.4 хувь байсан бол 2017 онд 7.6 хувь болж 1.8 пунктээр буурсан харин эздийн өмчийн өгөөж 2013 онд 14.7 хувь байсан бол 2017 онд 10.0 хувь болжээ. Үүнд ББСБ-ын нийт хөрөнгийн эргэц болон санхүүгийн хөшүүрэг буурсан нь нөлөөлсөн байна.

График 30. ББСБ-ын голлох ашигт ажиллагааны харьцаанууд



000074





2.2.7. Бизнесийн хууль, эрх зүйн орчин



“Ард Кредит ББСБ” ХХК нь Монгол Улсын Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Банк, Эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа удирдлага болгон Санхүүгийн Зохицуулах Хорооны зөвшөөрлийг үндэслэн өөрсдийн мөрдөж буй дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2011 оны 4 сарын 21-ний өдрийн №108 тоот шийдвэрийн дагуу зээл, гадаад валют арилжаа, хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө өгөх тусгай зөвшөөрөл, 2014 оны 1 сарын 29-ний өдрийн №30 тоот шийдвэрийн дагуу хаалттай өрийн бичиг гаргах тусгай зөвшөөрөл, 2014 оны 6 сарын 25-ны өдрийн №533 тоот шийдвэрийн дагуу итгэлцлийн үйлчилгээ авах тусгай зөвшөөрлийг тус тус аваад байна. Мөн 2017 онд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах тусгай зөвшөөрөл, 2018 оны 6 сард цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын тусгай зөвшөөрлийг тус тус нэмж аван үйл ажиллагаагаа тэлсээр байна.

Банк бус санхүүгийн салбарын үйл ажиллагааг зохицуулдаг гол хуулиуд болох Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль 2002 онд, Санхүүгийн Зохицуулах Хорооны эрх зүйн байдлын тухай хууль 2005 онд тус тус батлагдсан. Эдгээр хуулиудыг шинэчлэх, эрх зүйн орчинг сайжруулах хэрэгтэй хэмээн ББСБ-ууд үзэж байгаа ба Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоо, Санхүүгийн Зохицуулах Хороотой хамтран шинэ хуулийн төсөл дээр ажиллаж байна. Ялангуяа шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, төлбөр тооцооны шинэ хэрэгсэл гаргах, финтект суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх хэрэгтэй хэмээн Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбооноос үзэж байгаа юм.

2.2.8. Ард Кредит ББСБ-ын зах зээлд эзлэх байр суурь

2017 онд нийт ББСБ-ын салбарын хөрөнгийн хэмжээ 23.1 хувиар өсөж 969.2 тэрбум төгрөгт хүрсэн бол Ард Кредит ББСБ-ын хувьд нийт хөрөнгө нь 79.1 хувиар өсөж 10.2 тэрбум төгрөгт хүрэв. Ард Кредит ББСБ-ын 10.2 тэрбум төгрөгийн хөрөнгө нь нийт ББСБ-ын хөрөнгө болох 969.2 тэрбум төгрөгийн 1.1 хувийг эзэлж байна.

График 32. ББСБ салбарын хөрөнгө, өсөлт





График 31. Ард Кредит хөрөнгө, өсөлт



000075




Унот цаасны танилцуулга
 2019-01-09
 БҮРГЭЭ
 №

ARД КРЕДИТ ББСБ
 2018-11-29
 БҮРГЭЭ №3-02

2017 онд Ард Кредит ББСБ-ын гаргасан нийт зээлийн хэмжээ 56.1 хувиар өсөж 8.0 тэрбум төгрөгт хүрэв. Нийт салбарын хувьд олгосон зээлийн хэмжээ өмнөх оноос 33.4 хувиар өсөж 638.1 тэрбум төгрөгт хүрлээ. Ард Кредит ББСБ-ын нийт зээлийн үлдэгдэл салбарын зээлийн 1.2 хувийг эзэлж байна.

График 33. Ард Кредит ББСБ болон салбарын зээлийн харьцуулалтууд




Зээлийн чанарын хувьд 2017 оны байдлаар Ард Кредит ББСБ-ын чанаргүй зээл нийт зээлийн 4.3 хувийг эзэлж байгаа бол ББСБ-ын салбарын чанаргүй зээл нийт зээлийн 12.7 хувийг эзэлж байна. Энэ нь Ард Кредит ББСБ-ын нийт зээлд эзлэх зээлийн чанаргүй зээлийн салбартай харьцуулахад 2 дахин бага байгааг харуулж байна.

График 34. Ард Кредит болон салбарын зээлийн чанарын харьцуулалтууд



2017 онд ББСБ-ын нийт орлого өмнөх онтой харьцуулахад 1.3 хувиар өсч 195.9 тэрбум төгрөгт хүрсэн бол Ард Кредит ББСБ-ын орлого 15.1 хувиар өсч 1.95 тэрбум төгрөгт хүрсэн байна.

График 35. Ард Кредит болон салбарын орлогын харьцуулалтууд



ARД КАПИТАЛ ГРУПП УЛААНБААТАР ХОТ ТТА8632-883835
 ARD CAPITAL GROUP SECURITIES COMPANY LLC
 УЛААНБААТАР ХОТ ТТА8632-883835

000076


УЛААНБААТАР ХОТ
 ARД КРЕДИТ ББСБ
 ТТГ5759-4459567

Унэт цаасны танилцуулга
 2019-01-09
 БҮРТГЭВ
 № 01

МОНГОЛ АРД КРЕДИТ ББСБ
 2018-11-29
 БҮРТГЭВ-02


2017 онд Ард Кредит ББСБ-ын орлого нийт салбарын орлогын 1.2 хувийг эзэлж байна. Ашгийн хувьд ББСБ-ын нийт ашиг 2017 онд 66.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүний 1.0 хувь буюу 641.8 сая төгрөгийг Ард Кредит ББСБ-ын ашиг бүрдүүлж байна.

График 36. Ард Кредит ББСБ-ын ББСБ-ын салбарын орлого болон ашигт эзлэх харьцаа



2017 онд ББСБ-ын нийт ашиг өмнөх онтой харьцуулахад 13.1 хувиар өсч 66.8 тэрбум төгрөгт хүрсэн бол Ард Кредит ББСБ-ын ашиг 59.9 хувиар өсч 641.8 сая төгрөгт хүрсэн байна.

График 37. ББСБ-ын ашиг Ард Кредит ББСБ-ын ашгийн харьцуулалт



Ард Кредит ББСБ-ын SWOT шинжилгээ

Компанийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор компанийн давуу, сул талыг тодорхойлж, үүсэх боломж, аюул зэргийг доорх хүснэгтэд дурдсан болно.

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> - Хүчтэй брэнд: Монгол Улсын санхүүгийн салбарт тэргүүлэгч “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн хөрөнгө оруулалттай компани. - Финтек: Санхүүгийн салбарт хувьсгал хийж буй финтек шийдлийг (санхүүгийн технологи) салбартаа нэвтрүүлж буй хоёрдогч ББСБ. - Монгол Улсын өнцөг булан бүрт байрлах салбар: Стратегийн хамтрагч байгууллагууд болох 24 салбартай “Ард даатгал” ХХК, 283 салбартай “Монгол Шуудан” ХК-ийн дэд бүтэц, салбаруудыг ашиглан салбаргүй агент байдлаар 	<ul style="list-style-type: none"> - Финтек зах зээлд анхдагч бус хоёрдогч тоглогч: “ЛэндМН ББСБ” ХК нь Монголын анхны финтек компани болон үйл ажиллагаагаа өргөжүүлэн явуулж байна. - “Ард” аппликэйшн нь нэг бэлтгэн нийлүүлэгчээс хамааралтай. - Салбарын дунджаас илүү өндөр хөшүүрэгтэй: 2017 оны эцэст өр төлбөр эздийн өмчийн харьцаа 1.73 байсан бол ББСБ-ын салбарын дундаж 0.28 байсан.

ARAD CAPITAL GROUP
 ARD CAPITAL GROUP
 SECURITIES COMPANY
 LLC
 33855

000077

УЛААНБААТАР ХОТ
 АРД КРЕДИТ ББСБ
 ХХК
 ТТГ576 4459567

СЗУ
 Үнэт цаасны танилцуулга
 он 2019 сг. 01. 09 өр
 БҮРТГЭВ
 № 01
 ажиллана.

МОНГОЛЫН ХӨРӨНГӨЙН СЗУ
 MONGOLIAN FOREIGN CURRENCY
 ARD КРЕДИТ
 ББСБ
 2018-11-29
 БҮРТГЭВ-02

- Синержи: Ард Санхүүгийн Нэгдэлийн хөрөнгө оруулалттай компаниудтай хамтран санхүүгийн цогц үйлчилгээг харилцагчдад хүргэдэг.
- Чанартай зээлийн багц: Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь салбарын дунджаас даруй 2 дахин бага.
- ББСБ-ын салбарт хамгийн бага хүү: Ард Кредит ББСБ-ын 2017 оны эцэст олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 2.36 хувь байсан бол ББСБ-ын салбарын олгосон зээлийн ЖДХ 3.36 хувьтай байсан.
- Туршлагатай баг: Бичил санхүүгийн чиглэлээр олон жилийн туршлага хуримтлуулсан удирдлагын баг бүрэлдэхүүн.

- Цэвэр ашгийн хувь салбарын дунджаас доогуур: 2017 онд ББСБ-ын салбарын цэвэр ашгийн маржин 34.1 хувь байсан бол Ард Кредит ББСБ-ын цэвэр ашгийн маржин 27.4 хувь байсан.

Боломж

Аюул


- Өсөн томорч буй зах зээл: ББСБ-ын салбарын 5 жилийн дундаж өсөлт 26.3 хувь байсан.
- Эдийн засгийн өсөлт: Монгол Улсын эдийн засаг ирэх 3 жил дунджаар 5.4 хувиар өснө гэж ОУВС болон Сангийн Яам төсөөлж байна.
- Шинэ технологиуд: Сүлийн үед шинэ технологиуд хурдацтай гарч байгаа бөгөөд энэ нь хэрэглээг хялбарчилж, зардал хэмнэх боломжийг олгож байна.
- Өсөж буй өрхийн орлого: Өрхийн бодит орлого сүүлийн 5 улирал дараалан өссөн дүнтэй байна.
- Өсөн нэмэгдэж буй технологийн хэрэглээ: Харилцагчдын технологийн хэрэглээ нэмэгдэх нь "Ард" аппликэйшн, онлайн зээлийн өргөдлийн хэрэглээнд эерэг нөлөөтэй.
- Тогтвортой инфляц: Монголбанкны 2018 оны 6 сарын 15-ны өдрийн мэдэгдэлд инфляци зорилтот 8 хувийн түвшинд тогтворжих хандлагатай буйг дурдсан.

- Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ: Монгол Улсын эдийн засаг уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай ба түүхий эдийн үнэ унаснаар эдийн засгийн өсөлт удааших, цаашлаад уналтад шилжих аюултай.
- Хүүгийн төвшин: Монголбанк 2023 он гэхэд зээлийн хүүг 5.0-7.0 хувиар бууруулах зорилт тавин ажиллаж байна.
- Иргэдийн санхүүгийн байгууллагад хандах хандлага сөрөг байна.
- Иргэдийн санхүүгийн боловсрол: Дэлхийн банкнаас 2012 онд хийсэн судалгаа Монгол Улсын иргэдийн банк санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдлэг дутмаг хэмээн дүгнэсэн ба энэ нь санхүү, эдийн засгийн тогтвортой байдалд сөрөг нөлөөтэй юм.
- Өрсөлдөөн: Хэдийгээр ББСБ-ын салбарт шинээр нэвтрэгчдийн тоо буурч буй боловч салбарын дотоод өрсөлдөөн нэмэгдэж байна.
- Валютын ханшийн эрсдэл: Ард Кредит ББСБ нь доллараар санхүүжилт татах төлөвлөгөөтэй байгаа ба төгрөгийн ханш

ARD CAPITAL GROUP
 ARD CAPITAL GROUP
 SECURITIES COMPANY
 LLC -
 УЛААНБААТАР ХОТ ТТ8632-783855

000078

УЛААНБААТАР ХОТ
 ARD
 КРЕДИТ ББСБ
 ХХК
 ТТ8576 & 8459567
 77



<p>- Буурч буй санхүүжилтийн зардал: Бодлогын хүү буурч, Монгол Улсын макро эдийн засгийн орчин тогтворжихын хэрээр дотоод болон гадаад санхүүжилтийн зардал буурч байна. Ард Кредит ББСБ нь хамгийн сүүлд 2017 онд 19.7 хувийн хүүтэй 1.7 тэрбум төгрөгийн бондын санхүүжилтийг татсан.</p>	<p>унах нь санхүүжилтийн зардлыг өсгөх эрсдэлтэй.</p>
--	---

TOWS стратегинуд:

Компани нь SWOT шинжилгээн дээр тулгуурлан TOWS буюу боломжийг ашиглах, сул талаа сайжруулах доорх стратегийг баримтлан ажиллах болно.

Давуу талаа ашиглан боломжийг ашиглах нь- Компанийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ болох “Ард” финтек шийдлийг ашиглан хэрэглээний зээл олголтыг нэмэгдүүлнэ.

Монгол Шуудан, Ард Даатгал, Ард Санхүүгийн Нэгдэлийн салбарыг ашиглан хөдөө орон нутгийн иргэдэд хэрэглээний болон бизнесийн зээлийг хялбар аргаар, түргэн шуурхай, зардал багатайгаар хүргэнэ.

Сул талаа сайжруулан боломжийг ашиглах нь- Финтек аппликэйшн болон хамтрагч компаниудын дэд бүтцийг ашиглан ажиллаж, компанийн бизнес моделийг өөрчилж, цэвэр ашгийн хувийг нэмэгдүүлнэ.

Макро эдийн засгийн орчин сайжирч буй энэ үед хөшүүрэг ашиглан зээл олголтыг нэмэгдүүлнэ.

Давуу талаа ашиглан аюулыг сөрөх нь- Өөрсдийн финтек шийдэл болон стратегийн хамтын ажиллагаатай компаниудын салбарыг ашиглан иргэдэд санхүүгийн мэдлэгийг түгээнэ.

Зардал багатай санхүүжилт татан өөрсдийн дэд бүтэц, технологийг ашиглан зээлийн бүтээгдэхүүнийг зардал багатайгаар, хүртээмжтэйгээр хүргэнэ.

Сул талаа сайжруулан аюулыг сөрөх нь- буурч буй хүүг ашиглан санхүүжилтийн зардлыг бууруулж хүү багатай зээлийг харилцагчдад олгоно.

Портерийн 5 хүчин зүйлс:

Аливаа бизнесийн стратеги төлөвлөлтийг боловсруулахын тулд Портерийн 5 хүчин зүйлсийг ашигладаг. Ингэснээр үйл ажиллагаа явуулж буй бизнесийн салбарт нөлөөлөгч хүчин зүйлс болоод болзошгүй эрсдэлийг урьдчилан харах боломжийг бүрдүүлдэг. Энэхүү 5 хүчин зүйлсэд 1. Салбарын өрсөлдөгчид, 2. Компанийн бэлтгэн нийлүүлэгчид, 3. Компанийн хэрэглэгчид, 4. Салбарт шинээр өрсөлдөгчид орж ирэх шалгуур, 5. Орлуулах бүтээгдэхүүний аюул зэргийг авч үздэг.

Өрсөлдөгч:

- Зах зээлд үйл ажиллагаа явуулж буй 534 ББСБ байна.(2017 оны байдлаар)
- Финтек үйлчилгээ үзүүлж буй 2 ББСБ байна.

Компанийн бэлтгэн нийлүүлэгчид:



000079



- Зээлийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагын хувьд үндсэн үйл ажиллагаанд шууд нөлөөлөх нийлүүлэгч байхгүй.
- Технологийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага.

Компанийн хэрэглэгчид:

- 2017 оны байдлаар ББСБ-ын тоо 534 ба тэдний харилцагчдын тоо 1.4 сая хүн байгаа хэдий ч финтек үйлчилгээ үзүүлж буй 2 ББСБ нь нийт харилцагчдын 81.4 хувийг бүрдүүлж байна.
- Ард Кредит ББСБ-ын хувьд ердөө 691 үйлчлүүлэгчидтэй байгаа тул финтек суурилсан санхүүгийн үйлчилгээг үзүүлэх замаар харилцагчдын тоог нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллана.

Шинэ өрсөлдөгчид нэвтрэх аюул:

- ББСБ-ын тоо хурдтай нэмэгдэж зах зээлд өрсөлдөгчид ихээр нэмэгдэж байсан боловч 2016 оноос энэхүү өсөлт удааширч эхлэв. Тухайлбал, 2013 онд 263 байсан ББСБ тоо 2016 онд 518 хүртэл нэмэгдэж 97.0 хувиар өссөн бол 2017 оны байдлаар 534-д хүрч, өмнөх оноос 3.0 хувиар өсөв.
- ББСБ-ын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нэмэгдэж 2.5 тэрбум төгрөгт хүрэв.

Орлуулах бүтээгдэхүүн:

- Арилжааны банкуудаас гаргаж буй кредит карт

2.3. Зах зээлийн багтаамж

Жижиг дунд бизнесийн зээл

Жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийг эрчимтэй дэмжиж, бодлогоор хөгжүүлэх нь дэлхийн улс орнуудын эдийн засгийн нэн тэргүүний зорилго хэвээр байна. ЖДҮ-ийг хөгжүүлэх нь ядуурал, ажилгүйдлийг бууруулахын зэрэгцээ эдийн засгийн өсөлт хүртээмжтэй байхад чухал үүргийг гүйцэтгэдэг. Түүнчлэн ЖДҮ-ийг хөгжүүлснээр орлогын тэгш бус байдлыг бууруулах, нийгмийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх, хувийн секторын хөгжлийг хангахад онцгой хувь нэмэр үзүүлдэг.

График 38. ААН, ЖДҮ эрхлэгчдийн тоо



Эх сурвалж: УСХ, ХХААХҮЯ


2016 оны байдлаар бизнес регистрийн санд бүртгэлтэй 141,502 аж ахуйн нэгжээс 72,182 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 78% буюу 56,189 аж ахуйн нэгж жижиг, дунд үйлдвэрийн салбарт хамаарч байна. Статистик үзүүлэлтээс харахад жижиг, дунд үйлдвэрийн салбарт 730,000 хүн ажиллаж байгаа нь нийт ажиллах хүчний 57%-ийг эзэлж байна.

Монгол улсын Засгийн газраас ЖДҮ-ийн талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлийг тогтоож 2007 онд “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хуулийг батлан гаргаж, 2008 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Жижиг, дунд үйлдвэрийн газар, 2009 онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санг байгуулсан. Төрөөс ЖДҮ-ийг хөгжүүлэх, бизнесийн орчинг сайжруулахад анхаарч 2009 оныг “Үйлдвэрлэлийг дэмжих жил”, 2010 оныг “Бизнесийн орчны шинэтгэлийн жил”, 2011 оныг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил”, 2012 оныг “Өрхийн хөгжлийг дэмжих жил”-ээр тус тус зарласан бөгөөд 2014 онд Засгийн газраас “Жижиг, дунд



000080






Үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр (2014- 2016)"-ийг баталсан. Уг хөтөлбөрийн хүрээнд 2016 оныг “Дотоодын үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжих жил”-ээр зарлан жижиг, дунд үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлд тодорхой бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж иржээ. “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах түр журам”-ын дагуу 2009-2016 оны хооронд нийт 775.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 7,173 төсөлд олгосон байна”¹

Монголбанкны 2017 оны 9 сард явуулсан жижиг дунд үйлдвэрлэлийн түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 56 хувь нь өмнө нь тодорхой хэмжээний гадаад санхүүжилт авч байсан бол үлдсэн 44 хувь нь санхүүжилт авч байгаагүй гэж хариулжээ. Гадаад санхүүжилт хамрагдаж байсан ЖДҮ эрхлэгчдийн 88 хувь нь банк, санхүүгийн байгууллагаас санхүүжиж байсан байна. Судалгаанд хамрагдсан ААН, иргэдийн 65 хувь нь үйл ажиллагаагаа цаашид эрхлэхэд санхүүжилт зайлшгүй хэрэгцээтэй гэж үзсэн бол 27 хувь нь санхүүжилт авах шаардлагагүй гэж хариулжээ.

Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн 65 хувь нь цаашид үйл ажиллагаа эрхлэхэд санхүүжилт зайлшгүй шаардлагатай гэж үзсэн байна.

Санхүүжилтийн хэрэгцээ зайлшгүй шаардлагатай гэж үзсэн ЖДҮ эрхлэгчдийн 63 хувь банк, санхүүгийн байгууллагаас зээл авах замаар санхүүжих хүсэлтэй байна хэмээжээ.

График 39. ЖДҮ-ийн шаардлагатай санхүүжилтийн хэмжээ



Үйл ажиллагаанд санхүүжилт шаардлагатай гэж үзсэн ЖДҮ эрхлэгчдийн 32.7 хувь нь 10-аас 50 хүртэлх сая төгрөгийн санхүүжилт бизнесийн үйл ажиллагаа явуулахад нь шаардлагатай гэж үзсэн бол 28.7 хувь нь 5 сая хүртэлх, 17.4 хувь нь 5-аас 10 хүртэлх, 17.6 хувь нь 50-иас 100 сая хүртэлх, 18.4 хувь нь 100 саяас дээш төгрөгийн санхүүжилт хэрэгцээтэй гэж хариулжээ.

Эх сурвалж: Монголбанк, Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал (2017)

Монголбанкны жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн түүвэр судалгаа болон Үндэсний статистикийн хорооны бизнес регистрийн санд бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн тоонд тулгуурлан тооцоолоход жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд нийт 1.9 их наяд төгрөгийн санхүүжилтийн хэрэгцээ байна.

Өрхийн зээл, хэрэглээний зээл

2017 оны 10 сарын байдлаар давхардсан тоогоор 1 сая гаруй иргэн банк, санхүүгийн байгууллагуудад зээлийн үлдэгдэлтэй байгаа нь Монгол Улсын нийт өрхийн тооноос өндөр буюу дунджаар өрх тус бүрт 1 хүн зээлтэй байгааг харуулж байна.



<https://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/tosol23.pdf>

000081




CSX
 2019.01.09
 БҮРТГЭЛ
 № 01

Үнэт цаасны танилцуулга

МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ ТЭГЭРГ
 АРД КРЕДИТ ББСБ
 2018-11-29
 БҮРТГЭЛ-02

График 40. Иргэдийн зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөг)




Эх сурвалж: YCX

2018 оны 3 дугаар улиралд иргэдийн зээлийн үлдэгдэл 8.2 их наяд төгрөгт хүрч 2013 оны дүнгээс 76.4 хувь өссөн байна. Үүнд орон сууцны ипотекийн зээлийн үлдэгдэл нэмэгдсэн, иргэдийн бодит орлого буурсан, бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн, цалин тэтгэврийн зээл нэмэгдсэн зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна.


2017 оны эцсийн байдлаар өрхийн сарын дундаж мөнгөн орлого нь 936 мянган төгрөг байсан бол дундаж мөнгөн зарлага 993 мянган төгрөг байсан юм. Монголбанкны Нийгэм-эдлийн засаг, өрхийн амьжиргааны түүвэр судалгаанаас үзэхэд нийт өрхийн 41 хувь нь илүүдэл зардлаа банкны зээлээр санхүүжүүлдэг гэсэн бол 28 хувь нь ойр дотны хүмүүсээс зээл авдаг, 20 хувь нь бусад санхүүгийн байгууллагаас зээл авж санхүүжүүлдэг гэсэн байна.

График 42. Өрхийн мөнгөн орлого, зарлага



Эх сурвалж: YCX

График 41. Өрхийн илүүдэл зардал санхүүжүүлэх үүсвэр



Эх сурвалж: Монголбанк, НЭӨС түүвэр судалгаа

2017 оны байдлаар Монгол улсын нийт өрхийн тоо 885.6 мянгад хүрсэн ба нийт өрхийн орлогоос давсан санхүүгийн хэрэгцээ нь сард 50.4 тэрбум төгрөг байх боломжтой ба жилд 604.5 тэрбум төгрөгийн багтаамжтай байх боломжтой байна.

Мөн ЛэндМН ББСБ-ын үнэт цаасны танилцуулгад нас орлогын түвшинд суурилсан, орлого, зарлагад суурилсан, технологийн хэрэглээгээр тодорхойлсон, ББСБ-ын зээлийн үзүүлэлтээр тодорхойлсон, бизнесийн мөчлөгт үндэслэсэн зэрэг 5 аргачлалаар бичил хэрэглээний зээлийн зах зээлийн багтаамжийг тооцоолсон ба дундаж зах зээлийн багтаамж нь 900 тэрбум төгрөг байна.

2.4. Ард Кредит ББСБ-ын бизнесийн үйл ажиллагаа

Ард Кредит ББСБ-ын үйл ажиллагааны үндсэн зорилго нь орчин үеийн санхүүгийн технологи, хамтран ажиллагч байгууллагуудын дэд бүтцийг ашиглан Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгжүүдэд хэрэглээний болон жижиг дунд бизнесийн зээлийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх юм. Энэхүү зорилгынхоо хүрээнд компани нь ирэх 5 жилд шинээр "Ард" ашигтэйшд суурилсан санхүүгийн үйлчилгээ, хувьцаа барьцаалсан зээл зэрэг шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчиддаа хүргэхээр төлөвлөөд байна. Үүний дагуу ирэх 5 жилд доорх зээлийн бодлогийг барьж ажиллахаар төлөвлөөд байна. Үүнд:

ARL CAPITAL GROUP SECURITIES COMPANY LLC
 УЛААНБААТАР ХОТ ТТ8637-25982855

000082

УЛААНБААТАР ХОТ
 АРД КРЕДИТ ББСБ
 ТТГ5746-5459567

С Үнэт цаасны танилцуулга
2019-01-09
БҮРТГЭЭ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨН АЖИЛЛАГАА
АРД КРЕДИТ ББСБ
2019-11-29
БҮРТГЭЭ-42

- Орчин үеийн санхүүгийн технологи, хамтран ажиллагч байгууллагуудын дэд бүтцийг ашиглан Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгжүүдэд хэрэглээний болон жижиг дунд бизнесийн зээлийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэнэ.
- Бид уламжлалт санхүүгийн үйлчилгээг илүүд үздэг харилцагчиддаа ч зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг өөрсдийн оффис болон хамтран ажиллагч байгууллагуудын салбаруудаар дамжуулан үзүүлсээр байх болно.
- Зээлийн бүтээгдэхүүний зорилтот зах зээлээр байгууллагын болон иргэдийн зээл байх болно. Тэр дундаа зээлийн багцын 65.0 хувийг хэрэглээний зээлийн бүтээгдэхүүн, 35 хувийг бизнесийн зээлийн үйлчилгээ бүрдүүлэхээр төлөвлөж байна.
- Зээлийн хүүгээ бууруулж, бизнесийн зээлээ сарын 1.99%-2.3%-ийн хүүтэй олгохоор төлөвлөсөн бол хэрэглээний зээлийг 1.56%-3.0%-ийн хүүтэй олгохоор төлөвлөсөн.

Ард Кредит ББСБ нь зээлийн багцыг 100 хувь барьцаагүй зээл бүрдүүлэх нь хэт эрсдэлтэй хэмээн үздэг бөгөөд өөрийн зээлийн багцын эрсдэлийг зохистой түвшинд хадгалах зорилгоор барьцаагүй зээлийн хэмжээг нийт зээлийн багцын 45 хувьд хадгалах стратеги барин ажиллана. 2022 онд хэрэглээний зээл нь нийт зээлийн багцын 65 хувийг бүрдүүлэхээр төлөвлөж байгаа ба үүнээс Ард зээл болон Ард кредит картын бүтээгдэхүүнүүд нь 100 хувь барьцаагүй зээлүүд бол хувьцаа барьцаалсан болон цалингийн зээлүүд нь тодорхой хэмжээний барьцаа шаардах зээл юм. Ард Кредит нь зээлийн багцын эрсдэл болон нэмүү эрсдэлд оногдох өгөөжийг шийдвэр гаргалтад анхааралтай авч үздэг ба компанид ашигтай гэж үзсэн тохиолдолд зээлийн багцын эрсдэлийг тодорхой хэмжээгээр өсгөдөг.

Ард Кредит ББСБ нь өөрийн зээлийн багцын эрсдэлийг зохистой түвшинд хадгалах зорилгоор барьцаагүй зээлийн хэмжээг нийт зээлийн багцын 45 хувьд хадгалах стратеги барин ажиллана. 2022 онд хэрэглээний зээл нь нийт зээлийн багцын 65 хувийг бүрдүүлэхээр төлөвлөж байгаа ба үүнээс Ард зээл болон Ард кредит картын бүтээгдэхүүнүүд нь 100 хувь барьцаагүй зээлүүд бол хувьцаа барьцаалсан болон цалингийн зээлүүд нь тодорхой хэмжээний барьцаа шаардах зээл юм. Монголбанк нь мөн иргэдийн өрийн дарамтыг хязгаарлах бодлого баримталж байгаа ба 2018 оны 6 сарын 15-ны өдөр гаргасан мөнгөний бодлогын мэдэгдэлд “өрхийн орлого алгуур нэмэгдэж байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд огцом нэмэгдэж буй иргэдийн хэрэглээний зээлийн өсөлт өндөр түвшинд хүрч өрхийн өрийн түвшинг нэмэгдүүлж байна. Иймээс Монголбанк иргэдийн өрийн дарамтыг хязгаарлаж улмаар санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх хэрэгтэй” хэмээжээ. Уг мөнгөний бодлогын мэдэгдэлээр Монголбанк иргэдийн хэрэглээний зээлийн өр-орлогын харьцааны дээд хязгаарыг 70 хувиар тогтоосон ба мөн 2018 оны 9 сарын 20-ны өдрийн мөнгөний бодлогын мэдэгдэлд иргэдийн хэрэглээний зээлийн хугацааг 30 сараас дээшгүй байхаар тус тус хязгаарлаад байна.

2017 оны байдлаар компани нь бизнесийн, хэрэглээний, шуурхай гэсэн 3 төрлийн үндсэн зээлд хуваагдах 12 төрлийн төрөлжсөн бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчдад хүргэж байсан билээ. Харин ирэх 5 жилд компани нь хүртээмжтэй санхүүжилтийг түгээх стратегийн хүрээнд хэрэглээний болон жижиг дунд бизнесийн зээлд төвлөрөн ажиллахаар төлөвлөж байна. 2022 онд зээлийн багцын 35.0 хувийг бизнесийн зээл, үлдсэн 65.0 хувийг хэрэглээний зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрдүүлэхээр төлөвлөж байна.


Зээл	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл
------	----------------	------------------

Зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ	- Жижиг, дунд бизнес - Бичил бизнесийн зээл	- Цалингийн зээл - Кредит карт
---------------------------------	--	-----------------------------------



000083





	- Төслийн зээл	- Ард зээл - Хувьцаа барьцаалсан зээл 2
Зээлийн нөхцөл	- Хугацаа: 3-24 сар - Хүү: 1.99-2.3%	- Хугацаа: 3-24 сар - Хүү: 1.56-3.0%

“Ард” аппликэйшний хэрэглээ нэмэгдэхийн хэрээр шуурхай, цалингийн, хэрэглээний, худалдан авалтын зээлүүд “Ард” бүтээгдэхүүнд шилжинэ хэмээн төсөөлж байгаа ба орон сууц худалдан авалтын зээлүүд нь уламжлалт арга барилтай тул ирэх 5 жилийн хугацаанд уг 7 зээлийн бүтээгдэхүүнийг зогсоох төлөвлөгөөтэй байна.

Хүснэгт 45. Бүтээгдэхүүн үйлчилгээний зээлийн багцад эзлэх хувь

	2017	2018*	2019*	2020*	2021*	2022*
Бизнесийн зээл						
Жижиг дунд бизнес	38.6%	45.0%	40.0%	35.0%	30.0%	25.0%
Бичил бизнесийн зээл	5.7%	6.5%	6.0%	5.5%	5.0%	5.0%
Төслийн зээл	2.0%	2.0%	5.0%	5.0%	5.0%	5.0%
Бөөний зээл	3.8%	3.0%	2.0%	1.0%	0.0%	0.0%
Хэрэглээний зээл						
Ажиллагсдын зээл	2.5%	2.5%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Итгэлцэл барьцаалсан зээл	0.0%					
Өрхийн зээл	1.3%	2.0%	2.0%	1.0%	0.0%	0.0%
Хэрэглээний зээл	1.7%	2.0%	1.0%	0.0%	0.0%	0.0%
Цалингийн зээл	4.0%	2.0%	4.0%	6.0%	8.0%	10.0%
Зээлийн карт	7.2%	7.5%	10.5%	13.5%	14.0%	15.0%
Орон сууцны зээл	4.1%	4.0%	3.0%	2.0%	1.0%	0.0%
“Ард” аппликэйшн Хувьцаа барьцаалсан зээл		1.0%	7.5%	15.0%	24.0%	30.0%
		2.5%	4.0%	6.0%	8.0%	10.0%
Шуурхай зээл	29.0%	20.0%	15.0%	10.0%	5.0%	0.0%
Нийт зээл	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%

Компани нь 2017 онд 691 харилцагчтай байсан бөгөөд энэ нь өмнөх оноос 110.0 хувиар өссөн үзүүлэлт юм. Ирэх 5 жилд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж байгаатай холбогдуулан харилцагчийн тоо жил бүр дунджаар 146.9 хувиар өсөж, 2022 онд 51,602 харилцагчтай болохоор төлөвлөж байна.

Хүснэгт 46. Харилцагчийн тоо, зээлийн төсөөлөл

	2017	2018*	2019*	2020*	2021*	2022*
Харилцагчдын тоо	691	1,933	7,204	14,645	31,415	51,602
Зээлийн үлдэгдэл (сая төгрөг)	7,975	16,522	29,536	35,485	54,543	75,203

Компани нь 2017 онд 8.0 тэрбум төгрөгийн зээлийн багцтай байсан бөгөөд энэ нь өмнөх оноос 56.1 хувиар өссөн үзүүлэлт юм. Бид ирэх 5 жилд зээлийн багцаа дунджаар 56.6 хувиар өсгөж, 2022 онд 75.2 тэрбум төгрөгийн зээлийн багцтай байхаар төлөвлөж байна. Тус онд зээлийн



000084



СЗХ
 2019 оны 01, 09 сар
 БҮРТГЭВ
 № 01

ARD КРЕДИТГИЙН БӨГӨӨД
 ББСБ-ЫН ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
 2018-11-29
 БҮРТГЭВ-02

багцын 35.0 хувийг бизнесийн зээл, үлдсэн 65.0 хувийг хэрэглээний зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрдүүлэх юм.
 Хүснэгт 47. Зээлийн үлдэгдэл

	2017	2018*	2019*	2020*	2021*	2022*
Бизнесийн зээл	3,999	9,335	15,654	16,500	21,817	26,321
Хэрэглээний зээл	1,663	3,883	9,451	15,436	29,999	48,882
Кредит карт	574	1,239	3,101	4,790	7,636	11,281
Ард	-	165	2,215	5,323	13,090	22,561
Бусад	1,089	2,478	4,135	5,323	9,272	15,041
Шуурхай зээл	2,312	3,304	4,430	3,548	2,727	-
Нийт зээл	7,975	16,522	29,536	35,485	54,543	75,203
Зээлийн эрсдэлийн сан	(178)	(691)	(1,236)	(1,485)	(2,282)	(3,147)
Цэвэр зээл	7,796	15,831	28,300	34,000	52,261	72,056

Итгэлцэл

Итгэлцлийн үйлчилгээ нь Ард Кредит ББСБ-ын чухал бүтээгдэхүүн, үйлчилгээний нэг бөгөөд харилцагчдаас мөнгөн хөрөнгийг итгэлцлийн үндсэн дээр авч зах зээлийн эрсдэл үнэгүйдлээс хамгаалж, өндөр өгөөж олгох зорилгоор зээл хэлбэрээр гаргадаг үйл ажиллагааг итгэлцэл гэдэг байна. Уг бүтээгдэхүүн, үйлчилгээ нь компанийн санхүүжилтийг нэмэгдүүлэх боломж олгодог бөгөөд дээд хязгаарыг Санхүүгийн Зохицуулах Хорооноос тогтоож өгдөг болно. Одоогоор СЗХ-оос итгэлцлийн нийт хөрөнгө нь өөрийн хөрөнгийн 80.0 хувь буюу түүнээс бага байна гэж заасан байна. Цаашид компанийн үйл ажиллагаа тэлэхийн хэрээр өөрийн хөрөнгийн хэмжээ нэмэгдэх тул тогтоосон дээд хязгаарын хүрээнд итгэлцлийн үйлчилгээний хэмжээг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 48. Итгэлцлийн үйлчилгээний нөхцөл

Хугацаа	6 сар - 24 сар
Хүү (жил)	12% - 18%
Татах доод хэмжээ	3 сая төгрөг

Уг бүтээгдэхүүн, үйлчилгээ нь компанийн санхүүжилтийг нэмэгдүүлэх боломж олгодог бөгөөд дээд хязгаарыг Санхүүгийн Зохицуулах Хорооноос тогтоож өгдөг болно. Одоогоор СЗХ-оос “ББСБ-ын итгэлцлийн үйлчилгээ нь өөрийн хөрөнгийн 80.0 хувь буюу түүнээс бага байна” гэж зааж өгсөн байдаг. 2017 онд компани нь 2.8 тэрбум төгрөгийн итгэлцлийн үйлчилгээ татаж байсан бол СЗХ-оос тавьсан хязгаарын хүрээнд ирэх 5 жилд итгэлцлийн үйлчилгээг жилд дунджаар 49.5 хувиар өсгөж, 2022 онд 20.1 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөж байна.


Хүснэгт 49. Итгэлцлийн төсөөлөл

	2017	2018*	2019*	2020*	2021*	2022*
Татах итгэлцэл	2,773	6,662	7,835	12,640	19,214	30,109
Буцаан төлөх итгэлцэл	1,639	3,364	7,245	10,120	14,981	23,347



000085






№ Үлдэгдэл	2,690	5,988	6,578	9,098	13,332	20,100
------------	-------	-------	-------	-------	--------	--------

2.4.1. Бичил болон Жижиг дунд бизнесийн зээл

Бичил болон жижиг, дунд бизнесийн зээл нь бизнесийн зээлийн нэг төрөл бөгөөд үйлдвэрлэл, худалдаа, санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, иргэдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгодог юм. 2017 оны байдлаар Ард Кредит ББСБ-аас олгосон бичил болон жижиг дунд бизнесийн зээл нь нийлээд нийт зээлийн багцын 44.3 хувь буюу 3.5 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь компанийн үйл ажиллагааны нэн чухал хэсэг гэдгийг харуулж байна. Иймд Ард Кредит ББСБ нь бичил болон жижиг дунд бизнесийн зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь хэмжээг тогтвортой барихаар зорьж байгаа бөгөөд 2022 оны байдлаар нийт зээлийн багцын 30.0 хувьд хүргэхээр төлөвлөсөн. Энэ нь мөнгөн дүнгээр 22.6 тэрбум төгрөг юм.

График 43. Бичил болон жижиг дунд бизнесийн зээл (сая төгрөг)



Ард Кредит ББСБ нь иргэдэд санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй байлгах үүднээс 2017 онд бизнесийн зээлийн сарын хүүг 2.3 хувь болгон бууруулж, ББСБ-ын салбарт хамгийн бага хүүг санал болгосон бөгөөд хүү буурсантай холбоотой эзэлдэгчид үүсэх санхүүгийн дарамт багассан. Тухайлбал, Ард Кредит ББСБ-ын нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь 4.3 хувь байгаа нь салбарын дунджаас 2 дахин бага буюу 8.4 пунктээр доогуур байна. Цаашид компани нь бичил болон жижиг дунд бизнесийн зээлийн хүүгээ бууруулах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд 2022 он гэхэд сарын хүүгээ 1.99 хувьд хүргэхээр төлөвлөөд байна

2.4.2. Төслийн болон хоршоо хөгжлийн зээл

Ард Кредит ББСБ нь 2014 оноос Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн бага орлоготой иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор “Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан” (БСХС)-тай хамтран төслийн бага хүүтэй зээлийг дамжуулан олгож эхэлсэн билээ.



000086




Сүү
Унот цаасны танилцуулга
он 2019 о. 01. 09 өдөр
БҮРТГЭВ
№ 01
Шигтгээ 2.

АРД КРЕДИТ ББСБ
2019-11-29
БҮРТГЭВ-02

БСХС нь 2002 онд бичил зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, улмаар салбарын хөгжлийг дэмжих зорилгоор байгуулагдсан ба бичил санхүүгийн салбарын хөгжлийг дэмжих, салбарын чадавхыг бэхжүүлэх, хөдөө орон нутгийн иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг явуулдаг байна.

Ард Кредит ББСБ нь “Тогтвортой амьжиргаа” төслийн хүрээнд БСХС-тай 2014 онд 300.0 сая төгрөг, 2015 онд 500.0 сая төгрөгийн дамжуулан зээлдэх гэрээ байгуулан, Улаанбаатар хотын Сонгино хайрхан, Баянзүрх, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул дүүрэг, хөдөө орон нутгаас Баян-Өлгий, Завхан, Ховд, Булган, Төв, Увс, Сүхбаатар, Архангай, Баянхонгор, Дорнод, Дархан-Уул, Говьсүмбэр зэрэг аймгуудын иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгосон байна.

Зураг 6. Төслийн хамрах хүрээ



Баянхонгор, Дорнод, Дархан-Уул, Говьсүмбэр зэрэг аймгуудын иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгосон байна.


Ард Кредит ББСБ нь БСХС-тай урт хугацаанд хамран ажилласнаар санхүүгийн байгууллагын хувьд илүү хүртээмжтэй, зардал багатай санхүүгийн бүтээгдэхүүнийг иргэд, бичил бизнес эрхлэгчдэд хүргэх бололцоотой болсон. 2019 онд Компани нь БСХС-аас 1 тэрбум төгрөгийн санхүүжилт авч, ирэх 3 жилийн хугацаанд нийт 2,400 орчим хот, хөдөөгийн иргэд, бичил бизнес эрхлэгчдэд хүргэхээр төлөвлөж байна. Үүнд 800 хүн шууд, 1,600 орчим хүн шууд бусаар ашиг хүртэх боломжтой юм.

Төслийн зээлийн ерөнхий нөхцөл:

Төслийн зээлийг дамжуулан олгохдоо зээлийн нөхцөл дээр анхаарч дунджаар сарын 1.8 хувийн хүүтэйгээр олгох

төлөвлөгөөтэй байгаа ба бичил зээлийг илүү хүртээмжтэй байлгах үүднээс зээлийн дундаж хэмжээг ойролцоогоор 3 сая төгрөгт хадгалахаар төсөөлсөн болно.

График 44. Төслийн зээл (сая төгрөг)



Ард Кредит ББСБ нь бага орлоготой иргэдэд хүү багатай зээлийн үйлчилгээ үзүүлэхээс гадна санхүүгийн боловсрол, мэдээ мэдээллээр ханган ажиллаж ирсэн бөгөөд энэ нь зээлийн эргэн төлөлтөд эерэг үр дүн үзүүлсээр ирсэн.

АРД КАПИТАЛ ГРУП
АРД КРЕДИТ ББСБ
УЛААНБААТАР
ARD CAPITAL GROUP
SECURITIES COMPANY
LLC
7703855
000087

АРД
КРЕДИТ ББСБ
УУХ
86

2.3.3. Кредит карт

2016 онд Ард Кредит ББСБ нь Худалдаа Хөгжлийн Банктай хамтарч “Ард” кредит карт гаргасан билээ. Ингэснээр ББСБ-ын салбарт олон нийтэд зориулан кредит карт гаргасан анхны банк бус санхүүгийн байгууллага болсон бөгөөд энэхүү үйлчилгээ нь харилцагчдын талархлыг хүлээгээд байна. “Ард” кредит карт нь цалин болон бизнесийн орлоготой бүхий л хэрэглэгчдэд зориулагдсан компаниас олгосон зээлийн эрхийн хэмжээнд бэлэн мөнгө авах, төлбөр тооцоо гүйцэтгэх боломжтой зээл болон картын шинж чанарыг аль алийг агуулсан бүтээгдэхүүн юм. Тухайлбал, харилцагч энэхүү картыг Ард Кредит ББСБ дээр нэг удаа ирж нээлгэсэн байхад гэнэтийн мөнгөний хэрэгцээ гарах эсхүл шаардлагатай зүйлээ худалдан авахад мөнгө хүрэлцэхгүй байгаа тохиолдолд зээл хүсэж, бичиг цаас бололгүйгээр өөрийн тодорхой зээлийн эрхийн хэмжээнд зээл авч ашиглаад эргүүлэн төлөх боломжтой карт юм.

Зураг 7. Ард Кредит картын загвар



“Ард” кредит карт нь дараах нөхцөлтэй байна:

	Зээлийн карт 1	Зээлийн карт 2
Ашиглах хэлбэр	-Зээлээр худалдан авалт хийх -Бэлэн мөнгө зээлж авах -Цалингаа картаараа авах -Бэлэн мөнгө байршуулах	-Зээлээр худалдан авалт хийх -Бэлэн мөнгө зээлж авах -Цалингаа картаараа авах -Бэлэн мөнгө байршуулах
Хураамж -Элсэлтийн хураамж -Жилийн хураамж	-0 төг -30,000.0 төг	-0 төг -30,000.0 төг
Зээлийн эрх -Доод хэмжээ -Дээд хэмжээ	-500.0 мян.төг -10.0 сая төг	-500.0 мян.төг -5.0 сая төг
Төлөх төлбөрийн доод хэмжээ	Зээлийн үнийн дүнгийн 10%	Зээлийн үнийн дүнгийн 10%



000088



Үнэт цаасны танилцуулга
2019.01.09

МОНГОЛ АРД КРЕДИТ ББСБ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2018-11-29

Зээлийн хүү	2.6%	2.8-3.0%
Зээл эргэн төлөх хугацаа	Сар бүрийн 15-ны өдөр	Сар бүрийн 15-ны өдөр
Картын Хүчинтэй хугацаа		
- Доод хугацаа	- 12 сар	- 12 сар
- Дээд хугацаа	- 24 сар	- 24 сар

Кредит картын өрсөлдөгчийн судалгаа

Манай улсад одоогоор мастер, виза, юнион пэй кредит картууд ашиглагдаж байна. Кредит карт нь буюу зээлийн карт нь хүмүүсийн цаг хугацаа, зардлыг хэмнэсэн, гэнэтийн санхүүгийн хэрэгцээгээ хангах боломжийг олгодгоороо давуу талтай юм. Монгол Улсын хэмжээнд Хаан Банк, Худалдаа Хөгжлийн Банк, Голомт Банк, Төрийн Банк, Улаанбаатар Хотын Банк, Чингис Хаан Банк, ХасБанк нь кредит картын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэн ажиллаж байна. Зах зээлд нэвтэрсэн кредит картуудаас Голомт, Хаан болон ХХБ-ны кредит картууд эрэлттэй байна. Банк бус санхүүгийн байгууллагын салбарт Ард Кредит ББСБ-аас гадна “Жи Эс Би Капитал ББСБ” ХХК нь зөвхөн Шунхлай группийн ажиллагсдад зориулан кредит карт гаргасан байна. Дээр дурдсан зээлийн картуудыг доорх байдлаар харьцуулав:

Хүснэгт 50. Зах зээлд нэвтэрсэн кредит картны харьцуулалт

	Голомт Банк		Хаан банк		Жи Эс Би капитал ББСБ
	Энгийн мастер карт	Алтан мастер карт	Алтан карт	Энгийн карт	Энгийн карт
Жилийн хураамж (мян төг)	Үнэгүй	100.0	50.0	20.0	30.0
Өдрийн бэлэн мөнгөний хязгаар (сая төг)	4.0	5.0	16.0	8.0	байхгүй
Зээлийн лимит	- 5.0 сая. төг	- 15.0 сая. төг	-15.0 сая төг	-15.0 сая төг	-3.0 сая төг
- Дээд хэмжээ	- 100.0 мян.төг	- 2.0 сая төг	-300.0 мян.төг	-300.0 мян.төг	- 500.0 мян.төг
Бэлэн бус гүйлгээний зээлийн хүү	2% (зарцуулалт төлөх эцсийн өдрөөс)	2% (зарцуулалт төлөх эцсийн өдрөөс)	2.0%	2.0%	3.0%
Бэлэн мөнгөний зээлийн хүү	3.5% (Бэлэн мөнгө авсан өдрөөс)	3.5% (Бэлэн мөнгө авсан өдрөөс)	2.5%	2.5%	3.0%
Эргэн төлөх доод хэмжээ	20.0%	20.0%	10.0%	20.0%	
Хугацаа хэтгүүлсний	1.0%	1.0%	25,000	25,000	

ARLD CAPITAL GROUP SECURITIES COMPANY LLC
УЛААНБААТАР ХОТ ТТ8855

000089

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХХК
ТТГ536 д.549567

СҮЙЭТ цаасны танилцуулга
 он 2019 с. 01. 0-р сар
 БҮРТГЭВ
 ШИМТГЭЛ

АРД КРЕДИТ ББСБ
 2018-11-29
 БҮРТГЭВ-02


Картын хүчинтэй хугацаа	2 жил	2 жил	2 жил	2 жил	2 жил
-------------------------	-------	-------	-------	-------	-------

“Ард” кредит карт нь хязгаарлагдмал бус хүрээнд, нийтэд зориулагдсанаараа онцлог бөгөөд ББСБ-ын зах зээлд анхдагч нь болсон. “Ард” кредит картын бусад банкны картаас ялгарах хамгийн том давуу тал бол бэлэн бусаар өөрийн кредит картын данснаас бусад аль ч банкны дансанд мөнгөн шилжүүлэг хийх боломжтой бөгөөд энэ нь харилцагчдын цаг завьг хэмнэсэн чухал ач холбогдолтой үйлчилгээ юм. Одоогийн байдлаар бусад банкны кредит картууд АТМ – с бэлнээр мөнгө авах болон ПОС-н машинаар бэлэн бусаар төлбөр тооцоо гүйцэтгэх боломжтой байгаа бөгөөд зөвхөн Ард Кредит ББСБ-ын “Ард” кредит карт нь гар утсаа ашиглан бэлэн бусаар шилжүүлэг хийх боломжийг олгож байна.

График 46. Кредит картын зээл (тэрбум төгрөг)



График 45. Кредит картын зээлийн чанар



Кредит картын зээл 2012 онд 167.6 тэрбум төгрөг байсан бол 2014 он гэхэд огцом өсөж 262.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Түүнээс хойш тасралтгүй буурсаар 2017 онд 116.3 тэрбум төгрөгт хүрчээ. Зээлийн чанар мөн буурсан үзүүлэлттэй байна. Хэвийн зээл 97.0 хувиас 85.0 хувь хүртэл буурч, хугацаа хэтэрсэн зээл 1.0 хувиас 5.0 хувь хүртэл өсөж, чанаргүй зээл 2.0 хувиас 10.0 хувь хүртэл өссөн дүнтэй байна. Энэ нь эдийн засгийн орчин муудаж хүмүүсийн хэрэглээ багасантай холбоотой ба мөн арилжааны банкууд хэрэглэгчдийн зээлийн эргэн төлөлтөд бага анхаардагтай холбоотой.

Кредит картын төлөвлөгөө

Ард Кредит ББСБ-ын шинээр нэвтрүүлсэн кредит картын зээлийн үлдэгдэл 2016 онд 83.0 сая төгрөг байсан бол 2017 оны эцэст 573.9 сая төгрөг болж 5.9 дахин нэмэгдсэн. 2017 оны эцсийн байдлаар нийт 429 хүн “Ард” кредит картыг эзэмшиж байгаа ба цаашид дараах байдлаар өснө гэж төсөөлөв.

Хүснэгт 51. Ард Кредит картын харилцагчдын тооны төсөөлөл

/Өссөн дүнгээр/	2018	2019	2020	2021	2022
Нийт харилцагчдын тоо	600	1260	1920	2580	3240
Шинэ харилцагчдын тоо	600	1200	1800	2400	3000



000090



СҮНэт цаасны танилцуулга
 2019.01.09
 БҮРТГЭВ
 № 01

МОНГОЛ АРД КРЕДИТ ББСБ
 2018.11.29
 БҮРТГЭВ-02

Давтан харилцагчдын тоо		60	120	180	240
Зээлийн үлдэдэл (сая төгрөг)	1,239	3,101	4,790	7,636	11,281

2.3.4. “Ард” бүтээгдэхүүн, үйлчилгээ

Харилцагчдад амар хялбар, зардал багатай, найдвартай санхүүгийн үйлчилгээг үзүүлэх нь Ард Кредит ББСБ-ын зорилго юм. Иймээс төлбөр тооцоо хийх, зээл авах зэрэг санхүүгийн бүхий л үйлчилгээг гар утсаа ашиглан авах боломжийг харилцагчиддаа олгохоор Ард Кредит ББСБ нь “Ард” аппликэйшнийг зах зээлд нэвтрүүлээд байна. Энэхүү аппликэйшнээр дамжуулан Ард Кредит ББСБ нь санхүүгийн хамгийн сүүлийн үеийн технологийн ололт амжилтыг ашиглан өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээг Монгол Улсын ард иргэдэд илүү хялбараар хүргэх юм.

Ард Кредит ББСБ нь “Ард” аппликэйшнийг “Мост ПСП” ХХК болон “Грэйпсита Монголиа” ХХК-тай хамтран бүтээсэн билээ. “Ард” аппликэйшн нь Монгол Улсын үндэсний хэмжээний цахим төлбөр тооцооны систем, оператор болох Мост Мони платформ дээр суурилан ажиллах юм. Систем нь бүх банкуудыг холбосон нээлттэй интерфэйстэй бөгөөд Монголбанкны клирингийн сүлжээг ашигласан банк хоорондын тооцооны онлайн шийдэлтэй болно.

Хууль эрх зүй

2002 оны 12 сарын 12-ны өдөр батлагдсан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, 2005 оны 11 сарын 17-ны өдөр батлагдсан СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хууль, 2012 оны 12 сарын 12-ны өдөр Монгол Банкны Ерөнхийлөгч, СЗХ болон Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга нар хамтран баталсан Хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний талаар баримтлах бодлого, 1997 онд Монголбанкнаас баталсан Банк хоорондын клирингийн тооцооны журам, 2006 онд Монголбанкнаас баталсан Банк хоорондын их дүнтэй төлбөр тооцооны журам, Банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцоон журам зэрэг нь технологийн дэвшлийг ашиглан бэлэн бус төлбөр, тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээг эрхлэх үйл ажиллагаа зохицуулж байгаа болно. Тухайлбал, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд “Банк бус санхүүгийн байгууллага нь төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад валютын арилжаа зэрэг үйл ажиллагааг эрхэлж болох ба энэ үйл ажиллагаатай холбогдсон төлбөр тооцоог банкаар зуучлуулж банк хоорондын төлбөр тооцоонд шууд бус оролцогчийн үүрэг гүйцэтгэхээр” тусгагдсан. Энэхүү хууль эрх зүйн зохицуулалтын дагуу Ард Кредит ББСБ нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2018 оны 5 сарын 23-ны өдөр авч “Ард” аппликэйшнийг хуулийн дагуу эрхлэх боломжтой болоод байна.

Танилцуулга, хөгжүүлэлт

Зураг 8. Ард аппликэйшн



“Ард” аппликэйшн нь харилцагч өөрийн гар утсаа ашиглан хаанаас ч банк, санхүүгийн үйлчилгээг авч санхүүгийн төлбөр тооцоогоо хийх, хянах боломжтой үйлчилгээ юм. “Ард” аппликэйшн нь мөнгөн шилжүүлэг, төлбөр тооцоо, зээлийн үйлчилгээ үзүүлэх цогц бүтээгдэхүүн бөгөөд өөрийн мөнгөн хөрөнгийг удирдах, захиран зарцуулах, хянах, боломжийг олгож байгаагаараа давуу талтай. Мөн компани нь цаашид Ард Санхүүгийн Нэгдэл нэрийн дор үйл ажиллагаа явуулж буй үнэт цаас, даатгал, хадгаламж зээлийн хоршоо зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, данс нээх, хадгаламж

АРД КАПИТАЛ ГРУПП ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ
 ARD CAPITAL GROUP SECURITIES COMPANY LLC
 9056 45459567

000091

МОНГОЛ АРД КРЕДИТ ББСБ
 ХХК
 9056 45459567

Сүүнэт цаасны танилцуулга
 2019 оны 11 сар
 БҮРТГЭВ
 № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ХАМГААГАХ
 HONGKONG STOCK EXCHANGE
 ARD КРЕДИТ ББСБ
 2019-11-29
 БҮРТГЭВ-02

үүсгэх, зээл авах, даатгал хийлгэх, тэтгэврийн санд хамрагдах, үнэт цаасны арилжаанд оролцох, гадаад мөнгөн гуйвуулга хийх зэрэг санхүүгийн цогц үйлчлэгээг “Ард” аппликэйшнээр хүргэхээр зорьж ажиллаж байна. Ингэснээр харилцагчид “Ард” аппликэйшнийг татаж суулгаснаар утсаараа дамжуулан доорх санхүүгийн цогц бүтээгдэхүүн үйлчилгээг газар зүйн байршил, цаг хугацаа харгалзахгүй, 24 цагийн турш дэлхийн хаанаас авах боломжтой болох юм.

“Ард” аппликэйшнээр одоо үзүүлж буй үйлчилгээ:

Данс Даны мэдээлэл, хууга	Шилжүүлэг Утасны дугаараар шилжүүлэх, өөрийн данс хооронд шилжүүлэх, банк хооронд шилжүүлэх, мөнгөн гуйвуулга	Төлбөр, тооцоо Билл төлөх, ногж авах, замчлалт төлбөр зийлэх	qPay QR кодээр төлөх, QR кодтой нэмэгдэх аргаар	Бэлэг мөнгө Банкны хэстгүүрээр ATM-ээс бэлэн мөнгө авах
---	---	--	---	---

“Ард” аппликэйшнээр цаашид үзүүлэх үйлчилгээ:

Харилцагч өөрөө бүртгүүлэх Харилцагч өөрийн утсаараа шилжлэн цахимгаар бүртгүүлэх	Онлайн зээл Цалим зээлийн хүсэлт болон олголт	Зээлжих эрх Харилцагчийн зээлжих эрхийг (Credit score) хиймэл оюун ухаан ашиглан тооцоолох	Валют арилжаа P2P буюу харилцагч хоорондын валют арилжаа	ePOS Мөнгөтүүдэд зориулсан төлбөрийн цахимгаар хүлээн авах систем
---	---	--	--	---

Одоогоор Ард Кредит ББСБ нь “Ард” аппликэйшнээр дамжуулан харилцагчийг өөрийн мөнгөн хөрөнгийг удирдах, захиран зарцуулах, хянах, төлбөр тооцоо төлөх боломжийг олгоод байна. Мөн 2018 ондоо багтаан 300,000-3,000,000 төгрөг хүртэлх зээлийг барьцаагүй, түргэн шуурхай авах боломжийг олгохоор ажиллаж байна. “Ард” аппликэйшнээр хүргэх зээлийн бүтээгдэхүүний ерөнхий нөхцөл дараах байдлаар байна:

“Ард” зээлийн ерөнхий нөхцөл:

Зээлийн хугацаа	1-3 сар
Зээлийн хэмжээ	300,000-3,000,000 төгрөг
Зээлийн хүү	2.6 - 3.0%
Зээлийн шимтгэл	Шатлалаар

Схем 6. “Ард” аппликэйшн онлайн зээл олгох үе шат




Харилцагч “Ард” аппликэйшнийг суулгаж, өөрийн зураг болон иргэний үнэмлэхний зургийг



000092





авж бүртгүүлнэ. Most Скор систем нь харилцагчийн оруулсан мэдээлэл, Хур систем дэх мэдээлэлд үндэслэн тусгай алгоритмаар кредит оношлогоог автоматаар хийж, “Ард” аппликэйшн нь харилцагчид зээлийн санал гаргах юм. Харилцагч зээлийн дүн болон хугацааг сонгон зээл авах хүсэлтийг илгээх ба Ард Кредит ББСБ нь “Ард” аппликэйшнээр дамжуулан зээлийг харилцагчийн дансанд шилжүүлэх юм. Харилцагч нь Монгол Шуудан ХК-ийн өөрт ойр салбар дээр очин нэг удаа Зээлийн гэрээ байгуулснаар зээлийн эрх нээгдэх юм.

Өрсөлдөгчийн судалгаа

Финтек буюу англиар Fintech гэдэг нь санхүүгийн технологи (financial technology) гэсэн 2 үгийн нийлмэл товчлол бөгөөд орчин үеийн техник технологийн дэвшилд тулгуурлан санхүүгийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилготойгоор үүссэн салбар юм. Технологийн хурдацтай хөгжлийг дагаад банк, санхүүгийн байгууллагууд ч өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээндээ технологийн дэвшлийг өргөнөөр ашиглаж байна.

Финтекийн тусламжтайгаар зээлийн үйлчилгээг түргэн шуурхай авах, peer-to-peer буюу хөндлөнгийн санхүүгийн зуучлагчийн оролцоогүйгээр энгийн хоёр хүн хоорондоо зээл олгох, авах, төлбөр тооцоог түргэн шуурхай гүйцэтгэх зэрэг давуу талууд бий болсон. Уламжлалт арга барилаар үйлчлүүлэгч нь санхүүгийн үйлчилгээг авахын тулд өөрийн биеэр санхүүгийн байгууллагын аль нэг салбар дээр очих, шаардлагатай анкет бөглөх, материал бүрдүүлэх зэргээр олон төрлийн шат дамжлага дамжиж цаг хугацаа алддаг байсан бол финтекийг нэвтрүүлснээр гар утас, компьютерийн тусламжтайгаар хэдхэн хормын дотор санхүүгийн үйлчилгээг хүртэх боломжтой.

Түүнчлэн финтекийн үр дүнд олон улсад дижитал банк, санхүүгийн байгууллагууд олноор гарч ирэх болсон бөгөөд эдгээр банкууд салбар, тооцооны төвгүй, бүх үйлчилгээгээ цахим хэлбэрээр хүртээдэг онцлогтой. Хамгийн ойрын жишээ бол Солонгос Улсад бидний мэдэх kakao talk-д үндэслэн 2017 оны 7 сард Какао дижитал банк байгуулагдсан бөгөөд сарын дотор 1.7 тэрбум долларын хадгаламж татаж, 1.3 тэрбум долларын зээлийг олгож чадсан байна. Финтекийн салбар нь санхүүгийн үйлчилгээг хялбар, хямдаар хүргэдэг нь уламжлалт санхүүгийн байгууллагаас давуу юм. Venture Scanner судалгааны фирмийн тооцоолсноор 2018 оны эхний улирлын байдлаар 2,407.0 финтект суурилсан компаниуд нийтдээ 90.0 тэрбум ам.долларын санхүүжилтийг татсан байна.

Манай орны хувьд ч финтекийн давлагаа тойрохгүй дайрч гарч байгаа бөгөөд томоохон арилжааны банкууд технологийн хөгжлөөс хоцрохгүйн тулд төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагаандаа финтекийг ашиглан сайжруулалт хийж хэрэглэгчиддээ хүргэхийг хичээж байна. Жишээлбэл банкууд хэрэглэгчдээ төлбөр тооцоог түргэн шуурхай гүйцэтгэх боломжоор хангахын тулд зөвхөн өөрийн харилцагчдад зориулсан тусгай аппликэйшн нэвтрүүлсээр байгаа юм. Одоогоор доорх банк, санхүүгийн байгууллагууд утасны аппликэйшнээр дамжуулан санхүүгийн үйлчилгээг үзүүлж байна.

Хүснэгт 52. Ижил төрлийн аппликэйшний харьцуулалт



000093



Унэт цаасны танилцуулга
 он 2019-01-09
 БҮРТГЭВ
 № 01

ARD КРЕДИТ
 ББСБ
 2018-11-29

	Голомт	Хаян	ХХБ	Төрийн	Хас	Мост Моши	ЛэндМН	Ард
Мөнгө шилжүүлэх	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
Төлбөр төлөх				✓	✓	✓	✓	✓
Бэлэн мөнгө авах								✓
Онлайн зээл							✓	✓
Нэгж авах	✓					✓	✓	✓
qPay		✓	✓	✓				✓
Дансны хуудга, үлдэгдэл шалгах	✓	✓	✓	✓	✓	✓		✓
Валютын ханш	✓	✓		✓	✓	✓		✓
Хадгаламж, зээлийн тооцоолуур	✓	✓		✓	✓	✓		✓
Даатгалын үйлчилгээ								✓
Хувьцааны арилжаанд оролцох								✓

Манай улсын финтек салбарт амжилт гаргаж буй бизнесийн нэг жишээ бол ЛэндМН (LendMN) аппликэйшн бөгөөд тус гар утасны аппликэйшнийг ашиглан богино хугацааны дотор нэг сая хүртэлх төгрөгийн зээлийг барьцаа хөрөнгөгүйгээр авах боломжтойгоороо онцлог юм. Энэ үйлчилгээ нь биг дата (big data) болон хиймэл оюун ухааны аргачлалыг ашиглан харилцагчийн зээлжих чадварыг үнэлэн зээл олгож буй хэлбэр билээ.

Мобиком корпораци нь өөрийн дэд бүтэц, дата өгөгдлийг ашиглан финтек технологид суурилсан зээлийн үйлчилгээг өөрийн охин компани болох “Мобифинанс ББСБ” ХХК-иар дамжуулан нэвтрүүлж, зах зээлд өрсөлдөж байна. Кэнди (Candy) цахим мөнгөтэй холбосон мессеж зээлийн үйлчилгээг зэх зээлд амжилттай танилцуулсан.


Хүснэгт 53. “Ард” зээлийн бүтээгдэхүүний ерөнхий нохилийг өрсөлдөгч байгууллагуудын бүтээгдэхүүнтэй харьцуулсан байдал

		Ард	ЛендМН	Кэнди Пэй
Зээлийн хэмжээ	Доод	300,000	100,000	10,000
	Дээд	3,000,000	1,000,000	500,000
Зээлийн шимтгэл		Шатлалаар	2%-10%	-
Зээлийн хүү		3.0%	0.0%	2.9% - 4.9%
Зээлийн хугацаа		14 хоног - 3 сар	7 хоног - 1 сар	10 хоног - 1 сар



000094





Тавигдах шаардлага	Бүх банкны харилцагч байж болно.	Бүх банкны харилцагч байж болно.	Мобиком Корпорацийн хэрэглэгч байх
Зээлийн мэдээллийн сан	Зээлийн мэдээллийн санд муу түүхгүй байх	Зээлийн мэдээллийн санд муу түүхгүй байх	Зээлийн мэдээллийн санд муу түүхгүй байх
Хэрэглэгч болох	Аппликэйшн суулган хамгийн ойрын Монгол Шуудан, Ард Даатгалын салбар дээр очиж гэрээ байгуулна.	Аппликэйшинд бүртгүүлж, байгаа газар нь очиж гэрээ байгуулна.	Мобиком Корпорацийн аль нэг салбарт иргэний үнэмлэхтэйгээ ирж гэрээ байгуулна.
Өөрийн биеэр очих эсэх	1 удаа өөрийн биеэр ирж гэрээ байгуулна.	1 удаа өөрийн биеэр ирж гэрээ байгуулна.	Зээл авах бүрд өөрийн биеэр очно.
Барьцаа шаардах эсэх	Барьцаа шаардахгүй	Барьцаа шаардахгүй	Барьцаа шаардахгүй

Ард нь бусад ижил төрлийн зээл олгож буй байгууллагуудаас зээлийн хэмжээ болон эргэн төлөх хугацааны хувьд давуу талтай юм. Мөн “Ард” аппликэйшн нь зөвхөн зээлийн үйлчилгээ бус мөнгөн гүйлгээ хийх, төлбөр тооцоо төлөх, QR-код, дансны хуулга шалгах, валютын ханш харах, хувьцааны арилжаанд оролцох зэрэг олон функц, боломжуудаараа давуу юм. Зээлийн үйлчилгээний хувьд бид харилцагчийн санхүүгийн чадавх, санхүүгийн мэдлэг, сахилга батыг үндэслэн хэрэглээний барьцаагүй зээлийг олгох юм. Зээлийн эргэн төлөлтийг хэвийн байлгах үүднээс Монголбанкны зээлийн мэдээллийн санд зээлийн мэдээллийг оруулах, хугацаандаа эргэн төлөлт хийж буй зээлдэгчийг урамшуулах бодлого хэрэгжүүлэх, харилцагчийн эргэн төлөлтийн хугацаа ойртож буй тухай сануулгуудыг аппликэйшнээр дамжуулан илгээх зэрэг хэд хэдэн төрлийн хөшүүргийг хэрэглэхээр төлөвлөж байна.

Төлөвлөгөө

Ард Кредит ББСБ нь онлайн зээлийн бүтээгдэхүүнийг “Ард” аппликэйшнээр 2018 оноос зах зээлд нэвтрүүлэх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд ирэх 5 жилийн зээлийн багцад эзлэх хувь хэмжээ болон мөнгөн дүнгээр дараах байдлаар төлөвлөж байна.

Хүснэгт 54. "Ард" зээлийн бүтээгдэхүүний ирэх 5 жилийн төсөөлөл

	2018	2019	2020	2021	2022
Нийт зээлийн багцад эзлэх хувь	1.0%	7.5%	15.0%	24.0%	30.0%
Ард зээлийн багц (цэвэр)	158.0	2,122.0	5,100.0	12,543.0	21,617.0
Ард зээлийн багц (нийт)	165.0	2,215.0	5,323.0	13,090.0	22,561.0
Эрсдэлийн сан	(7.0)	(93.0)	(223.0)	(548.0)	(944.0)
Харилцагчийн тоо	333	4,464	10,725	26,335	45,362

“Ард” зээлийн бүтээгдэхүүн нь орчин үеийн финтек шийдлийг агуулсан тул уламжлалт санхүүгийн үйл ажиллагаатай харьцуулахад харилцагчийн цаг завьг хэмнэсэн, ББСБ-ын хувьд зардал хэмнэсэн өндөр өгөөжтэй бүтээгдэхүүн юм. “Ард” бүтээгдэхүүний орлого үр дүнгийн төлөвлөгөө дараах байдлаар байна.

Хүснэгт 55. "Ард" бүтээгдэхүүний орлогын төсөөлөл (сая төгрөг)

	2018	2019	2020	2021	2022
--	------	------	------	------	------



000095



СЭХ
 2019.07.09
 Үнэт цаасны танилцуулга
 БҮРТЭГ
 №

МОНГОЛ АРД КРЕДИТ ББСБ
 ARD
 ББСБ EXCH
 2018-11-29
 БҮРТЭГ-02

Хүүгийн орлого	15	644	1,695	3,914	6,465
Шимтгэлийн орлого	15	1,113	3,033	7,259	12,425
Нийт орлого	30	1,757	4,727	11,173	18,889
Хүүгийн зардал	10	197	505	1,234	1,982
Нийт үйл ажиллагааны ашиг	20	1,560	4,223	9,939	16,907
Үйл ажиллагааны зардал	9	100	201	443	535
Түрээс, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн зардал	3	36	48	54	60
Үйл ажиллагааны ашиг	8	1,424	3,974	9,442	16,313

2018 онд Ард аппликэйшнээс нийт 30 сая төгрөгийн хүү болон шимтгэлийн орлого олохоор төлөвлөсөн бол 2022 онд “Ард” үйлчилгээ нь нийт 18.9 тэрбум төгрөгийн хүү болон шимтгэлийн орлого олохоор тооцоолж байна. Хүүгийн орлого өссөн шалтгаан нь “Ард” зээлийн бүтээгдэхүүн нь нийт зээлийн багцын 30.0 хувийг эзлэх тул бидний цаашдын үйл ажиллагааны чухал нэг хэсэг болох юм.

2.4. Маркетингийн стратеги

Компанийн маркетинг удирдлагын хамгийн чухал хэсэг нь төлөвлөлт билээ. Ард Кредит ББСБ-ын маркетингийн төлөвлөгөө толгой болон охин компаниудын алсын хараа, зорилго болон төлөвлөгөөтэй нягт уялдаатай байдаг. Хамтын ажиллагааг үр ашигтай, оновчтой байлгах, огтолцоо борлуулалтыг идэвхжүүлэх, орчны хувьсал, хандалтыг ажиглаж зорилго, зорилтоо дэвшүүлж, хэрэгжүүлэх арга замаа сонгодог.

Банк нь санхүүгийн салбарын гол тоглогч хэвээр байна. Гэсэн хэдий ч ББСБ-ын өөрийн хөрөнгө банкны салбартай харьцуулахад 24.0 хувьтай тэнцэж байгаа нь уг салбар хурдацтай өсч томорч байгаагийн тод жишээ юм. ББСБ-ын салбарын хөгжлийн цар хүрээ нь банкны салбартай өрсөлдөхүйц харагдаж байгаа ба бид богино хугацаанд зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлж, хэрэглэгчдэд танигдсан ТОП 5 ББСБ-ын нэг болох зорилтыг тавин ажиллаж байна. Банк болон банк бус санхүүгийн байгууллагын хувьд зээлийн хүү хамгийн чухал үзүүлэлт бөгөөд үйлчлүүлэгчдийн шийдвэрт шууд нөлөөлж байдаг. Ард Кредит ББСБ-ын хувьд зээлийн хүү ББСБ-ын салбартаа хамгийн бага буюу банкны салбартай өрсөлдөхүйц байгаа нь маркетингийн томоохон хөшүүрэг юм.

Харилцаа холбооны зохицуулах газраас гаргасан тайланд дурдсанаар 2017 оны эцсийн байдлаар Монгол улсын хэмжээнд 2.4 сая хүн ухаалаг утас ашиглаж байгаа ба интернет үйлчилгээ хэрэглэгчийн тоо 2.9 саяд хүрээд байна. Бид энэхүү мэдээлэл технологийн эрин үед уламжлалт маркетингийг халж, харилцагчдад хамгийн үр дүнтэй хүрэх дижитал маркетингийг өргөн ашиглаж байна.

Ард Кредит ББСБ нь 2015 оноос эхлэн онлайн зээлийн өргөдөл бөглөх системийг нэвтрүүлсэн нь салбартаа хамгийн анхдагч болсон юм. Энэхүү системээр дамжуулан иргэдэд санхүүгийн зөвлөгөө, хэрэгцээт мэдээ мэдээлэл болон өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулгыг цаг алдалгүй хүргэж байна. Цаашид санхүүгийн салбарт тэргүүлдэг зурган контентууд буюу инфографи, бүх төрлийн видео бичлэгээр харилцагчдынхаа санхүүгийн боловсролд хувь нэмэр оруулахуйц маркетинг хийхээр төлөвлөж байна.

Бид нийгмийн хариуцлагыг эрхэмлэгч байгууллагын хувьд байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж, спортын залуу баг тамирчдыг бүх талаар дэмжин ажиллана. Мөн бид жилийн тайлангаа олон нийтэд нээлттэй тайлагнадаг, салбартаа компанийн засаглалаар мандайлан ажиллахаар зорьж байна.

Facebook



000096





2015 оноос дижитал маркетинг буюу фэйсбүүк, бусад олон нийтийн сүлжээгээр дамжуулан иргэдэд санхүүгийн зөвлөгөө, хэрэгцээт мэдээ мэдээлэл болон өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулгыг цаг алдалгүй хүргэж байна.

Ард Кредит ББСБ нь хамгийн их хандалт авдаг социал нийгмийн сүлжээний хэрэгсэл болох фэйсбүүкийг тулхуу ашигладаг бөгөөд 2016 оны байдлаар 38,000 лайктай, 2017 оны байдлаар 43,000 лайктай байна. Бүтээгдэхүүн үйлчилгээ болон мэдээ мэдээлэл өгөх контентийг фэйсбүүк хуудсаар дамжуулж иргэдэд хүргэхэд, контент тавьж байгаа хуудсын лайкны тоо шууд хамааралтай байдаг.

- Өөрийн зар сурталчилгааг бичлэг хэлбэрээр фэйсбүүк хуудсанд байршуулах
- Олон нийтэд урамшуулалт уралдаан зарлах

Бусад социал нийгмийн сүлжээний хэрэгсэл болох твиттер, инстаграммаар маркетинг хийж, уламжлалт зар сурталчилгааны арга барилыг халж харилцагчдын үнэт цагийг хэмнэхийн хажуугаар санхүүгийн мэдлэг олгож, зөв зохистой хэрэглээг дэмжин ажиллана.

Бэлэг дурсгалын зүйлс

Ард кредит ББСБ нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш өөрийн нэр бүхий биет бэлэг дурсгалын зүйлсийг харилцагчиддаа бэлэг болгон өгч ирсэн бөгөөд маркетингийн хэрэгсэл болгон тогтмол ашигладаг.

- Бал
- Аяга
- Дэвтэр
- Календарь
- Картын гэр (гар утсанд зориулсан)

Хэвлэл мэдээлэл

- Эдийн засгийн сэтгүүлчдийн “Өөрчлөгч” клубтэй үргэлжлүүлэн хамтран ажиллах бөгөөд энэхүү сувгийг ашиглан Ард Кредит ББСБ санхүүгийн зах зээлийн талаарх боловсрол, мэдлэг, мэдээллийг олон нийтэд хүргэх, өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулах боломжтой юм.

ARD NEWS

- Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн үйлчлүүлэгчид болон харилцагчидад өдөр тутам зах зээлийн талаар, компанийн талаар шинэ мэдээллүүд хүрдэг. Энэхүү суваг нь мөн Ард Кредит ББСБ-ын бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчлах нэгэн суваг болох боломжтой юм.

Маркетингийн иж бүрдэл

1. **Баяр ёслол, ямар нэгэн тэмдэглэлт өдрүүдтэй холбоотойгоор урамшууллыг фэйсбүүк хуудсаар дамжуулан постер хэлбэрээр зарлах.**

Зураг 9 Маркетингийн иж бүрдлүүд



000097

СЗУ
 2019-01-09
 БҮРТГЭЭ
 № 01

АРД КРЕДИТ ББСБ
 MONGOLIAN STOCK EXCHANGE
 2018-11-29
 тохиолдуулан

2018 оны сар шинийн баярт зориулсан Ард Кредит ББСБ бизнесийн зээлийн хүүгээ 2.0-2.3% болгож бууруулав.

Зуны амралтыг үйлчлүүлэгчиддээ болон олон нийтэд Ард Кредит ББСБ-ын зээлийн картыг санал болголоо.

2. Шинээр нэвтрүүлж буй үйлчилгээ болон олон нийтийн дунд сугалаа, уралдаант тэмцээн зохион байгуулж маркетингийн ажлыг идэвхжүүлдэг.



Хэрэглэгчдэд илүү хялбар байх үүднээс Ард Кредит зээлийн картыг фэйсбүүкээр захиалдаг боллоо.

Хэрэглэгч, үйлчлүүлэгчдээ идэвхжүүлэх зорилгоор 2018 онд сар бүр сугалаа явуулж Iphone 10 гар утсыг бэлэг болгон өгөв.

3. Шинэ бүтээгдэхүүн санал болгох, компанийн нэр бүхий бэлэг дурсгалын зүйлсийг олон нийтэд тараах.



Ард Кредит ББСБ логотой гар утсанд зориулсан картын гэрийг харилцагчиддаа бэлэглэв.


Зээлийн салбарт цоо шинэ бүтээгдэхүүн болох хувьцаа барьцаалсан зээлийг Ард Кредит ББСБ санал болгож байна.

2.5. Санхүүгийн төлөвлөгөө

“Ард кредит ББСБ” ХХК-ийн 2018 оноос 2022 он хүртэлх 5 жилийн санхүүгийн төлөвлөгөөг сар бүрээр нь дэлгэрэнгүй тооцон дараах байдлаар хураангуйлан хүргэж байна.

Хүснэгт 56. Санхүү байдлын тайлангийн төсөөлөл (сая төгрөг)

	2018	2019	2020	2021	2022
Хөрөнгө	20,166	35,657	42,752	65,312	89,814



000098



СЗХ
 2019.01.09
 БҮРТГЭЭ
 №01

Үнэт цаасны танилцуулга


ARD КРЕДИТ ББСБ
 MONGOLIAN STOCK EXCHANGE
 2018-11-29
 БҮРТГЭЭ-02

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3,024	6,046	7,447	11,757	16,482
Зээлийн багц (цэвэр)	15,831	28,300	34,000	52,261	72,056
Үндсэн хөрөнгө (цэвэр)	312	312	306	294	276
Үндсэн хөрөнгө	400	450	500	550	600
Хуримтлагдсан элэгдэл	(88)	(138)	(194)	(256)	(324)
Бусад хөрөнгө	1,000	1,000	1,000	1,000	1,000

Өр төлбөр	10,813	22,625	23,662	36,136	45,037
Нийт санхүүжилт	10,501	22,313	23,350	35,824	44,725
БСХС	-	1,000	600	200	2,000
Банк	300	2,167	2,333	-	2,000
Итгэлцэл	5,988	6,578	9,098	13,332	20,100
Хаалттай өрийн бичиг	1,713	6,318	6,318	13,958	13,958
Бусад санхүүжилт	-	-	-	-	-
Гадаад санхүүжилт 1	-	5,000	5,000	3,333	1,667
Кровд кредит	2,500	1,250	-	-	-
Гадаад санхүүжилт 2	-	-	-	5,000	5,000
Бусад өр төлбөр	312	312	312	312	312
Өөрийн хөрөнгө	9,353	13,031	19,090	29,176	44,776
Энгийн хувьцаа	2,800	2,800	2,800	2,800	2,800
Нэмж төлөгдсөн капитал	4,200	4,200	4,200	4,200	4,200
Тайлант үеийн ашиг	716	3,822	6,823	11,450	17,890
Хуримтлагдсан ашиг	1,637	2,209	5,267	10,726	19,886

Бид 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 10.2 тэрбум төгрөгийн активтай байсан бол 2022 оны жилийн эцэст нийт 89.8 тэрбум төгрөгийн активтай болж өсөхөөр төлөвлөж байна. Үүнээс 80.2 хувь буюу 72.1 тэрбум төгрөг нь үйл ажиллагааны үндсэн бүтээгдэхүүн үйлчилгээ болох зээлийн багцыг бүрдүүлэхээр тооцоолж байгаа юм. Зээлийн багцын 35.0 хувийг бизнесийн зээл, үлдсэн 65.0 хувийг хэрэглээний төрлийн зээлүүд эзлэхээр төлөвлөж байна. Балансын өр төлбөр болон өөрийн хөрөнгө хэсэг нь IPO болон өрийн хэрэгсэл ашиглан санхүүжилт татахтай холбоотойгоор нэмэгдэхээр төлөвлөсөн. Мөн зээлийн эх үүсвэр нэмэгдсэнээр зээл олголт нэмэгдэж цэвэр ашиг өсөх юм.

График 47. Нийт активын өсөлтийг графикаар дүрслэн үзүүлбэл (сая төгрөг)



ARD CAPITAL GROUP
 SECURITIES COMPANY
 LLC
 УЛААНБААТАР ХОТ ТТ8632-5193855

000099

УЛААНБААТАР ХОТ
 АРД
 КРЕДИТ ББСБ
 УЛХ
 98
 ТТ8736-5459567

Унэт цаасны танилцуулга
 ОН 2019-01-09
 БҮРТГЭВ
 № 101

АРД КРЕДИТ ББСБ
 MONGOLIAN STOCK EXCHANGE
 2018-11-29
 БҮРТГЭВ-СЭ

2018 онд компани нь олон нийтэд хувьцаагаа арилжаалж татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээ 4.9 тэрбум төгрөг байх ба ирэх 5 жилийн хугацаанд санхүүгийн байгууллагуудаас нийт 39.7 тэрбум төгрөгийн санхүүжилт татахаар төлөвлөж байна. Эдгээр эх үүсвэрийг ашиглан үйл ажиллагаагаа явуулснаар дараах үр дүнтэй ажиллана хэмээн төлөвлөж байна.

Орлого үр дүнгийн тайлангийн хувьд 5 жилийн хугацаанд дараах байдлаар төлөвлөв.

Хүснэгт 57. Орлого үр дүнгийн тайлангийн төсөөлөл (сая төгрөг)

	2018	2019	2020	2021	2022
Санхүүгийн орлого	2,960	9,050	13,475	22,531	32,594
Хүүгийн орлого	2,445	7,164	9,494	13,751	18,101
Шимтгэлийн орлого	259	1,753	3,798	8,470	14,043
Ханшийн тэгшитгэлийн орлого	4	(167)	(167)	(90)	-
Бусад орлого	252	300	350	400	450
Нийт эх үүсвэрийн хүүгийн зардал	975	2,625	3,363	5,140	6,607
Итгэлцлийн үйлчилгээний зардал	511	1,053	1,456	2,133	3,216
Санхүүжилтийн зардал	464	1,572	1,908	3,007	3,391
Нийт үйл ажиллагааны орлого	1,985	6,426	10,112	17,392	25,987
Эрдэлийн сан	278	599	274	877	951
Нийт үйл ажиллагааны орлого	1,707	5,827	9,838	16,514	25,036
Нийт үйл ажиллагааны зардал	911	1,330	1,340	1,847	1,783
Хүний нөөц боловсон хүчний зардал	398	587	704	819	950
Удирдлагын зардал	460	520	580	647	721
Элэгдэл	33	50	56	62	68
Санхүүгийн зардал	20	173	-	319	43
Татварын өмнөх цэвэр ашиг	796	4,496	8,498	14,667	23,254
ОАТ	80	674	1,674	3,217	5,363
Татварын дараах цэвэр ашиг	716	3,822	6,823	11,450	17,890

Үйл ажиллагааны үндсэн орлого нь зээлийн хүүгийн орлого болон шимтгэлийн орлого байх бөгөөд 2017 оны байдлаар 2.0 тэрбум төгрөгийн санхүүгийн орлоготой байсан бол, 2018 онд 33.3 хувийн өсөлт үзүүлж 2.7 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөөд байна. Цаашид санхүүгийн орлого нэмэгдэх нь зээлийн багцын хэмжээтэй шууд хамааралтай бөгөөд зээлийн багцын хэмжээ жил ирэх тусам томорч байгаа нь орлого нэмэгдэх үндсэн хүчин зүйл болох юм. 2022 оны байдлаар 32.6 тэрбум төгрөгийн санхүүгийн орлого олохоор төлөвлөсөн бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад 44.7 хувийн өсөлт үзүүлэх дүн юм. Эх үүсвэрийн зардлын хувьд бид санхүүжилтийн зардлыг бага хэмжээнд хадгалахаар төлөвлөж байгаа ба уг зардал нь санхүүгийн орлогын хэмжээтэй харьцуулахад 2017 онд 36.0 хувь байсан бол 2022 онд 20.6 хувь хүртэл бууруулж ажиллахаар төлөвлөж байна. Энэ нь 2018 онд IPO хийх болон гадаадаас бага хүүтэй санхүүжилт татахаар төлөвлөж байгаатай холбоотой. Үйл ажиллагааны зардлын хувь жил бүр 10.0 хувиар өсөх бөгөөд мөн инфляцийн нөлөөллийг тооцоолсон болно. Үйл ажиллагааны зардал бага байгаа нь бидний ирээдүйн үйл ажиллагаа финтек чиглэлрүү шилжин



000100





уламжлалт зардлууд багасаж, мөн “Монгол Шуудан” ХК болон “Ард Даатгал” ХХК-ийн дэд бүтцийг ашиглан салбаргүй агент ББСБ байдлаар үйл ажиллагаа явуулахтай холбоотой юм.

Хүснэгт 58. Мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл (сая төгрөг)

	2018	2019	2020	2021	2022
Үйл ажиллагааны мөнгөн урсгал	(7,586)	(8,597)	1,178	(6,749)	(1,836)
Цэвэр ашиг	716	3,822	6,823	11,450	17,890
Элэгдэл	33	50	56	62	68
Эрсдэлийн сан	278	599	274	877	951
Ханшийн тэгшитгэлийн зөрүү	4	(167)	(167)	(90)	-
Дансны цэвэр өөрчлөлтүүд	(8,618)	(12,902)	(5,808)	(19,048)	(20,746)
Цэвэр үндсэн хөрөнгийн мөнгөн урсгал	(50)	(50)	(50)	(50)	(50)
Санхүүгийн мөнгөн урсгал	9,565	11,669	273	11,109	6,611
Санхүүжилт болон эргэн төлөлт	4,985	11,812	1,037	12,474	8,901
IPO	4,900	-	-	-	-
Ногдол ашиг	(320)	(143)	(764)	(1,365)	(2,290)
Цэвэр мөнгөн урсгал	1,928	3,022	1,401	4,309	4,725
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	1,095	3,024	6,046	7,447	11,757
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,024	6,046	7,447	11,757	16,482

2.6. Санхүүжилт, эх үүсвэрийн төлөвлөгөө

Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2016 болон 2017 онуудад банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх шийдвэр гаргасан бөгөөд үүнтэй холбоотойгоор Ард Кредит ББСБ нь хувь нийлүүлсэн хөрөнгөө амжилттай нэмэгдүүлж хоёр тэрбум төгрөгт хүргэсэн билээ. Ингэснээр компанийн хөрөнгийн чадавх сайжирсан байна. Мөн компани нь 2018 онд олон нийтэд хувьцаагаа санал болгон арилжих замаар 4.9 тэрбум төгрөгийн санхүүжилт босгож хувь нийлүүлсэн хөрөнгөө дахин нэмэгдүүлэхээр төлөвлөөд байна. Уг санхүүжилтийг дараах байдлаар зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээнд зарцуулахаар төлөвлөж байна.

Хүснэгт 59. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

	Зарцуулах дүн	Эзлэх хувь
Зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ	сая төгрөг	хувь
Бизнесийн зээл	2,768.5	56.5%
Хэрэглээний зээл	612.5	12.5%
Шуурхай зээл	980.0	20.0%
Кредит карт	367.5	7.5%
“Ард” зээл	49.0	1.0%
Хувьцаа барьцаалсан зээл	122.5	2.5%
Нийт	4,900.0	100.0%



000101



СҮНэт цаасны танилцуулга
 2019-01-09
 БҮРТГЭВ
 NEW

ARD КРЕДИТ ББСБ
 2018-11-29
 БҮРТГЭВ

Хөрөнгийн чадавх нэмэгдэж байгаатай холбоотойгоор компани нь санхүүгийн хөшүүргээ нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжтой болох юм. Тухайлбал, компани нь хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэхээс гадна олон жил хамтран ажилласан түнш байгууллагуудаасаа нэмэлт санхүүжилт авахаар төлөвлөөд байна. Доорх хүснэгтээр Ард кредит ББСБ нь ирэх 5 жилд татах хөрөнгө оруулалт болон санхүүжилтийг төлөвлөгөөг хүргэж байна.

Хүснэгт 60. Санхүүжилтийн төлөвлөгөө (сая төгрөг)

Зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ	Татан төвлөрүүлэх дүн
2018 он	
Олон нийтэд хувьцаагаа санал болгох (IPO)	4,900
Гадаад төслийн зээл	2,500
2019 он	
Банк, санхүүгийн байгууллагын зээл	2,000
БСХС-ийн төслийн зээл	1,000
Гадаад санхүүжилт	5,000
Хаалттай өрийн бичиг	6,300
2021 он	
Гадаад санхүүжилт	5,000
Хаалттай өрийн бичиг	13,900
2022 он	
БСХС-ийн төслийн зээл	2,000
Банк, санхүүгийн байгууллагын зээл	2,000

2017 онд Ард Кредит ББСБ-ын өр төлбөр өөрийн хөрөнгийн харьцаа 1.73 байсан бол 2018 онд төлөвлөсөн санхүүжилтээ татсанаар өр төлбөр болон өөрийн хөрөнгийн харьцаа 1.16, 2022 онд 1.01 байхаар байна.

Ард Кредит ББСБ нь 2018 онд Кроуд Кредит Японы хөрөнгө оруулалттай байгууллагаас 2.5 тэрбум төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн байгаа бөгөөд цаашид гаднын бусад бичиг санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаас санхүүжилт нэмж авахаар төлөвлөөд байна.


Ард Кредит ББСБ нь 2013 оноос Бичил Санхүүгийн Хөгжлийн Сантай хамтран ажиллаж эхэлсэн бөгөөд “Тогтвортой амьжиргаа” төслийн хүрээнд тус сантай нийтдээ 800.0 сая төгрөгийн дамжуулан зээлдэх гэрээ байгуулсан байна. Энэ төслийн хүрээнд компани нь нэмж 2019 онд 1 тэрбум төгрөгийн зээл, 2022 онд 2 тэрбум төгрөгийн зээл авахаар төлөвлөж байна. БСХС-ийн бөөний зээлийг авснаар 2 жилийн хугацаанд нийт 1,000 орчим хот, хөдөөгийн иргэд ашиг хүртэх бөгөөд үүнээс 800 хүн шууд, 200 орчим хүн шууд бусаар ашиг хүртэх тооцоо гарч байна.

Мөн Ард Кредит ББСБ нь СЗХ-оос авсан зөвшөөрлийн хүрээнд хаалттай өрийн бичиг гаргаж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрээ шийдэж ажиллаж ирсэн билээ. Тухайлбал, компани нь 2014 онд 550.0 сая төгрөг, 2017 онд 1.7 тэрбум төгрөгийн хаалттай өрийн бичиг гарган амжилттай санхүүжилт татаж байсан билээ. СЗХ-ны шалгуур үзүүлэлтийн хүрээнд ББСБ нь өөрийн хөрөнгийн 50.0 хувь хүртэлх хэмжээнд хаалттай өрийн бичиг гаргах боломж байдаг ба бид үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн хэрээр өрийн бичиг гарган санхүүжилт татах боломж нэмэгдсээр байна. 2019 онд 6.3 тэрбум төгрөгийн, 2021 онд 13.9 тэрбум



000102





Үнэт цаасны танилцуулга

2019.07.09

БҮРТГЭВ

№...

төгрөгийн хаалттай өрийн бичиг гаргаж, тус бүр нийт 2 жилийн хугацаатай жилийн 17-18%-ийн хүүтэй байхаар тооцоолж байна.



Итгэлцлийн үйлчилгээ нь Ард Кредит ББСБ-ын чухал бүтээгдэхүүн, үйлчилгээний нэг бөгөөд харилцагчдаас мөнгөн хөрөнгийг итгэлцлийн үндсэн дээр авч зах зээлийн эрсдэл үнэгүүдлээс хамгаалж, өндөр өгөөж олгох зорилгоор зээл хэлбэрээр гаргадаг үйл ажиллагааг итгэлцэл гэдэг. Уг бүтээгдэхүүн, үйлчилгээ нь компанийн санхүүжилтийг нэмэгдүүлэх боломж олгодог бөгөөд дээд хязгаарыг Санхүүгийн Зохицуулах Хорооноос тогтоож өгдөг болно. Одоогоор СЗХ-оос итгэлцлийн нийт хөрөнгө нь өөрийн хөрөнгийн 80.0 хувь буюу түүнээс бага байна гэж заасан байна. 2017 онд компани нь 2.7 тэрбум төгрөгийн итгэлцлийн үйлчилгээ татаж байсан бол СЗХ-оос тавьсан хязгаарын хүрээнд ирэх 5 жилд итгэлцлийн үйлчилгээг жилд дунджаар 49.5 хувиар өсгөж, 2022 онд 20.1 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөж байна.

2.7. Эрсдэлийн шинжилгээ

АРД КРЕДИТ ББСБ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Эрсдэлийн тодорхойлолт: Компани зорилго, зорилтдоо хүрэхэд учрах тодорхой бус байдал, үр дагавар, гарз хохирлыг ойлгоно.

Эрсдэлийн удирдлагын тодорхойлолт: Байгууллагын бүхий л үе шатанд эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрсдэлд тохирох хариу арга хэмжээ авах, мэдээлэх тасралтгүй үйл ажиллагаа юм.

Эрсдэлийн ангилал: Ард Кредит ББСБ-ын “Эрсдэлийн удирдлагын бодлого”-ын хүрээнд компанид учирч болохуйц эрсдлийг үүсгэж буй хүчин зүйлээс нь хамааруулан 4 ангилдаг.

Стратегийн эрсдэл: Гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан стратеги зорилго, зорилтыг хангахад учрах эрсдэлийг ойлгоно.

Санхүүгийн эрсдэл: Гадаад болон дотоод хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан компанийн санхүүгийн үйл ажиллагаанд учрах эрсдэлийг ойлгоно.

Үйл ажиллагааны эрсдэл: Дотоод хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан компанийн үйл ажиллагаанд учрах эрсдэлийг ойлгоно.

Комплайнсийн эрсдэл: Гадаад болон дотоод хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан үл нийцэл учрах эрсдэлийг ойлгоно.

Ард Кредит ББСБ-ын “Эрсдэлийн удирдлагын бодлого”-ын хүрээнд эрсдэлийг үр дагавраас нь хамааруулан 3 ангилдаг.

Стратегийн түвшний эрсдэл: Стратегийн зорилго, зорилтод нөлөөлөх үр дагавар бүхий эрсдэлийг ойлгоно.

Бизнес процессийн түвшний эрсдэл: Бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөх үр дагавар бүхий эрсдэлийг ойлгоно

Функциональ нэгжүүд болон хувь хүний түвшний эрсдэл: Бүтцийн чиг үүрэг бүхий нэгжүүдэд болон хувь хүнд нөлөөлөх үр дагавар бүхий эрсдэлийг ойлгоно.



000103



Үнэт цаасны танилцуулга

ОН 2019-01-09

БҮРТГЭВ-02

Эрсдэлийн удирдлагын зарчим: Ард Кредит ББСБ нь Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дараах 6 зарчмыг баримтлан ажилладаг. Үүнд:



Соёлыг түгээх:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс эрсдэлийн удирдлагын хүчирхэг соёлыг бий болгоход манлайлан оролцох
- Эрсдэлийн удирдлагын бодлого, заавар, журмууд нь компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд үйлчлэх ба компанийн удирдлага, ажилтан бүр дагаж мөрдөх

Үнэ цэнийг бүтээх:

- Эрсдэлийн удирдлага нь компанид үнэ цэнийг нэмэгдүүлэх компанийн бүхий л үйл ажиллагааны салшгүй чухал хэсэг байна

Шийдвэр гаргалтанд ашиглагдах:

- Эрсдэлийн удирдлага шийдвэр гаргалтын түвшин бүрт ашиглагддаг байх

Мэдээлэлтэй, ил тод байх:

- Эрсдэлийн удирдлага нь тодорхойгүй байдлыг ил болгох, системтэй, цаг хугацаандаа, үнэн зөв мэдээлэл дээр суурилсан байх
- Компанийн эрсдэлийн удирдлагын мэдээлэл солилцох ба зөвлөлдөх, хяналт ба мониторинг хийх үйл ажиллагаанд оролцох гадаад болон дотоод оролцогч талуудын оролцоо, хувь нэмрийг хүндэтгэн үздэг байх


Чиг үүргийн хуваарилалт хийх:

- Эрсдэлийн удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх алба, нэгжүүдийн үйл ажиллагаа, эрх, үүргийн хуваарилалт оновчтой, тодорхой байх.

Тасралтгүй байх:

- Компани эрсдэлийн удирдлагын иж бүрэн тогтолцоог компанийн бүхий л түвшний үйл ажиллагаанд нэвтрүүлж, хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулах
- Компани нь стратеги зорилтууд, гадаад орчны өөрчлөлт, олон улсын практикт гарч байгаа эрсдэлийн удирдлагын шинэ мэдлэг, технологийг дотоод мэдээллийн систем, технологи, бодлого, заавар, журам зэрэг эрсдэлийн удирдлагын бүхий л элементүүдэд тусган байнга боловсронгуй болгон сайжруулж байх.

Эрсдэлийн удирдлагын үйл явц:



Эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэлт:



000104




СЗХ
2019.07.09 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Үндэс цаасны танилцуулга


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БЭЛЭГ
ARD КРЕДИТ ББСБ
2019.11.29
БҮРТГЭВ-02

Эрсдэлийн удирдлагыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) болон Гүйцэтгэх удирдлага дараах байдлаар хэрэгжүүлнэ.

Төлөөлөн Удирдах Зөвлөл




Гүйцэтгэх удирдлага



Хяналт, сайжруулалт, өөрчлөлт оруулах:

Ард Кредит ББСБ нь Эрсдэлийн удирдлагын дэргэдэх Дотоод хяналтын алба болон дотоод аудитын нэгжээр дамжуулан эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, түүний хэрэгжилтэнд хяналт тавидаг ба бодлогод өөрчлөлт оруулах тохиолдолд дотоод аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж болон Төлөөлөн Удирдах Зөвлөл, түүний дэргэдэх Аудитын хороо, Гүйцэтгэх удирдлагын саналыг үндэслэнэ.

2. АРД КРЕДИТ ББСБ-ЫН ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО



000105



СҮДЭТ цаасны танилцуулга
2019 о. 01. 19
БҮРТГЭВ
№ 01

ARD КРЕДИТ
ББСБ-ЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 о. 01. 19
БҮРТГЭВ
№ 02

Ард Кредит ББСБ-ын үндсэн үйл ажиллагааны чиглэл болох зээл олгох үйл явц нь компанийн дотоод Зээлийн эрсдлийн бодлогын дагуу явагддаг. Зээлийн эрсдэл нь зээлдэгчийн зээл болон зээлийн хүүгийн төлбөрийг гэрээний нөхцөлийн дагуу бүрэн төлөхгүй байх эрсдлийг хэлнэ.

Зээлийн эрсдлийг 1) Зээл нэг бүрийн эрсдэл, 2) Зээлийн багцын эрсдэл гэсэн үндсэн 2 чиглэлд удирдан ажилладаг.

Зээл нэг бүрийн эрсдэл:

Компани нь хэрэглээний зээлийн эрсдлийг мөнгөн урсгал болон кредит скорингийг ашиглан тооцоолол хийдэг бол бичил болон жижиг дунд бизнесийн зээлийн эрсдэл/зээлжих чадварыг дараах үндсэн 6 хүчин зүйлсийг харгалзан зээлийн судалгаа/зээлийн хяналт тавьж байна. Үүнд: 1) Менежмент, 2) Зах зээл, 3) Санхүүгийн байдал, 4) Компанийн түүх, хөгжил, 5) Бизнесийн эрсдэл, 6) Барьцаа хөрөнгө

Зээлжих чадварыг тогтоох нь зээл хүсэгч, зээлдэгчдийн хүсэлтэнд эрсдлийн шинжилгээ хийж, зээл олгох эсэх шийдвэр гаргахад болон зээлдэгчийн зээлээ хэрхэн төлөх чадварыг үнэлж, гарч болзошгүй эрсдлийг урьдчилан таамаглах, тэдгээрээс сэргийлэх ач холбогдолтой юм. Зээлийн эрсдлийн шинжилгээг зээлийн санхүүжилтийн зорилго, эргүүлэн төлөх эх үүсвэр, бизнесийн эрсдлүүд, санхүүгийн шинжилгээ гэсэн үндсэн чиглэлүүдээр хийх бөгөөд зээлийн эрсдлийг шинжлэхдээ тоон болон чанарын шинжилгээг хийж үздэг. Чанарын шинжилгээгээр зээлдэгчийн санхүүгийн хариуцлагын талаар мэдээлэл олж авах, зээлийн жинхэнэ зориулалтыг мэдэх, зээлдэгчийн бизнест тулгарч болзошгүй эрсдлүүдийг тодорхойлох, түүнээс урьдчилан сэргийлэх, ирээдүйн зах зээлийн болон эдийн засгийн байдлыг таамаглах, мөн зээлдэгч зээлээ төлөх хүсэл эрмэлзэлтэй байгаа эсэхийг гадаад ба дотоод хүчин зүйлсүүдээр хэмжин, тодорхойлж эрсдэлд чанарын үнэлгээг өгнө.

Зээлийн эрсдэлд тоон шинжилгээ (credit scoring) хийх үйл явц нь зээлдэгчийн өнгөрсөн үеийн санхүүгийн үзүүлэлтүүд болон ирээдүйн эдийн засгийн тооцоог үнэлсний үндсэн дээр зээлдэгчийн зээл төлөх санхүүгийн чадварыг тодорхойлох явдал юм. Бизнесийн зээлийн хувьд тоон шинжилгээг дараах санхүүгийн харьцааны шинжилгээнүүдээр хийнэ. Үүнд хөрвөх чадварын, эргэцийн, санхүүгийн хөшүүргийн, ашигт ажиллагааны, мөнгөн урсгалын зэрэг харьцаа үзүүлэлт тус тус багтана.

Зээлийн багцын эрсдэл:

Ард Кредит ББСБ нь зээлийн багцын эрсдлийн түвшинг тогтоохдоо зээлийн багцын төвлөрөл, зээлийн хязгаарлалт, зээлийн багцын чанар үзүүлэлтийг тооцох буюу зээлийн эрсдлийн бодлогодоо тусган мөрдөн ажиллаж байна.

- *Зээлийн багцын төвлөрлийн* хувьд санхүүгийн зах зээл болон эдийн засгийн нөхцөл байдлыг байгууллагын бүтээгдэхүүний стратеги бодлого, бизнес төлөвлөгөө болон чанаргүй зээлийн тайлангийн түүх зэргийг харгалзан үзэж бүтээгдэхүүнээр болон үйл ажиллагааны чиглэлээр хязгаар тогтоон тус хязгаарын хүрээндээ зээлийн багцаа удирдан ажиллаж ирсэн билээ.




Хүснэгт 01. Зээлийн бүтээгдэхүүний хязгаар

Зээлийн эрсдэлийн хязгаар Хязгаар

000106





Нийт багцад эзлэх хувь

1. Бүтээгдэхүүнээр

1	Шуурхай зээл	Дээд хязгаар	35
2	Бичил бизнесийн зээл	Дээд хязгаар	35
3	ЖДБ-ийн зээл	Дээд хязгаар	40
4	Хэрэглээ	Дээд хязгаар	40

2. Сектороор

1	Хөдөө аж ахуй, газар тариалан	Дээд хязгаар	20
2	Уул уурхай, ачаа тээвэр	Дээд хязгаар	20
3	Үйлдвэрлэл	Дээд хязгаар	30
4	Хэрэглээ	Дээд хязгаар	40
5	Зам, барилга	Дээд хязгаар	30
6	Худалдаа	Дээд хязгаар	30
7	Санхүүгийн үйлчилгээ	Дээд хязгаар	35
8	Үйлчилгээ	Дээд хязгаар	40
9	Бусад*	Дээд хязгаар	15

- Зээлийн хязгаарлалтын хувьд байгууллага нь СЗХ-оос тавигдах шаардлага болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллаж ирсэн.
- Зээлийн багцын чанар, ангилалын хувьд МБ болон СЗХ-оос баталсан “Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулах, зарцуулах журам” үндэслэн, активын ангилалыг хийж, учирч болзошгүй алдагдалд зориулсан санг байгуулан ажилладаг. Байгууллага нь хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийг төлүүлэх, үйл ажиллагааг холбогдох журам, заавар болон Иргэний хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлж явуулахаас гадна системийн нийт чанаргүй зээлийн дунджаас доогуур байх бодлого барин ажиллаж байна. Мөн зээлийн шийдвэр гаргах эрх хэмжээ, зээл батлах процессийн хувьд зээлийн бодлогоор зохицуулан ТУЗ-ийн дэргэдэх Зээлийн хороо, дотоод зээлийн хороо, эрх бүхий ажилтны шийдвэрээр холбогдох зээлийг хэлэлцэн шийдвэрлэж байна.

Зээлийн эргэн төлөлт удаашрах, олгосон зээлийн чанар муудах, зээлийг цөөн тооны байгууллага, салбар нэгжүүдэд олгож төвлөрөл үүсэх зэрэг эрсдэл гаргахаас сэргийлж компани нь дээрхи эрсдлийн удирдлагын бодлогыг мөрдөж ажиллахаас гадна борлуулалт маркетингийн ажлыг тогтмол явуулж, зээлийн эргэцийг нэмэгдүүлэх, шаардлагатай тохиолдолд зээлийн олгох шалгуурыг өндөрсгөх, эрсдэлийн сан байгуулах, ХУР системтэй холбогдсон кредит скорингийн моделийг нэвтрүүлэх гэх зэрэг ажлыг хийж байгаа болно.

3. АРД КРЕДИТ ББСБ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД УЧИРЧ БОЛОХ ЭРСДЭЛҮҮД, СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМУУД

Ард Кредит ББСБ нь үйл ажиллагаагаа явуулж байх явцад гадаад болон дотоод хүчин зүйлсээс үүдэн учирч болох эрсдэлүүдийг компанийн “Эрсдлийн удирдлагын бодлого”-г тусгасан гол 4 төрлөөр ангилан авч үзэн, тэдгээр эрсдлээс сэргийлэх, хамгаалах үүднээс авч хэрэгжүүлэх арга замыг дор тусгав.



000107



1. Стратегийн эрсдэл

- 1.1. Улс төр, хууль эрх зүйн эрсдэл: Компанийн эрхэлж буй үйл ажиллагаа нь Монгол Улсад хэрэгжин мөрдөгдөж буй Үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооны ББСБ-ын үйл ажиллагааг зохицуулдаг дүрэм, журамд захирагдан ажилладаг. Иймд тэдгээр хуульд УИХ-аас гэнэтийн өөрчлөлт оруулах, Банкуудад давуу байдал олгосон, ББСБ-ын үйл ажиллагааг хязгаарласан хууль, тогтоомжийн зохицуулалтыг батлах; СЗХ-оос ББСБ-ын үйл ажиллагааг зохицуулдаг дүрэм, журамд өөрчлөлт орох, шалгуур үзүүлэлтүүдийг өндөрсгөх; СЗХ удирдлага солигдож, үйл ажиллагаа, тавих шаардлагад өөрчлөлт орох; улс төрөөс үүдэлтэй гэнэтийн үймээн самуун гарч, онцгой байдал үүсэх; төрийн байгууллагын хээл хахууль, авлигын үр дагавраар улсын бүртгэл, иргэдийн өмч хөрөнгийг бүртгэлд хуурамч, худал мэдээлэл орох, уг мэдээлэл дээр үндэслэн зээл олгох зэрэг нь компанид ихээхэн эрсдэл учруулах боломжтой. Эдгээр эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдлийн үзүүлэх нөлөөг багасгах үүднээс компани нь шинээр сонгогдсон, эрх баригчдын шийдвэр бодлогуудыг тогтмол ажиглан судлах, өргөн баригдаж буй төслүүдийг тогтмол хянаж, үйл ажиллагааны цар хүрээг хязгаарласан дүрэм, журмын төсөлд санал өгөх замаар хяналт тавьж оролцох; мэргэжлийн хуулийн фирм болон салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бусад ББСБ-уудтай холбооны шугамаар хамтран ажиллаж нийт ББСБ-ын эрх ашгийг төлөөлж болон хамгаалж нөлөөллийн ажиллагаа явуулах; Хууль, дүрмийн өөрчлөлтийг цаг тухайд нь хэрэгжүүлж мөрдөн ажиллах, Хууль дүрмийн хэрэгжилт хариуцсан тухайлсан ажилтантай болох; Мөнгө угаах, терроризмтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, харилцагчдын мэдээллийг давхар шалган боловсруулах зэрэг арга хэмжээг аван ажиллаж байна.
- 1.2. Нэр хүндийн эрсдэл: Компани нь групп компанийн хамааралтай учир зэргэлдээ охин компани эсвэл толгой компанийн нэр хүнд, тэдгээрийн удирдлагын нэр хүнд унахад компанид шууд нөлөө үзүүлэх эрсдэлтэй. Мөн компанийн хаяг, шошго, лого зэргийг хөндлөнгийн этгээд ашиглах, компанийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм журам байхгүй байх, гаргасан дүрэм журмыг дагаж мөрдөхгүй байх зэргээс шалтгаалан олон нийтийн дунд компанийн нэр хүнд унах магадлал бий. Эдгээр нөлөөг хамгийн бага түвшинд барихын тулд компани нь удирдлагын хийж буй үйлдэл хуулийн журмын дагуу, ёс зүйтэй байхад анхааран, компанийн нэр бүхий хаяг, шошго, логог патент авч, Монгол улсын хууль, болон холбогдох эрх бүхий байгууллагаас тавигдах шаардлагын дагуу компанийн дотоодод мөрдөгдөх дүрэм журмыг гаргаж батлан, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.
- 1.3. Мэдээлэл технологийн эрсдэл: Ард Кредит ББСБ-ын үйл ажиллагаа нь Поларис үндсэн банкны систем болон Ард аппликэйшн аппликэйшнээс шууд хамааралтай. Иймд компанид учирч болох мэдээллийн технологийн эрсдэлийг 5 хэсэгт хуваан үзэв.


Системийн хүртээмжтэй байдал: Поларис үндсэн банкны систем нь Tier-2 дата төвд тооцогдох АйТүүлс модулар дата төвд байршиж буй cloud буюу үүлэн системд суурилсан систем юм. АйТүүлс дата төв нь 2 тустаа сүлжээ түгээгчээс өндөр хурдны интернетийн холболтоо авдаг ба ТЭЦ-4-с цахилгаан эрчим хүчээ авдаг.

Дата төвийн физик аюулгүй байдлыг хангахын тулд системийн инженерүүд нь 24/7 байрладаг ба төв рүү гарын хуруу болон ID card –ыг уншуулсан тохиолдолд нэвтрэх боломжтой.



000108





Поларис үндсэн банкны систем нь системийн ачаалалыг харгалзан өргөжүүлэх боломжтой модулар систем юм. Үндсэн банкны системийн датабааз нь өдөр бүр back-up р хийгддэг. Системийн найдвартай ажиллагаа нь 99.99% гэж үздэг.

Дата менежмент: Грэйпсити Монголиа ХХК нь Поларис үндсэн банкны системийг хөгжүүлэхдээ банк, санхүүгийн салбарын аюулгүй software хөгжүүлэх стандартыг мөрдөн ажилласан. Тэдгээр стандартад ‘General Security Architecture’, ‘Application Security’, ‘Sensitive Data Security’, ‘Data Transfer Security’ зэрэг харилцагчийн нууц мэдээллийг encryption буюу гуравдагч этгээд тайлж ашиглах боломгүйгээр кодлон нууцалж өндөр төвшний хамгаалалтад хадгалах, зэрэг урьдчилсан арга хэмжээнүүд авах боломжтой үйлдлүүд багтдаг байна.

Кибер аюулгүй байдал: Кибер аюулгүй байдлыг Айтүүлс дата төвийн сүлжээний мөн программын firewall хангаж байна. Тус firewall нь дүрэм дээр үндэслэн халдалт, холболтын оролдлогыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, зогсооход ашиглагддаг юм.

Нэг бэлтгэн нийлүүлэгчээс хараат байгаа эрсдэл: Ард Кредит ББСБ нь Грэйпсити Монголиа ХХК-тай байгуулсан стратегийн түншлэлийн гэрээний хүрээнд Ард аппликэйшн, Поларис банкны суурь системийг cloud хувилбараар нэвтрүүлсэн байгаа билээ. Нэг бэлтгэн нийлүүлэгчээс хамааралтай байгаа нь түншлэгч байгууллагын эрсдэл үүсгэж байна.

Гуравдагч этгээдийн эрсдэл: Ард аппликэйшн нь бусад гуравдагч аппликэйшнтэй функцийн хувьд холбогдох төлөвлөгөөтэй байгаа билээ. Энэ нь одоогийн Ард аппликэйшний үйл ажиллагаа хэвийн явахад нөлөөлөх эрсдэлтэй. Үүнээс урьдчилан хамгаалахын тулд гуравдагч компаниудтай Service Level Agreements хийхээр төлөвлөж байна.

1.4. Зах зээлийн эрсдэл: Зах зээл дэх экспортын гол түүхий эдийн үнэ, ханшийн өөрчлөлт, эдийн засгийн өсөлт удааширч иргэд болон аж ахуйн нэгжүүдийн зээлийн чанар муудаж, эдийн засаг хямарч системийн хувьд зээлийн чанар муудах зэрэг нь ББСБ-ын салбарын үйл ажиллагаа болон санхүүгийн байдалд сөрөг нөлөөтэй. Мөн зах зээлийн уналтаас шалтгаалж гадаад хөрөнгө оруулагчдын итгэл буурах, санхүүжилт оруулахгүй байх зэрэг эрсдэл учирж болзошгүй. Үүнээс урьдчилан сэргийлэх үүднээс компани нь макро эдийн засгийн орчин, түүхий эдийн үнийг тогтмол судлаж, Статистикийн хороо, Монгол банк болон бусад эх сурвалжаас мэдээлэл цуглуулан гаргах зээлийн багцыг салбараар тараан байршуулах, урт хугацааны санхүүжилт олгох байгуулагыг сонгон ажиллах зэрэг дээр анхааран ажиллаж байна.

2. Санхүүгийн эрсдэл

2.1. Ханшийн эрсдэл: Компанийн гадаадын хөрөнгө оруулагчдаас татсан санхүүжилт, гадаад валютаар олгосон зээл зэрэг нь ханшийн хөдөлгөөнд хэт мэдрэг байдаг ба түүнээс үүдэн ханшийн зөрүүний алдагдал хүлээх эрсдэл бий. Валютын ханшид нөлөөлөхүйц улс төр, эдийн засгийн үйлдлүүдийг тогтмол хянаж, ханшийн таамаглал дээр үндэслэн зээл олголтыг хумих эсвэл тэлэх бодлого барин, хугацааны давтамжтай гадаад валютын ханшийн таамаглал хийх, эзэмшиж буй гадаад валютын тодорхой хувийг төгрөгт хөрвүүлэх, гадаад хөрөнгө оруулалтыг татахдаа хэджинг хийх зэргээр компани нь ханшийн эрсдлээс сэргийлж байна.



000109



Үнэт цаасны танилцуулга
СЭХ
он 2019-01-09
БҮРТГЭВ
№ 01

ARD КРЕДИТ
ББСБ

2018-11-29

2.2. Хөрвөх чадвар: Зах зээлийн төлөв, ханшийн савалгаа, чанаргүй зээл болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан компани нь бэлэн мөнгөний хомсдолд орж зээл олгоход шаардлагатай бэлэн мөнгө дутагдах эрсдэл үүсэх боломжтой байдаг тул компани нь бэлэн мөнгөний зохистой харьцааг ханган тогтмол хяналт тавин ажиллаж байна.


3. Үйл ажиллагааны эрсдэл

3.1 Үйл ажиллагааны эрсдэл гэдэгт зээлдэгч талаас харилцагч худал мэдээлэл өгөх, хуурамч баримт бичиг бүрдүүлж зээл, мөнгөн хөрөнгө гаргуулж авах, гуравдагч этгээд, албан бус санхүүгийн байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн санд харилцагчдын бүх зээлийн талаар мэдээлэл оруулдаггүйгээс харилцагчдын зээлжих чадварын үнэлгээ буруу, дутуу хийгдэх, цаашлаад эргэн төлөлтийн чадваргүй харилцагчид өндөр хэмжээний зээл олгох, харилцагчид санхүүгийн хүндрэл үүсэх, зээлийн эргэн төлөлтийг цаг тухайд нь хийж чадахгүй байх, зээлийн барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэ буурах, харилцагчдаа бусад ББСБ-д алдах зэргийг багтаан авч үзнэ. Дотоод үйл ажиллагааны хувьд хүний нөөцийн эргэц нэмэгдэх, ажилчдын тоо болон ажил үүргийн хуваарь давхардсанаас болж үр ашиггүй зардал гарах, хөдөлмөрийн хуваарилалтыг оновчтой явуулаагүйн улмаас ажилчдын бүтээмж буурах, үр ашиггүй байдал үүсэх, ажилчдын хариуцлагагүй байдлын улмаас байгууллагын үйл ажиллагаа доголдох зэрэг асуудал үүсэх магадлалтай. Компанийн хувьд эдгээр эрсдлийг гаргахгүйн тулд зээлдэгчиддээ зээлийн эрсдлийн бодлогын хүрээнд барьцаа хөрөнгийн шалгуур үзүүлэлтийг сайжруулж, зээлийн багцыг салбараар тараан байршуулах, харилцагчдад тогтмол мэдээлэл хүргэж, холбоотой байх, харилцагчийн санхүүгийн мэдээллийг тогтмол авч, шаардаж хэвших, харилцагчдад тохирсон бонус урамшууллыг тогтмол явуулах зэрэгт анхааран ажиллаж байна. Мөн компани нь хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд тогтмол хяналт тавин, ажилчдыг чадваржуулах арга хэмжээг тогтмол явуулж, ажил үүргийн хуваарийг тодорхой гарган өгч ажиллаж байгаа билээ.



000110





3. ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

3.1. Үнэт цаас гаргах тухай шийдвэр

Ард Кредит ББСБ нь нийт гаргасан хувьцааны 25 хувь буюу 70,000,000 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган, нэг бүрийг нь 70 төгрөг (санал болгох доод үнэ) -өөр олон нийтэд санал болгож байна. Хөрөнгө оруулагчид өөрсдийн харилцагч үнэт цаасны компаниараа дамжуулан Монголын Хөрөнгийн Бирж дээрээс Ард Кредит хувьцааг худалдан авах боломжтой.

Үнэт цаас гаргач	Ард Кредит ББСБ
Үнэт цаасны төрөл.....	Энгийн хувьцаа
Олон нийтэд санал болгох хувьцааны тоо.....	70,000,000 ширхэг
Олон нийтэд санал болгох хувьцааны хувь.....	25 хувь
Олон нийтэд санал болгосны дараах хувьцааны тоо	280,000,000 ширхэг
Олон нийтэд санал болгох нэгж хувьцааны доод үнэ (түвшин).....	70 төгрөг (70-85 төгрөг)
Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ.....	10 төгрөг
Татан төвлөрүүлэх хөрөнгийн доод дүн.....	4,900,000,000 төгрөг
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зориулалт.....	Зээлийн бүтээгдэхүүнийг санхүүжүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх
Стратегийн хөрөнгө оруулагчидад санал болгох арга	Тогтоосон үнийн арга
Олон нийтэд санал болгох арга хэлбэр.....	Захиалгын бүртгэлийн арга
Арилжааг зохион байгуулах байгууллага.....	Монголын Хөрөнгийн Бирж

3.2. Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдээс гаргасан шийдвэр

Ард Кредит ББСБ нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3, 62.1.4 дэх заалтууд, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг болон Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4.2, 7.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн олон нийтэд хувьцаагаа санал болгон гаргаж байгаа болно. КТХ-ийн 62-р зүйлд компанийн хэлбэрийг өөрчлөх, хувьцаа нэмж гаргах, түүний үнийг тогтоох зэрэг асуудал нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийн асуудал байна гэж заасан байна. Иймд Ард Кредит ББСБ-ийн хувьцаа эзэмшигчид 2018 оны 8 сарын 2-ны өдөр хуралдаж, 2018/12 тоот хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор компанийн хэлбэрээ өөрчлөн хувьцаат компани болох, 70,000,000 ширхэг хувьцааг нэмж гарган, нэг бүрийг 70 төгрөгөөсдоошгүй үнээр (70-85 төгрөгийн хооронд) олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн болно.

3.3. Хувьцаа эзэмшигчийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгө

Ард Кредит ББСБ-ын зарласан болон гаргасан энгийн хувьцаа нь 210,000,000 ширхэг бөгөөд нэмж 70,000,000 ширхэг энгийн хувьцааг гаргаж, олон нийтэд санал болгосноор 280,000,000 ширхэг энгийн хувьцаатай болох юм. Олон нийтэд санал болгон нэмж гаргаж буй хувьцаа нь нийт хувьцааны 25 хувь байна.



000111





2018 -11- 29

Хувьцаа эзэмшигч	Хувьцаа гаргахаас өмнө		Хувьцаа гаргасны дараа	
	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
1 Ард Санхүүгийн Нэгдэл ХК	169,472,000	80.7%	169,472,000	60.5%
2 В.Баяржаргал	13,856,000	6.6%	13,856,000	4.9%
3 С.Гэрэлтуяа	26,672,000	12.7%	26,672,000	9.5%
4 Олон нийт		0.0%	70,000,000	25.0%
Нийт хувьцаа эзэмшигчид	210,000,000	100.0%	280,000,000	100.0%

Компанийн дүрэмд тусгасны дагуу компанийн энгийн хувьцааны нэрлэсэн үнэ 10 төгрөг бөгөөд нэмж хувьцаа гаргасанаар компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө 2.8 тэрбум төгрөг болох юм.

Хүснэгт 63. Олон нийтэд хувьцаа санал болгосны дараах хувь нийлүүлсэн хөрөнгө

	Хувьцааны тоо ширхэг	Нэрлэсэн үнэ төгрөг	Хувь нийлүүлсэн хөрөнгө төгрөг
Хувьцаа гаргахаас өмнөх	210,000,000	10	2,100,000,000
Нэмж гаргасан хувьцаа	70,000,000	10	700,000,000
Нийт	280,000,000		2,800,000,000

3.4. Үнэт цаасаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

“Ард Кредит ББСБ” ХХК нь нийт хувьцааны 25% буюу 70,000,000 ширхэг хувьцааг нэг бүрийг 70 төгрөг болон түүнээс доошгүй үнээр (70-85 төгрөг) олон нийтэд санал болгох замаар нийт 4.9 тэрбум төгрөг болон түүнээс доошгүй санхүүжилтийг олон нийтээс татан төвлөрүүлнэ. Компани нь хувьцааны борлуулалтаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг үндсэн зээлийн үйлчилгээгээ нэмэгдүүлэх болон шинээр нэвтрүүлж байгаа “Ард” аппликэйшн, хувьцаа барьцаалсан зээлийн үйлчилгээг нэвтрүүлэхэд зарцуулахаар төлөвлөж байна.



Хүснэгт 64. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

Зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ	Зарцуулах дүн сая төгрөг	Эзлэх хувь хувь
Бизнесийн зээл	2,768.5	56.5%
Хэрэглээний зээл	612.5	12.5%
Шуурхай зээл	980.0	20.0%
Кредит карт	367.5	7.5%
Ард	49.0	1.0%
Хувьцаа барьцаалсан зээл	122.5	2.5%
Нийт	4,900.0	100.0%



000112





3.5. Үнэт цаасны үнэ тогтоосон үндэслэл

КТХ-ийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалтыг үндэслэн Ард Кредит ББСБ-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас нэмж гаргаж буй хувьцааны анхдагч зах зээлд санал болгох доод үнэ 70 төгрөг (70-85 төгрөг) байхаар шийдвэрлэж, 2018 оны 8 сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018/12 тоот тогтоолоор баталгаажуулсан байна.

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд санал болгох үнийг тогтоохдоо “БДО Аудит” ХХК-ийн тогтоосон хараат бус бизнесийн үнэлгээг чиглэл болгосон ба уг үнэлгээгээр компанийн бизнесийн өмчийн үнэ цэнэ 24.6 тэрбум төгрөг буюу нэгж хувьцааны үнэ цэнэ 87.7 төгрөг хэмээн гарсан байна. Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад тааламжтай нөхцлийг санал болгох үүднээс өөрийн хувьцааг худалдах доод үнийг 70.0 төгрөгөөр тогтоон хувьцааны үнэ цэнэ болох 87.7 төгрөгөөс 20.2 хувиар хямдруулан олон нийтэд санал болгож байна.

Бизнесийн үнэлгээ

“БДО Аудит” ХХК нь Ард Кредит ББСБ-тай 2018 оны 2 сарын 27-ны өдөр байгуулсан Үнэлгээний зөвлөх үйлчилгээний гэрээнд заасны дагуу үнэт цаас гаргагчийн банк бус санхүүгийн үйл ажиллагааг хамарсан бизнесийн өмчийн 100 хувийн хувь оролцоог үнэлж, бизнесийн үнэлгээний тайланг бэлтгэсэн. Уг тайланг Ард Кредит ББСБ-ын 2017 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар аудитлагдсан тайлан болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд үндэслэн 2017 оны эцсийн байдлаар бизнесийн үнэлгээний үр дүнг бэлтгэсэн болно.

Үнэлгээний зорилго нь Ард Кредит ББСБ хөрөнгийн зах зээлд хувьцаа санал болгож, өмчийн санхүүжилт босгох зорилгоор бизнесийн өмчийн 100 хувийн хувь оролцоо буюу өмчийн 100 хувийн үнэлгээ хийхэд оршино.

БДО Аудит нь энэхүү тайланг бэлтгэхдээ Үнэлгээний олон улсын консул (ҮОУК)-ын бэлтгэн толилуулдаг Үнэлгээний олон улсын стандарт (ҮОУС)-ыг дагаж мөрдсөн. Энэхүү үнэлгээний хүрээнд зах зээлийн үнэ цэнийн суурийг ашигласан бөгөөд дараах байдлаар тодорхойлогдоно.

Зах зээлийн үнэ цэнэ гэдэг нь ҮОУС 104-ийн 30.1-р мөрөнд тодорхойлсны дагуу нь “зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа, талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагчийн хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө, өр төлбөрийг арилжвал зохино гэж уг үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн”-г хэлнэ.

Үнэлгээний үндсэн ба тусгай таамаглалууд


БДО Аудит нь дараах таамаглалуудад үндэслэн компанийн өмчийн 100 хувийн хувь оролцооны зах зээлийн үнэ цэнийг тооцсон. Үүнд:

- Ард Кредит ББСБ нь урьдчилан харах боломжтой ирээдүйд өөрийн банк бус санхүүгийн бизнесээ тасралтгүй үргэлжлүүлэх үйл ажиллагааны төсөөлөл баримтална.
- Ард Кредит ББСБ-ын тасралтгүй ажиллагаа эсвэл бизнесийн үндсэн чиглэлд урьдчилан харах боломжтой ирээдүйд мэдэгдэхүйц өөрчлөлт орохгүй гэж таамагласан. Жишээлбэл, банкны секторт үйл ажиллагаагаа тэлэх гэх мэт.
- Мөнгөн урсгалын төсөөлөл нь Ард Кредит ББСБ-аас ирүүлсэн дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөнд суурилсан бөгөөд уг төлөвлөгөөнд багтсан мэдээллийн агуулга, тооцоолол нь үнэн зөв, бодитой гэж таамагласан.



000113





- Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөнд багтсан аливаа тооцоолол нь бизнесийн үйл ажиллагааны хамгийн сайн ашиглалт (High and best uses)-д үндэслэсэн. Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөнд байгууллагын нөөц ашиглалтыг боломжит хамгийн дээд төвшин-д тодорхойлсон бөгөөд эдгээр тооцоолол нь удирдлагын хамгийн сайн мэдлэг, туршлага дээр үндэслэн бэлтгэгдсэн гэж таамагласан.
- Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөнд тодорхойлсноор Ард Кредит ББСБ-ын хүүгийн орлого таамагласан хугацааны туршид жил бүр дунджаар 66 хувиар өснө. ТЖ18 онд нийт хүүгийн орлогын 42 хувийг жижиг, дунд бизнесийн зээл, 24хувийг шуурхай зээл, 8хувийг картын зээл, 6хувийг бичил зээл бүрдүүлнэ гэж таамагласан. Харин ТЖ22 он гэхэд шуурхай зээлийн бүтээгдэхүүний борлуулалтад эзлэх хувь буурч, жижиг дунд бизнесийн зээл (34%), цалингийн зээл (15%), картын зээл (25%), хувьцаагаар баталгаажсан зээл (15%)-ийн бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдэнэ гэж төлөвлөсөн.
- Эх үүсвэртэй холбогдон үүсэх хүүгийн зардал таамагласан хугацааны туршид жил бүр дунджаар 65 хувиар өснө гэж таамагласан. Эх үүсвэрийн үндсэн хэрэгсэлд итгэлцэл, бонд, банк санхүүгийн байгууллагын зээл, хөгжлийн сан, олон улсын санхүүгийн байгууллагууд, бусад сангууд багтана.
- Үйл ажиллагааны нийт зардал таамагласан хугацааны туршид жил бүр дунджаар 5хувиар өснө. Үүнд боловсон хүчний зардлын өсөлт голлон нөлөөлнө гэж таамагласан.
- Үйлчилгээний өртөгт материаллаг үр нөлөөтэй хөдөлмөрийн орцын өсөлт, боловсон хүчний сургалт, ажил олгогчоос ажилтанд олгох нийгмийн халамжийн төлөвлөгөө байхгүй. Мөн түүнчлэн боловсон хүчний мэргэжлийн ур чадварын дутагдал, мэргэжлийн ёс зүйн доголдлоос үүсэх аливаа зарга, маргаан үүсэхгүй гэж таамагласан.
- Засгийн газрын бодлого, зохицуулалтын гэнэтийн өөрчлөлт Ард Кредит ББСБ-ын бизнесийн үйл ажиллагаа (загвар) болон банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд мэдэгдэхүйц нөлөөлөхгүй.
- Ард Кредит ББСБ-ын бизнесийн үйл ажиллагааны татварын харилцаа нь Монгол улсын татварын хуулиар зохицуулагдах бөгөөд урьдчилан харах боломжтой ирээдүйд татварын орчин мэдэгдэхүйц өөрчлөгдөхгүй гэж таамагласан.
- Ард Кредит ББСБ-ын санхүүгийн тайланд тусгагдсан бизнесийн хэвийн үйл ажиллагаанаас бусад тодруулаагүй хөрөнгө/өр төлбөр эсвэл хэвийн бус үүрэг хариуцлага, үнэлгээний өдрийн байдлаар шийдвэрлэгдээгүй шүүхийн зарга маргаан зэрэг үнэлгээнд мэдэгдэхүйц нөлөөтэй аливаа болзошгүй зүйл байхгүй.
- Банк бус санхүүгийн бизнест мэдэгдэхүйц нөлөөлөх байгалийн гамшиг, цаг уурын таагүй нөхцөл урьдчилан харах боломжтой ирээдүйд үүсэхгүй.

Үнэлгээний арга хандлага

Ард Кредит ББСБ-ын бизнесийг үнэлэхдээ дээрх төсөөлөлд үндэслэн орлогын хандлагаас Хорогдуулсан Мөнгөн Урсгал (ХМУ)-ын загвар, зах зээлийн хандлагаас жишиг компани ба жишиг арилжааны арга зүйг сонгон ашигласан.


Зах зээлийн хандлага: Жишиг компанийн арга зүй (ЖКАЗ) ба жишиг арилжааны арга зүй (ЖААЗ)

Бизнес дэх өмчийн хувь оролцоог үнэлэхдээ зах зээлийн хандлага нь үнэлж буй бизнесийн санхүүгийн өнөөгийн нөхцөл байдал, түүхэн ба хүлээгдэж буй санхүүгийн гүйцэтгэлийн нээлттэй компаниуд болон (1) ижил буюу төстэй бизнесийн шугамд үйл ажиллагаа явуулдаг (2) эдийн засгийн, байгаль орчны, улс төрийн эрсдэлд адилхан өртдөг, (3) хөрөнгө оруулагчийн



000114





дараагийн сонголт байх боломжтой компаниудын зах зээлийн үнэлгээ болон эдгээр компанийн бодит арилжаатай харьцуулдаг.

- ЖКАЗ: Энэ арга зүй нь нээлттэй чөлөөт зах зээлд идэвхтэй арилжаалагддаг, бизнесийн ижил шугамд үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны зах зээлийн үнээс тооцсон зах зээлийн үржүүлэгчийг ашигладаг. Үнэлж буй бизнесийн санхүүгийн гүйцэтгэлийг илтгэх хэмжүүрт тохирох үржүүлэгчийг сонгосноор арилжаалагдахуйц цөөнхийн сонирхлоор үнэ цэнэ тодорхой болдог.
- ЖААЗ: Энэ арга зүйг мөн “арилжааны арга” эсвэл “нэгдэл ба худалдан авалтын арга” гэж нэрлэдэг. Жишиг арилжаагаар зах зээлийн үнэ цэнийг тооцохдоо ижил бизнесийн шугамд үйл ажиллагаа явуулдаг компаниудын хяналтын эрхтэй буюу их дүнтэй арилжаанаас үүссэн үржүүлэгч ашигладаг.

Орлогын хандлага: ХМУ-ын загвар

Ирээдүйн мөнгөн урсгалын цэвэр өнөөгийн үнэ цэнийн шинжилгээ буюу ХМУ-ын загвар нь ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ нь бизнесийн үнэ цэнийг илтгэнэ гэсэн үзэл баримтлалд суурилдаг. Энэ арга зүйг ашиглахын тулд ирээдүйн мөнгөн урсгалын хүлээгдэж буй дүнг капиталын жигнэсэн дундаж өртгөөр хорогдуулдаг. Хэрэв мөнгөн урсгалын төсөөлөл нь шууд өмч рүү чиглэсэн бол өмчийн өртгийг хорогдуулах хүү болгон ашигладаг. КЖДӨийн бүрэлдэхүүн болох өмчийн капиталын өртгийг сайжруулсан Капитал хөрөнгө үнэлгээний загвар (КХҮЗ) ашиглан тооцно.

Банк, санхүүгийн байгууллагын мөнгөн урсгалыг тооцохдоо үнэлгээний практикт ихэвчлэн ногдол ашиг хорогдуулах загвар болон илүүдэл өгөөжийн загвар ашигладаг. Энэхүү хоёр загвар дараах байдлаар тодорхойлно:

- Ногдол ашиг хорогдуулах загвар: Банк, санхүүгийн байгууллагын үнэлгээнд хамгийн өргөн ашиглагддаг загвар бөгөөд санхүүгийн байгууллагын үнэ цэнийг тооцохдоо ирээдүйн ногдол ашгийг өмчийн өртгөөр хорогдуулдаг загвар юм.
- Илүүдэл өгөөжийн загвар: Энэ загвар нь санхүүгийн байгууллагын үнэ цэнэ нь өмчийн хөрөнгө оруулагчид зохих өртгөөр өгөөж хүртсэний дараа үлдэх илүүдэл үнэ цэнээр тайлбарлагддаг гэж үздэг.

Үнэлгээний үр дүн

БДО Аудит нь үнэт цаас гаргагчийн бизнесийн зах зээлийн үнэ цэнийг тооцохдоо зах зээлийн хандлага ба орлогын хандлагыг авч үзсэн. Зах зээлийн хандлагаар тооцсон үнэлгээнд жишиг компанийн арга зүй болон жишиг арилжааны арга зүйг ашигласан бол орлогын хандлагаар тооцсон үнэлгээнд хорогдуулсан мөнгөн урсгалын загварыг удирдлагын төсөөлөлд үндэслэн тооцсон. Ашигласан гол аргачлал тус бүрийн үнэлгээний үр дүнг дараах хүснэгтэд хураангуйлав.

Үнэлгээний үр дүн нь ирээдүйн бизнесийн үнэ цэнэ буюу хөрөнгийн зах зээлээс санхүүжилт босгосны дараа буюу удирдлагын баг “Ард” үйлчилгээг багтаасан бизнесийн төлөвлөгөөгөө зохих ёсоор амжилттай биелүүлсэн нөхцөлд үүсэх үнэ цэнийг илтгэнэ.

Хүснэгт 65. Үнэлгээнд ашигласан параметрууд

Үнэлгээнд ашигласан параметрууд
Монгол Улсын урт хугацааны инфляц
Нэрлэсэн жигнэсэн дундаж капиталын өртөг



000115



СҮНЭТ ЦААСНЫ ТАНИЦУУЛГА
ОЧ 2019-01-09
БҮРТГЭВ
№01

МОНГОЛЫН ХРЭДИТ-
МОНГОЛЫН ББСБ БХК
2018-11-29
25.1%
8.9%
БҮРТГЭВ-С

Нэрлэсэн өмчийн өртөг	
Бодит жигнэсэн дундаж капиталын өртөг	
Бодит өмчийн өртөг	16.5%
Урт хугацаат өсөлтийн төвшин	3.6%
Үнэ ашгийн үржүүлэгч (тохируулаагүй)	18.71x
Үнэ/ дансны үнийн үржүүлэгч	6.27x
Бизнесийн үнэ цэнэ	
Ногдол ашиг хорогдуулах загвар (мянган төгрөг)	28,556,162
Илүүдэл өгөөжийн загвар (мянган төгрөг)	24,554,886
Жишиг арилжааны арга (мянган төгрөг)	22,247,580

Мөнгөн урсгалын төсөөлөл нь удирдлагаас ирүүлсэн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд үндэслэсэн. Хорогдуулах хүүг өмчийн өртгөөр тооцсон бөгөөд БДО Аудит-ын шинжилгээгээр өмчийн өртөг 24.1 хувиас 25.1 хувь гэж тооцсон. Мөн түүнчлэн дараах арга зүй, параметруудийг мөнгөн урсгалын төсөөлөлд ашигласан.

- Бизнесийн үлдэх үнэ цэнэ буюу эцсийн мөнгөн урсгалыг Гордоны тогтмол өсөлтийн загвар ашиглан тодорхойлсон.
- Урт хугацааны өсөлтийн параметрийг сонгохдоо Сангийн яамны урт хугацааны эдийн засгийн өсөлтийн судалгаанд тодорхойлсон 3.6 хувь байхаар сонгон авсан.
- Урт хугацааны хүлээгдэж буй инфляц 6.5 хувь байна.
- Хорогдуулах хүүний үеийг дундаж үеийн аргаар тооцсон.

Ногдол ашиг хорогдуулах загвар- Ард Кредит ББСБ-ын олгох боломжтой ногдол ашгийн өнөөгийн үнэ цэнийг тооцож бизнесийн өмчийн 100 хувийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнэ **28,556,162 мянган төгрөг** байна.

Илүүдэл өгөөжийн загвар- Ард Кредит ББСБ-ын үнэлгээний өдрийн байдлаар бизнесийн өмчийн 100 хувийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнэ **24,554,886 мянган төгрөг** байна.

Жишиг арилжааны арга- БДО Аудит нь өөрсдийн үнэлгээний шинжилгээ болон судалгаанд үндэслэн үнэт цаас гаргагчтай ижил бизнесийн эрсдэл бүхий жишиг компаниудын нэгдэл ба худалдан авалтын зах зээл дэх арилжаануудыг судлах замаар бизнесийн өмчийн 100 хувийн хувь оролцооны үнэ цэнийг тодорхойлсон. Үнэлгээний баг жишиг арилжаагаар ЛэндМН-ийн анхдагч болон хоёрдогч зах зээл дэх арилжааг сонгосон. Энэ нь дараах үндэслэлтэй байна.

Үүнд: (1) ЛэндМН нь үнэлж буй бизнестэй ижил эдийн засгийн анхдагч орчинтой (2) бизнесийн чиглэл, салбарын эрсдэлийн хувьд ижил төрлийн эрсдэл хүлээдэг (3) хөрөнгө оруулагчдын дараагийн сонголт байх боломжтой.

Жишиг арилжааны аргаар ЛэндМН ББСБ ХК-ийн 2018 оны 3 сарын 14-өөс 5 сарын 23-ны хооронд явагдсан хоёрдогч зах зээлийн арилжааны өгөгдлийг ашигласан ба үнэ/ дансны үнийн үржүүлэгчийн аргыг ашиглан тооцсон. Энэ үр дүнгээс дүгнэхэд үнэлгээний өдрийн байдлаар үйлчлүүлэгчийн бизнесийн өмчийн 100 хувийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнэ **23,418,505 - 22,247,580 мянган төгрөг** байна.

БДО Аудит нь мэргэжлийн багийн төвшинд шүүн тунгааж, дээр дурдсан арга хандлагуудаас үнэлгээний шинжилгээнд ашиглагдсан аргуудын медиан нь үнэлгээний өдрийн байдлаар бизнесийн зах зээлийн үнэ цэнийг илүү сайн төлөөлж чадна гэж дүгнэсэн байна. Өөрөөр



000116





Хэлбэл үнэлгээний өдрийн байдлаар Ард Кредит ББСБ ХХК-ийн бизнесийн 100 хувийн өмчийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнэ 24,554,886 мянган төгрөг байх үндэслэлтэй байна.

	Хувьцааны тоо	Бизнесийн үнэ цэнэ	Нэгж хувьцааны дотоод үнэ цэнэ
Нэмж хувьцаа гаргасны дараа	280,000,000	24,554,886,000	87.7

БДО Аудит нь үнэт цаас гаргагчийн бизнесийн 100 хувийн өмчийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнийг тооцохдоо ногдол ашиг хорогдуулах загвар, илүүдэл өгөөжийн загвар, жишиг арилжааны аргыг сонгон ашигласан ба эдгээр аргын үр дүнд компанийн өмчийн үнэ цэнэ 22.2 - 28.6 тэрбум төгрөгийн хооронд гарсан байна. Үүнээс үнэлгээчин нь үнэлгээний шинжилгээнд ашигласан аргуудын медиан үр дүн болох 24.6 тэрбум төгрөг нь үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэ цэнийг илүү сайн илтгэж чадна хэмээн үзсэн ба энэ нь нэгж хувьцааны дотоод үнэ цэнэ 87.7 төгрөг юм.

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад тааламжтай нөхцлийг санал болгох үүднээс өөрийн хувьцааг худалдах доод үнийг 70.0 төгрөгөөр тогтоон дотоод үнэ цэнэ болох 87.7 төгрөгөөс 20.2 хувиар хямдруулан хөрөнгө оруулагчдад санал болгож байна.

3.6. ҮНЭТ ЦААСНЫ ӨГӨӨЖИЙН ТӨСӨӨЛӨЛ

Үнэт цаас гаргагч нь өөрийн хувьцааг олон нийтэд санал болгон татан төвлөрүүлсэн хөрөнгийг өөрийн үндсэн үйл ажиллагаа болох зээлийн бүтээгдэхүүнийг санхүүжүүлэхэд зарцуулах ба ингэснээр компанийн нийт зээлийн үлдэгдэл өсөж орлого нэмэгдэх юм.

Доорх төсөөлөл нь Ард Кредит ББСБ ХХК-ийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд суурилсан ба үнэт цаас гаргагчийн балансын нийт хувьцааны тоо, эздийн өмчийн дүн, цэвэр ашиг зэрэг үзүүлэлтүүдийн 2022 он хүртэлх төсөөллийг тусгасан.

Уг төсөөлөлд тулгуурлан үнэт цаас гаргагчийн нэгж хувьцааны ханшийг энгийн байдлаар төсөөлсөн ба энэхүү ханшийн төсөөллийг жишиг компанийн арга ашиглан тооцлоо.

Хүснэгт 66. Үнэт цаасны өгөөжийн төсөөлөл

	2018P	2019P	2020P	2021P	2022P
Нийт хувьцааны тоо (сая ширхэг)	280	280	280	280	280
Эздийн өмч (сая төгрөг)	9,353	13,031	19,090	29,176	44,776
Цэвэр ашиг (сая төгрөг)	716	3,822	6,823	11,450	17,890
Дансны үнэ	33	47	68	104	160
Нэгж хувьцаанд ногдох ашиг	3	14	24	41	64
Үнэ ашгийн харьцаа	10	10	10	10	10
Үнэ дансны үнийн харьцаа	2	2	2	2	2
Ханшийн төсөөлөл P/E	137	137	244	409	639
Ханшийн төсөөлөл P/B	67	93	136	208	320
Ханшийн төсөөлөл (P/B*0.7, P/E*0.3)	88	106	169	269	416
Жилийн өгөөж	25%	21%	59%	59%	55%
IPO өгөөж	25%	52%	141%	284%	494%
Нийт үнэлгээ	24,560	29,709	47,195	75,196	116,356



000117



2019.01.09 өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛ

МОНГОЛ АЖИРАХ КРЕДИТ
MONGOL AGRICULTURAL CREDIT
2018-11-29
БҮРТГЭВ

Үнэт цаасны танилцуулга

БДО Аудит нь үнэт цаас гаргагчтай бизнесийн ижил шугамд үйл ажиллагаа явуулдаг, компанийн бүтцийн хувьд ижил төсөөтэй, зах зээлийн үнэлгээ ойролцоо, нээлттэй чөлөөт зах зээлд идэвхтэй арилжаалагддаг компаниудыг судалсан ба зүүн Азийн бүсийн Энэтхэг, Тайланд зэрэг эдийн засгийн хувьд хөгжиж буй улсуудад үйл ажиллагаа явуулдаг ББСБ-уудыг сонгон зах зээлийн үржүүлэгчдийг тооцсон. Үүнд үнэт цаас гаргагчтай төсөөтэй санхүүжилтийн бүтэцтэй, зах зээлийн үнэлгээ ойролцоо буюу дундаж зах зээлийн үнэлгээ бүхий ББСБ-уудын медиан үржүүлэгчдийг тооцоход үнэ ашгийн харьцаа 18.71, форвард үнэ ашгийн харьцаа 12.14, үнэ дансны үний харьцаа 1.16 байна. Эдгээр үржүүлэгчид нь Энэтхэг, Тайланд зэрэг улсын зах зээлийн нөхцөл байдлыг илтгэх ба Монгол Улсын зах зээлийн нөхцөлийг тусгах зорилгоор 0.88 коэффицентээр эдийн засгийн анхдагч орчны тохируулга хийв. Ингэснээр Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлыг тусгасан ББСБ-ын зах зээлийн үржүүлэгч үнэ ашгийн харьцаа 16.46, форвард үнэ ашгийн харьцаа 10.7, үнэ дансны үнийн харьцаа 1.02 гарсан.

Үнэт цаас гаргагчтай нэг зах зээлд үйл ажиллагаа явуулдаг ЛэндМН ББСБ ХК-ийн үнэ ашгийн харьцаа 37.12, форвард үнэ ашгийн харьцаа 11.56, үнэ дансны үнийн харьцаа 3.84 байна. Бид компанийн нэмж үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгө компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх хугацаа, компанийн санхүүжилтийн бүтэц зэргийг харгалзан үзэн, энэхүү төсөөллийг хэт өндөр бус, хүрч болохуйц байлгах үүднээс жишиг зах зээлийн үржүүлэгчийг үнэ ашгийн харьцаа 10.00, үнэ дансны үнийн харьцаа 2.00 байхаар тооцооллоо. Үүнд хөрөнгө оруулалт татсан эхний жил буюу 2018 оны ханшийн төсөөлөлд форвард үнэ ашгийн харьцааг ашигласан ба энэ нь олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгө нь тухайн оны эцсээр орж ирж, компанийн үйл ажиллагаанд бодит нөлөө үзүүлж амжихгүй гэж үзсэнтэй холбоотой. Мөн боломжит ханшийг тооцолоход банк санхүүгийн байгууллагыг үнэлэх олон улсын практикт үнэ дансны үнийн харьцааг өргөн ашигладгийг даган үнэ дансны үнийн харьцаанд давамгайл буюу 70 хувийн жин, форвард үнэ ашгийн харьцаанд 30 хувийн жинг оноосон.

Энэхүү төсөөллөөс үзэхэд үнэт цаас гаргагч өөрийн бизнес төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэн үйл ажиллагааны зорилтуудыг биелүүлснээр хөрөнгө оруулагчид урт хугацаанд буюу 5 жилд 494 хувийн өгөөж хүртэх боломжтой байна.

3.7. Хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэг


Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ.

- 1 Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах шийдвэр гаргах үед ТУЗ-өөс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч хуралд оролцож, хэлэлцэж буй асуудлаар өөрийн эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;
- 2 ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн бол эзэмшиж буй хувьцаанд оногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль журамд заасан хугацаандаа олгохгүй бол алданги төлөхийг шаардах;
- 3 Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон журмын дагуу үндсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
- 4 Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу тэргүүн ээлжид худалдан авах;



000118





Дор дурдсан асуудлаар гаргасан хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувь эзэмшигч бүр өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрхтэй. Үүнд:

- 5.1 Нийлэх, нэгдэх, хуваах, болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгон өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах болсон бол;
- 5.2 Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргасан зэргээр их хэмжээний хэлцэл хийсэн бол;
- 5.3 Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан бол;
- 5.4 Хувьцаа эзэмшигч дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
6. Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшиж буй этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д санал хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал зарлагдсан үед хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг шаардан гаргуулах;
7. Хувьцаа эзэмшигч нь улирал бүр компанийн санхүүгийн тайлантай танилцах эрхтэй.
8. Хууль тогтоомж болон компанийн дүрмээр тогтоосон бусад эрх.

Компанийн хувьцаа эзэмшигч дараах үүрэг хүлээнэ:

1. Компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин суугаа хаяг болон өөрийн эзэмшилдээ байгаа үнэт цаасны тоо, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар бүртгэл хөтлөх этгээдэд зохих журмын дагуу мэдэгдэх зэрэг үүрэг хүлээнэ.
2. Хувьцаа эзэмшигч нь компанийн нэрийг хувийн ашиг сонирхолд ашиглах, компанийн ажил хэргийн нэр хүнд, өмч хөрөнгөнд гэм хор учруулж болзошгүй үйлдэл хийхийг хориглоно
3. Хууль тогтоомж болон энэхүү дүрмээр тогтоосон бусад үүрэг.

3.8. Үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг МХБ-тэй “Анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах гэрээ” байгуулан явуулах ба үнэт цаасыг МХБ-ийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын 3 дугаар бүлэгт заасан “ТОГТООСОН ҮНИЙН АРГА”, 5 дугаар бүлэгт заасан “ЗАХИАЛГЫН БҮРТГЭЛИЙН АРГА”-уудыг хослуулан ашиглан санал болгоно. Үнэт цаасыг стратегийн хөрөнгө оруулагчдад тогтоосон үнийн арга ашиглан арилжаалах бол олон нийтэд захиалгын бүртгэлийн арга ашиглан арилжаална.



000119



ҮНЭТ цаасны танилцуулга
 2019.01.09
 БҮРТГЭВ
 Хүснэгт 67. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах хуваарь

МОНГОЛ АРД КРЕДИТ БЭСЭ
 MONGOL ARD CREDIT BBS
 2018-11-29
 БҮРТГЭВ 02

	1 дэх долоо хоног	2 дах долоо хоног	3 дах долоо хоног
Зохицуулах байгууллагаас шийдвэр гарч, гэрээ хийх			
МХБ, СЗХ-оос үнэт цаасыг бүртгэх шийдвэр гарах			
МХБ-тэй анхдагч арилжааны гэрээ байгуулах			
Олон нийтэд танилцуулж, захиалга авах			
Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах			
Үнэт цаасны захиалга авах			
Хоёрдогч зах зээлийн арилжаа			
Үнэт цаасны нийлүүлэлт хийж анхдагч зах зээлийн арилжааг хаах			
СЗХ-нд анхдагч зах зээлийн арилжааны тайлан мэдэгдэх			
Хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх			

Зохицуулагч байгууллагын шийдвэр

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлтийг МХБ болон СЗХ-нд нэгэн зэрэг гаргах ба уг зохицуулагч байгууллагууд үнэт цаасыг олон нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны жагсаалтад бүртгэхийг зөвшөөрснөөр үнэт цаасыг олон нийтэд танилцуулж, арилжаалах эрх нээгдэнэ.

Андеррайтер, эсхүл үнэт цаас гаргагч нь үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг СЗХ-оос авах ба энэ тухай хүсэлтийг уг ажиллагааг эхлүүлэхээс ажлын гурваас доошгүй өдрийн өмнө СЗХ-нд гаргах бөгөөд хүсэлтэд хугацаа, хуваарийг тодорхой тусгасан байна.

СЗХ нь анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрөл олгосноор МХБ-тэй анхдагч арилжааны гэрээ байгуулах ба ингэснээр үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны захиалга авахад бэлэн болно.

Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжаа, эсхүл захиалгын бүртгэл явагдаж дууссанаас хойш ажлын гурван өдөрт багтаан арилжааны тайланг СЗХ-нд хүргүүлнэ. СЗХ нь уг тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн захиалгын бүртгэл болон арилжаа амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийх буюу үнэт цаасны нийлүүлэлт хийх болон арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус олгох тухай албан бичгийг ажлын гурван өдөрт багтаан хүргүүлнэ.

Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах



000120



Сүнэт цаасны танилцуулга
 2019 о. 01. 09
 БҮРТГЭВ

ARD КРЕДИТ БҮСБ
 2018-11-29
 БҮРТГЭВ-02

МХБ болон СЗХ үнэт цаасыг олон нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэснээр үнэт цаас гаргагч нь өөрийн үнэт цаасыг олон нийтэд танилцуулах эрх үүснэ.

- Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдод зориулан үнэт цаас гаргагчийн танилцуулга уулзалт зохион байгуулах,
- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зар сурталчилгаа, мэдээллийг хүргэх уулзалт зохион байгуулах,
- Үнэт цаасны хэвлэмэл танилцуулга, материал тараах,
- Үнэт цаасыг олон нийтэд танилцуулахаас өмнө стратегийн хөрөнгө оруулагчдад танилцуулга хийж болно.

Үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга авах


Андеррайтер, эсхүл үнэт цаас гаргагч нь үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг СЗХ-оос авах ба СЗХ зөвшөөрөл олгож, үнэт цаас гаргагч МХБ-тэй “Анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах гэрээ”-г байгуулснаар анхдагч зах зээлийн захиалгыг эхлүүлэх эрх бүрдэнэ. Үнэт цаасыг анхдагч зах зээлд ТОГТООСОН ҮНИЙН АРГА болон ЗАХИАЛГЫН БҮРТГЭЛИЙН АРГА-ийг хослуулан ашиглан санал болгох ба үнэт цаасыг стратегийн хөрөнгө оруулагчдад Тогтоосон үнийн арга ашиглан санал болгох бол олон нийтэд захиалгын бүртгэлийн арга ашиглан санал болгоно. Нийт санал болгож буй хувьцааны 50.0 хувь буюу 35,000,000 ширхэг хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчдад тогтоосон үнийн аргаар санал болгох бол үлдсэн 50.0 хувийг олон нийтэд захиалгын бүртгэлийн аргаар санал болгоно.

Хүснэгт 68. Анхдагч зах зээлд санал болгох хэлбэр

Хөрөнгө оруулагч	Санал болгох хувьцааны ширхэг	Санал болгох арга, санал болгох үнэ
Стратегийн хөрөнгө оруулагч	35,000,000	Тогтоосон үнийн арга, 70 төгрөгөөр
Олон нийт	35,000,000	Захиалгын бүртгэлийн арга, 70-аас 85 төгрөг хооронд

- Олон нийтэд санал болгох үнэт цаасны худалдан авах захиалгыг МХБ-ийн гишүүн бүх брокер, дилерийн компаниар дамжуулан авна.
- Стратегийн хөрөнгө оруулагч нарт андеррайтер, үнэт цаас гаргагч хуваарилалт хийж, арилжааг явуулна.
- Хөрөнгө оруулагч нь үнэт цаас гаргагчын тогтоосон үнийн түвшинд захиалга өгнө.
- Үнэт цаасыг ЗАХИАЛГЫН БҮРТГЭЛИЙН АРГА-аар санал болгоход хөрөнгө оруулагч захиалга бүртгэх хугацаанд өөрийн өгсөн захиалгын тоо ширхэг, үнийн дүнд өөрчлөлт оруулж болохоос гадна цуцалж болно.
- Үнэт цаасыг ЗАХИАЛГЫН БҮРТГЭЛИЙН АРГА-аар санал болгоход хөрөнгө оруулагч нь худалдан авах үнэ, тоо заалгүй худалдан авах нийт үнийн дүнг зааж өгч болно.

Үнэт цаасыг ЗАХИАЛГЫН БҮРТГЭЛИЙН АРГА-аар санал болгоход Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжих үнийг андеррайтер, үнэт цаас гаргагч хамтран тогтооно. Уг үнийг тогтоохдоо үнэт цаасыг худалдан авахаар ирүүлсэн нийт захиалгын жигнэсэн дундаж үнэ, үнэт цаасны анхдагч зах зээлд арилжих үнийг андеррайтер, үнэт цаас гаргагч хамтран тогтооно.



000121



2019 оны 01 сар
БҮРТГЭВ
№01

2019-11-29

цаасны борлуулалтаас олохоор төлөвлөсөн хөрөнгийг бүрэн бүрдүүлэх боломжит үнэ, аль болох олон этгээдийн захиалгыг биелүүлэх боломжит үнэ зэргийг харгалзана.

БҮРТГЭВ-02

- Стратегийн бус хөрөнгө оруулагчын үнэт цаас худалдан авах захиалгын дээд мөнгөн дүн 300,000,000 (гурван зуун сая) төгрөг байна.

Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

Андеррайтер нь анхдагч зах зээлийн захиалгын бүртгэл явагдаж дууссанаас хойш ажлын гурван өдөрт багтаан арилжааны тайланг СЗХ-нд хүргүүлнэ. СЗХ нь уг тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн захиалгын бүртгэл амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийх болон арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус олгох тухай албан бичгийг ажлын гурван өдөрт багтаан хүргүүлнэ. ҮЦТХТ болон МХБ уг зөвшөөрлийг хүлээн авснаар үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ.

Үнэт цаас худалдан авах захиалга өгөх заавар

- МХБ-д бүртгэлтэй ҮЦК-д үнэт цаасны данс нээлгэх,
- Хөрөнгө оруулагч өөрийн үнэт цаасны дансанд дараах зааврын дагуу үнэт цаас худалдан авах мөнгөн хөрөнгө байршуулна.

Хүлээн авагч банк	Арилжааны төлбөр тооцоо ХХК
Хүлээн авагчийн дансны нэр	Харилцагчийн өөрийн нэр
Хүлээн авагчийн дансны дугаар (Харилцагч ҮЦК-аас авах)
Гүйлгээний утга	Хувьцааны мөнгө, Регистрийн дугаар, Холбогдох утасны дугаар

- Өөрийн харилцагч ҮЦК-д үнэт цаас худалдан авах захиалга өгөх,

3.9. Нээлттэй хувьцаат компанийн үйл ажиллагаа явуулах хууль, эрх зүйн орчин


Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 7-д зааснаар “Нээлттэй хувьцаат компани” гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагддаг компанийг хэлнэ. Үнэт цаасаа олон нийтэд нээлттэй санал болгон биржид бүртгэгдэж буй нээлттэй хувьцаат компани нь Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиуд болон СЗХ болон МХБ-ээс баталсан холбогдох дүрэм, журмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана. Эдгээр хууль, дүрмүүдээс нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдэд шууд хамааралтай гэж үзсэн зарим заалтуудыг дор тусгав.


3.9.1. Компанийн тухай хууль

Компанийн тухай хуулийн 4.1-т зааснаар хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах эрх эдэлнэ.



000122





Компанийн тухай хуулийн 32.1-т зааснаар компанийн хувьцаа нь компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг хувьцаа эзэмшигчийн эрхийг гэрчилнэ.

Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:


- хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;
- давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлсний дараагаар компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-өөс тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах;
- компанийг татан буулгах үед энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх.
- Хувьцаат компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь энэ хуулийн 38 дугаар зүйл болон компанийн дүрэмд заасны дагуу компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй.
- Компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчийн эзэмшиж болох энгийн хувьцааны тоог хязгаарлаж болохгүй.
- Энгийн хувьцааг компанийн давуу эрхийн хувьцаа болон бусад үнэт цаасанд хөрвүүлж үл болно.
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх зарим асуудлаар энгийн хувьцаа эзэмшигчийн санал өгөх эрхийг энэ хуулиар хязгаарлаж болно.

Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ гаргах бөгөөд уг шийдвэрт үнэт цаасны төрөл, тоо, гаргах хугацаа, нөхцөлийг заана.

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлд зааснаар ногдол ашиг зарлах болон олгохтой холбоотой харилцааг дараах байдлаар зохицуулна:

- Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана.
- Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хуулийн 46.1-д заасан шийдвэрийн талаар хувьцаа эзэмшигчид мэдэгдэх үүрэгтэй.
- Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна.
- Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнах үүрэгтэй.
- Ногдол ашгийг компанийн татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилна.
- Компани нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг хуваарилна.

Компани ногдол ашгаа ногдол ашгийн шийдвэрт заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх бөгөөд үүнээс компанид учирсан хохирлыг тухайн компанийн гүйцэтгэх удирдлага нөхөн төлнө.



000123



2019.01.09

БҮРТГЭЛ
№ 01

ARD КРЕДИТ
ББСБ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2018-11-29

БҮРТГЭЛ

Ногдол ашгийн шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгаа аваагүй нь тухайн хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг авах эрхийг үгүйсгэх, эсхүл тухайн компани ногдол ашиг олгохгүй байх үндэслэл болохгүй.


- Ногдол ашгаа аваагүй хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийг түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэж хадгалах бөгөөд компани хувьцаа эзэмшигчийн анхны шаардлагаар ногдол ашгийг олгох үүрэгтэй.
- Хувьцаат компани нь ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.
- Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилалтын тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд заавал тайлагнана.

Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлд зааснаар дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчийн шаардлагаар компани хувьцаагаа эргүүлэн худалдан авна:

- Дор дурдсан асуудлаар хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй:
 - o нийлүүлэх, нэгтгэх, хуваах болон хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
 - o компани энэ хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлах шаардлагатай их хэмжээний хэлцэл хийсэн;
 - o компанийн дүрэмд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан;
 - o компанийн дүрэмд заасан бусад тохиолдол.
- Хувьцаа эзэмшигч дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 75 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа, түүнчлэн төрийн өмчийн эзэмшилд байсан компанийн хувьцааны хяналтын багцыг хувьчлан авсан тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй.


Компанийн тухай хуулийн 9 дүгээр бүлэгт зааснаар хувьцаа эзэмшигчдийн хурал

- Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна.
- Компани хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шийдвэр гарснаас хойш тав хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигчид хүргэх үүрэгтэй.
- Компанийн төлөөлөн удирдах зөвлөл санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно.
- Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн бүрэн эрх нь дуусгавар болсон өдрөөс хойш байгуулсан гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус байна.



000124





Дараах тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна:

- төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүний 50-аас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;
- төлөөлөн удирдах зөвлөлийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан;
- компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн;
- компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болсон;
- төлөөлөн удирдах зөвлөл шийдвэр гаргасан;
- аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан;
- компанийн дүрэмд заасан бусад тохиолдол.

Компанийн тухай хуулийн 62.1-т зааснаар дараах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:

- компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
- нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
- компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
- компанийн хэлбэрийг өөрчлөх;
- компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
- хувьцааг хуваах буюу нэгтгэх;
- төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
- энэ хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигч нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх;
- компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- энэ хуульд заасны дагуу компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;
- компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хувьцаа эзэмшигчдэд зориулан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар бичсэн тайланг батлах;
- төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
- энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал.

Компанийн тухай хуулийн 75.1-т зааснаар хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна.

- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог компанийн дүрмээр тогтооно. Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.



000125





Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

Компанийн тухай хуулийн 76.1-т зааснаар төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хууль болон компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
- хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
- компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;
- компанийн дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах;
- энэ хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
- өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;
- компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;
- компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
- аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
- компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;
- компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлох;
- төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;
- компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;
- компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- энэ хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- энэ хуулийн арван хоёрдугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал.
- Хувьцаат компанийн хувьд энэ хуулийн 76.1.6, 76.1.10, 76.1.17-д заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд заавал оролцож саналаа өгнө.

3.9.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль


Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1-т зааснаар үнэт цаас гаргагч дараах нийтлэг үүрэгтэй байна:

- үнэт цаас гаргах тухай шийдвэрийг эрх бүхий байгууллагын хурлаар хэлэлцэн гаргах; үнэт цаасны арилжаатай холбоотой мэдээ, тайланг холбогдох аргачлал, маягтын дагуу үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд Хороонд хүргэх, нийтэд мэдээлэх;
- Компанийн тухай хуульд зааснаас доошгүй тооны хараат бус гишүүнтэй байх; тохиромжтой этгээдийг эрх бүхий албан тушаалтнаар томилох буюу сонгох;



000126





2018-11-29

БҮРТГЭВ-02

- № 01- үнэт цаасны танилцуулгад заасан төслийн хэрэгжилт өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр нийтэд болон хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх;
- хагас жилийн болон Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд Хороо болон хөрөнгийн биржид хүргүүлэх;
 - Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаарх мэдээллийг Хорооноос тогтоосон журмын дагуу нийтэд мэдээлэх;
 - хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг нийтэд нэн даруй мэдээлж, холбогдох баримт бичиг, мэдээллийг хурал хуралдсанаас хойш ажлын гурван өдрийн дотор Хороо, хөрөнгийн биржид хүргүүлэх;
 - үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлж болох нөхцөл байдал үүсмэгц энэ тухай нийтэд нэн даруй мэдээлэх;
 - Хорооноос баталсан компанийн засаглалын зарчмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх.
 - Үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлж болох мэдээллийн төрөл, түүнийг нийтэд мэдээлэх журмыг Хорооны зөвшөөрснөөр хөрөнгийн бирж тогтооно.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 21.1-т зааснаар дараах нөхцөл байдал үүссэн, эсхүл үүсч болзошгүй гэж үзвэл Хороо үнэт цаас гаргагчаас мэдээлэл ирүүлэхийг шаардах эрхтэй:

- хөрөнгө оруулагч болон нийтэд хүргэвэл зохих мэдээллийг холбогдох журмын дагуу хүргээгүй.
- Үнэт цаас гаргагч, эсхүл түүний эрх бүхий албан тушаалтан нь хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хохироосон, хууль бус үйл ажиллагаа явуулсан гэж үзвэл Хороо хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 55.1-т зааснаар үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаас гаргагч нь дор дурдсан мэдээллийг үнэ төлбөргүйгээр сонирхсон этгээдэд өгөх үүрэгтэй:

- үнэт цаасны танилцуулгад туссан мэдээлэл;
- үнэт цаас гаргагчийн дүрэм, журамд заасан үнэт цаас гаргах, үнэт цаасыг арилжих журам;
- санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;
- Хороо, хөрөнгийн бирж болон бусад эрх бүхий байгууллагаас тогтоосон болон үнэт цаас гаргагчийн дүрэм, журамд нийтэд мэдээлэхээр тусгасан мэдээлэл.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56.1-т зааснаар үнэт цаасны хоёрдогч зах зээлд үнэт цаасаа арилжиж байгаа үнэт цаас гаргагч нь дор дурдсан нөхцөл байдал үүссэнээс хойш ажлын нэг өдөрт багтаан энэ талаар Хороо, хөрөнгийн бирж болон өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх үүрэгтэй:

- үнэт цаас гаргагчийн удирдлагын бүтцэд өөрчлөлт орсон;
- нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн бүтэц, түүний бусад компанид эзэмшиж байгаа хувьцаанд өөрчлөлт орсон;
- үнэт цаас гаргагч болон түүний охин, хараат, зэргэлдээ компанид зохион байгуулалтын өөрчлөлт орсон;
- үнэт цаас гаргагчийн хөрөнгийг битүүмжилсэн, эсхүл хураасан;
- үнэт цаас гаргагч тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх болсон, эсхүл түүнийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон;



000127





- үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан;
- үнэт цаасны үнэ, ханшид нөлөөлж болох бусад.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56.2-т зааснаар Хөрөнгийн бирж нь өөрийн бүртгэлд байгаа үнэт цаас, үнэт цаас гаргагчийн талаарх дор дурдсан мэдээллийг цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх үүрэгтэй:

- үнэт цаасны ханш, түүнд нөлөөлж болох бусад мэдээлэл;
- үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдал;
- үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэрийн талаар;
- үнэт цаас гаргагчийн байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл;
- үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтны эзэмшиж байгаа хувьцаа болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн хувь хэмжээ, тоо ширхэг;
- удирдлага, зохион байгуулалтын бүтцэд орсон өөрчлөлт болон төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн талаарх мэдээлэл;
- үнэт цаас гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид болон тэдгээрийн холбогдох этгээдийн талаарх мэдээлэл;
- хууль тогтоомж, Хороо, хөрөнгийн биржээс тогтоосон бусад мэдээлэл.
- Энэ хуулийн 56.2-т заасан мэдээллийн үнэн зөвийг үнэт цаас гаргагч өөрөө хариуцна.


3.9.3.МХБ болон СЗХ-ноос баталсан журам

Дээр дурдсан хууль тогтоомжоос гадна нээлттэй хувьцаат компани нь МХБ болон СЗХ-оос баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам, Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам, Хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилалтад хяналт тавих тухай журам, Үнэт цаасны дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчийн үнэт цаасны зах зээл дээр явуулах үйл ажиллагааны тухай журам, Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны тухай журам, Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам, МХБ-ээс баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам, Хувьцаат компанийн мэдээллийн журам зэрэг журмуудыг мөрдөн үйл ажиллагаагаа явуулна.



000128





Үнэт цаасны танилцуулга



4. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ТАНИЛЦУУЛГА

4.1. Үндсэн Андеррайтер

“Ард Капитал Групп ҮЦК” ХХК нь Монголын тэргүүний үнэт цаасны компаниудын нэг бөгөөд хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээг үзүүлэх үндсэн зорилготойгоор 2007 онд байгуулагдсан. Компани нь СЗХ-оос үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер болон андеррайтерийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, МХБ болон МҮЦАЭХ-ийн гишүүн байгууллага юм.


“Ард Капитал Групп ҮЦК” ХХК нь дотоодын үнэт цаасны арилжаа төдийгүй Монголд анх удаа НКЕХ, LSE, ASX and NYSE зэрэг гадаадын биржийн арилжаанд оролцох үйлчилгээг нэвтрүүлж, энэхүү үйлчилгээгээр дотооддоо тэргүүлсээр байна. Сүү ХК-ийн 6.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий бондын санхүүжилт босгох үйл ажиллагаанд хамтрагч андеррайтераар ажилласан. 2018 онд Үндэсний өв соёлыг эрхэмлэгч, НААД брэндийн эрхийг эзэмшигч Талын Эзэн ХХК-ийн 420.0 сая төгрөгийн бондыг хаалттай хүрээнд амжилттай арилжаалж, Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв-д бүртгүүлж хөрөнгө оруулагчдын эзэмшлийг баталгаажуулсан нь Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд анхны тохиолдол байв. Мөн оны 6 сард Урбан брендийн 600.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий Урбан бонд, 8 сард 1.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий Бэрс хаалттай бондуудын санхүүжилт босгох үйл ажиллагаанд хамтрагч андеррайтераар тус тус ажиллаад байна.

“Ард Капитал Групп ҮЦК” ХХК нь үнэт цаасны гадаад, дотоод арилжаа, андеррайтерийн ажил үйлчилгээнээс гадна байгууллагын санхүүжилт, М&А болон бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд 2015-2018 онуудад Япон улсын JICA хамтын ажиллагааны байгууллагад макро эдийн засгийн зөвлөх, “Зэс Эрдэнийн Хувь” ХХК, “Түшиг Уул” ХК, “Eurofeu” ХХК зэрэг компаниудад санхүүгийн зөвлөхийн үүрэг гүйцэтгэсэн. “Ард Капитал ҮЦК” ХХК-ийн Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд оруулж буй манай компанийн хувь нэмрийг үнэлж Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооноос 2011 онд “Шилдэг Брокерийн компани”-аар, 2013 онд Монголын хөрөнгийн зэх зээлийн дээд шагнал GRAND BULL AWARDS “Шилдэг Шинийг Санаачлагч” байгууллагаар тус тус шалгаруулсан байна.

Компанийн нэр:	“Ард Капитал Групп ҮЦК” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011125147
Регистрийн дугаар:	5183855
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити центр, 1003 тоот
Утас:	7731-0262
И-мэйл:	info@ardcaital.mn


Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Үндсэн Андеррайтер нь 2008 оны 04 сарын 18-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооны 86 дугаар тогтоолоор авсан “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх” 3/42 тоот тусгай зөвшөөрлийн хүрээнд Үнэт цаас гаргагчтай 2018 оны 05 дугаар сарын 17 өдөр байгуулсан 09 тоот “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний дагуу мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх андеррайтерийн үүрэг гүйцэтгэж байгаа болно. Тус гэрээний зорилго нь Андеррайтер Үнэт цаас



000129





Үнэт цаасны танилцуулга



гаргагчийн хувьцааг олон нийтэд санал болгож арилжаалах үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээ үзүүлэх, шаардагдах тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх, үнэт цаасны зах зээл дээр хувьцаа гаргахтай холбоотой хууль тогтоомж, журмыг мөрдөх тал дээр зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулагч нарт Компанийг танилцуулах, санал болгох, анхдагч зах зээл дээр хувьцааг амжилттай арилжаалахад дээд зэргийн хүчин чармайлт гарган ажиллах, зөвлөхүүдийг гэрээгээр хүлээсэн ажлаа гүйцэтгэхэд нь дэмжин ажиллаж шаардлагатай мэдээллээр ханган хамтран ажиллахаар харилцан тохиролцсонтой холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Энэхүү гэрээний хүрээнд талууд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Андеррайтер нь Үнэт цаас гаргагчид нээлттэй хүрээнд санхүүжилт татахад компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны чадавх дээр магадлан шинжилгээ хийх, үнэт цаасны танилцуулга материалыг (Проспектус) бэлтгэх, Компанийн үнэт цаасыг ҮЦЗЗ-н тухай хуулийн 41.4.3 дугаар зүйлд заасан андеррайтерийн үйлчилгээний төрлөөр өөрийн бүхий л хүчин чармайлтыг гарган арилжаалах, Компанийн бизнесийн нууцад хамаарах мэдээ, мэдээлэл, нийтэд тараагдаагүй байгаа мэдээллийн нууцыг чанд хадгалах, ҮЦЗЗ-н тухай хуулийн 9.10-т заасан нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлж холбогдох андеррайтерийн бичиг баримтад тусгасан мэдээллийн үнэн зөвийг хянаж, стандартыг шалгах үүрэг хүлээнэ.

- Үнэт цаас гаргагч нь Андеррайтерийг гэрээгээр хүлээсэн ажлаа гүйцэтгэхэд нь шаардлагатай үнэн зөв, бодит мэдээлэл, бичиг баримт болон материалуудын эх хувь, баталгаажсан хуулбарыг цаг тухайд нь бүрэн гаргаж өгөх, бичиг баримт дутуу шаардлага хангаагүй нөхцөлд Андеррайтерийн тавьсан шаардлагын дагуу баримт бичгийг бүрдүүлэх, эрх бүхий байгууллагаар баталгаажуулах, Андеррайтераас үзүүлэх үйлчилгээнд муугаар нөлөөлөх нөхцөл байдлыг арилгах талаар өөрөөс шалтгаалах бүхий л арга хэмжээг авах үүрэг хүлээнэ.

4.2. Туслах Андеррайтер


Туслах андеррайтер нь 1997 онд анх Батс Инвест нэртэйгээр үүсгэн байгуулагдаж Санхүүгийн Зохицуулах Хорооноос брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн тусгай зөвшөөрлүүдийг авч 2015 оноос “Ард Секюритиз ҮЦК” ХХК нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Компани нь 2008 оноос дэд бүтэц, санхүү, аялал жуучлал, барилга, үйлдвэрлэл зэрэг салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудад санхүүгийн жуучлалын үйлчилгээг амжилттай үзүүлсээр иржээ. “Ард Секюритиз ҮЦК” ХХК нь иргэдийн хөрөнгийн зах зээл, хөрөнгө оруулалтын боловсролыг сайжруулах, мэдлэг олгох зорилготой “Ард Боловсролын Академи” –ийн сургалтын үйл ажиллагааг 2016 оны 9 дүгээр сараас хойш тасралтгүй явуулж буйгаас гадна хөрөнгийн зах зээл дээр компаниудад хаалттай хүрээнд бондын санхүүжилт татаж өгөх болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлж үйл ажиллагаагаа өргөжүүлсээр байна.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-г “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-д, “Ард Менежмент” ХХК-г СЗХ-д, “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” ХК-ийг үүсгэн байгуулахад, “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” ХК-ийн “Жинст Увс” ХК-тай нэгдэх нэгдлийн ажилд хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг тус тус үзүүлсэн. “Хөнгөн Бетон” ХК-ийн тендер санал зарлахад, “Жинст Увс” ХК-ийн 84.6 хувийг худалдан авахад, “Монгол Шуудан” ХК-ийн төрийн өмчийн хувьчлалыг Монголын Хөрөнгийн Биржээр арилжаалахад, харилцагчийн нэрийн өмнөөс нийт арилжааны 31 хувийг авахад брокерийн үйлчилгээ үзүүлсэн. “Steppe Gold” JSC-ийн Торонтогийн хөрөнгийн биржид гаргасан хувьцааны Монгол талын зуучлалын



000130





Үнэт цаасны танилцуулга



Үйлчилгээнд мөн брокерийн үүрэг гүйцэтгэсэн байна. 2017 онд “Хүннү Эйр” ХХК-ийн 600 сая долларын бонд, “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн 2 тэрбум төгрөгийн бонд, “Ард Кредит ББСБ”-ийн 2 тэрбум төгрөгийн бонд, “ЭнЭйПи” ХХК-ийн 350 сая төгрөгийн бондын санхүүжилтэнд андеррайтераар ажиллажээ.

Компанийн нэр:	“Ард Секюритиз ҮЦК” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011472112
Регистрийн дугаар:	2111063
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж, “Ард Санхүүгийн нэгдэл ХК”-ийн байр, 2 давхар
Утас:	11-321899
И-мэйл:	info@ardsecurities.com

Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

2007 оны 08 сарын 17-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооны 111 дугаартай тогтоолоор авсан 3/13 тоот “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх” тусгай зөвшөөрлийн хүрээнд Үнэт цаас гаргагчтай байгуулсан 2017 оны 05 сарын 17-ны өдрийн 09 тоот “Туслах андеррайтерийн гэрээ”-ний дагуу Үнэт цаас гаргагчийн хувьцааг нийтэд санал болгох үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээг хамтран үзүүлэхээр харилцан тохиролцсон. Тус гэрээний зорилго нь үнэт цаас гаргагчийн шинээр гаргаж буй үнэт цаасны танилцуулгыг бэлтгэхэд хамтран ажиллах ба андеррайтерийн ажил үйлчилгээнд туслан нийтэд санал болгон санхүүжилт татан төвлөрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Энэхүү гэрээний хүрээнд талууд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

-Талууд хамтран ажиллахдаа Монгол улсын холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх ба гэрээгээр зохицуулаагүй бусад асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ. Нэг нэгнийхээ бизнесийн нэр хүнд, хууль ёсны эрх ашгийг харилцан хүндэтгэнэ. Хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг чухалчлан үзнэ.Хөрөнгө оруулагчдад хүргэх шаардлагатай мэдээллээс бусад бизнесийн болон байгууллагын нууцад хамаарах мэдээллийн нууцыг чанд хадгалах үүрэгтэй.

- Туслах андеррайтер нь үндсэн андеррайтерт туслах ажлыг гүйцэтгэх, хөрөнгө оруулагчидтай уулзалт, танилцуулга, мэдээлэл хийх, үнэт цаасыг санал болгох болон бусад боломжит арга замаар үнэт цаасыг танилцуулан дээд зэргийн хүчин чармайлт гарган борлуулна.


4.3. Хуулийн фирм

“Өмгөөллийн И Эл Си” ХХН нь 2000 оны 8 дугаар сараас эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба Монголын Хуульчдын Холбооны 2017 оны “Шилдэг Хуулийн Нөхөрлөл”-өөр шалгарсан, салбартаа тэргүүлэх байгууллагуудын нэг юм. Тус ХХН нь Улсын дээд шүүхэд бүртгэлтэй өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх 19 хуульч, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны зах зээлд оролцогчдоод хууль зүйн зөвлөгөө үзүүлэх эрх бүхий 3 хуульч, Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх бүхий 3 хуульч, Татварын итгэмжлэгдсэн болон Мэргэшсэн нягтлан бодогч, санхүү бүртгэлийн зөвлөх 3, Хятад, англи, орос, герман болон япон хэлээр



000131





мэргэжлийн түвшинд ажиллах чадвартай 20 гаруй хуульч, эрх зүйчдийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. 2013 онд Олон Улсын "Chambers and Partners" /Чамбэрс энд Партнерс/ байгууллагын Олон Улсад нэр хүнд, үйлчилгээгээрээ тэргүүдэгч хуулийн фирмүүдийн "Chambers Asia Pacific Guide 2014" жагсаалтад багтжээ. Тус ОУ-ын байгууллага нь "Өмгөөллийн И Эл Си" ХХН-ийн хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн гадаадын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн байдал, тэднээс авсан хараат бус мэдээллийг үндэслэн "Chambers Global - The Client's Guide 2015" жагсаалтад оруулж, бизнесийн эрх зүйн тэргүүлэх хуулийн фирмээр дахин шалгаруулсан байна.

Компанийн нэр:	"Өмгөөллийн И Эл Си" ХХН
Улсын бүртгэлийн дугаар	9022001046
Регистрийн дугаар:	5765412
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Гэндэнгийн гудамж 16, Ардчиллын Өргөө, 6 давхар
Утас:	7711-8193
И-мэйл:	info@elclawoffice.mn

Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

"Өмгөөллийн И Эл Си" ХХН нь 2014 оны 01 дугаар сарын 29 ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооны 24 тоот тогтоолоор "Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө үзүүлэх" хуулийн этгээдээр бүртгэгдсэн ба 2018 оны 04 дугаар сарын 13-ны өдөр үнэт цаас гаргагчтай байгуулсан "Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний дагуу олон нийтэд Компанийн хувьцааг санал болгох үйл ажиллагаанд хуульчийн мэргэжлийн дүрмийг баримтлан мэргэжлийн төвшинд, ашиг сонирхлын зөрчилгүйгээр, хараат бусаар ажиллах хуулийн зөвлөхийн үүргийг гүйцэтгэж байгаа болно.

Тус гэрээний зорилго нь Үнэт цаас гаргагчийн хувьцааг "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн үнэт цаасны бүртгэл болон Санхүүгийн Зохицуулах Хорооны үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэхтэй холбоотой асуудлаар хуульзүйн дүгнэлт гаргах ажлыг гүйцэтгэх харилцааг зохицуулахад оршино.

Энэхүү гэрээний хүрээнд талууд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

Хуульчид нь МХБ-ийн бүртгэлийн журмын 2.2-т заасны дагуу дараах хууль зүйн судалгаа/due diligence/ хийж дараах агуулгын дагуу тайлан гаргах үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээнэ.

- Тухайн компанийн улсын бүртгэл, татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх;
- Компанийн дүрэм, үнэт цаасаа анх удаа нийтэд санал болгон гаргаж байгаа компанийн хувьд хувьцаат компанийн дүрмийн төсөл, бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, Хорооноос баталсан "Монголын компанийн засаглалын кодекс"-т нийцсэн эсэх;
- Бусадтай байгуулсан худалдах, худалдан авах, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ хэлцэл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх,

Сүүлийн 1 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх;



000132

СЭХ нэт цаасны танилцуулга
2019-01-09
БҮРТГЭЭЛ
№ 01

МОНГОЛЫН АРД КРЕДИТНИЙ
ББСБ ЕХК
2018-11-29

- Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг, газар эзэмших эрх нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн зэргээр үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлж болох нөхцөл байгаа эсэх;
- Үнэт цаас, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх;
- Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн 6.13-т заасан хуулийн этгээдийн нэгдэлд хамаарч байгаа бол толгой, охин, хараат, зэргэлдээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээд нь хэн болохыг тодорхойлох.

Үнэт цаас гаргагч нь хуульчдыг гэрээгээр хүлээсэн ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай үнэн зөв, бодит мэдээлэл, бичиг баримт болон материалуудын эх хувь, баталгаажсан хуулбарыг цаг тухайд нь бүрэн гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

4.4. Аудитын компани

“Далайван Аудит” ХХК нь 1993 онд байгуулагдсан Монголын анхны аудитын компани бөгөөд үүсгэн байгуулагдсанаас өнөөг хүртэл 20 гаруй жилийн хугацаанд аудитын салбарт манлайлагч, тэргүүлэгч байр сууриа хадгалж, Монголын аудитын салбарыг бэхжүүлэх, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоход үнэтэй хувь нэмэр оруулсан байгууллага юм. 2007 онд дэлхийн 137 улс орны 161 гишүүн байгууллагыг нэгтгэсэн аудит, нягтлан бодох бүртгэл, бизнесийн зөвлөх үйлчилгээний томоохон сүлжээ “Бэйкер Тилли Интернэйшл” (Baker Tilly International)-ийн Монгол улсыг төлөөлөх хараат бус бие даасан гишүүн болсон. “Далайван Аудит” ХХК нь 2013 оноос эхлэн Бейкер Тилли Интернэйшнлээс гаргасан “AUD-IT” аудитын программыг аудит баталгаажуулах үйлчилгээндээ ашиглаж байгаа ба Бейкер Тилли Интернэйшнлийн төв байгууллага нь гишүүн байгууллагуудаа мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх арга аргачлалаар хангадаг олон улсын стандартын шинэчлэлт, өөрчлөлтүүдээр цаг алдалгүй баяжуулан боловсруулж байдаг байна. Тус ХХК нь аудит болон баталгаажуулах үйлчилгээ, нягтлан бодох бүртгэлийн зөвлөх үйлчилгээ, компанийн засаглал ба эрсдэлийн удирдлагын үйлчилгээ, корпорацийн зөвлөх үйлчилгээ, татварын зөвлөх үйлчилгээ, хөрөнгийн ба бизнесийн үнэлгээ зэрэг үйлчилгээ үзүүлдэг.

Компанийн нэр:	“Далайван Аудит” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9018001041
Регистрийн дугаар:	2018365
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар, Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5, “Далайван Аудит ХХК”-ийн байр
Утас:	7000-5401
И-мэйл:	info@dalaivanaudit.mn



Санхүүгийн тайланд аудит хийх гэрээний тухай

“Далайван Аудит” ХХК нь 2014 оны 01 дугаар сарын 29 ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооны 22 тоот тогтоолоор “Үнэт цаас зах зээлд хууль зүйн зөвлөгөө үзүүлэх” хуулийн этгээдээр бүртгэгдсэн ба 2017 оны 12 дугаар сарын 19 ны өдөр үнэт цаас гаргагчтай байгуулсан 01/17-13 тоот “Санхүүгийн тайланд аудит хийхгэрээ”-ний дагуу мэргэжлийн ёс зүйг баримтлан, хараат бус бие даасан байдлаар үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайланд



000133





аудит хийх үүргийг гүйцэтгэж байгаа болно. Тус гэрээний зорилго нь Монгол улсын "Аудитын тухай хууль" болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг удирдлага болгон аудитын байгууллагаас үнэт цаас гарагчийн санхүүгийн тайланд аудитын шалгалт хийж, 2017 оны 12 дугаар 31-ээр тасалбар болгосон санхүүгийн тайланд аудиторын дүгнэлт, зөвлөмж гаргахад оршино.

Энэхүү гэрээний хүрээнд талууд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

-Аудитын байгууллага нь үйлчлүүлэгчийн жилийн эцсийн санхүүгийн тайланд аудиторын тайлан, зөвлөмж гаргах, аудитын үйл ажиллагааг Аудитын Олон Улсын Стандартад нийцүүлэн мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн акт, заавар аргачлалуудын дагуу явуулах, аудитын шалгалтаар алдаа дутагдал илэрсэн тохиолдолд үйлчлүүлэгчийн удирдлагад мэдээлэх, тайлагнах, аудитын тайлангийн үнэн зөвийг хариуцах үүрэг хүлээнэ.

-Үнэт цаас гаргагч нь санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон Монгол улсын хууль, тогтоомж, бусад дүрэм, журамд нийцүүлэн бүрэн гаргаж аудитын байгууллагад 2018 оны 2 сарын 9 ний дотор хүргүүлсэн байх; Компанийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд тодруулах мэдээлэл, тохируулгууд, тайлбарууд, санхүүгийн тайлангийн задаргаанууд бусад шинжилгээ анализ, мөн бүртгэлийн журнал, баримтууд, гадаад болон дотоод удирдлагын тайлангууд, бусад шаардлагатай мэдээлэл тайлангууд болон аудитын үйлчилгээ үзүүлэхэд гуравдагч этгээдээс шаардагдах мэдээллийг бүрэн гүйцэд цаг хугацаанд нь бүрдүүлж өгөх үүрэг хүлээнэ.

4.5. Үнэлгээний компани

“БДО Аудит” ХХК нь аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний дэлхийн тав дахь том сүлжээ юм. БДО нь дэлхий даяар 60,000 гаруй ажилчид дэлхийн 152 орон дахь 1,328 салбар нэгжтэй. БДО-ийн Монгол дахь оффис 2012 оны 12 сард Улаанбаатар хотноо “БДО Аудит” нэртэйгээр Монгол улсын аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний салбарт 15 жилийн туршлагатай “Итгэлт Аудит” ХХК-ийн суурин дээр үүсгэн байгуулагдсан. “БДО Аудит” ХХК нь мэргэшсэн цолтой 2 партнер, 40 орчим мэргэжилтнүүд бүхий чадварлаг багийн туршлага, мэдлэгийн хүрээнд аудит ба баталгаажуулалт, бизнесийн зөвлөх үйлчилгээ, татварын цогц үйлчилгээ, гадаад, дотоод аутсорсингийн үйлчилгээг үзүүлдэг. Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооны шаардлагыг хангаж Монголын хөрөнгийн зах зээл дээр үнэт цаас гаргагчдад аудитын, хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэгдсэн.

Компанийн нэр:	“БДО Аудит” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9018001010
Регистрийн дугаар:	2546442
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам 62, Юнескогийн гудамж, Юнион Бюлдинг, Б блок, 1502 тоот
Утас:	7740-4040
И-мэйл:	info@bdo.mn



Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх гэрээний тухай

000134



СҮНэт цаасны танилцуулга
2019.01.09
БҮРТГЭВ

ARD КРЕДИТ
ББСБ ИЙН БИРЭГ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2018.11.29
БҮРТГЭВ-02

“БДО Аудит” ХХК нь 2014 оны 01 дугаар сарын 29 ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооны 22 тоот тогтоолоор “Үнэт цаас зах зээлд хууль зүйн зөвлөгөө үзүүлэх” хуулийн этгээдээр бүртгэгдсэн. Монгол Улсын иргэний хуулийн нийтлэг үндэслэл, 343-358 дугаар зүйлүүд, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг үндэслэж, гэрээгээр хүлээх үүргээ зохих ёсоор болон бодитой биелүүлэх зарчмыг удирдлага болгон 2018 оны 3 дугаар сарын 12 ны өдөр Үнэт цаас гаргагчтай байгуулсан 2018-ҮЗ тоот “Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх гэрээ”-ний дагуу 2017 оны 12 сарын эцсийн байдлаар үнэт цаас гаргагчийн бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг хийх үүргийг гүйцэтгэж байгаа болно. Үнэлгээний байгууллага нь Үнэт цаас гаргагчаас гаргаж өгсөн мэдээлэл, баримт материалд үндэслэн өөрийн сонгосон аргачлалын дагуу үнэт цаасны зах зээлд шинээр хувьцаа гаргах үйл ажиллагаанд холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн хөрөнгийн ба бизнесийн үнэлгээ хийж, тайлан гаргана. “Үнэлгээчдийн ёс зүйн дүрэм”-ийн хараат бус байх, үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах, шударга байх, хууль тогтоомжид нийцсэн байх зарчмуудыг баримтлан, ажлын гүйцэтгэлийг хамгийн үнэн зөв, бодит барьж ажиллана.

Энэхүү гэрээний хүрээнд талууд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:


-Үнэлгээний компани нь үнэт цаас гаргагчийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх, холбогдох үйл ажиллагааны талаар тэмдэглэл хөтлөх, ажлын явц үр дүн, гарч болох эрсдэл, нөхцөл байдлын талаар шуурхай мэдээлэл өгөх; Гэрээт ажлыг гүйцэтгэх явцад аливаа байдлаар сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон даруйд үйлчлүүлэгчид мэдэгдэх: үнэт цаас гаргагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг аливаа үйлдэл хийхгүй байх үүрэгтэй бөгөөд үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, энэхүү гэрээний нөхцөлийг чанд мөрдөх; Үнэт цаас гаргагчаас өгөх аливаа мэдээлэл болон гэрээт ажил гүйцэтгэх явцад олж мэдсэн бүх мэдээллийг зөвхөн уг гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой ашиглах ба үнэт цаас гаргагчаас бичгээр олгосон зөвшөөрөл, шүүхийн шийдвэрээр шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

- Гэрээт ажилтай холбоотой компанийн бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, удирдлагын дотоод мэдээлэл зэрэг бүхий л мэдээлэл, шаардлагатай нэмэлт баримт, материалыг шаардсан тухай бүрд бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгөх бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах бүх талын дэмжлэг үзүүлэх; Үнэлгээний байгууллагын өөрийн байранд нэвтрэх, уулзалт хийх, дүгнэлт гаргахад шаардлагатай холбогдох мэдээллийг авах, шалгах ажлыг гүйцэтгэх орчноор хангах, тухайн мэдээлэл, баримтыг хариуцсан ажилтнуудыг томилж ажиллуулах, мэдээ, материал, түүний агуулгыг тодорхойлоход туслах зэрэг ажлыг үнэн зөв, цаг хугацаанд нь гүйцэтгэхэд шаардлагатай бусад ажлыг зохион байгуулах; Үнэлгээний байгууллагыг ашиг сонирхлын зөрчил, хараат байдалд оруулахуйц харилцаа холбоо үүсгэх болон хууль бус шаардлагыг биелүүлэх талаар хүсэлт, шаардлага гаргахгүй байх үүрэг хүлээнэ.



000135





ХАРААТ БУС ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДҮҮДИЙН ДҮГНЭЛТ

Андеррайтерийн дүгнэлт

Үндсэн андеррайтер болох “Ард Капитал Групп ҮЦК” ХХК нь 2008 оны 4 сарын 18-ны өдөр “Санхүүгийн Зохицуулах Хороо”-ны 86 дугаар тогтоолоор авсан “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх” 3/42 тоот тусгай зөвшөөрлийн хүрээнд үнэт цаас гаргагч “Ард Кредит ББСБ” ХХК-тай 2018 оны 5 сарын 17-ны өдөр байгуулсан 09 тоот “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний дагуу мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх андеррайтерийн үүрэг гүйцэтгэж байгаа болно.

“Ард Капитал Групп ҮЦК” нь дотоодын үнэт цаасны арилжаанд оролцох төдийгүй НКЕХ, LSE, ASX, NYSE зэрэг гадаадын биржийн арилжаанд оролцох үйлчилгээгээр дотооддоо тэргүүлсээр байна. Андеррайтер нь Монголд анхлан гадаад улсын хөрөнгийн биржийн арилжаанд оролцох боломжийг харилцагчиддаа олгосон ба Mongolian Mining Corporation 2010 онд Хонг Конгын хөрөнгийн бирж дээр олон нийтэд хувьцаагаа санал болгоход Монгол харилцагчдыг зуучлан 3.0 сая ам.долларын хөрөнгө босгож байсан. Мөн МХБ дээрх хамгийн өндөр үнийн дүн бүхий 6.0 тэрбум төгрөгийн СҮҮ бондын хамтрагч андеррайтер, Талын Эзэн ХХК-ийн 420.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий НААД бондын андеррайтер, 600.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий Урбан бондын хамтрагч андеррайтер, Бэрс Капитал ХХК-ийн 1.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хаалттай бондын хамтрагч андеррайтераар ажилласан туршлагатай ба 2015-2018 онуудад Япон улсын JICA хамтын ажиллагааны байгууллагад макро эдийн засгийн зөвлөх, Зэс эрдэнийн хувь ХХК, Түшиг Уул ХК, Eurofeu ХХК зэрэг компаниуд санхүүгийн зөвлөхийн үйлчилгээ үзүүлж байсан. Эдгээр туршлагад үндэслэн Ард Капитал Групп ҮЦК нь андеррайтер хийх, дүгнэлт гаргах чадвартай, мэргэшсэн, туршлагатай, хангалттай нөөц бололцоотой гэж үзэж байна. Андеррайтер нь үнэт цаас гаргагч компани болон түүний хувь эзэмшигчидтэй холбоо хамааралгүй бөгөөд бие даасан хөндлөнгийн дүгнэлт гаргасан.

Үнэт цаасны танилцуулга боловсруулах болон андеррайтерийн дүгнэлт гаргахад бид Монгол Улсын макро эдийн засгийн орчин, ирээдүйн төлөв, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй салбарын хөгжил, ирээдүйн төлөв, чиг хандлага, хууль эрх зүйн орчин, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, стратеги, бизнес төлөвлөгөө зэргийг судалсан. Үүнд YCX, Монголбанк, Сангийн яам зэргээс гаргадаг Монгол Улсын макро эдийн засгийн тойм, тайлан, үнэт цаас гаргагчийн удирдлагатай хийсэн ярилцлага, үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөө, Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргадаг банк бус санхүүгийн байгууллагын салбарын тайлан зэрэг мэдээллийг ашиглав.


Үнэт цаас гаргагчийн тухай

Үнэт цаас гаргагч нь 2011 оны 3 сарын 22-ны өдөр "Ард Кредит ББСБ" оноосон нэртэйгээр үүсгэн байгуулагдаж 2011 оны 4 сард Санхүүгийн Зохицуулах Хорооноос зээлийн үйл ажиллагаа, валют арилжаа, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авснаар үйл ажиллагаагаа эхэлсэн байна. 2013 онд Ард Санхүүгийн Нэгдэл нь Ард Кредит ББСБ-ын 50.0 хувийг худалдан авч менежмент болон бүтэц зохион байгуулалтын цогц шинэчлэл хийн компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагыг шинээр томилж, компанийн бизнес загвар, стратеги бодлогыг шинэчилжээ. Үнэт цаас гаргагчийн алсын хараа нь Монгол Улсад банкны үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж, санхүүгийн боловсролыг дэлгэрүүлэх зорилго бүхий нийгмийн хариуцлагын тэргүүлэгч байгууллага болох ба энэхүү алсын харааны хүрээнд өнгөрсөн хугацаанд Бичил Санхүүгийн Хөгжлийн Сантай хамтран 800.0 сая төгрөгийн



000136





Үнэт цаасны танилцуулга



дамжуулан олгох хөнгөлөлттэй зээлийг Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул дүүргүүд, Дархан-Уул, Завхан, Булган, Төв, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Ховд, Увс, Сүхбаатар, Дорнод, Говьсүмбэр аймгуудын төв болон сумдын хадгаламж зээлийн хоршоодоор дамжуулан бага, дунд орлоготой малчин иргэдэд олгосон байна. Мөн үнэт цаас гаргагч нь санхүүгийн хүртээмжийг дээшлүүлэх зорилгын хүрээнд зээлдэгчдийн санхүүжилтийн зардлыг бууруулахыг зорьсоор ирсэн ба 2017 онд ББСБ-ын салбарт хамгийн бага хүүг тогтоосон нь салбарын дундаж болох 3.4 хувиас даруй 1.0 пунктээр доогуур байна.

Үнэт цаас гаргагч нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш хувьцаа эзэмшигчиддээ үнэ цэнийг тогтмол бий болгосоор ирсэн ба Ард Санхүүгийн Нэгдэл 2013 онд компанийн хяналтын багцыг эзэмшсэнээс хойш нийт хөрөнгө 1.8 тэрбум төгрөгөөс 10.2 тэрбум болон 5.6 дахин, цэвэр ашиг 123.3 сая төгрөгөөс 641.8 сая төгрөг болон 5.2 дахин өссөн байна. Мөн үнэт цаас гаргагч нь 2015 оноос хойш тасралтгүй хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг олгож байгаа ба нийт 620.0 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг хэлбэрээр олгожээ. Үүнээс 2016 болон 2017 онуудад нийт цэвэр ашгийн 50.0 хувийг ногдол ашиг болгон тараажээ.

Ард Кредит ББСБ нь салбартаа манлайлагч, шинийг санаачлагч байхыг зорьсоор ирсэн ба 2015 онд харилцагчиддаа түргэн шуурхай, хялбараар үйлчилгээ үзүүлэх зорилгоор онлайн зээлийн өргөдийг нэвтрүүлсэн байна. 2016 онд ББСБ-ын салбарт анхдагч болон “Ард” кредит картыг зах зээлд нэвтрүүлсэн нь харилцагчдын талархлыг хүлээсээр байна. Үнэт цаас гаргагч нь өрхийн зээл, сургалтын төлбөрийн зээл, итгэлцэл барьцаат зээл, ажиллагсдын зээл, худалдан авалтын зээл, кредит карт зэрэг 13 төрлийн зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчиддаа үзүүлж байна.

Үнэт цаас гаргагчийн хяналтын багцыг эзэмшигч Ард Санхүүгийн Нэгдэл нь 2005 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудад хөрөнгө оруулалт хийж, зах зээлд эзлэх байр суурь, өрсөлдөх чадвар болон үнэ цэнийг дээшлүүлэх замаар өөрийн хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөх зорилготой үндэсний санхүүгийн холдинг компани юм. Ард Санхүүгийн Нэгдэл нь 2014 оноос хаалттай хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах болсон ба үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг олон нийгэд нээлттэй тайлагнадаг, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдлэн ажиллаж буй санхүүгийн салбарт манлайлагч компаниудын нэг юм. Ард Санхүүгийн Нэгдэл нь 2017 оны эцсийн байдлаар 49.7 тэрбум төгрөгийн хөрөнгийн үнэлгээтэй байна. Компанийн тухай хуулийн 6.15-д заасны дагуу Үнэт цаас гаргагч нь нийт 13 зэргэлдээ компанитай ба эдгээр нь хөрөнгө удирдлага, үнэт цаасны, даатгал, шуудан зэрэг үйл ажиллагаа эрхэлдэг мэргэшсэн компаниуд юм. Ард Кредит ББСБ нь өөрийн зэргэлдээ компаниудтай хамтран харилцагчдад санхүүгийн цогц үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.


Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 7 гишүүнтэй бөгөөд бүгд Компанийн тухай хуулийн 75.8-д заасны дагуу компанийн засаглалын сургалтад хамрагдсан ба салбартаа олон жил ажилласан туршлагатай, мэргэшсэн, бие даан шийдвэр гаргах чадвартай этгээдүүд байна. ТУЗ-ийн дор Аудитын, Эрсдэлийн, Засаглалын хороодыг байгуулан дотоод хяналтын болон үйл ажиллагааны тогтолцоог бий болгон ажиллаж байгаа нь компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэгч байгууллага хэмээн дүгнэх үндэслэл болж байна.

2018 оны I улирлын байдлаар ББСБ-ын салбарт 537 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаагаас нийт хөрөнгийн хэмжээ 5.0 тэрбум төгрөгийг давсан 32 ББСБ байгаагийн нэг нь Ард Кредит юм. Үнэт цаас гаргагч нь олон улсын санхүүгийн салбарын хөгжил, цаашдын чиг хандлагыг



000137





даган цахим хэлбэрээр бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлж эхлээд байгаа ба өөрийн финтек шийдэл болох "Ард" аппликэйшнийг зах зээлд нэвтрүүлээд байна.

Үнэт цаас гаргагчийн өнөөг хүртэлх бизнесийн тойм

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй банк бус санхүүгийн зах зээл нь тогтмол өсөж буй зах зээл юм. 2013 онд нийт ББСБ-ын харилцагчдын тоо 533.0 мянга байсан бол 2018 оны эхний улиралд энэ тоо 1.4 сая хүрсэн байна. Харин нийт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-н тоо энэ хугацаанд 263-аас 537 болон 2.0 дахин өсжээ. ББСБ-ын салбарын нийт хөрөнгийн хэмжээ 2018 оны эхний улиралд 1.0 их наяд төгрөгт хүрсэн нь 2013 оны дүнгээс 2.7 дахин өссөн үзүүлэлт байна. Энэ нь ББСБ-ын салбарын нийт хөрөнгө жилд дунджаар 26.3 хувиар өссөн гэсэн үг юм. Харин энэ хугацаанд ББСБ-ын салбарын нийт зээлийн үлдэгдэл 3.2 дахин өсөж 706.7 тэрбум төгрөгт хүрсэн байна. 2013 онд ББСБ-ын салбарын нийт зээлийн үлдэгдэл ДНБ-ийн 1.6 хувийг эзэлж байсан бол 2017 онд энэ тоо 3.8 хувьд хүрсэн нь ББСБ-ын салбарын нийт эдийн засагт үзүүлэх хувь нөлөө нэмэгдэж буйг илтгэсэн үзүүлэлт болжээ.

Ард кредит ББСБ нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш хөрөнгө оруулагчиддаа өндөр өгөөжийг хүртээн, тасралтгүй өсөн дэвжсээр ирсэн байна. 2013 онд Ард Санхүүгийн Нэгдлийн охин компани болон үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш компанийн нийт хөрөнгө 5.6 дахин, нийт орлого 7.9 дахин өссөн нь жилд дунджаар 53.7 хувь, 67.7 хувийн өсөлтийг тус бүр үзүүлсэн гэсэн үг юм. Ард Кредит ББСБ-ын үйл ажиллагаа, ололт, амжилтыг он цагийн дарааллаар үзүүлбэл:

- 2013 онд Ард Санхүүгийн Нэгдэл үнэт цаас гаргагчийн 50.0 хувийг худалдан авч, компанийн бизнес загвар, стратеги бодлогыг шинэчлэн баталсан байна. Тус онд Ард Кредит нь 1.8 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, 1.7 тэрбум төгрөгийн зээлийн багцтай, 123.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

- 2014 онд СЗХ-ны зөвшөөрлөөр 550.0 сая төгрөгийн хаалттай бонд гаргаж, БСХС-тай хамтран ажиллаж 300.0 сая төгрөгийн дамжуулан олгох төслийн зээлийг амьжиргааны түвшин доогуур иргэдэд олгосон байна. Мөн онд СЗХ-оос итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл аван үйл ажиллагааны хүрээгээ өргөжүүлжээ. 2014 онд үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн хэмжээ 85.4 хувь өсөж 3.4 тэрбум төгрөг, нийт зээлийн үлдэгдэл 61.5 хувь өсөж 2.7 тэрбум төгрөг, цэвэр ашиг 143.3 хувь өсөж 300.0 сая төгрөг хүрсэн байна.


- 2015 онд Ард Санхүүгийн Нэгдэл эзэмшлийн хувиа 58.0 хувь хүргэн нэмэгдүүлсэн байна. БСХС-аас 500.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй санхүүжилт авч эмзэг бага орлоготой иргэдэд дамжуулан олгожээ. Мөн харилцагчдын цаг завьг хэмнэх онлайн зээлийн өргөдөл бөглөх системийг нэвтрүүлжээ. 2015 онд үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн хэмжээ 37.2 хувь өсөж 4.7 тэрбум төгрөг, нийт зээлийн үлдэгдэл 38.4 хувь өсөж 3.7 тэрбум төгрөг, цэвэр ашиг 37.0 хувь өсөж 410.9 сая төгрөг хүрсэн байна. Ард Кредит ББСБ нь цэвэр ашгийн 24.3 хувь буюу 100.0 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг хэлбэрээр олгон анхны ногдол ашигаа тараажээ.

- 2016 онд хэдийгээр Монгол Улсын эдийн засгийн өсөлт сааран ДНБ-ийн өсөлт 1.2 хувь хүрсэн боловч үнэт цаас гаргагч нь шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, харилцагчидтайгаа илүү ойртон ажиллах зорилгынхоо хүрээнд Худалдаа Хөгжлийн Банк (ХХБ)-тай хамтран кредит карт гаргаж, зах зээлд нэвтрүүлсэн байна. Ингэснээр Ард Кредит ББСБ нь салбартаа анх удаа олон нийтэд зориулан кредит карт гаргасан байгууллага болжээ.



000138





Мөн онд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн ба Ард Санхүүгийн Нэгдлийн эзэмшлийн хувь 80.7 хувьд хүрсэн байна. 2016 онд үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн хэмжээ 22.4 хувь өсөж 5.7 тэрбум төгрөг, нийт зээлийн үлдэгдэл 37.9 хувь өсөж 5.1 тэрбум төгрөг хүрч өссөн байна. Харин цэвэр ашиг 401.8 сая төгрөг хүрч 2.2 хувиар буурсан байна. Үүнээс цэвэр ашгийн 50.0 хувь буюу 200.0 сая төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр хувьцаа эзэмшигчиддээ тараажээ.

- 2017 онд Ард Кредит нь 1.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хаалттай бондын хэлбэрээр татан төвлөрүүлж зээлийн эх үүсвэрээ нэмэгдүүлсэн байна. Ингэснээр Ард Кредитийн нийт зээлийн үлдэгдэл 8.0 тэрбум төгрөгт хүрчээ. Мөн онд СЗХ-оос богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөл авч өсөн нэмэгдэж буй санхүүгийн нөөц бололцоог илүү үр дүнтэй удирдах, орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлжээ. 2017 онд үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн хэмжээ 79.1 хувь өсөж 10.2 тэрбум төгрөг, нийт зээлийн үлдэгдэл 56.1 хувь өсөж 8.0 тэрбум төгрөг, цэвэр ашиг 59.7 хувь өсөж 641.8 сая төгрөг тус тус хүрсэн байна. Үүнээс цэвэр ашгийн 50.0 хувь буюу 320.0 сая төгрөгийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчиддээ тараажээ.

- 2018 онд хувьцаа барьцаалсан зээлийг салбартаа анх удаа нэвтрүүлсэн байна. Мөн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг СЗХ-оос авч “Ард” гар утасны аппликэйшнийг зах зээлд нэвтрүүлжээ. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 8 сарын 02-ны өдрийн 2018/12 тоот тогтоолоор үнэт цаас гаргагч нь МХБ-д үнэт цаасаа олон нийтэд нээлттэй санал болгон IPO хийх түүхэн шийдвэрийг гаргажээ.

Үнэт цаас гаргагчийн бизнесийн төлөвлөгөө

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын салбар нь макро эдийн засгийн байдалд ихээхэн мэдрэг юм. Хэдийгээр Монгол Улсын эдийн засаг 2013 оноос хойш удааширч ДНБ-ийн өсөлт 2016 онд 1.2 хувь хүрсэн боловч ББСБ-ын салбар жилд дунджаар 26.3 хувийн өсөлт үзүүлсэн байна. 2017 онд ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдсан, олон улсын зах зээлд уул уурхайн түүхий эдийн үнэ өссөн зэргээс шалтгаалан 2018 оны II улиралд ДНБ-ийн өсөлт 6.3 хувьд хүрч Монгол Улсын эдийн засаг эргэн сэргэж эхлээд байна. Энэхүү өсөлт цаашид ч үргэлжлэх төлөвтэй байгаа ба ОУВС, Сангийн яам Монгол Улсын эдийн засаг 2018 онд 5.0 хувь, 2019 онд 6.3 хувь тус тус өснө хэмээн тооцоолжээ. Эдийн засгийн өсөлт түргэссэнээр ББСБ-ын салбарын өсөлт ч эрчимжих төлөвтэй байгаа ба энэ өсөлт нь ББСБ-ын салбарын түүхэн өсөлтийн хувь болон банкны салбарын өсөлтийн хувиас давах хүлээлттэй байна.


Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь орчин үеийн санхүүгийн технологи, хамтран ажиллагч байгууллагуудын дэд бүтцийг ашиглан Монгол улсын иргэд, аж ахуйн нэгжүүдэд хэрэглээний болон жижиг дунд бизнесийн зээлийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх юм. Энэхүү зорилгынхоо хүрээнд үнэт цаас гаргагч нь өөрийн бизнес төлөвлөгөөнд шинэчлэлт хийн өөрсдийн финтек шийдэл болох “Ард” аппликэйшнийг зах зээлд нэвтрүүлээд байгаа ба мөн өөрийн зэргэлдээ компаниуд болох Монгол шуудан ХК болон Ард даатгал ХХК-ийн салбаруудаар дамжуулан зээлийн үйлчилгээг харилцагчдад үзүүлэн салбаргүй агент банк байдлаар ажиллахаар төлөвлөж байна.



Компани нь өөрийн стратеги, бизнес төлөвлөгөөний дагуу хэрэглээний болон жижиг дунд бизнесийн зээлд төвлөрөн ажиллах төлөвлөгөөтэй байгаа ба энэхүү стратегийн хүрээнд 2022



000139



Үнэт цаасны танилцуулга



он гэхэд өөрийн санал болгож буй 13 төрлийн зээлийн бүтээгдэхүүнээс 6 төрлийн зээлийн бүтээгдэхүүнийг зогсоох төлөвлөгөөтэй байна. 5 жилийн дараа буюу 2022 онд зээлийн багцын 35.0 хувийг бизнесийн зээл, үлдсэн 65.0 хувийг хэрэглээнд суурилсан зээлийн бүтээгдэхүүнүүд эзлэхээр төлөвлөж байна. “Ард” аппликэйшний хэрэглээ нэмэгдэхийн хэрээр шуурхай, цалингийн, хэрэглээний, худалдан авалтын зээлүүд “Ард” бүтээгдэхүүнд шилжинэ хэмээн төсөөлж байгаа юм.

“Ард” аппликэйшн- Финтек шийдэл

ЛэндМН ББСБ ХК-ийн үнэт цаасны танилцуулгад тусгагдсан бичил хэрэглээний зах зээлийн судалгаанд дурдсанаар бичил хэрэглээний зээлийн зах зээлийн багтаамж 900.0 тэрбум төгрөг байх магадлалтай хэмээн тооцоолжээ. Энэхүү судалгаанд дурдсан бичил хэрэглээний зээлийн зах зээл нь ББСБ-ын салбарын зах зээлээс ондоо, дэд зах зээл гэдгээрээ онцлог юм. Ард Кредит ББСБ нь өөрийн финтек шийдэл болох “Ард” аппликэйшнээр дамжуулан бичил хэрэглээний зээлийг харилцагчиддаа олгоход бэлэн болоод байна. “Ард” нь бусад ижил төрлийн зээл олгож буй байгууллагуудаас зээлийн хэмжээ болон эргэн төлөх хугацааны хувьд давуу талтай ба мөн “Ард” аппликэйшн нь зөвхөн зээлийн үйлчилгээ бус мөнгөн гүйлгээ хийх, төлбөр тооцоо төлөх, QRau, дансны хуулга шалгах, валютын ханш харах, хувьцааны арилжаанд оролцох зэрэг олон функц, боломжуудаараа давуу юм. Зээлийн эргэн төлөлтийг хэвийн байлгах үүднээс Монголбанкны зээлийн мэдээллийн санд зээлийн мэдээллийг оруулах, хугацаандаа эргэн төлөлт хийж буй зээлдэгчийг урамшуулах бодлого хэрэгжүүлэх, харилцагчийн эргэн төлөлтийн хугацаа ойртож буй тухай сануулгуудыг аппликэйшнээр дамжуулан илгээх зэрэг хэд хэдэн төрлийн хөшүүргийг хэрэглэхээр төлөвлөж байна.

Агент банк

Хэдийгээр үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо болон харилцагчдын тоо тасралтгүй нэмэгдэж буй боловч хөдөө орон нутагт амьдарч буй иргэд, аж ахуйн нэгжид хүрэх хүртээмж хязгаарлагдмал хэвээр байна. 2017 оны эцсийн байдлаар нийт банк бус санхүүгийн байгууллагын ердөө 13.1 хувь нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. Үүнд ББСБ-ын салбарын зээлийн хүртээмж газар зүйн байршлаар эрс ялгаатай байгаа ба Улаанбаатар хотын хэмжээнд 8 иргэн тутмын нэг нь банк бус санхүүгийн байгууллагад зээлийн үлдэгдэлтэй байгаа бол хөдөө орон нутагт энэ тоо 183 хүн тутамд нэг байна. Мөн Улаанбаатар хотын зээлдэгчийн зээлийн дундаж үлдэгдэл 6.1 сая төгрөг байгаа бол хөдөө орон нутагт байрлах зээлдэгчийн зээлийн дундаж үлдэгдэл 3.3 сая төгрөг байгаа юм. Үнэт цаас гаргагч нь өөрийн алсын хараа болон стратегийн хүрээнд санхүүгийн хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор 2014 оноос хойш БСХС-тай хамтран бага дунд орлоготой иргэдэд хөнгөлөлттэй нөхцөлтэй дамжуулан олгох төслийн зээлийг олгосоор байна. Мөн цаашид өөрийн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор өөрийн зэргэлдээ компаниуд болох Монгол шуудан ХК болон Ард даатгал ХХК-тай хамтран, Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт байрлах салбаруудаар дамжуулан харилцагчдад хүргэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани болох Монгол шуудан ХК нь Монгол Улсын 21 аймаг, 330 сумдад салбартай томоохон дэд бүтэц бүхий компани юм.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь 2018 онд IPO хийх замаар 4.9 тэрбум төгрөгийн санхүүжилт босгож хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Уг санхүүжилтийг дараах байдлаар зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээнд зарцуулахаар төлөвлөж байна.



000140



Зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ	Зарцуулах дүн сая төгрөг	Эзлэх хувь хувь
Бизнесийн зээл	2,768.5	56.5%
Хэрэглээний зээл	612.5	12.5%
Шуурхай зээл	980.0	20.0%
Кредит карт	367.5	7.5%
“Ард” зээл	49.0	1.0%
Хувьцаа барьцаалсан зээл	122.5	2.5%
Нийт	4,900.0	100.0%

Санхүүгийн төлөвлөгөө

ББСБ-ын салбар нь зээлийн санхүүжилтийг харьцангуй бага ашигладаг ба 2017 оны байдлаар ББСБ-ын салбарын нийт хөрөнгийн 21.8 хувийг өр төлбөр бүрдүүлж байна. Ард Кредит ББСБ нь үйл ажиллагаандаа зээлийн санхүүжилтийг өргөн ашиглаж ирсэн ба 2017 оны байдлаар нийт хөрөнгийн 63.4 хувийг зээлийн санхүүжилт бүрдүүлсэн байна. Санхүүгийн хөшүүргийн зохистой хэрэглээ нь компанийн ашигт ажиллагааг дэмжиж өөрийн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлдэг ашигтай юм. 2017 онд үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн өгөөж 8.0 хувь байсан нь салбарын дунджаас 0.4 пунктээр өндөр байсан бол өөрийн хөрөнгийн өгөөж 18.3 хувь байсан нь салбарын дунджаас 8.3 пунктээр өндөр байгаа юм.

2018 оны IV улиралд IPO хийж хөрөнгө босгох ажил хийхтэй холбоотой 4.9 тэрбум төгрөг татан төвлөрүүлэх ба ирэх 5 жилийн хугацаанд санхүүгийн байгууллагуудаас нийт 39.7 тэрбум төгрөгийн санхүүжилт татахаар төлөвлөж байна. Эдгээр эх үүсвэрийг ашиглан үйл ажиллагаагаа явуулснаар дараах үр дүнтэй ажиллана хэмээн төлөвлөж байна.


Санхүү байдлын тайлангийн төсөөлөл (сая төгрөг)

	2018	2019	2020	2021	2022
Хөрөнгө	20,166	35,657	42,752	65,312	89,814
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3,024	6,046	7,447	11,757	16,482
Зээлийн багц (цэвэр)	15,831	28,300	34,000	52,261	72,056
Үндсэн хөрөнгө (цэвэр)	312	312	306	294	276
Үндсэн хөрөнгө	400	450	500	550	600
Хуримтлагдсан элэгдэл	(88)	(138)	(194)	(256)	(324)
Бусад хөрөнгө	1,000	1,000	1,000	1,000	1,000
Өр төлбөр	10,813	22,625	23,662	36,136	45,037
Нийт санхүүжилт	10,501	22,313	23,350	35,824	44,725
БСХС	-	1,000	600	200	2,000
Банк	300	2,167	2,333	-	2,000
Итгэлцэл	5,988	6,578	9,098	13,332	20,100
Хаалттай өрийн бичиг	1,713	6,318	6,318	13,958	20,588



000141





Бусад санхүүжилт	-	-	-	-	-
Гадаад санхүүжилт 1	-	5,000	5,000	3,333	1,667
Кровд кредит	2,500	1,250	-	-	-
Гадаад санхүүжилт 2	-	-	-	5,000	5,000
Бусад өр төлбөр	312	312	312	312	312
Өөрийн хөрөнгө	9,353	13,031	19,090	29,176	44,776
Энгийн хувьцаа	2,800	2,800	2,800	2,800	2,800
Нэмж төлөгдсөн капитал	4,200	4,200	4,200	4,200	4,200
Тайлант үеийн ашиг	716	3,822	6,823	11,450	17,890
Хуримтлагдсан ашиг	1,637	2,209	5,267	10,726	19,886


Орлогын тайлангийн төсөөлөл (сая төгрөг)

	2018	2019	2020	2021	2022
Санхүүгийн орлого	2,960	9,050	13,475	22,531	32,594
Хүүгийн орлого	2,445	7,164	9,494	13,751	18,101
Шимтгэлийн орлого	259	1,753	3,798	8,470	14,043
Ханшийн тэгшитгэлийн орлого	4	(167)	(167)	(90)	-
Бусад орлого	252	300	350	400	450
Нийт эх үүсвэрийн хүүгийн зардал	975	2,625	3,363	5,140	6,607
Итгэлцлийн үйлчилгээний зардал	511	1,053	1,456	2,133	3,216
Санхүүжилтийн зардал	464	1,572	1,908	3,007	3,391
Нийт үйл ажиллагааны орлого	1,985	6,426	10,112	17,392	25,987
Эрсдэлийн сан	278	599	274	877	951
Нийт үйл ажиллагааны орлого	1,707	5,827	9,838	16,514	25,036
Нийт үйл ажиллагааны зардал	911	1,330	1,340	1,847	1,783
Хүний нөөц боловсон хүчний зардал	398	587	704	819	950
Удирдлагын зардал	460	520	580	647	721
Элэгдэл	33	50	56	62	68
Санхүүгийн зардал	20	173	-	319	43
Татварын өмнөх цэвэр ашиг	796	4,496	8,498	14,667	23,254
ОАТ	80	674	1,674	3,217	5,363
Татварын дараах цэвэр ашиг	716	3,822	6,823	11,450	17,890

Үнэт цаас гаргагчийн өнгөрсөн хугацааны амжилт, стратеги, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагаа явуулж буй салбарын төлөв, санхүүгийн төсөөлөл, зэргэлдээ компаниудын дэд бүтэц, финтек зах зээлд шинэ оролцогч болон нэвтэрч буй зэрэгээс үзэхэд Ард Кредит ББСБ нь бизнес төлөвлөгөөний дагуу зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлж, үйл ажиллагааны зорилтдоо хүрэх нөөц бололцоо бий гэж үзэж байна.

Монголын Хөрөнгийн Бирж-ийн II ангиллын шалгуурыг хангах нь

Монголын Хөрөнгийн Биржид үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлтэй үнэт цаас гаргагч нь үнэт цаасны ангиллаас үл хамааран биелүүлэх шаардлага, мөн үнэт цаасны ангилал тус бүрт тогтоосон шалгуурыг хангасан байна.



000142



С Үнэт цаасны танилцуулга
2019.01.09
БҮРТГЭЭХ

МОНГОЛЫН ХӨРӨНГӨ БЭРЭГ
ARD КРЕДИТ ББСБ
2018.11.29
БҮРТГЭЭХ-02

МХБ-ын “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 10.5-д зааснаар үнэт цаас гаргагч нь үнэт цаасны ангилал үл хамааран дараах нийтлэг шаардлагыг хангана:

- Үнэт цаас гаргагч, түүний хувьцааны хяналтын багцыг эзэмших этгээд, ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал нь татварын болон хугацаа хэтэрсэн их хэмжээний зээлийн өргүй байх;

Ард Кредит ББСБ нь татварын, нийгмийн даатгалын, зээлийн хугацаа хэтэрсэн их хэмжээний өргүй тухай “Өмгөөллийн И Эл Си” ХХН-ийн дүгнэлтийн 7.3 болон 7.5-р зүйлд тусгасан байна. Мөн үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх захирал нь хугацаа хэтэрсэн зээлийн өргүй тухай уг дүгнэлтийн 2.1.2-г тусгасан байна. Татварын болон хугацаа хэтэрсэн их хэмжээний зээлийн өргүй тухай Хуулийн дүгнэлтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

- Үнэт цаас гаргагчийн хөрөнгө нь бүхэлдээ эсхүл дийлэнх хэсэг нь мөнгөн хөрөнгө болон богино хугацаат үнэт цааснаас бүрддэггүй байх. Энэ шаардлагыг компанийн үйл ажиллагааны чиглэлээс хамааруулан хөнгөлж болно;

Ард Кредит ББСБ-ын 2017 оны 12 сарын 31-ны өдрөөр тасалбар болгосон аудитлагдсан тайланд тусгагдсанаар мөнгө түүнтэй адилгах хөрөнгийн дүн 1.1 тэрбум төгрөг буюу энэ нь компанийн нийт хөрөнгийн 10.7 хувийг бүрдүүлсэн байна. Компанийн санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүй мэдээллийг аудитын тайлангаас дэлгэрүүлэн үзнэ үү.

- Үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргахаас өмнөх хамгийн сүүлийн санхүүгийн жилийн үеэр санхүүгийн тайлагналын хугацаагаа өөрчлөөгүй байх;

Ард Кредит ББСБ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1-д зааснаар “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар болно.” гэж заасны дагуу санхүүгийн тайлагналыг хөтөлж байна.


- Үнэт цаас гаргагчийн биржид бүртгүүлэх хүсэлт гаргахаас өмнөх санхүүгийн тайлангийн сүүлийн хугацаа нь 6 сараас ихгүй байх ба заасан хугацаанаас их байгаа тохиолдолд хамгийн сүүлийн улирлын тайланг аудитаар баталгаажуулах эсхүл уг тайланд материаллаг өөрчлөлт ороогүй тухай мэдэгдэл;

Ард Кредит ББСБ нь МХБ болон СЗХ-нд үнэт цаас бүртгүүлэх өргөдлийг 2018 оны 3 улиралд өгч байгаа ба 2018 оны II дугаар улирлын санхүүгийн тайланд материаллаг өөрчлөлт ороогүй тухай мэдэгдлийг МХБ болон СЗХ-нд хүргүүлнэ.

- Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам болон өөрийн эрх зүйн баримт бичгийг бүрэн дагаж мөрддөг байх;

Ард Кредит ББСБ нь Монгол улсын “Иргэний хууль”, “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль”, “Банк, Эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль”, “Компанийн тухай хууль” болон холбогдох бусад хууль тогтоомж, Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох журам, компанийн дүрэм, журмыг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж байна.

ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь үнэнч шударга ёс зүйтэй байх;



000143



СЗ
Үнэт цаасны танилцуулга
2019-01-09
БҮРТГЭВ
№ Ард Кредит ББСБ-ын ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон нөлөө бүхий хувьцаа

МОНГОЛЫН АРД КРЕДИТ ББСБ БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2018-11-29
БҮРТГЭВ-02

зээмшигчид нь үнэнч шударга, ёс зүйтэй болно.

- Эрх бүхий албан тушаалтнууд нь компанийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай мэдлэг, туршлагатай байх;

Ард Кредит ББСБ-ын ТУЗ-ийн бүрэлдэхүүнд банк, эдийн засаг, бизнесийн менежмент, ОУ-н харилцааны чиглэлээр мэргэшсэн, тус бүрийн чиглэлээр компани болон ТУЗ-ийн үйл ажиллагаанд бодит хувь нэмэр оруулж чадах хүмүүс багтсан. ТУЗ-ийн бүх гишүүд нь Компанийн тухай хуулийн 75.8-д заасны дагуу компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн дарга нарт зориулсан компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна. Гүйцэтгэх удирдлагын баг нь бизнесийн удирдлага, төслийн удирдлага, эдийн засагч чиглэлээр мэргэшсэн ба компанийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай мэдлэг туршлагатай гэж үзэж байна. Компанийн ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын багын намтрыг хуулийн дүгнэлт болон энэхүү үнэт цаасны танилцуулгаас дэлгэрүүлэн үзнэ үү.

- Компанийн удирдлага болон хяналтын багц эзэмшигчид бүртгэгдсэнээс хойш 6-аас доошгүй сарын хугацаанд, уул уурхайн компаниудын хувьд 12-оос доошгүй сарын хугацаанд хувьцаагаа худалдахгүй байх.

Ард Кредит ББСБ-ын одоогийн хувьцаа эзэмшигчид нь МХБ-д бүртгэгдсэнээс хойш 6-аас доошгүй сарын хугацаанд өөрсдийн эзэмшлийн хувьцааг худалдахгүй.

МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 12.1-т заасны дагуу хувьцааны бүртгэлийн II ангилалд бүртгүүлэх үнэт цаас гаргагч дараах шалгуур хангасан байна:

- Өргөдөл гаргахаас өмнө 2-оос доошгүй жил тухайн чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;

Ард Кредит ББСБ ХХК нь 2011 оны 3 сарын 15-ны өдөр үүсгэн байгуулагдан 2011 оны 4 сард Санхүүгийн Зохицуулах Хорооноос эзэлийн үйл ажиллагаа, валют арилжаа, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авснаар үйл ажиллагаагаа эхэлсэн. Үнэт цаас гаргагч нь үүнээс хойш 7 жилийн турш ББСБ-ын чиглэлээр үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байна.


- Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын дагуу бэлтгэж, аудитын байгууллагаар баталгаажуулан, дүгнэлт гаргуулсан байна.

Ард Кредит ББСБ-ын 2016 оны санхүүгийн тайланд БДО Аудит ХХК аудит хийн баталгаажуулсан ба 2017 оны санхүүгийн тайланд Далайван Аудит ХХК аудит хийн баталгаажуулсан байна. 2017 оны 12 сарын 31-ны өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланг Далайван аудит дүгнэхдээ “Бидний дүгнэлтээр Ард Кредит ББСБ ХХК-ийн 2017 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна” хэмээжээ. Компанийн санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүй мэдээллийг аудитын тайлангаас дэлгэрүүлэн үзнэ үү.



000144





Компани бүртгэгдсэнээс хойш 12 сарын хугацаанд үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хангалттай хэмжээний ажлын капитал /эргэлтийн хөрөнгөөс богино хугацаат өр төлбөрийг хассан дүн/-тай байх эсхүл 100.0 сая төгрөгөөс доошгүй хэмжээний ашигтай ажилласан байх;

Ард Кредит ББСБ-ын 2017 оны 12 сарын 31-ны өдрөөр тасалбар болгосон аудитлагдсан санхүүгийн тайланд дурдсанаар үнэт цаас гаргагч нь 2017 онд 641.8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Компанийн санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүй мэдээллийг аудитын тайлангаас дэлгэрүүлэн үзнэ үү.

- Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх, хэрэв мөрддөггүй бол тайлбар гаргах;

Ард Кредит ББСБ нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2014 оны 5 сарын 7-ны өдөр 162 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийг компанийн дүрэм, дүрмийн төсөл болон ТУЗ-өөс баталсан журмуудад тусган үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Компанийн дүрэм нь Компанийн засаглалын кодекс-т нийцэж буй эсэх талаар Хуулийн дүгнэлээс дэлгэрүүлэн үзнэ үү.

МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 12.2-т зааснаар хувьцааны бүртгэлийн II ангилалд бүртгүүлэх үнэт цаас нь дараах шалгуур хангасан байна:

- Үнэт цаасыг арилжаанд оруулах өдөр үнэт цаас гаргагчийн зах зээлийн үнэлгээ нь 1,000,000,000 /нэг тэрбум/ төгрөгөөс дээш байх ба зах зээлийн үнэлгээг үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны тоо ширхэг болон олон нийгэд санал болгож буй үнээр тооцно;

Үнэт цаас гаргагч нь өөрийн хувьцааг олон нийгэд санал болгосны дараах хувьцааны тоо нь 280,000,000 /хоёр зуун наян сая/ ширхэг ба нэгж хувьцааг санал болгох доод үнэ нь 70 төгрөг байна. Иймд үнэт цаасыг олон нийгэд санал болгох үеийн компанийн зах зээлийн үнэлгээ нь 19,600,000,000 (арван есөн тэрбум зургаан зуун сая) төгрөг байна.

- Үнэт цаас гаргагчийн Бирж дээр бүртгүүлэх нийт хувьцааны 25-аас доошгүй хувийг олон нийгэд санал болгосон байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаанд хэвээр хадгалах;

Ард Кредит ББСБ-ын хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 8 сарын 02-ны өдрийн 2018/12 тогтоолоор Ард Кредит ББСБ нь өөрийн зарласан хувьцааны 25.0 хувийг олон нийгэд санал болгохоор шийдвэрлэсэн байна.

- Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн тоо 50-аас доошгүй байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаанд хэвээр хадгалах;

Ард Кредит ББСБ нь МХБ-ээр дамжуулан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах ба нийт хувьцаа эзэмшигчдийн тоо 50-аас доошгүй байхаар үнэт цаасны хуваарилалтыг хийнэ.

- Бүртгүүлэх үнэт цаас нь барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр хягаарлагдаагүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой байх.



000145



2019.01.09
БҮРТГЭВ-02

Үнэт цаасны танилцуулга

МОНГОЛЫН ХӨРӨНГӨЙН БИРЖ
ARX КРЕДИТ ББСБ
EXCHANGE
ББСБ
2018-11-29
БҮРТГЭВ-02

Ард Кредит ББСБ-ын үнэт цаас нь эзэмших эрх хүчин төгөлдөр, ямар нэгэн үүргийн гүйцэтгэлийн хангах үүрэг хүлээгээгүй тухай “Өмгөөллийн И Эл Си” ХХН-ийн дүгнэлтийн 7.1-р зүйлд тусгасан байна. Бүртгүүлэх үнэт цаас нь барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр хязгаарлагдаагүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийн ямарваа хязгаарлалтгүй тухай Хуулийн дүгнэлтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Үнэт цаасны үнэ тогтоосон үндэслэл

БДО Аудит нь үнэт цаас гаргагчийн бизнесийн 100 хувийн өмчийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнийг тооцоходоо ногдол ашиг хорогдуулах загвар, илүүдэл өгөөжийн загвар, жишиг арилжааны аргыг сонгон ашигласан ба эдгээр аргын үр дүнд компанийн өмчийн үнэ цэнэ 22.2 – 28.6 тэрбум төгрөгийн хооронд гарсан байна. Үүнээс үнэлгээчин нь үнэлгээний шинжилгээнд ашигласан аргуудын медиан үр дүн болох 24.6 тэрбум төгрөг нь үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэ цэнийг илүү сайн илтгэж чадна хэмээн үзсэн ба энэ нь нэгж хувьцааны дотоод үнэ цэнэ 87.7 төгрөг юм.

	Хувьцааны тоо	Бизнесийн үнэ цэнэ	Нэгж хувьцааны дотоод үнэ цэнэ
Нэмж хувьцаа гаргасны дараа	280,000,000	24,554,886,000	87.7

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад тааламжтай нөхцөлийг санал болгох үүднээс өөрийн хувьцааг худалдах доод үнийг **70.0 төгрөг** байхаар тогтоон дотоод үнэ цэнэ болох 87.7 төгрөгөөс 20.2 хувиар хямдруулан хөрөнгө оруулагчдад санал болгосон байна.

Хөрөнгө оруулалтын өгөөж

Үнэт цаас гаргагч нь өөрийн хувьцааг олон нийтэд санал болгон татан төвлөрүүлсэн хөрөнгийг өөрийн үндсэн үйл ажиллагаа болох зээлийн бүтээгдэхүүнийг санхүүжүүлэхэд зарцуулах ба ингэснээр компанийн нийт зээлийн үлдэгдэл өсөж орлого нэмэгдэх юм.

Доорх төсөөлөл нь Ард Кредит ББСБ -ийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд суурилсан ба үнэт цаас гаргагчийн балансын нийт хувьцааны тоо, эздийн өмчийн дүн, цэвэр ашиг зэрэг үзүүлэлтүүдийн 2022 он хүртэлх төсөөллийг тусгасан.

	2018P	2019P	2020P	2021P	2022P
Нийт хувьцааны тоо (сая ширхэг)	280	280	280	280	280
Эздийн өмч (сая төгрөг)	9,353	13,031	19,090	29,176	44,776
Цэвэр ашиг (сая төгрөг)	716	3,822	6,823	11,450	17,890
Дансны үнэ	33	47	68	104	160
Нэгж хувьцаанд ногдох ашиг	3	14	24	41	64
Үнэ ашгийн харьцаа	10	10	10	10	10
Үнэ дансны үнийн харьцаа	2	2	2	2	2
Ханшийн төсөөлөл P/E	137	137	244	409	639
Ханшийн төсөөлөл P/B	67	93	136	208	320
Ханшийн төсөөлөл (P/B*0.7, P/E*0.3)	88	106	169	269	416
Жилийн өгөөж	25%	21%	59%	59%	55%
IPO өгөөж	25%	52%	141%	284%	494%
Нийт үнэлгээ	24,560	29,709	47,195	75,196	116,356

ARX CAPITAL GROUP
ARD CAPITAL GROUP
SECURITIES COMPANY
LLC
УЛААНБААТАР ХОТ ТТ863425183855

000146

ARX КРЕДИТ ББСБ ХХК
ТТГ5-14549567

Унэт цаасны танилцуулга
2019.01.09

МОНГОЛ АРД КРЕДИТ БИРЖ
МОНГОЛ АРД КРЕДИТ БИРЖ
BBSBXCHANGE

2018-11-29

Бид үнэт цаас гаргагчийн хувьцааны ханшийн төсөөллийг тооцох жишиг харьцааг тооцохдоо компанийн санхүүжилтийн бүтэц, зах зээлийн үнэлгээ, МХБ дээр арилжаалагдаж буй ижил төрлийн компанийн зах зээлийн үржүүлэгч зэргийг харгалзан үзсэн ба ханшийн төсөөллийг хэт өндөр бус, хүрч болохуйц байлгахыг зорьж жишиг үнэ ашгийн харьцаа 10.00, үнэ дансны үнийн харьцаа 2.00 байхаар тооцоолсон. Мөн боломжит ханшийг тооцоход банк санхүүгийн байгууллагыг үнэлэх олон улсын практикт үнэ дансны үнийн харьцааг өргөн ашигладгийг даган үнэ дансны үнийн харьцаанд давамгайл буюу 70 хувийн жин, форвард үнэ ашгийн харьцаанд 30 хувийн жинг оноосон.

Ард Кредит ББСБ нь нэгж хувьцаагаа олон нийтэд санал болгох доод үнийг 70 төгрөгөөр тогтоосон ба үнэт цаас гаргагч нь өөрийн бизнес төлөвлөгөөг биелүүлэн, тусгагдсан зорилтуудад хүрч чадсанаар хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын эхний жилд 25.0 хувийн өгөөж, урт хугацаанд буюу 5 жилд 494 хувийн өгөөжийг хүртэх боломжтой хэмээн таамаглав. Энэхүү төсөөлөл нь үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлж, үйл ажиллагааны зорилтуудад хүрэх чадвар, зах зээлийн орчин зэргээс хамаарах хялбар тооцоолол ба үнэт цаасны бодит өгөөж нь дээр төсөөлснөөс материаллаг зөрүүтэй байж болно.

Хөрөнгө оруулагчдад зөвлөх нь

Үнэт цаас гаргагч болох Ард Кредит ББСБ нь үүсгэн байгуулагдсан цагаас хойш хувьцаа эзэмгчиддээ тогтмол, өндөр өгөөжийг хүртээж ирсэн нь компанийн түүхэн амжилт, үйл ажиллагааны үр дүнгээс тод харагдаж байна. Ард Кредит нь МХБ-д үнэт цаасаа санал болгон хувьцаат компани болохоор зорьж, бэлтгэж ирсэн ба энэхүү андеррайтерийн дүгнэлтэд дурдсанчлан МХБ-ийн хувьцааны II ангиллын шалгуурыг хангаж байгаа юм.

Хөрөнгө оруулагчид нь Ард Кредит ББСБ-ын хувьцааг авснаар өнгөрсөн түүхээрээ үйл ажиллагааны чадвараа баталсан, ББСБ-ын салбарт томоохонд тооцогдох, үндэсний тэргүүлэх санхүүгийн нэгдэл группийн бүрэлдэхүүн компанид хөрөнгө оруулах ба компанийн өмнө буй ирээдүйн томоохон боломжуудаас ашиг хүртэх боломж нээгдэх юм. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй банк бус санхүүгийн байгууллагын салбар нь өнгөрсөн хугацаанд өндөр өсөлтийг үзүүлсэн ба цаашид өсөлт нь улам хурдсах хүлээлттэй байна. Мөн үнэт цаас гаргагч нь өөрийн стратеги, бизнес төлөвлөгөөний дагуу олон улсын санхүүгийн байгууллагуудын чиг хандлагыг даган өөрийн үйл ажиллагааг цахимжуулан, финтек зах зээлд нэвтэрч өөрийн үйл ажиллагааны цар хүрээ, зах зээл, боломжийг тэлэхээр ажиллаж байна. ЛэндМН ББСБ-ын үнэт цаасны танилцуулгад дурдсанаар бичил хэрэглээний зээлийн зах зээл нь жилд 900.0 тэрбум төгрөгийн багтаамжтай байх магадлалтай ба энэхүү зах зээлд Ард Кредит ББСБ нь өөрийн финтек бүтээгдэхүүн болох "Ард" аппликэйшнээр нэвтэрч буй юм. Үнэт цаас гаргагч нь мөн цаашид өөрийн зэргэлдээ компаниуд болох Монгол шуудан ХК, Ард даатгал ХХК-ийн салбаруудаар дамжуулан өөрийн үйлчилгээг Монгол Улсын 21 аймаг, 330 сумдад хүргэхээр зорин ажиллаж байна.


Үнэт цаас гаргагч нь өөрийн хувьцааг 70.0 төгрөгөөр олон нийтэд санал болгож байгаа нь дотоод үнэ цэнэ болох 87.7 төгрөгөөс 20.2 хувиар хямдруулсан үнэ юм. Үнэт цаас гаргагч нь өөрийн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэн, тусгагдсан зорилтуудад хүрч чадсанаар хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын эхний жилд 25.0 хувийн өгөөж, урт хугацаандаа буюу 5 жилд 494.0 хувийн өгөөжийг хүртэх боломжтой хэмээн тооцоолж байна.

Хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргахад өгөөж болон эрсдэлийг хамтад нь харж, цэгнэх хэрэгтэй байдаг. Хэдийгээр үнэт цаас гаргагч бизнесийн ирээдүйн боломж



000147






Ихтэй боловч хөрөнгө оруулагч нь компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлүүдийг харгалзан хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргах нь зүйтэй. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд зээлийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, нэр хүндийн эрсдэл, макро эдийн засгийн эрсдэл, технологийн эрсдэл зэрэг дотоод болон гадаад хүчин зүйлүүд нөлөөлж болох ба эдгээрээс хамгийн давамгай нь зээлийн багцын чанар муудах, компанийн брэнд, нэр хүндэд халдах, “Ард” аппликэйшний хэвийн ажиллагаа доголдох, макро эдийн засгийн орчин муудах, харилцагчдын бодит цалин буурах зэрэг эрсдэлүүд байна. Хөрөнгө оруулагч нь үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын тухай мэдээллийг энэхүү үнэт цаасны танилцуулгын 102-оос 110 дугаар хуудаснаас дэлгэрүүлэн унших боломжтой. Мөн хөрөнгө оруулагч нь энэхүү үнэт цаасны танилцуулгын бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөлөл зэрэг хэсэгт тусгагдсан урьдчилсан төсөөллүүд нь олон тооны таамаглалд суурилсан ба Ард Кредит ББСБ-ын бодит бизнес, үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн байдал, Ард Кредит ББСБ-ын үйл ажиллагаа явуулж буй салбарын хөгжил нь энэхүү үнэт цаасны танилцуулгад тусгагдсан урьдчилсан төсөөллөөс материаллаг зөрүүтэй байж болно гэдгийг санах нь зүйтэй.



000148





ХАВСРАЛТ: Тайлангийн дараах үйл явдал

Энэхүү үнэт цаасны танилцуулга нь Ард Кредит ББСБ-ын 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн түүхэн мэдээллийг агуулсан болно. Иймд энэхүү хугацаанаас хойш компанийн үйл ажиллагаа болон санхүүд гарсан дэвшил, өөрчлөлтийн талаар сүүлийн үеийн мэдээллийг энэхүү хэсэгт хүргэхийг зорилоо.

Компанийн үйл ажиллагаа

- Компани нь 2018 оны 4 сарын 28-ны өдөр “Ард” аппликэйшнийг олон нийтэд танилцуулж, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал дээр аппликэйшний нээлтийг хийсэн болно. Технологийн хурдацтай хөгжилтэй хөл нийлүүлэн, бизнесийн чиг хандлага, стратегийг өөрчлөн уламжлалт ББСБ-аас финтект суурилсан санхүүгийн үйлчилгээ үзүүлэх компани болох алхмаа хийсэн. Өнөөдрийн байдлаар харилцагчид манай “Ард” аппликэйшнийг ашиглан төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, худалдан авалт, төрийн үйлчилгээний төлбөр төлөх, нэгж карт авах, QRau, АТМ –ээс ТАН код ашиглан картгүй бэлэн мөнгө гаргах зэрэг үйлчилгээнүүдийг авч байна.
 - Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь 2018 оны 7 сарын 30-ны өдөр ГрэйпСити Монгол ХХК-тай стратегийн хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Энэхүү гэрээний хүрээнд Ард Кредит ББСБ нь “Ард” аппликэйшнээр дамжуулан дахин нэг шинэ бүтээгдэхүүн болох онлайн барьцаагүй зээлийг харилцагчиддаа санал болгож байгаа юм. Энэ үйлчилгээний туршилтыг сүүлийн 3 сарын турш хийж байгаа бөгөөд 2018 оны 12 сараас эхлэн үйл ажиллагаандаа нэвтрүүлж барьцаагүй зээл олгож эхлэхээр төлөвлөөд байна.
 - Дээрх үйлчилгээ нэвтрүүлснээр 2017 онд компани нь 691 харилцагчтай байсан бол 2018 оны 11 сарын байдлаар даруй 3,000 харилцагчтай болсон байна. Ялангуяа сүүлийн үед компанийн зүгээс “Ард” аппликэйшний танилцуулгыг фэйсбүүкээр сурталчилж, урамшуулал зарласантай холбоотойгоор харилцагчдын тоо огцом өсөж зөвхөн 2018 оны 11 сарын 1-ний өдрөөс 11 сарын 11-ний өдрийн хооронд буюу 10 өдөрт 1,712 харилцагч шинээр нэмэгдсэн байна. Энэ нь 2018 онд хүрэхээр төлөвлөж буй нийт харилцагчдын тоо болох 1,933-ийг даваад байгаа бөгөөд үнэт цаасны танилцуулганд дурьдсан компанийн бизнес төлөвлөгөө бүрэн биелэх боломжтойг илтгэж байгаа нэг үзүүлэлт юм.
- Харилцагчдын тоо

	Бодит			Төлөвлөсөн				
	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Уламжлалт санхүүгийн үйлчилгээ	199	329	691	1,600	2,740	3,920	5,080	6,240
Ард онлайн зээл				333	4,464	10,725	26,335	45,362
Нийт	199	329	691	1,933	7,204	14,645	31,415	51,602

- Бид компанийн харилцагчдын тоог ирэх 5 жилд дунджаар 147 хувиар жил бүр өснө гэж төсөөлсөн бөгөөд 2022 онд нийт харилцагчдын тоо 51,602-д хүрэхээр төлөвлөсөн болно. Энэхүү өсөлтийг тооцоолохдоо “Ард” аппликэйшнээр хүргэх зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөлөөллийг тусгасан болно. Тухайлбал, 2017 онд компанийн нийт харилцагчид уламжлалт аргаар зээл авч байсан бол 2022 онд нийт харилцагчдын 88 хувь буюу 45,362 харилцагч “Ард” аппликэйшнээр дамжуулан зээл авахаар төлөвлөсөн болно. “Ард” аппликэйшнийг ашиглах харилцагчдын тооны өсөлтийг өөрсдийн туршилтын дүнгээс нилээн доогуур төсөөлсөн болно. Тухайлбал, Ард Кредит ББСБ нь



000149



СЭХ
2019.01.09
БҮРТГЭЛ
№ 01

Үнэт цаасны танилцуулга

ARD КРЕДИТ ББСБ БИРЖ
BBSB EXCHANGE
2018-11-29
БҮРТГЭВ-02

2018 оны 11 сарын 1-ний өдрөөс 11-ний өдрийн хооронд 10 хоногт “Ард” аппликэйшнийг олон нийтэд таниулах ажлыг идэвхижүүлэхэд App стор болон Плей стороос 15,000 гаруй удаа “Ард” аппликэйшний таталт хийн Монголоос хамгийн их татагдсан апп болсон байна. Мөн 1,712 харилцагч компанид бүртгүүлж, албан ёсны нэвтрэх эрхээ авсан. Энэ нь бид 2018 онд “Ард” аппликэйшнээр зээл авах харилцагчдынхаа тоог 333 гэж төлөвлөснөөс даруй 10 дахин өндөр үзүүлэлт байлаа. Мөн компанийн шинээр нэвтрүүлж буй “Ард” аппликшнээр зээл олгох үйлчилгээтэй төстэй үйл ажиллагаа явуулдаг ЛэндМН ХК-ийн харилцагчдын тоо 2018 оны 9 сард 71.2 мянган хүрсэн нь Ард Кредит ББСБ нь бизнес төлөвлөгөөний зорилтод хүрэх итгэл төрүүлж байна. Харин уламжлалт санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний харилцагчдын өсөлтийг тооцоолоходоо компанийн харилцагчдын түүхэн өсөлтийг суурь болгосон бөгөөд сүүлийн 3 жилийн хугацаанд компанийн харилцагчдын тоо 64 хувиар өссөн байна. Мөн, Ард Кредит нь “Ард даатгал” ХК, “Монгол шуудан” ХК зэрэг зэргэлдээ компаниудын салбараар дамжуулан хөдөө орон нутагт зээлийн үйлчилгээг үзүүлэхээр төлөвлөж байна. Харилцагчдын тоо нэмэгдэх, “Ард” аппликэйшнээр дамжуулан зээлийн үйлчилгээ нэвтрүүлснээр үйлчилгээний цар хүрээ тэлж, зээлийн хэмжээ нэмэгдэх нь компанийн үндсэн орлого болох хүүгийн болон шимтгэлийн орлого өснө. 2017 онд хүүгийн орлого өмнөх онтой харьцуулахад 30 хувь өсөж, 1.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. 2018 онд бид хүүгийн орлогоо 38 хувь, өсгөхөөр төлөвлөж байгаа бөгөөд цаашид 2018-2022 оны хооронд нийт хүүгийн орлогыг жилд дунджаар 68 хувь өсгөхөөр тооцоолов. Үүнд компанийн хэлбэрийг өөрчлөн олон нийтээс санхүүжилт татаж байгаатай холбоотой зээлийн эх үүсвэр нэмэгдэж байгаа мөн “Ард” аппликэйшнээр олгож буй зээл олголт шинээр нэмэгдэж байгаа нь нөлөөлсөн болно. Тухайлбал, 2017 онд нийт хүүгийн орлогыг 100 хувь уламжлалт зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс орсон орлого бүрдүүлж байсан бол 2022 онд нийт хүүгийн орлогын 64 хувийг уламжлалт зээлийн хүүгийн орлого, 36 хувийг “Ард” аппликэйшнээр олгож буй зээлийн хүүгийн орлого бүрдүүлэхээр тооцоолсон болно.

Хүүгийн орлого (үнийн дүнгээр, сая төгрөг)

	Бодит			Төлөвлөсөн				
	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Уламжлалт санхүүгийн үйлчилгээ	944	1,364	1,767	2,430	6,520	7,799	9,837	11,636
Ард онлайн зээл				15	644	1,695	3,914	6,465
Нийт хүүгийн орлого	944	1,364	1,767	2,445	7,164	9,494	13,751	18,101


Хүүгийн орлого (өөрчлөлт, хувь)


	Бодит			Төлөвлөсөн				
	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Уламжлалт санхүүгийн үйлчилгээ	6%	45%	30%	38%	168%	20%	26%	18%
Ард онлайн зээл					4193%	163%	131%	65%
Нийт хүүгийн орлого	6%	45%	30%	38%	193%	33%	45%	32%

Өнгөрсөн хугацаанд компанийн орлогын дийлэнх хэсгийг хүүгийн орлого бүрдүүлж байсан бол “Ард” аппликэйшнийг зах зээлд нэвтрүүлсэнээр шимтгэлийн орлого нь



000150





компанийн томоохон орлогын эх үүсвэр болох юм. 2017 онд нийт санхүүгийн орлогын 87.2 хувийг хүүгийн орлого, 4.5 хувийг шимтгэлийн орлого эзэлж байсан бол 2022 онд 55.5 хувийг хүүгийн орлого, 43.0 хувийг шимтгэлийн орлого эзлэхээр төлөвлөж байна. 2017 онд компанийн шимтгэлийн орлого 146 хувиар өсөж, 91 сая төгрөгт хүрсэн байна. 2018 онд бид шимтгэлийн орлогоо 185 хувиар өсгөхөөр төлөвлөж байна. Цаашид 2018-2022 оны хооронд шимтгэлийн орлогыг жилд дунджаар 213 хувиар өсгөхөөр тооцоолсон болно. Энэ нь компани ирэх жилүүдэд хүүгийн орлогоос илүүтэй “Ард” аппликэйшнийг зах зээлд нэвтрүүлж цахим, барьцаагүй зээл олгож эхлэх ба энэхүү зээлийн бүтээгдэхүүн нь 2022 онд 12.4 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого олж, нийт зээлийн багцын 30 хувийг эзлэхээр төлөвлөж байна. “Ард” аппликэйшнээр дамжуулан олгож буй зээлийн дундаж хугацаа нь 30 хоног, зээлийн эргэц жилд 12 байна. “Ард” аппликэйшн нь финтекийн технологийн шийдлийг ашиглаж байгаа тул уламжлалт зээлийн үйл ажиллагаатай харьцуулахад эргэц өндөр нийт олгосон зээлийн дүн өндөр байх тул шимтгэлийн орлого өндөр байна. Бидний явуулсан бичил судалгаа болон “ЛэндМН ББСБ” ХК-ийн явуулсан судалгаанаас үзэхэд бичил хэрэглээний зах зээл нь 600-аас 900 тэрбум төгрөгийн багтаамжтай байх боломжтой ба компанийн “Ард” зээлийн үлдэгдэл 2022 онд 22.6 тэрбум байхаар төсөөлж байгаа нь зах зээлийн 4 орчим хувь юм. Мөн, компанийн шууд өрсөлдөгч болох “ЛэндМН ББСБ” ХК нь 2018 оны эхний 9 сарын байдлаар 39.5 тэрбум төгрөгийн зээл олгож 4.6 тэрбум төгрөгийн шимтгэл болон түүнтэй адилтгах орлоготой ажилласан нь зах зээлийн багтаамжийг батлаад зогсохгүй компани өөрийн бизнес төлөвлөгөөнд хүрч ажиллах итгэл төрүүлж байна.

Шимтгэлийн орлого (үнийн дүнгээр, сая төгрөг)

	Бодит			Төлөвлөсөн				
	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Уламжлалт санхүүгийн үйлчилгээ	50	37	91	244	640	765	1,211	1,618
Ард онлайн зээл				15	1,113	3,033	7,259	12,425
Шимтгэлийн орлого	50	37	91	259	1,753	3,798	8,470	14,043

Шимтгэлийн орлого (өөрчлөлт, хувь)


	Бодит			Төлөвлөсөн				
	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Уламжлалт санхүүгийн үйлчилгээ	4%	-26%	146%	168%	162%	20%	58%	34%
Ард онлайн зээл					7320%	173%	139%	71%
Шимтгэлийн орлого	4%	-26%	146%	185%	577%	117%	123%	66%

- “Ард” аппликэйшний бусад санхүүгийн цахим үйлчилгээ үзүүлдээг байгууллагуудын аппликэйшнаас нэг том ялгаатай бөгөөд давуу тал нь энэхүү аппликэйшнийг ашигласнаар санхүүгийн цогц үйлчилгээ авах боломжтой болох юм. Өөрөөр хэлбэл, Ард Санхүүгийн нэгдэлд багтаж байгаа Ард Даатгал компанийн даатгалын үйлчилгээ, Ард Секюритиз УЦК-ийн хөрөнгийн зах зээл дээрх үнэт цаасны арилжааны зуучлалын үйлчилгээ, Тэтгэврийн санд хамаарагдах, валют арилжаа, цахим худалдааны үйлчилгээ зэрэг үйлчилгээнүүдийг нэг дороос авах боломж бүрдэх бөгөөд энэхүү синержийг үүсгэж



000151





Эрсдэлийн шинжилгээ

“Ард” аппликэйшнээр дамжуулан онлайн барьцаагүй зээл олгох үйлчилгээний туршилтын явцад эрсдэлийн шинжилгээг эргэн харж, зарим нэгэн тооцоогүй эрсдэлийг тодорхойлох, илүү дэлгэрэнгүй болгох, эрсдэлийг бууруулах талаар авах арга хэмжээнүүдийг тодорхой болгох шаардлага үүссэн билээ. Тиймээс үнэт цаасны танилцуулгад дурдагдсан Эрсдэлийн удирдлагад зарим шинэ төрлийн эрсдэлүүдийг оруулах, эдгээр эрсдэлийг удирдах арга зам зэргийг нэмэлтээр оруулж байна. Үүнд:

- Стратегийн эрсдэл

Улс төр, хууль эрх зүйн орчны эрсдэл: Компанийн эрхэлж буй үйл ажиллагаа нь Монгол Улсад хэрэгжин мөрдөгдөж буй Үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооны ББСБ-ын үйл ажиллагааг зохицуулдаг дүрэм, журамд захирагдан ажилладаг. Иймд тэдгээр хуульд УИХ-аас гэнэтийн өөрчлөлт оруулах, Банкуудад давуу байдал олгосон, ББСБ-ын үйл ажиллагааг хязгаарласан хууль, тогтоомжийн зохицуулалтыг батлах; СЗХ-оос ББСБ-ын үйл ажиллагааг зохицуулдаг дүрэм, журамд өөрчлөлт орох, шалгуур үзүүлэлтүүдийг өндөрсгөх; СЗХ удирдлага солигдож, үйл ажиллагаа, тавих шаардлагад өөрчлөлт орох; улс төрөөс үүдэлтэй гэнэтийн үймээн самуун гарч, онцгой байдал үүсэх; төрийн байгууллагын хээл хахууль, авлигын үр дагавраар улсын бүртгэл, иргэдийн өмч хөрөнгийг бүртгэлд хуурамч, худал мэдээлэл орох, уг мэдээлэл дээр үндэслэн зээл олгох зэрэг нь компанид ихээхэн эрсдэл учруулах боломжтой.

Эдгээр эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийн үзүүлэх нөлөөг багасгах үүднээс компани нь шинээр сонгогдсон, эрх баригчдын шийдвэр бодлогуудыг тогтмол ажиглан судлах, өргөн баригдаж буй төслүүдийг тогтмол хянаж, үйл ажиллагааны цар хүрээг хязгаарласан дүрэм, журмын төсөлд санал өгөх замаар хяналт тавьж оролцох; мэргэжлийн хуулийн фирм болон салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бусад ББСБ-уудтай холбооны шугамаар хамтран ажиллаж нийт ББСБ-ын эрх ашгийг төлөөлж болон хамгаалж нөлөөллийн ажиллагаа явуулах; Хууль, дүрмийн өөрчлөлтийг цаг тухайд нь хэрэгжүүлж мөрдөн ажиллах, Хууль дүрмийн хэрэгжилт хариуцсан тухайлсан ажилтантай болох; Мөнгө угаах, терроризмтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, харилцагчдын мэдээллийг давхар шалган боловсруулах зэрэг арга хэмжээг аван ажиллаж байна.

Нэр хүндийн эрсдэл: Компани нь групп компанийн хамааралтай учир зэргэлдээ охин компани эсвэл толгой компанийн нэр хүнд, тэдгээрийн удирдлагын нэр хүнд унахад компанид шууд нөлөө үзүүлэх эрсдэлтэй. Мөн компанийн шошго, лого зэргийг хөндлөнгийн этгээд ашиглах, компанийн үйл ажиллагаанд дагаж мөрддөг дүрэм, журам алдагдах зэргээс шалтгаалан олон нийтийн дунд компанийн нэр хүнд унах эрсдэл бий. Эдгээр нөлөөг хамгийн бага түвшинд барихын тулд компани нь удирдлагын хийж буй үйлдэл хуулийн журмын дагуу, ёс зүйтэй байхад анхааран, компанийн нэр бүхий хаяг, шошго, логог патент авч, Монгол улсын хууль, болон холбогдох эрх бүхий байгууллагаас тавигдах шаардлагын дагуу компанийн дотоодод мөрдөгдөх дүрэм журмыг гаргаж батлан, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Өрсөлдөөний эрсдэл: Арилжааны банк, өрсөлдөгч банк бус санхүүгийн байгууллагууд, үүрэн телефоны оператор, үндэсний томоохон группууд нь финтек технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, зах зээлд нэвтрэх болон уламжлалт үйлчилгээ үзүүлдэгч



000152



Сүүнэт цаасны танилцуулга
2019 о.01.09
БҮРТГЭВ
№ 01

ARD КРЕДИТ ББСБ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2018-11-29
БҮРТГЭВ-02

банк бус санхүүгийн байгууллагууд хоорондын өрсөлдөөн ширүүсэх зэрэг эрсдэл нь компанид тулгарч болно.

Компани нь энэхүү эрсдэлийг бууруулах стратеги баримталдаг ба эрсдэлийг бууруулах арга зам нь өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээг бусад ижил төрлийн үйлчилгээнээс ялгаруулж, дахин давтагдашгүй, хуулбарлах боломжгүй үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх юм. Ард аппликэйшний одоогийн хувилбар нь мөнгөн шилжүүлэг хийх, төлбөр тооцоо хийх, худалдан авалт хийх зэрэг функцуудыг багтаасан бол 2019 оны 1 сард зах зээлд нэвтрүүлэх дараагийн хувилбар нь цахимаар богино хугацаат, барьцаагүй зээл олгох, цахим худалдаа хийх, үнэт цаасны арилжаа, даатгалын үйлчилгээ, тэтгэврийн сангийн үйлчилгээ зэрэг олон төрлийн санхүүгийн үйлчилгээг Ард Санхүүгийн Нэгдлийн бүрэлдэхүүн компаниудтай хамтран, цогцоор харилцагчдад санал болгох юм. Бид аппликэйшний энэхүү давуу тал, дахин давтагдашгүй байдлыг ашиглан өөрсдийн зах зээлд эзлэх байр суурийг хурдтайгаар нэмэгдүүлж, бэхжүүлэхээр төлөвлөж байна.

Зах зээлийн эрсдэл: Зах зээл дэх экспортын гол түүхий эдийн үнэ, ханшийн өөрчлөлт, улс төрийн шийдвэр зэрэг гадаад хүчин зүйлсээс шалтгаалан Монгол Улсын эдийн засгийн өсөлт удааширч, хөрөнгө оруулагчдын итгэл унах, иргэд болон аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадвар муудаж, эдийн засаг хямарч системийн хувьд зээлийн чанар муудах эрсдэл нь ББСБ-ын салбарын үйл ажиллагаа болон санхүүгийн байдалд сөрөг нөлөөтэй. Энэхүү эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс компани нь макро эдийн засгийн орчины судалгааг тогмол явуулах, зээлийн багцыг салбараар тархаан байршуулж аль нэг бизнесийн сектроос хэт хамаарал үүсгэхгүй байх, урт хугацааны санхүүжилт олгох байгуулагыг сонгон ажиллах зэрэг дээр анхааран ажиллаж байна.

Хүүгийн түвшний эрсдэл: Монголбанк баримталж буй мөнгөний бодлогын чиглэлийг өөрчлөх, мөнгөний бодлогын хүү огцом өсөх болон буурах, санхүүгийн салбарын хүүгийн түвшин өөрчлөгдөх зэрэг нь компанийн үндсэн үйл ажиллагаа болох зээл олголтод сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Компани нь уг эрсдэлийг бууруулах стратеги баримталдаг ба энэ стратегийг өөрийн хүүгийн түвшинг нам дор барьж, салбартаа хамгийн бага хүүг санал болгох, мөнгөний бодлогын чиглэлийг үйл ажиллагаандаа анхааралтай ажиглах, түүнтэй уялдсан стратеги, үйл ажиллагааны шийдвэр гаргах зэргээр хэрэгжүүлж байна. Мөн компани санхүүжилт татах хүүгийн орчин хэт сөрөг буюу өндөр болсон тохиолдолд гадаад санхүүжилтийг бага хүүгээр татах зэргээр эрсдэлийг удирдаж байна.

- Санхүүгийн эрсдэл


Зээлийн эрсдэл: Зээлдэгч гэрээний үүргээ үл биелүүлэх, зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбөрийг цаг хугацанд төлөхгүй байх, зээлийн багцын чанар муудах зэрэг эрсдэл орно. Зээлийн эрсдэл нь компанийн үндсэн санхүүгийн эрсдэл юм. Компанийн алсын хараа, үйл ажиллагааны зорилгоос шалтгаалан зээлийн эрсдэл нь голчлон компанийн олгосон зээлээс үүсдэг ба мөн засгийн газрын бондод оруулсан хөрөнгө оруулалт, компанийн өрийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалт зэрэг нь мөн зээлийн эрсдэлийг үүсгэж байна.

Компанийн зээлийн эрсдэлийн удирдлага нь компанийн зээлийн багцын чанарыг өндөр түвшинд хадгалаж, компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад оршино. Компани нь зээлийн эрсдэлийг зээл нэг бүрийн болон зээлийн багцын гэсэн 2 түвшинд удирддаг ба зээл нэг бүрийг зээлийн бодлогын дагуу хянаж, зээлжих чадварыг тодорхойлдог бол зээл, эрсдэлийн хороо нь зээлийн багцын эрсдэлийг хянадаг. Зээл нэг бүрийн түвшинд зээлийн эрсдэлийг зээл олгох түвшинд зээлийн мэргэжилтэн хянадаг ба зээлийн материалыг хянан, зээлдэгчийн санхүүгийн байдал, барьцаа хөрөнгө зэрэгт тулгуурлан зээлийн шийдвэрийг гаргадаг. Зээл, эрсдэлийн хороо нь зээлийн багцын



000153





зээлийн бүтээгдэхүүний төвлөрөл, бизнесийн салбарын төвлөрөл, нэг зээлдэгчийн төвлөрөл зэргийг хянан зээлийн багцын эрсдэлийг хянадаг.

Компани нь 100 хувь барьцаагүй, хэрэглээний зээлийн багц нь хэт эрсдэлтэй хэмээн үздэг ба зээлийн багцад эзлэх зээлийн бүтээгдэхүүний хувь хэмжээг стратеги зорилтын дагуу зохистой түвшинд хадгалж ажиллаж байна.

Ханшийн эрсдэл: Компанийн гадаад валютаар татсан санхүүжилт, гадаад валютаар олгосон зээл зэрэг нь ханшийн хөдөлгөөнд мэдрэг ба энэ нь гадаад валютын ханшийн эрсдэл бий болгож байна. Компани нь валютын ханшид нөлөөлөхүйц улс төр, эдийн засгийн үйлдлүүдийг тогтмол хянах, ханшийн таамаглал дээр үндэслэн зээл олголтыг хумих эсвэл тэлэх бодлого барих, хугацааны давтамжтай гадаад валютын ханшийн таамаглал хийх, үүсмэл санхүүгийн хэрэгслүүд ашиглан ханшийн эрсдэлийг хэджинг хийх зэргээр ханшийн эрсдэлийг удирдаж байна.

Хөрвөх чадварын эрсдэл: Зах зээлийн төлөв, ханшийн савалгаа, чанаргүй зээл болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан компани нь бэлэн мөнгөний хомсдолд орж зээл олгоход шаардлагатай бэлэн мөнгө дутагдах эрсдэл үүсэх боломжтой.

Компани нь бэлэн мөнгөний зохистой харьцааг ханган, тогтмол хяналт тавин ажиллах, зээлийн шугам, засгийн газрын бонд, МХБ дээр нээлттэй арилжаалагдаж буй хувьцаанууд зэрэг хөрвөх чадвар өндөр санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулж, хөрвөх чадварын зохистой түвшинг барих зэргээр уг эрсдэлийг удирдан ажиллаж байна.

Төлбөрийн чадварын эрсдэл: Компани нь богино хугацаат өр төлбөр, хүлээсэн үүргийн биелүүлэлтийг мөнгөн хөрөнгөөр барагдуулах чадамжгүй байх эрсдэл.

Энэ эрсдэлийг санхүү төлөвлөлтөд төлбөрийн үүргийг тусгах, хөрөнгийн удирдлагын бодлогын дагуу хөрвөх чадвар өндөр санхүүгийн хэрэгслийг зохистой хэмжээнд хадгалах зэргээр удирдаж байна.

Барьцаа хөрөнгийн эрсдэл: Зээлийн барьцаанд байгаа эд хөрөнгийн зах зээлийн үнэ огцом унах, зээлийн үнийн дүнгээс доош орох эрсдэл юм. Компани нь зээлийн бодлогын дагуу барьцааны зүйлийн шинж чанараас хамааран зээлийн үнийн дүнг тодорхойлдог. Мөн зарим барьцааны эд хөрөнгийг даатгалын компанид даатгуулах замаар эрсдэлийг шилжүүлдэг.

- Үйл ажиллагааны эрсдэл

Харилцагчийн мэдээллийн эрсдэл: Харилцагч худал мэдээлэл өгөх, хуурамч баримт бичиг бүрдүүлж зээл, мөнгөн хөрөнгө гаргуулж авах эрсдэл орно.

Энэхүү эрсдэлийг зээлийн мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулж, зөвхөн хүлээн зөвшөөрөгдсөн мэдээллийн эх үүсвэрийн мэдээллийг хүлээж авах, зээлийн мэдээллийн сангийн мэдээлэлтэй зээлдэгчийн мэдээллийг тулгах зэргээр эрсдэлийг бууруулна.

Хүний нөөцийн эрсдэл: Хүний нөөцийн эргэц нэмэгдэх, ажилчдын ур чадвар буурснаар компанийн бүтээмж буурах, үүнээс үүдэн компанийн нэр хүнд унах зэрэг эрсдэл орно. Компани нь боловсон хүчний сургалтыг тогтмол явуулдаг ба үйл ажиллагааны дотоод журмуудыг ажилчидад тогтмол зааварлах, зах зээлд өрсөлдөхүйц цалин, урамшууллыг ажилчдад санал болгох зэргээр уг эрсдэлийг бууруулж байна.

Серверийн ажиллагааны эрсдэл: Поларис үндсэн банкны систем нь Tier-3 дата төвд тооцогдох АйТүүлс модулар дата төвд байршиж буй cloud буюу үүлэн системд суурилсан систем юм. АйТүүлс дата төв нь 2 тустаа сүлжээ түгээгчээс өндөр хурдын интернэтийн холболт авдаг ба ТЭЦ 4 цахилгаан станцаас эрчим хүчээ авдаг байна. Дата төвийн физик



000154



СХК
Унэт цаасны танилцуулга
2019.01.09
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛ АРД КРЕДИТ ББСБ
MONGOLIAN ARD CREDIT BBSB
EXCHANGE
2018-11-29
БҮРТГЭВ-02

аюулгүй байдлыг хангахын тулд системийн инженерүүд 24/7 байрладаг ба дата төвд нэвтрэх эрх нь зөвхөн ажилчдын дунд хязгаарлагдсан байдаг. АйТүүлс ХК нь өөрийн дата төвийн серверийн баталгаат ажиллагааг ханган ажилладаг ба мөн компани нь өөрийн мэдээллийг хоёрдогч дата төвд байршуулан серверийн эрсдэлийг бууруулахаар төлөвлөж байна.

Кибер аюулгүй байдал: Кибер аюулгүй байдлыг АйТүүлс дата төвийн сүлжээний мөн программын firewall хангаж байна. Тус firewall нь дүрэм дээр үндэслэн халдалт, холболтын оролдлогыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, зогсооход ашиглагддаг юм. АйТүүлс ХК нь 2011 онд үүсгэн байгуулагдан мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байгаа ба Монголын программ хангамж, мэдээллийн технологийн салбарт тэргүүлэгч Ай Си Ти Групп-ийн охин компани юм.

Мөн Ард Санхүүгийн Нэгдэл болон Ард Кредит нь Грэйпсити-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр Грэйпсити-тэй хамтран поларис үндсэн банкны систем болон Ард аппликэйшний аюулгүй байдлыг ханган ажиллах юм.

Ард аппликэйшний найдвартай ажиллагаа: Компани нь Ард аппликэйшнийг үйл ажиллагааны томоохон бүрэлдэхүүн болгон хөгжүүлэх зорилготой байгаа ба Ард аппликэйшний үйл ажиллагааны доголдол нь харилцагчдаа алдах, нэр хүндийн, мэдээллийн аюулгүй байдлын зэрэг эрсдэлүүдийг дагуулах эрсдэлтэй.

Ард аппликэйшнийг хөгжүүлэгч Грэйпсити нь 2000 оноос хойш тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа ба олон улсын стандартын дагуу иж бүрэн банкны суурь бүртгэлийн системийг хөгжүүлж, 11 арилжааны банкинд нэвтрүүлсэн, Монгол Улсад төлбөр тооцооны картын систем болон банкны суурь бүртгэлийн системийг нэвт онлайн (24x7) болгож, бүх банкинд нэвтрүүлж интеграци хийсэн салбартаа тэргүүлэгч компани юм. Ард Санхүүгийн Нэгдлийн Грэйпсити-тэй байгуулсан гэрээний дагуу Ард аппликэйшний ажиллагааны тогтвортой байдлыг Грэйпсити хариуцаж байна.

Нэг бэлтгэн нийлүүлэгчээс хараат байгаа эрсдэл: Ард Кредит ББСБ нь Грэйпсити Монгол ХХК-тай байгуулсан стратегийн түншлэлийн гэрээний хүрээнд Ард аппликэйшн, Поларис банкны суурь системийг cloud хувилбараар нэвтрүүлсэн билээ. Ард аппликэйшний хөгжүүлэлт, ашиглалт, поларис банкны суурь систем нь нэг бэлтгэн нийлүүлэгчээс хамааралтай байгаа нь түншлэгч байгууллагын эрсдэл үүсгэж байна.

Нэг бэлтгэн нийлүүлэгчээс хараат эрсдэлийг Грэйпсити Монгол ХХК-тэй байгуулсан гэрээний эрх зүйгээр зохицуулж байгаа ба Ард аппликэйшнийг ашиглах эрх нь Ард Санхүүгийн Нэгдэлд байх ба уг эрхийг гуравдагч этгээдэд АСН-ийн зөвшөөрөлгүйгээр эдлүүлэхийг хориглосон байна.

Интернэт сүлжээний тогтвортой ажиллагааны эрсдэл: 2018 оны байдлаар Харилцаа холбооны зохицуулах хорооноос интернэт үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан 77 аж ахуйн нэгж байгууллага байгаа ба нийт 294.6 мянган өрх, аж ахуйн нэгжид үйлчилгээгээ хүргэж байна. Эдгээр интернэт үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагаа доголдох нь компанийн өдөр тутмын ажил болон цахим зээл олголтод сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Үүрэн холбооны операторуудын үйл ажиллагаа: Ард аппликэйшний ажиллагаа нь цахим орчинд суурилсан ба Мобиком, Юнител, Скайтел зэрэг үүрэн холбооны операторуудын хөдөлгөөнт интернэтийн үйлчилгээ доголдох нь компанийн үйл ажиллагаанд шууд сөргөөр нөлөөлөх боломжтой.

Монгол Улсын хүрээнд аль нэг үүрэн холбооны операторын сүлжээ унах магадлал нь маш бага ба компани нь энэ эрсдэлийг бууруулах боломжгүй юм.

Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн тогтвортой үйл ажиллагаа: Харилцагчийн зээлийн мэдээллийг шалгах, мост скоринг системээр харилцагчийн кредит скорийг тодорхойлоход Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл нь чухал үүрэгтэй ба



000155



СЭХ
 Үнэт цаасны танилцуулга
 ОН 2018-01-09
 БҮРЭГ
 № 0133

МОНГОЛЫН ХАНАГААНЫ БИРЖ
 MONGOLIAN STOCK EXCHANGE
 ARD КРЕДИТ ББСБ
 2018-11-29
 БҮРЭГ-02

Уг мэдээллийн санд доголдол үүсэх нь компанийн зээл олголтод сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа нь доголдож, компанийн үйл ажиллагаанд хохирол учруулж байсан тохиолдол байхгүй байна.

Арилжааны банкуудын сүлжээний үйл ажиллагаа: Арилжааны банкуудын сүлжээ доголдох нь компанийн зээлийн үйлчилгээг харилцагчдад хүргэхэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Арилжааны банкуудын сүлжээ нь удаан хугацаагаар доголдох тохиолдол ховор ба энэ төрлийн эрсдэл нь харьцангуй үр дагавар багатай юм.

Санхүүгийн байдал

Компани өөрийн хэлбэрээ өөрчилж олон нийтэд нээлттэй компани болохоор үнэт цаасны танилцуулгаа хүргэснээс хойш 2018 оны III улирлын санхүүгийн тайлан гарсан болно.

Хөрөнгө оруулагчдад компанийн хамгийн сүүлийн үеийн мэдээлэл хүргэх үүднээс энэхүү тайланг аудитын дүгнэлтийн хамт хүргүүлж байна.

- 2018 оны III улирлын байдлаар компанийн нийт хөрөнгө 9.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.5 хувиар өссөн. Энэхүү өсөлтөд зээлийн үйл ажиллагаа өргөжсөн нь нөлөөлсөн бөгөөд тайланд хугацаанд зээл болон хүүгийн авлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.2 хувиар өссөн байна. Өр төлбөр 6.1 тэрбум төгрөг, эздийн өмч 3.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 8.8 хувь болон 5.3 хувиар тус тус өссөн байна.

Санхүүгийн тайлангийн мэдээлэл


	2017 III	2018 III	Өөрчлөлт	
	сая төг	сая төг	сая төг	%
ХӨРӨНГӨ	8,939	9,611	672	7.5%
Мөнгө	922	1,110	188	20.3%
Зээл болон хүүгийн авлага	6,277	6,915	638	10.2%
Хөрөнгө оруулалт	450	331	(119)	-26.5%
Санхүүгийн хөрөнгө	832	621	(210)	-25.3%
Үндсэн хөрөнгө	257	276	19	7.5%
Биет бус хөрөнгө	2	49	47	2656.6%
Бусад	199	309	110	55.1%
ӨР ТӨЛБӨР	5,630	6,126	496	8.8%
Банкны зээл	1,001	1,454	453	45.2%
Бусад эх үүсвэр	4,149	4,100	(48)	-1.2%
Хүүний өр төлбөр	236	360	124	52.5%
Бусад өр төлбөр	244	212	(32)	-13.2%
ЭЗДИЙН ӨМЧ	3,309	3,485	176	5.3%
Энгийн хувьцаа	1,313	2,100	788	60.0%
Нэмж төлөгдсөн капитал	788	-	(788)	-100.0%
Хуримтлагдсан ашиг	1,209	1,385	176	14.5%

- 2018 оны III улирлын байдлаар Ард Кредит ББСБ нь 1.3 тэрбум төгрөгийн хүүгийн орлоготой ажилласан бөгөөд энэ нь 2017 оны мөн үетэй харьцуулахад 4.5 хувь өссөн үзүүлэлт юм. Хэдийгээр хүүгийн орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тогтвортой өссөн боловч компанийн ашиг буурч 69.9 сая төгрөгт хүрсэн байна. Энэ нь "Ард" аппликэйшныг нэвтрүүлж байгаатай холбогдуулан компанийн арын албыг автоматжуулах, холбогдох мэдээллээ шинэ програмд шилжүүлэн оруулах, судалгаа



000156





шинжилгээ, туршилт хийх зэрэг ихээхэн хүн хүч, зардал шаардсан ажиллагаа хэрэгжүүлсэн болон өрийн санхүүжилт нэмэгдсэн, эрсдэлийн сангийн зардал нэмэгдсэнтэй холбоотой юм. хүүгийн зардал 2018 оны III улирлаар 342 сая төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 107.5%-р өссөн байна. Энэ нь бид зээлийн үйл ажиллагаагаа өрийн санхүүжилтийн ашиглаж нэмэгдүүлсэнтэй холбоотой юм. Цаашид бид өмчийн санхүүжилтийг нэмэгдүүлснээр энэхүү өсөлтийг тогтвортой болгохоор төлөвлөж байна.


Мөн Монголын Хөрөнгийн Бирж дээр IPO хийхтэй холбоотойгоор компаниас энэ жил хууль, үнэлгээ, андеррайтерийн үйл ажиллагаатай холбоотой зардлууд гаргасан байна. 2018 оны III улирлын байдлаар зээлийн эрсдэлийн сангийн зардал 231 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 90.1%-р өссөн байна. Энэ нь зээлийн ангилал солигдсонтой шууд холбоотой бөгөөд компани нь чанаргүй зээлийн эргэн төлөлт дээр цаашид анхаарч ажилласнаар энэхүү зардлыг бууруулахаар төлөвлөж байна.

Хэдийгээр 2018 оны III улирлын байдлаар компанийн зардлууд өссөн байгаа хэдий ч эдгээр зардал нь компанийн үйл ажиллагааг тэлэх, үр ашгийг нэмэх төслүүдийг санхүүжүүлж байгаа бөгөөд компани 2018 оны эцэст төлөвлөсөн ашигтаа хүрнэ гэсэн итгэлтэйгээр ажиллаж байгаа.

Орлогын тайлангийн мэдээлэл

	2017 III сая төг	2018 III сая төг	өөрчлөлт сая төг	%
Цэвэр хүүгийн орлого	1,049	927	(123)	-11.7%
Хүүгийн орлого	1,214	1,268	54	4.5%
Хүүгийн зардал	165	342	177	107.5%
Хүүгийн бус орлого	153	225	72	47.0%
Гадаад валютын арилжааны орлого	1	1	0	37.5%
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	77	6	(71)	-92.5%
Үйлчилгээний орлого	75	81	6	7.6%
Бусад		137		
Хүүгийн бус зардал	852	817	(34)	-4.0%
Гадаад валют арилжааны зардал	2	0	(1)	-72.7%
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн гарз	73	17	(56)	-77.0%
Боловсон хүчний зардал	293	301	8	2.6%
Үйл ажиллагааны бусад зардал	484	500	16	3.3%
Эрсдэлийн сангийн зардал	122	231	110	90.1%
Үндсэн үйл ажиллагааны ашиг	229	103	(126)	-55.0%
Үйл ажиллагааны бус ашиг	9	(15)	(24)	-258.8%
Татварын өмнөх ашиг	238	89	(150)	-62.9%
Орлогын татвар	(22)	(19)	4	-17.1%
Татварын дараах цэвэр ашиг	216	70	(146)	-67.6%

- Далайван Аудит ХХК нь Ард Кредит БЭСБ ХХК-ийн 2018 оны 9 сарын 30-ы өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн болон өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын бусад нэмэлт тодруулагад завсрын үеийн нягтлах гэрээт ажлын тайланг хийж гүйцэтгэсэн болно. Далайван Аудит ХХК-аас Ард Кредит БЭСБ ХХК-ийн санхүүгийн тайланд хийсэн нягтлах гэрээт ажлын дүгнэлтийг доорх байдлаар тайлагнасан байна. “Бидний нягтлах гэрээт ажлаар, тухайн завсрын үеийн санхүүгийн тайлан нь 2018 оны 9 сарын 30-ний өдрийн байдлаар тус байгууллагын санхүүгийн



000157



СЗХ
Ом 2019-01-01
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны танилцуулга

МОНГОЛЫН ХУВИЙН БИРЖ
ARJ КРЕДИТ БИСБ
BSECK EXCHANGE
2018-11-29
БҮРТГЭВ-02

байдлын тайлан, мөн өдрөөр дуусгавар болгосон 9 сарын санхүүгийн үр дүн ба өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бүх материаллаг зүйлсийн хувьд бодитой илэрхийлээгүй байна гэж итгэх зүйл бидний анхааралд өртөөгүй болно” гэжээ.



000158

